

**Монгол Улсын Их Хурлын 2013 оны хаврын ээлжит чуулганы  
04 дүгээр сарын 25-ны өдөр (Пүрэв гараг)-ийн  
нэгдсэн хуралдааны гар тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга З.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Өглөөний хуралдаанд ирвэл зохих 74 гишүүнээс 41 гишүүн ирж, 55.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 22 минутад Төрийн ордны Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд эхлэв.

**Хоцорсон:** Н.Алтанхуяг-1:45, Д.Арвин-0:30, О.Баасанхүү-1:50,  
Сү.Батболд-0:40, Х.Баттулга-0:40, Д.Батцогт-0:30, З.Баянсэлэнгэ-1:50,  
С.Баярцогт-0:35, Д.Ганбат-0:30, Л.Гантөмөр-0:40, Д.Ганхуяг-0:30,  
Ц.Даваасүрэн-0:55, Б.Наранхүү-2:10, Ц.Нямдорж-0:30, Ц.Оюунбаатар-0:40,  
Д.Оюунхорол-0:40, Д.Сарангэрэл-1:15, Ч.Сайханбилэг-0:35, О.Содбилэг-0:50,  
Д.Тэрбишдагва-2:10, Ц.Цолмон-0:40, Б.Чойжилсүрэн-0:30, Ж.Энхбаяр-0:45,  
Ж.Эрдэнэбат-0:35;

**Чөлөөтэй:** Су.Батболд, Р.Бурмаа, Л.Цог;

**Өвчтэй:** Ц.Дашдорж.

Үдээс өмнөх хуралдаанд нийт 70 гишүүн ирж, 94.5 хувийн ирцтэй байв.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга З.Энхболд хариулж, тайлбар хийв.

**Нэг. Цагдаагийн албаны тухай хуулийн төсөл, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөх оруулах тухай, Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архидан согтуурахтай тэмцэх хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд (хэлэлцэх эсэх асуудлаар санал хураана).**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүйн сайд Х.Тэмүүжин, Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Баярцэцэг, мөн яамны Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын дарга Б.Баасандорж, Эрх зүйн шинэчлэлийн бодлогын

газрын дарга Т.Бат-Өлзий, мөн газрын ахлах мэргэжилтэн Д.Ариунтуяа, мэргэжилтэн Э.Сэлэнгэ, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, судалгааны төвийн дарга Ц.Азбаяр, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Э.Түвшинжаргал, референт К.Пүрэвсүрэн нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байлцав.

**3.Энхболд:** - Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг дэмжье.

Зөвшөөрсөн:	38
Татгалзсан:	12
Бүгд:	40

79.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 09 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал.**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Ч.Дашням, Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч Д.Ганзориг, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Э.Түвшинжаргал, референт К.Пүрэвсүрэн нар байлцав.

Улсын Их Хурлаас санал болгосон нэр дэвшигчийн талаар Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Түвдэндорж нар танилцуулав.

Танилцуулга болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг, Ө.Энхтүвшин нарын тавьсан асуултад нэр дэвшигч Д.Ганзориг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Ц.Нямдорж, Р.Гончигдорж, Д.Лүндээжанцан нар санал хэлэв.

**3.Энхболд:** - Дондовын Ганзоригийг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох саналыг дэмжье.

Зөвшөөрсөн:	58
Татгалзсан:	7
Бүгд:	65

79.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд **“Үндсэн хуулийн цэцийн**

**гишүүнээр томилох тухай**” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн найруулгыг уншиж танилцуулав.

Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд дээрх тогтоолын эцсийн найруулгыг сонсов. (09:52)

**3.Энхболд:** - Дүгэржавын Мөнхгэрэлийг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье.

Зөвшөөрсөн:	57
Татгалзсан:	9
Бүгд:	66

86.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд **“Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай”** Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн найруулгыг уншиж танилцуулав.

Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд дээрх тогтоолын эцсийн найруулгыг сонсов. (10:00)

Уг асуудлыг 10 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

**Гурав. Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогтын ёс зүйн зөрчлийн асуудлаар Ёс зүйн дэд хорооноос гаргасан санал, дүгнэлт.**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх М.Тайшир, зөвлөх М.Элбэгдорж, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны дарга С.Дэмчиг нар байлцав.

Ёс зүйн дэд хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг танилцуулав.

Дэд хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ц.Даваасүрэн, Г.Уянга, Ө.Энхтүвшин, Ц.Оюунбаатар, Ц.Нямдорж нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэв.

- Улсын Их Хурлын дарга З.Энхболд төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Ч.Улаан, Ц.Баярсайхан, С.Одонтуяа нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэв.

Уг асуудлыг 10 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

***Дөрөв. Улсын Их Хурлын дэд дарга С.Баярцогтыг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудал (үргэлжлэл).***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх М.Тайшир, зөвлөх М.Элбэгдорж, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны дарга С.Дэмчиг нар байлцав.

Улсын Их Хурал дахь “МАХН-МУАН-ын Шударга-Ёс эвсэл” бүлгийн завсарлага авсан хугацаа дуусч байгааг бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг мэдэгдэв.

Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт үг хэлэв.

**З.Энхболд:** - Улсын Их Хурлын дэд дарга С.Баярцогтыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх саналыг дэмжье.

Зөвшөөрсөн:	56
Татгалзсан:	8
Бүгд:	64

87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд ***“Монгол Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай”*** Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн найруулгыг уншиж танилцуулав.

Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд дээрх тогтоолын эцсийн найруулгыг сонсов. (10:46)

Уг асуудлыг 10 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

***Тав. Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах эсэх тухай асуудал (үргэлжлэл).***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх М.Тайшир, зөвлөх М.Элбэгдорж, референт С.Энхцэцэг нар байлцав.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг завсарлага авсан талаар бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд танилцуулав.

Уг асуудлаар Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэгийн тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Дэмбэрэл, Сү.Батболд, Д.Оюунхорол, Н.Энхболд, Ц.Цолмон, Ё.Отгонбаяр, А.Тлейхан, Д.Хаянхярваа, Ч.Хүрэлбаатар, А.Бакей, Ц.Нямдорж, Д.Ганхуяг, О.Содбилэг, Д.Лүндээжанцан, Ц.Оюунгэрэл, Н.Батбаяр, Ж.Батзандан, Р.Гончигдорж, М.Энхболд, С.Бямбацогт, Ж.Эрдэнэбат, Ч.Сайханбилэг, Б.Бат-Эрдэнэ, С.Дэмбэрэл, Н.Номтойбаяр, Ө.Энхтүвшин, С.Эрдэнэ нар үг хэлэв.

**Хуралдаан 13 цаг 00 минутад завсарлаж, 14 цаг 24 минутаас үргэлжлэв.**

**Үдээс хойших хуралдаанд ирвэл зохих 74 гишүүнээс нийт 68 гишүүн ирж, 91.8 хувийн ирцтэй байв.**

**Хоцорсон:** О.Баасанхүү-1:25, С.Ганбаатар-0:30, Ц.Даваасүрэн-0:30, Д.Лүндээжанцан-0:35, Д.Оюунхорол-1:52, Ч.Сайханбилэг-0:30, Я.Санжмятав-0:30, А.Тлейхан-0:50, Д.Тэрбишдагва-0:40, Ч.Улаан-0:40, Ц.Цолмон-0:40, Ж.Энхбаяр-0:30, С.Эрдэнэ-0:30, Ж.Эрдэнэбат-1:05;

**Чөлөөтэй:** Су.Батболд, Р.Бурмаа, Л.Цог;

**Өвчтэй:** Ц.Дашдорж;

**Тасалсан:** Р.Амаржаргал, Ц.Оюунбаатар;

**Тав. Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах эсэх тухай асуудал (үргэлжлэл).**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх М.Тайшир, зөвлөх М.Элбэгдорж, референт С.Энхцэцэг нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр, Ө.Энхтүвшин, С.Эрдэнэ нар үг хэлэв.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, Монгол Ардын намын бүлгийн санал, дүгнэлтийг бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нар танилцуулав.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг үг хэлэв.

**3.Энхболд:** - Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан, Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах шаардлагагүй гэсэн саналыг дэмжье.

Зөвшөөрсөн: 46  
 Татгалзсан: 23  
 Бүгд: 69  
 66.7 хувийн саналаар огцруулах шаардлагагүй гэж үзэв.

Уг асуудлыг 15 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

***Зургаа. Маршалын албаны тухай хуулийн төсөл, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд (хэлэлцэх эсэх).***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүйн сайд Х.Тэмүүжин, Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Баярцэцэг, мөн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын дарга Т.Бат-Өлзий, Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын дарга Б.Баасандорж, Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Д.Ариунтуяа, мэргэжилтэн Э.Сэлэнгэ, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, судалгааны төвийн дарга Ц.Азбаяр, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Э.Түвшинжаргал, референт К.Пүрэвсүрэн, Ч.Батбямба нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүйн сайд Х.Тэмүүжин, Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Түвдэндорж нар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, С.Баярцогт, Ш.Түвдэндорж нар үг хэлэв.

**3.Энхболд:** - Хууль зүйн байнгын хорооны хуулийн төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье.

Зөвшөөрсөн: 51  
 Татгалзсан: 18  
 Бүгд: 69  
 73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

***Долоо. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн төсөл, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд (хэлэлцэх эсэх).***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүйн сайд Х.Тэмүүжин, Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Баярцэцэг, мөн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын дарга Т.Бат-Өлзий, Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын дарга Б.Баасандорж, Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Д.Ариунтуяа, мэргэжилтэн Э.Сэлэнгэ, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, судалгааны төвийн дарга Ц.Азбаяр, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Э.Түвшинжаргал, референт К.Пүрэвсүрэн, Ч.Батбямба нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүйн сайд Х.Тэмүүжин, Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Түвдэндорж нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Нямдорж, М.Батчимэг, Д.Лүндээжанцан нарын тавьсан асуултад Хууль зүйн сайд Х.Тэмүүжин, Улсын Их Хурлын гишүүн Ш.Түвдэндорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

**3.Энхболд:** - Хууль зүйн байнгын хорооны хуулийн төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье.

Зөвшөөрсөн:	44
Татгалзсан:	22
Бүгд:	66

73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

***Найм. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн төсөл (хэлэлцэх эсэх).***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүйн сайд Х.Тэмүүжин, Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Баярцэцэг, мөн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын дарга Т.Бат-Өлзий, Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын дарга Б.Баасандорж, Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Д.Ариунтуяа, мэргэжилтэн Э.Сэлэнгэ, Цагдаагийн ерөнхий

газрын Мэдээлэл, судалгааны төвийн дарга Ц.Азбаяр, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Э.Түвшинжаргал, референт К.Пүрэвсүрэн, Ч.Батбямба нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүйн сайд Х.Тэмүүжин, Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Түвдэндорж нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, Д.Лүндээжанцан нарын тавьсан асуултад Хууль зүйн сайд Х.Тэмүүжин хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

**3.Энхболд:** - Хууль зүйн байнгын хорооны хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье.

Зөвшөөрсөн:	45
Татгалзсан:	21
Бүгд:	66

68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

**Ес. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл (хэлэлцэх эсэх).**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухааны хэлтсийн дарга Ө.Сүхбаатар, Олон улсын Монгол судлалын холбооны Ерөнхийлөгч Д.Төмөртоого, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Монгол судлалын сургуулийн захирал Ц.Өнөрбаян, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ё.Мөнхбаатар, зөвлөх С.Энхцэцэг, референт Г.Нарантуяа нарын бүрэлдэхүүнтэн ажлын хэсэг байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр, Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Дэмбэрэл нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр, Б.Бат-Эрдэнэ, Л.Энх-Амгалан, С.Дэмбэрэл нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр, ажлын хэсгээс Ө.Сүхбаатар, Д.Төмөртоого, Ц.Өнөрбаян нар



хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Ж.Энхбаяр, М.Батчимэг, Ё.Отгонбаяр нар санал хэлэв.

**3.Энхболд:** - Төсвийн байнгын хорооны хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье.

Зөвшөөрсөн:	53
Татгалзсан:	14
Бүгд:	67

79.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

- 11:15-11:20 цагт Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа “Шинэ Эхлэл” олон улсын лаборатори сургуулийн багш, сурагчид, 14:30-14:35 цагт Монголын Хүний нөөцийн удирдлага шинэчлэлийн академийн Хүний нөөцийн сургалтын төвийн Нягтлан бодох бүртгэлийн ангийн багш, оюутнууд, 15:15-15:20 цагт Баянгол дүүргийн “Эрдмийн өргөө цогцолбор” сургуулийн багш, сурагчид, 16:10-16:15 цагт Америкийн Нэгдсэн Улсын Жорж Вашингтоны их сургуулийн улс төрийн менежментийн багш, профессор Нэнси Фоскор Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцав /нэрсийг хавсаргав/.

***Хуралдаан 17 цаг 44 минутад өндөрлөв.***

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.БОЛДБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ПРОТОКОЛЫН АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2013 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
04 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДӨР (ПҮРЭВ ГАРАГ)-ИЙН  
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ**

***Хуралдаан 09 цаг 22 минутад эхлэв.***

**3.Энхболд:** - Ирвэл зохих 74 гишүүнээс 41 гишүүн ирж, 55.4 хувийн ирцтэй байгаа учраас нээгдсэнийг мэдэгдье.

Өнөөдрийн чуулганаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Эхний асуудал түрүүчийн чуулганы санал хураахад бэлэн болоод зогссон Цагдаагийн албаны тухай хуулийн төслөөс эхэлнэ.

Хоёр дахь асуудал, Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал.

Гурав дахь асуудал, Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогтын ёс зүйн зөрчлийн асуудлаар Ёс зүйн дэд хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэнэ.

Дөрөв дэх асуудал, Улсын Их Хурлын дэд дарга С.Баярцогтыг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудал үргэлжилнэ. Завсарлага авсан байгаа.

Тав дахь асуудал нь Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах эсэх тухай асуудал үргэлжилнэ. Бас завсарлага авсан байгаа.

Зургаа дахь асуудал, Маршалын албаны тухай хуулийн төсөл болон холбогдох хуулийн төсөл.

Долоо дахь асуудал, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн төсөл болон холбогдох өөрчлөлт орж байгаа хуулиуд.

Найм дахь асуудал, Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх.

Ес дэх асуудал, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх.

Арав дахь асуудал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөх Монгол Улсын эдийн засаг, санхүү, төсвийн төлөв байдлын тухай мэдээлэл.

Арван нэг дэх асуудал, Улсын Их Хурлын Байнгын хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл батлахаар байгаа. Ийм арван нэг асуудлыг өнөөдөр хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Н.Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** - Би сая буруу дуулчихав уу. Тэр нөгөө Ерөнхий сайдыг огцруулахын дараа Байнгын хорооны юу байгаа. Тийм ээ.

**3.Энхболд:** - Байнгын хороон дээр Ардын Намын бүлэг бичгээ өгсөн. Шударга-Ёс эвсэл, Ардчилсан Намын бичиг одоогоор ирээгүй байна. Уг нь өглөө 9 цагт өгнө гэсэн. Тэгэхээр техникийн асуудал гарч байх учраас би хамгийн сүүл рүү тавилаа.

***Нэг. Цагдаагийн албаны тухай хуулийн төсөл, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөх оруулах тухай, Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архидан согтуурахтай тэмцэх хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд (хэлэлцэх эсэх)***  
***Ес. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл (хэлэлцэх эсэх)***

За хэлэлцэх асуудлаа баталъя. Одоо хэлэлцэх асуудал эхнийх Цагдаагийн албаны тухай хуулийн төсөл, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд өөрчлөлт оруулах, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн хуульд нэмэлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Согтууруулах ундаа хэтрүүлсэн, хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлаар санал хураая.

Санал хураалт явагдах гэж байна. Санал хураалт. Цагдаагийн байгууллагын тухай хуулийг хэлэлцэх эсэх тухай санал хураалт. Тийм. Түрүүн юун дээр зогссон гэхээр асуулт асуугаад үгээ хэлээд яг санал хураах дээрээ ажлын цаг тарсан учраас санал хураахаар үлдсэн байгаа.

Санал хураалтад 48 гишүүн оролцож, 38 гишүүн зөвшөөрч, 79.2 хувиар саяны миний уншсан хуулийн төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

**Хоёр. Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал**

Дараагийн асуудал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцье.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгосон нэр дэвшигчийн тухай танилцуулъя.

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс 2013 оны 04 сарын 19-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон Улсын Их Хурлаас санал болгосноор томилогдон ажиллаж байсан Дүгэржавын Мөнхгэрэлийн бүрэн эрхийн хугацаа 2013 оны 4 сарын 20-ны өдөр дуусгавар болж байгаа тул асуудлыг хуулийг дагуу шийдвэрлэж өгөхийг хүссэн болно.

Үүний дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын болон Хууль зүйн байнгын хорооны 2013 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн санал, дүгнэлт болон албан бичгийг тус тус үндэслэн Дондов овогтой Ганзоригийг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар Улсын Их Хуралд санал болгож захирамж гаргасан болно.

Дондовын Ганзориг нь 1967 онд Улаанбаатар хотод төрсөн 46 настай. Эрэгтэй. Эхнэр, 2 хүүхдийн хамт амьдардаг. Тэрээр 1985 онд нийслэлийн 1 дүгээр дунд сургууль, 1990 онд ОХУ-ын Ивановын их сургуулийг тус тус суралцаж төгссөн. Эрх зүйч мэргэжилтэй.

Ажилласан байдал нь 1991-1992 онд Шинжлэх ухааны академийн Төр эрх зүйн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан. 1992 оны 2-оос 8 сард Улсын Бага Хурлын дэргэдэх төр, нийгэм судлалын академид эрдэм шинжилгээний ажилтан, 1992-1994 онд Улсын Их Хурлын Тамгын газарт Байнгын хорооны туслах, хуулийн зөвлөх, 1994-2012 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд багш, 2011-2012 онд Жи Жи Партнес ХХК-ийн захирлаар тус тус ажиллаж байсан бөгөөд одоо Улсын Их Хурлын даргын Хууль зүйн бодлогын асуудал эрхэлсэн зөвлөхөөр ажиллаж байна.

Д.Ганзориг нь хууль эрх зүйн салбарт тасралтгүй 20 гаруй жил ажиллаж байгаа. Ажлын туршлагатай. Хууль зүйн шинжлэх ухааныг онолын болон практикийн түвшинд эзэмшсэн. Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн чиглэлээр мэрэгшсэн манай чадварлаг хуульчдын нэгт бол Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилогдон ажиллах нөхцөл шаардлагыг бүрэн хангасан хүн гэж үзэж байна.

Иймд Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхнийг Үндсэн хуулийн цэцийн

гишүүнээр томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон. Дондовын Ганзоригийг хэлэлцэн дэмжиж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунбаатар танилцуулна. Ш.Түвдэндорж гишүүн танилцуулна. Индэрт урьж байна.

**Ш.Түвдэндорж:** - Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусч байгаатай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах нэр дэвшигчийн талаарх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2013 оны 04 сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч Дондовын Ганзориг нь 1967 онд Улаанбаатар хотод төрсөн. Эрх зүйч мэргэжилтэй. Нэр дэвшигч Д.Ганзориг нь хууль зүй, улс төрийн өндөр мэрэгшилтэй, мэдлэг боловсрол, ажлын туршлагаараа Монгол Улсын Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд заасан болзол, шаардлагыг хангасан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу Байнгын хороо дээрх асуудлыг хэлэлцэн санал хураалт явуулж Д.Ганзоригийг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах тухай саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тул Д.Мөнхгэрэлийг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай асуудлаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**3.Энхболд:** - Ш.Түвдэндорж гишүүнд баярлалаа. Танилцуулга, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Ч.Дашням Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга, Д.Ганзориг Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч нар танхимд ирсэн байна.

За дахиад шинээр нэр авъя. Асуулттай гишүүд. Гарахгүй байна уу. С.Одсүрэн дээшээ хэлдээ юу болчихов. За Ө.Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Н.Батцэрэг гишүүн асууя.

**Н.Батцэрэг:** - Баярлалаа. Өчигдөр би бас Байнгын хороон дээр товчхон асууж байсан юм. Д.Ганзориг нэр дэвшигчид баяр хүргэж, амжилт хүсэж байгаа. Төрийн хариуцлагатай албанд томилогдохоор сууж байгаад. Асуух гэж байгаа зүйл бол энэ Үндсэн хуулийн өөрчлөлт, эсвэл Үндсэн хуулийн нэмэлт гэсэн, Үндсэн хуулиндаа нэмэлт хийе гэсэн юм яригдаад байдаг л даа. Өнгөрсөн намар ч гэсэн орон нутгийн сонгуулийн өмнө жишээлэх юм бол сумын Засаг даргыг дээд шатны Засаг дарга шууд томилдог биш, орон нутгийн иргэд нууц санал хураалтаараа сонгууль явуулж гаргаж ирдэг байхаар зохион байгуулбал ямар вэ? Энэ чиглэлээр Үндсэн хуулийн нэмэлт хийгээд зарим гишүүд санаачлаад явж байсан.

Өчигдөр Байнгын хороон дээр танаас асууж байхад Үндсэн хуулиа өөрчлөх тухай бол асуулт асуулт асуудал байхгүй байх. Харин нэмэлтийн тухайд бол одоо байж болох юм гэж байсан. Та бол Үндсэн хуулийн судалгаа хийдэг мэргэжлийн хүний хувьд бол нэмэлт хийвэл яг аль бүлэг заалт, аль хүрээнд манай Үндсэн хуулийн нэмэлт байвал зүйтэй гэж боддог вэ гэсэн ийм асуулт байна.

За тэгээд үг хэлэхгүйгээр дараа нь хоёр санал хэлчихэд. Ер нь сүүлийн үед Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг бас жаахан улс төржиж томилоод байгаа нь үнэхээр харагддаг. Тэгээд дээрээс нь ч Үндсэн хуулийн цэцийн зарим шийдвэрүүдийг улс төрийн захиалгатай гарлаа гэсэн ийм буруутгах байдал нийгэмд бас байж л байдаг. Энэ удаа бол харин одоо мэргэжлийн хүн оруулж ирж байна. Ямар нэгэн улс төрийн шууд намын харъяалал, улс төржсөн байдалгүй ийм хүн томилогдож байна уу даа. Энэ их сайшаалтай зүйл юм болов уу ийм бодолтой байна.

**З.Энхболд:** - Нэр дэвшигч Д.Ганзориг Н.Батцэрэг гишүүний асуултад хариулъя.

**Д.Ганзориг:** - За баярлалаа. Тэгэхээр Үндсэн хууль судлаачийн хувьд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал дээр ихээхэн болгоомжтой хандах ёстой гэж ингэж бодож байгаа юм. Болгоомжтой гэдэг нь ямар утгаар вэ гэхээр нэлээн тооцоо судалгаатай, үндэслэлтэй, одоо байгаа Үндсэн хуулийн суурь зарчмыг хадгалалах байдлаар ийм нэмэлтийг хийх ёстой гэж ингэж үзэж байгаа юм.

Тухайлбал сая Н.Батцэрэг гишүүн асууж байна. Үндсэн хуулийн аль хэсэг өөрчлөлт, одоо нэмэлт оруулбал зүгээр вэ гэдэг ийм асуудал дээр тухайлах юм бол Үндсэн хуулийн 4 дүгээр бүлэг буюу нутаг дэвсгэрийн удирдлагын тухай

асуудал дээр ялангуяа засаг захиргааны хуваарыг тогтоох асуудал, хот тосгон эрх зүйн байдлын асуудал гээд гэх мэтчилэн ийм зүйлүүд дээр нэмэлт хийх боломжтой юмаа гэж ингэж бодож байгаа.

**3.Энхболд:** - Ө.Энхтүвшин гишүүн асууя.

**Ө.Энхтүвшин:** - За би нэг асуулт асууя. Энэ хүн маань Үндсэн хуулийн эрх зүйгээр судалгаа хийдэг ийм хүн юм байна. Сүүлийн үед Үндсэн хуулийн цэц дээр иргэдээс өргөдөл өгдөг. Үндсэн хуулийг зөрчсөн байна гээд ингээд өгдөг. Үндсэн хуулийн цэц маань түүнийгээ хянаж үзээд за энийг зүйтэй байна. Энийг хурлаараа ярья. Хэлэлцье гээд ингээд хурлынхаа товыг зарладаг. Гэтэл нөгөө зөрчсөн гэж одоо түүнд холбогдоод байгаа хүн маань урд өдөр нь шийдвэрээ хүчингүй болгочихдог. Гэтэл тэр шийдвэрийн үр дагавар маш их байдаг. Их олон сар болсон. Энэнээсээ болоод үр дагавар их үүссэн байдаг. Тэгээд шийдвэрээ хүчингүй болгохоор Үндсэн хуулийн цэц нь за одоо ярих юм байхгүй болчихлоо гээд ингээд татгалздаг энэ нэг ийм практик сүүлийн үед нэлээн хавтгайрах шинжтэй болж байна л даа. Энэ дээр ер нь та Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилогдох гэж байгаа хүний хувьд яг юу гэж үзэж байгаа вэ? Яаж харж байгаа вэ гэдгийг сонирхох гэсэн юм.

Зарим хүн бол энийг ингэж зүйрлээд байна шүү дээ. Хүний мал юм уу, эд хөрөнгийг хулгайлчихаад баригдахдаа юм уу, шүүх хурал нь болохын өмнө нөгөө хулгайлсан зүйлээ буцааж өгөөд одоо хулгайн хэрэг байхгүй болчихлоо гээд ингэдэг. Тэгэхээр нь шүүх хурал нь за тийм байна. Одоо тэгэхээр хулгайн хэрэг бол байхгүй учраас шүүх таслах ажиллагаа байхгүй гээд ингээд зогсож байгаатай адил нэг байна гээд ингэж тайлбарлаж байна шүү дээ. Тэгэхээр энийг та ер нь юу гэж үзэж байна вэ? Энэ талаар та өөрийнхөө саналыг хэлээч.

**3.Энхболд:** - Д.Ганзориг нэр дэвшигч Ө.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

**Д.Ганзориг:** - Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд хянан шийдвэрлэх тухай хуулиудыг боловсронгуй болгох, шинэчлэх шаардлага зайлшгүй байгаа. Тэгэхээр энэ хүрээнд сая Ө.Энхтүвшин гишүүний тавьсан асуудалд нэгдүгээрт хариу өгөх байх гэж ингэж бодож байна.

Яг тухайлсан хэрэг маргаан дээр одоо маргаж байгаа зүйл нь өөрөө тухайн хурал болохоос өмнө хүчин төгөлдөр юм уу, эсвэл хүчингүй болсон тохиолдолд Үндсэн хуулийн цэц бол өөрөө ямар нэг байдлаар одоо тухайн маргаж байгаа зүйлд, ялангуяа энд шийдвэр байдаг. Энэ зүйлд хууль зүйн талаас нь дүгнэлт өгөх нь өөрөө их төвөгтэй л дээ. Нөгөө талаасаа бол гомдол гаргагч иргэн хэдийгээр одоо маргаж байгаа зүйл нь хүчин төгөлдөр, эсвэл хүчингүй болсон ч гэсэн түүний үр дагаварыг арилгуулахаар одоо ямар нэг байдлаар хандах боломж нь нээлттэй байгаа гэж ингэж хууль зүйн талаас нь харж байгаа.

**3.Энхболд:** - Гишүүд асуулт тавьж хариулт авлаа. Үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү.

За би хаагаагүй байгаа. С.Бямбацогт, Д.Лүндээжанцан гишүүнээр тасалъя. Н.Энхболд гишүүн үг хэлнэ.

**Н.Энхболд:** - Би саяны хариултаас нэг зүйл ойлголоо. Хууль бусаар шийдвэр гарсныг үргэлжлээд, тэрнээс улбаалаад гарсан хууль бус шийдвэрүүд бол үндсэндээ хүчингүй болно гэж хэллээ гэж ойлголоо. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшиж байгаа. Би сонгогдох болов уу гэж бодож байна. Энэ хүний амнаас ийм үг гарлаа. Тэгэхээр энэ бол бид нарын ойрд, сүүлийн үед яриад байгаа Ерөнхий сайдын хууль зөрчсөнтэй холбоотой, хууль бус шийдвэр гаргаж тэр нь араасаа олон хууль бус бус шийдвэр дагуулж, тэр олон хууль бус шийдвэрүүд нь улс орон даяар маш олон хүний ажил амьдралтай холбоотой уршиг дагавар авчирсан ийм үйлдэл болсон. Тэр шийдвэр бол хүчин төгөлдөр бус гэж хуульчийн хувьд үзэж байгаа гэж ойлголоо. Энэ дагуу Засгийн газар холбогдох арга хэмжээ авах байх гэж бодож байна.

**3.Энхболд:** - Ц.Нямдорж гишүүн үг хэлнэ.

**Ц.Нямдорж:** - За баярлалаа. Манайх бол эх газрын системтэй Үндсэн хуультай орон л доо. Тэгээд аливаа үйлдэл хийгдээд дууссан бол төгссөн гэж үздэг ийм номтой. Жишээ нь, Ерөнхий сайд Үндсэн хууль зөрчөөд захирамж гаргачихсан бол үйлдэл нь тэр захирамж гаргасан цаг хугацаагаар дуусдаг. Дараа нь тэр нь хүчинтэй ч байсан, хүчингүй ч байсан Үндсэн хуулийн цэц дүгнэлтээ гаргаж байх ёстой ийм л системтэй орон шүү дээ.

Тийм учраас Д.Ганзоригт захиж хэлэх юм бол энэ улс төрийн үүрэг гүйцэтгэдэг явдлыг таслан зогсооход хувь нэмэр оруулаарай. Энэ олсон мэргэжилдээ, эзэмшсэн мэргэжилдээ үнэнч байгаарай. Улс төрийнхний гар хөл битгий болоорой. Үндсэн хууль зөрчсөн бол хэн ч байсан зөрчсөн гэдэг дүгнэлтээ гаргаж байгаарай. Мэргэжлээ битгий хулгайлуулаарай. Мэргэжлээ битгий хулгайлаарай гэж захих байна.

Энэ сүүлийн үед улс төрчдийн хулгай хийдэг арга их нарийн болсон шүү дээ. Нэг олсны үзүүрт үхэр уячихаад баригдахгүй бол чангаагаад татсаар байгаад өөр дээрээ авчраад наачихдаг. Яг баригдахдаа хүрээд ирэхээр олсоо тасалчихдаг. Ийм арганд шилжээд удаж байна шүү дээ. Нэг тасардаггүй бохь байдаг шүү дээ. Татаад л байдаг, сунаад байдаг. Тэгээд тасардаггүй. Яг ийм аргаар хууль хулгайлдаг болж байгаа юм. Удаж байгаа юм энэ үйлдэл. Энд цэц шийдвэртэй цохилт өгөхгүй байгаа юм.

Цэц энэ Үндсэн хуулийн манаачийнхаа үүргийг гүйцэтгэж, Үндсэн хуулинд үнэнч байж, энэ Үндсэн хуулийг сахин хамгаалах үндсэн үүргээ чин шударгаар гүйцэтгэхгүй бол энэ Монгол төрийн чинь Үндсэн хууль нураад дууслаа шүү дээ. Нураагаад дууслаа шүү дээ. Бурхан багшид итгэдэг нь байхгүй болсон. Олон шашинтай болчихсон. Нөгөө коммунизмд итгэдэг нь байхгүй болчихсон. Зах зээлд шилжчихсэн. Энийг далимдуулаад баахан хулгайч энэ улс төрд шургалчихсан. Хууль хулгайлдаг, зарчим хулгайлдаг, ёс зүй хулгайлдаг, төрийн ажил хэрэг хулгайлдаг, Үндсэн хуулийг хулгайлдаг ийм хулгайчийн систем



Монголд амь бөхтэй тогтож байхад Үндсэн хуулийн цэц тэнд мануухай юм шиг суугаад үүргээ гүйцэтгэхгүй байгаа шүү дээ.

Тэр Н.Алтанхуяг захирамжаа хүчингүй болгосон байна уу, хүчинтэй байна уу, тэр Үндсэн хуулийн цэцэд пад байхгүй. Шийдвэр гарсан, зөрчсөн. Үндсэн хуулийг зөрчсөн байна гэдэг дүгнэлтээ л гаргаж байх үүрэгтэй байгууллага, танайх. Цаашдаа Үндсэн хуулийн цэц иймэрхүү байдлаар байгаад байх юм бол Зайсангийн аман дахь тэр орд харшийг нь өөр газарт өгөөд энэ цэцийг татан буулгах хэрэгтэй. Захиалгат шийдвэр гаргадаг. Захиалгатай шийдвэр гаргадаггүй ийм байгууллага болж хувирчихаад байгаа юм аа, Д.Ганзориг нэр дэвшигчээ.

Өөрөө залуу хүн байна. Бид нар мөнх биш. Хэзээ нэгэн цагт энэ улс төрөөс явна. Хэзээ нэгэн цагт ертөнцийн мөнх бусыг үзнэ. Энэ эх орон бид нарын үр хүүхэд, хойч үе Үндсэн хууль чинь мөнх шүү. Би тэгэхээр эцэст нь хэлэх гэсэн юм бол мөнх бус юмны төлөө биш мөнх юмны төлөө зүтгэх сэтгэлийн эр зориг гаргаарай. Үндсэн хууль зөрчсөн бол тэр Ардын нам байна уу, Ардчилсан нам байна уу, МАХН байна уу, ИЗН байна уу пад байхгүй. Зөрчсөн гэдэг шийдвэрээ гаргаж сураарай та нар. Гаргахгүй байгаа шүү. Сүүлийн үеийн хэрэг явдлыг хараад байхад илэрхий зөрчсөн юм нь дээр очоод л урд өдөр нь баахан хэлэлцээр хийж гүйж гүйж байгаад маргааш нь нэг нь захирамжаа хүчингүй болгодог. Нөгөөдөх нь дүгнэлт гаргахаасаа татгалздаг ийм ёс бус ёстой муу ёрын жишиг Монголд тогтож байгаа юм. Тийм учраас би энэ хүнд юу захих гээд байна вэ гэвэл энэ аль нэг намын манаач биш Үндсэн хуулийн манаач гэдэг үүргээ битгий мартаарай гэдгийг л захих гэсэн юм.

**3.Энхболд:** - Р.Гончигдорж гишүүн үг хэлнэ.

**Р.Гончигдорж:** - За баярлалаа. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар нэр дэвшиж байгаа Д.Ганзоригийг дэмжиж байна.

Үндсэн хуулийн цэцэд алдаа оноонууд байгаа байх. Тэрийг бид шүүх гээд оролдохоор зэрэг л харин нөгөө нөлөөлдөг, захиалдаг тэр юм нь болчих болов уу гэж болгоомжлоод, бас тэгж зарим улсуудын шүүмжилж байгааг шүүмжилж чаддаггүй юм. Яагаад гэвэл би хэзээ ч захиалга өгч байгаагүй, юу гэдэг юм дарамталж байгаагүй, тэгээрэй ингээрэй гэж байгаагүй. Харин зүгээр цэцийн хуралдаан дээр Улсын Их Хурлаас баталсан хуулиудыг Үндсэн хууль зөрчлөө гэдэг асуудал дээр Их Хурлаа төлөөлж орж байсныхаа хувьд бол энэ нэг захиалгатай байгаа байх гэдэг тэр агуулгаар хуралдаан дээр хандаж байгаагүй юм. Харин ганцхан зүйл дээр сонгуулийн холимог системийг Үндсэн хууль зөрчлөө гээд 28-ын жагсаалтыг заавал тусгаарлаж параллель болгох ёстой гэсэн тэр асуудлыг ярихад санаандгүй нэг цэцийн хурал дээр энэ ямар улсуудын захиалга вэ гэж хэлчихээд тэгээд хэлсэн үгээ нэгэнт барьж болохгүй юм чинь жаахан тэвдэж байсан явдал миний хувьд бий л дээ.

Би зүгээр уг нь үг хэлье гэж бодоогүй юм. Тэгээд Ө.Энхтүвшин дарга түрүүн асуултаараа яриад ингээд нэг Ерөнхий сайд нэг гаргасан шийдвэрийг Үндсэн хуулийн цэцэд өгчихсөн. Ерөнхий сайд тэрийгээ хүчингүй болгочихсон. Хүчингүй болсон учраас Үндсэн хуулийн цэц үүсгэсэн хэрэг маргаанаа

зогсоогоод асуудлыг хэлэлцээгүй ингээд тойроод л одоо ер нь энэ хаваржин ярьж байна уу даа. Бараг өнөөдөр ярилцах бүх асуудал дээр энэ яригдах юм болов уу даа. Би Байнгын хорооны хоёр ч хурал дээр ярьсан. Төрийн байгуулалт, Хууль зүйн байнгын хорооны хурал дээр.

Ер нь бол Үндсэн хуулийн цэцийг шийдвэр гаргаагүй байхад Үндсэн хууль зөрчсөн, Үндсэн хууль зөрчсөн гэж цэц шийдвэр гаргах гэж байгаа юм гэж хэлээд байгаа улсуудыг би гайхаад байгаа юм. Урьдчилж гарах дүгнэлтийг нь мэдчихсэн. Тийм ээ. Энэ чинь нөгөө нэг захиалга гэдэг үг энэнээс л болдог юм болов уу, Үндсэн хууль ингэж дүгнэлтээ гаргах байсан юм уу, гаргах гэж байсан юм. Тэгээд асуудлыг татчихлаа гэж. Тийм учраас энэ л байдлаас бас болгоомжлоорой. Үнэн хэрэг дээрээ иймэрхүү байдлууд, таамаглалууд гэдэг маань бас нээрээ үнэхээр цаанаа захиалга байдаг юм биш байгаа гэж би бас болгоомжилж бодоод эхлээд байгаа юм л даа.

Гэтэл би өөрөөр бодож байгаа юм. Ерөнхий сайдыг Үндсэн хуулийг зөрчсөн гээд тэр нэг Засаг дарга нарын томилгооны тухай асуудлууд, нэг орлон гүйцэтгэгчийг томилсон тухай асуудлуудыг яриад Үндсэн хуулийн цэцэд өгч байгаа юм л даа. Уг нь энэ асуудал маань захиргааны хэрэг, захиргааны маргаан, захиргааны шүүх энэ асуудлыг шийдэж, Үндсэн хуулийг захиргааны шүүхийг орлодог шүүх болгож болохгүй л учиртай юм. Тэр миний хувьд ийм асуудал үүсэх юм бол Үндсэн хуулийн цэцийг ийм байдалд оруулахгүйн тулд Үндсэн хууль дээр тэр асуудлыг хэлэлцүүлэхгүйн тулд тэр шийдвэр маань зөв ч байсан, буруу ч байсан тэрнийгээ хүчингүй болгочихоод бас Үндсэн хуулийг, Үндсэн хуулийн цэцээ хүндэтгэж болохоор хандах ийм ухаан бол бас манай төрийн байгууллагуудад, төрийн өндөр албан тушаалтнуудад байх хэрэгтэй юм л даа. Би тэр талаас нь харж байгаа юм бас. Яагаад гэвэл шийдэл нь юу гэж гарахыг нь мэдэхгүй. Гэхдээ Үндсэн хуулийн цэц захиргааны хэргийн шинжтэй энэ асуудал дээр захиргааны шүүгчийг оролсон ийм байж болохгүй л дээ.

Тэгэхээр Үндсэн хуулийн цэц бол яг Үндсэн хуулийнхаа маргааныг хэлэлцдэг тэр агуулга дээрээ байхгүй бол шүүхүүд дээр хэлэлцэгдэх олон асуудлуудыг Үндсэн хуулийн хэлэлцэх маргаан байна гэж өөр дээр хэрэг үүсгээд тэгээд тэрийг одоо хянадаг болох юм бол энэ маань харин манай Үндсэн хуулийн цэцийн Үндсэн хуульд ногдсон үүргээсээ хазайсан буюу эрхээ хэтрүүлсэн байдал уруу орж болзошгүй гэж би боддог юм. Тийм учраас Үндсэн хуулийн цэц дээр хэрэг маргаан үүсгэхдээ энэ бусад шүүхүүдийн харъяаллын асуудал мөн үү, үгүй юу энэ маргаан гэдгийг хамгийн түрүүнд авч үзээд тэгээд биш гэдэг тохиолдолд за тэгвэл бид энэ дээр үүсгэх хэрэг үү, үгүй юу гэдэг хоёрдугаар алхам дээрээ үүсээд ингээд нэг хэрэг маргаанаа үүсгэдэг байвал их зөв байж магадгүй гэж боддог юм. Яагаад гэвэл би энийг одоо захиргааны шүүхээр өндөр хэмжээнд мэрэгшсэн хүний хувьд, онолчийнх нь хувьд, багшийнх нь хувьд бол энийг харин их анхаарч байгаарай гэж ингэж хэлмээр бодогдож байгаа юм. Энийгээ би Д.Ганзоригт хэлж байна. Ингээд танд амжилт хүсье. Баярлалаа.

**3.Энхболд:** - Д.Лүндээжанцан гишүүн үг хэлнэ.

**Д.Лүндээжанцан:** - Өчигдөр Хууль зүйн байнгын хороон дээр яг ийм асуудлаар бид асуулт тавиад мөн л одоо хэд дэх удаагаа нот өглөө гэдэг шиг Р.Гончигдорж гишүүн бид хоёр хоёр талаасаа мэтгэлцээд л. Ингээд өнөөдөр бас л энэ хурлын танхимд энэ юм үргэлжилж байна л даа.

Тэгэхээр Р.Гончигдорж гишүүн бол ингээд байна шүү дээ. Тэгэхээр Р.Гончигдорж гишүүн та бол ингээд байна шүү дээ. Урьд нь та нар захиалчихсан мэдэж байсан юм уу гэсэн сэтгэл төрөхөөр байна гэж. Тэгэхээр Үндсэн хуулийн цэц яг ийм асуудлаар бас өмнө нь зөрчсөн гэсэн дүгнэлт, шийдвэр гаргачихсан байсан байна.

Хоёрдугаарт, Ерөнхий сайд чинь өөрөө захирамжаа хүчингүй болгосон байна. Энэ чинь өөрөө нотлоод байгаа байхгүй юу. Тэрнээс биш энийг бол одоо логикоороо бол ойлгоно. Харин шүүхийн харъяалал уу, цэцийн харъяалал уу гээд ингээд яриад цаашдаа энэ маргаан өрнөх асуудал бол би байх асуудал гэж бодоод байгаа юм. Энэ Д.Ганзориг зөвлөх бол одоо энэ чиглэлийн бас манай гол мэргэжилтний нэг. Энэ асуудал дээр цөмөөрөө бас хэдийгээр Үндсэн хуулийн цэцийн гишүүн болохоор одоо шууд хууль тогтоох үйл ажиллагаанд оролцохгүй байлаа ч гэсэн Үндсэн хуулийг хэрэглэх явцдаа тодорхой зүйлүүдээр санал бодлоо илэрхийлэх эрх нь нээлттэй байгаа учраас санаа авах болов уу гэж өчигдөр би нэлээн хэдэн зүйл дээр, гурван гол зүйл дээр гол болгож ярьсан.

Ер нь цаашдаа Үндсэн хуулийн цэц, Их Хурлын харилцааны асуудал, Үндсэн хуулийн цэц, Ерөнхийлөгч болоод Засгийн газар, гүйцэтгэх эрх мэдлийн харилцааны асуудал, Үндсэн хуулийн цэц болоод шүүх эрх мэдэл, Дээд шүүхийн харилцааны асуудлын нарийвчлах шаардлага бол байна. Ерөөсөө гараад байна. Гурав гурван хүн илгээдэг гэдгээр нь, тэгээд 9 хүний бүрэлдүүлдэг гэдгээр нь энэ харилцааг одоо зохион байгуулалтын талаас нь журамласнаар хязгаарлаж болохгүй байгаа нь харагдлаа.

Тэр манай хууль тогтоох байгууллага, бусад байгууллагаас гарсан хууль зөрчсөн шийдвэр Үндсэн хуулийн цэцийн харъяалах маргааны 7 асуудал дотроо яаж эрэмбэлэгдэх вэ, яаж зохицуулагдах вэ гэдгийг нь бол боловсронгуй болгох шаардлага байсаар байна. Өчигдрийн Хууль зүйн байнгын хороон дээр ярьсан хүмүүс ерөөсөө Үндсэн хуулийн цэцийг баалахад чиглэсэн. Тэгэхээр бид Үндсэн хуулийн цэц бол ёстой жинхэнэ мэрэгшсэн, өндөр мэргэжлийн онол арга зүйтэй, юмыг олон талаас нь харж, өргөн цар хүрээнд нь харж чаддаг, тэгж юмаа шийдвэрээ гаргадаг байх ёстой. Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гарлаа бол бандан тас гэдэг шиг бид тэр дээр ярих юм байх ёсгүй. Гарахын тулд маш их өндөр хариуцлагатай эрх эдэлж байгаа учраас мөн өндөр хариуцлагатай үүрэг хүлээх ёстой гэдгийг гол нь анхаарах шаардлагатай байна. Үндсэн хуулийн цэцийн гишүүд онол арга зүйн өндөр түвшинд, тэр логик тайлбар, нийгэм, улс төрийн тайлбар, хэл зүйн тайлбар, системчилсэн тайлбар, үүрэгчилсэн тайлбар гэдэг энэ онол арга зүйг бол дээд хэмжээнд эзэмшиж, эрх зүйн соёл, харьцуулсан эрх зүйгээр цэнэглэгдэх ёстой байна. Энэ талаас нь одоо бид ярьж Д.Ганзоригийг орж ирэхэд нэг ярьж болно. Цэцийн гишүүн болсных нь дараа цэцийн асуудалд хөндлөнгөөс нь оролцоод байх боломж муутай болох учраас

ярьж авч байгаа юм гэдгийг хэлье.

Би өчигдөр хэлсэн үгээ давтан хэлэхийг хүсэж байна. Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн өмнөөс гэж гаргадаг. Монгол Улсын Үндсэн хуулийн өмнөөс. Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа байдаг. Үндсэн хуулийн манаач байдаг. Г.Совд багшийн хэлсэн үгийг өчигдөр би Хууль зүйн байнгын хорооны хурал дээр хэлсэн. Шүүхгүй Үндсэн хууль бол шүдгүй арслантай адил гэж. Хамгаалагч шүүх байхгүй бол юу байх юм бэ. Тийм учраас Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн шүүх юм. Шүүх гэж ойлгож шийдвэр нь эцсийн байдаг. Нэг удаа дүгнэлт нь орж ирээд тэгээд дараа нь эцэслэдэг учраас маш том хариуцлагатай ажил үйлсийг улс орны өмнө авч явж байгаа юм.

Ийм учраас бид Үндсэн хуулийн шүүхийн энэ цэцийн асуудал онцгой анхаарал тавих шаардлага байгаа гэж. Тэгээд би түрүүний Ц.Нямдорж гишүүний хэлснийг давтан хэлэхийг хүссэн. Өчигдөр бас хэлсэн. Уучлаарай, З.Энхболд дарга аа, таны нэрийг бариад хэлсэн явдал шууд илэн далангүй хэлчихье. Илгээсэн болон томилсон байгууллагынхаа захиалгаар ажилладаг Д.Ганзориг гэдэг хүн битгий байгаасай гэж. Тэрийг бол одоо бид анхааруулж хэлж байгаагаа давтан хэлье. Ингээд таны ажилд амжилт хүсье.

**З.Энхболд:** - Одоо санал хураалт явуулъя. Дондовын Ганзоригийг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

65 гишүүн оролцож, 58 гишүүн зөвшөөрч, 89.2 хувийн саналаар Дондовын Ганзоригийг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох санал дэмжигдэж байна. Үүгээр Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанаар тооцогдоно.

Уг тогтоолыг уншиж өгье. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай. Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын Их Хурлын санал болгосноор Дондовын Ганзоригийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай. Өнөөдрөөр үү. Тийм ээ. Энэ тогтоолыг 2013 оны 04 сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Үүгээр хуулийн дагуу бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Дүгэржавын Мөнхгэрэлийг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

Оролцсон 66, зөвшөөрсөн 57, 86.4 хувийн саналаар Дүгэржавын Мөнхгэрэлийг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх санал дэмжигдэж байна.

Санал дэмжигдсэн тул Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанаар тооцогдоно. Тогтоолыг уншиж өгье.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай. Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Дүгэржавын Мөнхгэрэлийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

Хоёр. Энэ тогтоолыг 2013 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

За одоо саяны миний уншсан томилох болон чөлөөлөх тухай хоёр тогтоол дээр эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу. Саналтай гишүүд алга байна. Эцсийн найруулгыг сонссоноор тооцлоо.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилогдсон Д.Ганзориг багшид баяр хүргээд, ажлын амжилт хүсээд өөрийн чинь томилох явцад гишүүдийн хэлсэн үг, Байнгын хороон дээр болон чуулганы нэгдсэн хуралдаан дээр хэлсэн үгнүүдийг ажилдаа тооцож ажиллах, Үндсэн хуулийн цэцийг цаашид улам сайжруулахад хувь нэмрээ оруулахыг ерөөгөөд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

### ***Гурав. Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогтын ёс зүйн зөрчлийн тухай***

Гурав дахь асуудал. Одоо Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогтын ёс зүйн зөрчлийн тухай Ёс зүйн дэд хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцье. Ёс зүйн дэд хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүйн дэд хорооны дарга М.Батчимэг танилцуулна. М.Батчимэг гишүүнийг урьж байна.

**М.Батчимэг:** - Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Батцогт, Н.Батцэрэг, Х.Болорчулуун, С.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Н.Сономпил, Г.Уянга нар 2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Улсын Их Хурлын дарга З.Энхболдод албан бичиг илгээж Улсын Их Хурлын дэд дарга С.Баярцогтын гадаадад байгуулсан компани болон банкин дахь дансны мэдээллээ хөрөнгө орлогын мэдүүлэгтээ тусгаагүй асуудлыг Ёс зүйн дэд хороогоор хэлэлцүүлэх шаардлага тавьсныг Улсын Их Хурлын даргаас Ёс зүйн дэд хороонд шилжүүлсэн болно.

Ёс зүйн дэд хороо дүрмийнхээ 8.1.1 дэх заалтыг үндэслэн 2013 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр хуралдаж Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогтод холбогдох асуудлыг авч хэлэлцлээ.

Ёс зүйн дэд хорооноос Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.12 дахь хэсэг, Ёс зүйн дэд хорооны дүрмийн 4.1.6 дахь заалтыг

үндэслэн дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж байна.

Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт нь Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 4.1 дэх заалтыг зөрчсөн нь ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл мөн болох тул түүнд хариуцлага хүлээлгэх асуудлыг Ёс зүйн дэд хорооны дүрмийн 9.1.3 дахь заалтын дагуу Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлэх нь зүйтэй гэж Ёс зүйн дэд хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи нь үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогтын асуудлаар Ёс зүйн дэд хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**3.Энхболд:** - Дэд хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Г.Уянга гишүүнээр, Ө.Энхтүвшин гишүүнээр асуулт тасаллаа. За Ц.Нямдорж гишүүнийг нэмээд асуулт тасаллаа. С.Бямбацогт гишүүн асууя.

**С.Бямбацогт:** - За баярлалаа. Ёс зүйн дэд хорооноос асууя. Энэ ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл мөн болох тул түүнд хариуцлага хүлээлгэх асуудлыг Ёс зүйн дэд хорооны дүрмийн 9.1.3 дахь заалтын дагуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж шийдүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна л даа.

Тэгэхээр ёс зүйн дүрмийн 9 дүгээр зүйл дээр 9.1.1-д нь сануулга өгөх, 9.1.2-т нь шаардлагатай тохиолдолд гишүүний ёс зүйн зөрчлийн асуудлыг холбогдох байгууллагад шалгуулахаар шилжүүлэх, 9.1.3-т нь тухайн гишүүний ёс зүйн зөрчлийн асуудлыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх, 9.1.4-т нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хариуцлага ногдуулах, санал гаргах гэсэн ийм 4 хариуцлага ногдуулах заалт байна л даа. Түүний одоо 3 дахь заалтаар нь хариуцлага ногдуулъя гэж Ёс зүйн дэд хороо үзэж байгаа юм байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх маань одоо ямар хэмжээний хариуцлага вэ? Хэлэлцүүлнэ гэж байна. Тийм ээ. Хэлэлцүүлээд ямар шийдвэр гарах ёстой вэ эндээс. Одоо бид нар яг ямар гэсэн, юу гэсэн шийдвэр гаргах ёстой. Ойлгохгүй байна л даа. Хэлэлцүүлж байгаа нь өөрөө ингээд эндээс харах юм бол нэлээн хүнд шийтгэл юм шиг байна. Хариуцлага юм шиг байна. 9.1.4 дэхийг би бас ойлгохгүй байгаа юм бас. Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу гэхээр тэнд бас л нөгөө сануулах, чуулганы хуралдаанаас гаргах, үг хэлэх эрхийг нь бас хаах гэсэн нэг хариуцлагууд байгаад байгаа л даа. Тэгэхээр хамгийн хүнд хариуцлага энэ харагдаад байх шиг байгаа юм. Энэ ойлгож байгаа зөв үү, буруу юу? Эндээс бид ямар шийдвэр гарах ёстой. Энийг нэг хариулж өгөөчээ.

9.2-т нь хариуцлагын төрлийг давхардуулан ногдуулахгүй гэсэн байгаа. 9.2-т. Тэгэхээр С.Баярцогт гишүүн маань өөрөө Улсын Их Хурлын дэд даргаас чөлөөлөгдөх өргөдлөө өгсөн байгаа. Улсын Их Хурлын дэд даргаас чөлөөлөгдөж байна гэдэг маань дахиад одоо хариуцлага ногдуулах асуудал үүсвэл давхардаж байгаа гэж үзэх үү, үзэхгүй юу? Өөрөөр ёс зүйн асуудлаараа Улсын Их Хурлын дэд даргаас чөлөөлөгдөх өргөдлөө өгчихсөн. Дээрээс нь дахиад чуулганы хуралдаанаар хэлэлцүүлээд хариуцлага ногдуулж байна гэдэг чинь давхардаж байгаа юм биш үү. Энийг бас нэг хариуж өгөөч.

**3.Энхболд:** - М.Батчимэг гишүүн асуултад хариулъя.

**М.Батчимэг:** - С.Бямбацогт гишүүний асуултад хариулъя. Та сая ёс зүйн дүрмийн дагуу ёс зүйн дүрэм зөрчсөн гишүүдэд хүлээлгэх хариуцлагыг яг нэг бүрчлэн уншлаа. Тэгэхээр ерөнхийд нь ингээд энэ 4 хариуцлагын төрөл байгаа. Тийм ээ. Аваад үзэх юм бол нэг дэх энэ сануулах гэдэг бол үндсэндээ Ёс зүйн дэд хороо өөрсдийнхөө дэд хорооныхоо дотоодод яриад шийдчих асуудал юм гэж үзэж байгаа асуудал дээр сануулга өгөх хариуцлага байлгах боломжтой байгаа. Бусад 3 нь бол дэд хорооны төвшнөөс энэ бол бас хальсан түвшний хариуцлага ярих шаардлагатай байна гэж үзээд бусад байгууллагуудад шилжүүлэх ийм заалтууд байгаа шүү дээ.

За үндсэндээ бол дэд хороо ярилцаад та тэр 9.1.4 дээр сая асууж байна л даа. Дэгийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх нь хамгийн хүнд хариуцлага юм биш үү гэж. Тэгэхээр энэ 4 дэх заалт бол яг Их Хурлын хуралдааны чуулганы үеэр дэг зөрчсөн гишүүдэд илүү хамаатай ёс зүйн хариуцлага болж хувирч байгаа юм.

Тэгэхээр С.Баярцогт гишүүний энэ хэлэлцэгдэж байгаа асуудал бол энэ шууд дэгийн хууль зөрчсөн асуудал зөрчсөн асуудал гэж үзэхгүй байгаа. Тэгэхээр 4 дэх заалт бол авч хэлэлцэгдээгүй. Ингээд Ёс зүйн дэд хороо бол хаалттай хуралдсан. Нэлээд ярилцсан. Тэгээд ярьж байгаад гишүүдийн олонхийн саналаар 9.1.3 дахь заалт буюу энэ Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хуралдаанд орж хэлэлцүүлэе. Тэгээд чуулган өөрөө ямар хариуцлага хүлээлгэх шийдвэрээ гаргах нь зүйтэй гэсэн одоо ийм хариуцлагын төрлийг сонгосон гэж.

За тэгээд энэ хариулт бол таны хоёр дахь асуулттай шууд холбогдож байна гэж бодож байна. Та сая асуулаа. Дэд даргаас чөлөөлөгдөх өргөдлөө өгөөд хэлэлцэгдээд явж байхад давхардаж байгаа юм биш үү гэж. Тэгэхээр Ёс зүйн дэд хороо бол энийг давхардаж байна гэж харахгүй байгаа. Яагаад гэвэл Ёс зүйн дэд хорооны санал бол өөрөө дэд даргаас нь чөлөөлье гэдэг юм уу, эсвэл одоо ямар хариуцлага хүлээлгэх тухай тодорхой санал биш. Олгогдсон эрх мэдэл нь ерөөсөө тухайн гишүүний асуудлыг нэгдсэн чуулганд оруулж ирж, нэгдсэн чуулган дээр ёс зүйн асуудлыг гишүүдээр хэлэлцүүлэх л асуудал байгаа юм. Тэгэхээр энийг бол зэрэгцэж явж байгаа арга хэмжээ болохоос, үйл ажиллагаа болохоос биш давхардсан гэж харахгүй байгаа Ёс зүйн дэд хороо.

**3.Энхболд:** - Ц.Даваасүрэн гишүүн асууя.

**Ц.Даваасүрэн:** - Тэгэхээр өмнөх хуралдаан дээр ер нь энэ асуудлыг бас Ёс зүйн дэд хороогоор нягталж байгаад оруулъя гэсэн саналыг би хэлсэн л дээ. Учир нь бол тэр олон улсын сэтгүүл зүйн байгууллага энэ асуудлыг тавихдаа офшор бүсэд компани байгуулж, данс нээж татвараас зайлсхийж, мөнгө угаасан гэсэн асуудлаар энэ улсуудын нэрийг гаргаж дансыг нийтэлсэн. Тийм учраас би энийг нягталж байгаад ярьж гэсэн. Тодорхой асуудал бас тавьсан. Жишээлбэл энэ мөнгө бол одоо татвараас зугтаагүй, мөнгө угаахад холбогдоогүй, Оюу Толгойн лобби мөнгө биш гэдгийг одоо батал гэж. Тэгэхээр Ёс зүйн хороо энэ асуудлыг би анхаарсан байх гэж бодож байна.

Хоёрт би энэ дансны хувьд яагаад жишээлбэл одоо С.Баярцогтын нэр дээр мөртлөө 3 найз гэдэг асуудал ярьсан бэ? Тэгэхээр энэ 3 найзыг бас тодруулаачээ гэсэн юм. Бидний дунд байхгүй, энэ танхимд байхгүй гэдгийг бас нотлоочээ. Ер нь энэ бол өөрт нь ч, алинд нь ч хэрэгтэй. Энэ мөнгө бол цэвэр. Тэгэхдээ алдаа гаргасан нь бол одоо бүртгүүлээгүй гэдэг энэ зүйлээ ингээд явчих юм бол аль аль талдаа бас хардлага төрүүлэхгүй энэ асуудал шийдэгдэх ёстой юм.

Тийм учраас би тэр жишээлбэл бусад байгууллагуудаар энэ асуудлыг шалгуулах шаардлагагүй гэж үзсэн байна л даа дэд хороо. Тэгэхээр дараа нь ямар нэгэн асуудал гарвал, эсвэл та бүхэн үнэхээрийн одоо тийм итгэл үнэмшилтэй нягталж үзсэн юм уу? Тэгж үзээд энэ бол одоо мөнгө угаагаагүй юм байна. Гурван найзын хувьд одоо бас бидний дунд байхгүй юм байна гэж ингэж үзсэн гэж би ойлгож болох уу? Та бүхэн болохоор нягтлах шаардлагагүй гэж үзэж байна шүү дээ.

Тэгэхээр Ёс зүйн хорооны хувьд энэ бас хариуцлагатай асуудал л даа. Яагаад гэвэл дараа ямар нэгэн асуудал гарвал та бүхэн бас дагаж хариуцлага хүлээх болно. Тийм учраас энэ асуултад хариулаачээ. Гурван найз тэр дансаар явсан мөнгө цэвэр.

С.Баярцогт гишүүнээс би нэг зүйл асууя гэж байгаа юм. Энэ асуудал ингээд олон улсын хэмжээнд яригдсан. Мөнгө угаасан. Одоо татвараас зайлсхийсэн. Та энэ байгууллагатай яагаад шүүхдэлцэхгүй байна вэ? Нэрээ цэвэрлэх. Улс орныхоо нэрийг бодох. Би бол одоо бас олон улсын шүүхэд ч юм уу хандана. Хэрвээ би байсан бол. Хэрвээ энэ одоо зүгээр цэвэр миний бизнесийн орлогын мөнгө байсан. Татвараас зайлсхийгээгүй гэдэг нь тодорхой байгаа юм бол би ийм асуудлыг хөндөх л байсан л даа. Тэгээд та яагаад хөндөхгүй байна вэ гэсэн нэг ийм зүйлийг тодруулаачээ.

**3.Энхболд:** - М.Батчимэг гишүүн хариулна. Бид анх удаа энэ ёс зүйн зөрчил гаргасан гишүүнийхээ тухай асуудлыг Ёс зүйн хороонд хэлэлцээд хэлэлцүүлэг гэдэг ийм шийтгэл оноож байгаа. Тэгээд энийг зохицуулсан дэг манай Их Хурлын дэг дотор байхгүй юм билээ. Тэгэхээр ердийн журмаар явахаар шийдсэн. Одоо зөвхөн дэд хорооноос асууна. С.Баярцогтоос асуух асуулт дараагийн хэлэлцэх асуудал дотор байгаа. Шударга-Ёс эвслийн бүлгийн



завсарлага дууссан бол С.Баярцогт гишүүнээс асууж болдог нөгөө асуудал бол үргэлжлээд явна. М.Батчимэг гишүүн хариулъя.

**М.Батчимэг:** - Ц.Даваасүрэн гишүүний асуултад хариулъя. Тодорхой асуултуудад хариулт өгөхийн өмнө би бас Ёс зүйн дэд хороо гэдэг ямар байгууллага вэ гэдгийг бас гишүүд маань сайн мэдэж байгаа байх. Нэг эргэж санаасай гэж бодож байна. Тэгэхээр Ёс зүйн дэд хороо гэдэг бол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг одоо сахиулах, сахиулж ажиллах үндсэн үүрэгтэй байгууллага. Энэ дэд хорооны эрх мэдэл, чиг үүрэг бол бас өөрийн хязгаартай. Энэ бол шүүх байгууллага биш, мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах эрх мэдэл байхгүй. Тэгэхдээ мэдээж боломжийн хэмжээнд асуудлыг нягталж тодруулах үүрэгтэй.

Бид бол Ёс зүйн дэд хороон дээр энэ асуудлыг одоо холбогдох байгууллагад шилжүүлж шалгуулах шаардлагагүй гэдэг зүйл огт яригдаагүй. Харин яагаад тэр холбогдох байгууллагад шилжүүлэх гэдэг 9.1.2 дээрх асуулт одоо энэ хариуцлагын төрлийг сонгоогүй вэ гэхээр угаасаа энэ асуудал маань С.Баярцогт гишүүн эхнээсээ бас Их Хурлын чуулганы хуралдаан дээр болон олон нийтэд мэдээлж байсан. Авлигатай тэмцэх газарт өөрөө холбогдох мэдээллүүдээ аваачиж өгөөд, Авлигатай тэмцэх газар энийг нь нягталж үзлээ. Холбогдох тэр хөрөнгө орлогын мэдүүлэг, орлого зарлагын тэр байдлыг нь, тэр хөрөнгийн тэр нөхцөл байдлыг нягталж үзлээ. Тэгээд энэ нягталж үзсэний дагуу гадаадад байгуулсан энэ байгаа данс, энэ холбогдох мэдээллийг бүртгэж авлаа гэсэн энэ албан бичгийг Улсын Их Хурлын даргын нэр дээр ирүүлсэн ийм үйл явц явагдсаныг бид нар харсан. Холбогдох тэр бичиг, бүх баримтууд нь бид нар дээр ирсэн. Тийм учраас Ёс зүйн дэд хороо бол өөрсдийнхөө чиг үүргийн хүрээнд ажиллаад өнөөдрийн энэ хэлэлцүүлж байгаа хариуцлагын төрлийг оногдуулсан. Тэрнээс биш одоо байгууллага шалгах шаардлагагүй гэдэг дүгнэлтийг хийгээгүй гэдгийг онцолмоор байна.

Та сая хэлж байна. Тэр гаднын байгууллагаас хүмүүс тэр мөнгө шилжүүлээгүй гэдгийг яаж мэдэж байгаа юм бэ гэж. С.Баярцогт гишүүн бол яах вэ өөрөө холбогдох хууль хяналтын байгууллагад нь, тухайлбал Авлигатай тэмцэх газарт бүх баримтуудаа аваачиж үзүүлсэн. Ёс зүйн дэд хороон дээр би одоо тийм мэдээж энэ бол бас хувь хүний мэдээлэлтэй холбоотой тодорхой асуудлууд дээр би бас өөрт чинь Ёс зүйн дэд хорооны дарга учраас Авлигатай тэмцэх газарт хууль хяналтын байгууллагад үзүүлсэн энэ мэдээллийг бас харуулчихъя гээд надад тэр банк руу Швейцарын банк руу тэр мөнгө шилжүүлсэн тэр шилжүүлгийн, одоо Монголоос шилжүүлсэн тэр шилжүүлгийн нэг хувийг харуулсан. Энэ бол гаднын компани биш Монгол хүний нэрээр Монголоос шилжсэн шилжүүлэг байна гэдгийг би харсан гэдгийг бас энд хэлмээр байна.

**3.Энхболд:** - Г.Уянга гишүүн асууя.

**Г.Уянга:** - Би бодохдоо С.Баярцогт гишүүний энэ асуудлыг зөвхөн одоо С.Баярцогт гэдэг хувь хүнтэй холбоотой асуудал гэж ерөөсөө бодохгүй байгаа. Энд ямар ч хүн чанарын асуудал байхгүй. Энд ямар ч жудагын тухай асуудал

ярих шаардлагагүй юмаа. Бид энд зарчим ярьж байна, ёс зүй ярьж байна, шударга ёс ярьж байна. Оюу Толгойн гэрээ байгуулагдсантай холбогдуулж энэ үйл явцыг шалгах зайлшгүй шаардлагатай гэж 7 гишүүн үзсэн. Хүний мууд дурладаг, хүний мууд дуртай нэг ч хүн энд байхгүй.

Энэ таны хийсэн энэ алдаа бол зүгээр хөрөнгө орлогын мэдүүлэгтээ мэдүүлээгүй нь бол маш бага хэрэг. Үүнээс том юм энэ одоо бидний хэлэлцэж байгаа энэ үйл явцаар далимдуулж далд орж үлдэх вий гэж би ихэд болгоомжилж байна.

Энэ бол та дэд даргынхаа хувьд хийсэн алдаа биш учраас дэд даргаа өгч байгаа нь өөрөө ёс зүйн хариуцлага тооцож байгаа гэж үзэх үндэслэлгүй юмаа гэж ингэж би бодож байна. Та их өрөвдөх арга тактик хэрэглэж байх шиг надад санагдсан. Энэ бол их утгагүй юмаа. Монголын ард түмэнд хохиролтой гэрээ байгуулж, Монгол Улсыг хохироосон гэрээ байгуулахад хамгийн түрүүн оройлон оролцож байхдаа ард түмнээ эхлээд өрөвдөх ёстой байсан. Монголын ард түмнээр өрөвдүүлж өөрийгөө хаацайлах тухай бодсоноос ард түмнээ өрөвдөх хайрлах тухай эхлээд бодож болсонгүй юу гэж би бас хэлмээр байгаа юм.

Хүмүүсийн байр суурь надад энэ чуулганд одоо хэлж байгаа хүмүүсийн үг байр суурь их сонирхолтой байна. Би хэлсэн. Энэ танхимын баруун зүүн жигүүр олон олон Баярцогт сууж байгаа. 1 сая долларын данс бол юу ч биш ээ. Бүгд энийг мэдэж айдас хүйдэст хургасан байгаа юм шиг надад санагдаж байна. Тийм ч учраас олон хүн, ялангуяа энэ зүүн жигүүр, зүүн гар талд сууж олон хүн хамгаалж үлдэх юм байна. Хамгаалах юм байна. Хүний чанар, ёс жудаг ярьж сайн хүн болж жүжиглэж хамгаалж үлдэх юм байна.

Бид энд маш том асуудлыг ярьж байгаа. Оюу Толгойн гэрээтэй холбоотой энэ маш том авлига, санхүүгийн бүлэглэл, нам дамнасан санхүүгийн бүлэглэл, олигархи бүлэглэл хуйвалдагчдын тухай ярьж байгаа. Энэ том үүр уурхай руу орох зориг өнөөдөр Ардчилсан намынханд байна уу, үгүй юу гэдгийг энэ үйл явцаас харж болно гэж бодож байна. Энэ бол шударга ёсны маш том индикатор юм. С.Баярцогт гэдэг хувь хүнийг өрөвдөх тухай асуудал огтхон ч биш ээ.

Та хэвлэл мэдээллийг их сайн атгасан юм билээ. Та уурга урт, хувь уужуу юм. Таны мөнгөний. Эсрэг байр суурь маш бага байсан. Энэ зарчмын асуудлыг, энэ шударга ёсны асуудлыг, хүн чанар жудагын асуудал болгож энэ зарчим ярьж байгаа хүмүүсийг муухай харагдуулах ийм процесс бол их идэвхтэй явж байна лээ. Гэхдээ цөөнч гэсэн одоо хэвлэл мэдээллийн хэрэгслэл байгаагаар нь энийг бас мэдээлэх байх. Шударга ёсны талд байгаа байх гэж найдаж байна.

Ёс зүйн дэд хороо холбогдох байгууллагад шилжүүлэхээр ийм шийдвэр гаргаагүй надад сонин санагдаж байна. Ё.Баярцогт гишүүн өөрөө хандаж одоо намайг шалгаад өгөөчээ. Би энэ компаниа мэдүүлээгүй байна гэж байгаа нь бол асуудлын гол руу орж байгаа хэрэг биш. Харин ч өнгөлөн далдлалт гэж би үзэж байгаа юм. Асуудлын гол руу оръё гэвэл холбогдох хууль хяналтын байгууллагууд, магадгүй эрүүгийн цагдаа, Авлигатай тэмцэх газар С.Баярцогт гишүүний хүсэлтээр биш энэ кейсээс үдээд өөрөөр санаачлага авч шалгаж энэ

дансыг, тэр гурван нөхөр хэн бэ, энэ дансаар ямар гүйлгээ орсон, анхны эх үүсвэр нь юу юм бэ гэдгийг шалгах ёстой байх. Ингэвэл шударга ёс тогтоно. Ингэж шалгах бололцоог бид хүссэн.

Ингэж шалгах, хэрвээ үнэхээр С.Баярцогт гишүүн алдаагүй юм бол бас алдаагүй гэдгийг илрүүлж шалгах бололцоог бас тэдэнд олгох ёстой ингэж үзэж байгаа юм.

Ерөнхийлөгч хэлсэн үгэндээ хэлсэн байна лээ. Нам, бүлэглэл, найз нөхдийн холбоо ямар хүчтэйг би мэднэ. Хэрвээ шударга ёс ийм юмны өмнө өвдөг... /минут дуусав/

**3.Энхболд:** - Г.Уянга гишүүн асуулт уу, үг үү? Гүйцээх боломжгүй л дээ. Нөгөө минут нь дуусчихсан. Асуулт байвал хариулъя. Үг байсан бол ингээд би цаашаа явах гээд байна. 1 минут гэж байхгүй л дээ. М.Батчимэг гишүүн хариулъя.

**М.Батчимэг:** - Би бол Г.Уянга гишүүнийг илүү байр сууриа илэрхийлэв үү гэж ойлголоо. Тэгэхдээ Ёс зүйн дэд хороо яагаад тэр хуулийн байгууллагад, бусад байгууллагад шалгуулахаар шилжүүлээгүй юм бэ гэдэг асуудал гэдэг асуудал хөндөгдөж байна. Тэрний тайлбарыг бол би өмнө нь хэлсэн.

Тэгэхдээ энд нэг зүйлийг онцолж хэлмээр байна. Ёс зүйн дэд хороо бол ямар нэгэн сэтгэл хөдлөл, субъектив дүгнэлтэд одоо хөтлөгдөх биш аль болохоор байгаа дүрэм журмынхаа хүрээнд, байгаа фактын хүрээнд бодитой дүгнэлт гаргах ийм хичээл зүтгэл гаргасан. Ингэж ажиллах нь өөрөө ёс зүйтэй үйлдэл гэж ойлгож байгаа гэдгийг хэлмээр байна.

**3.Энхболд:** - Г.Баярсайхан гишүүн асууя.

**Г.Баярсайхан:** - За баярлалаа. Би саналаа хэлчихье. С.Баярцогт гишүүнийг би хувьдаа Монгол төрийн гурван өндөрлөнгийн нэг гэж боддог л доо. Яагаад тэгж бодож байна вэ гэвэл Их Хурлын дарга гадаадад томилолттой байхад Их Хурлын дэд дарга орлодог. Энэ утгаараа Монгол төрийг бас төлөөлөх хүний нэг гэж харж байгаа. Гэтэл одоо тэр Виржиний арал гэнэ үү, тэнд С.Баярцогт гишүүний China Mongol гэж бичсэн байна л даа. Тэгэхээр би энэ асуудалд нь илүү их харамсаж байгаа.

За тэр мөнгө төгрөгний асуудал, тэр данс энэ тэрийн асуудал, ер нь монголчууд бид хаана ч яваад данс нээгээд явж болно. Үүнийг бол нэг их үгүйсгээд байж болохгүй. Энэ тусгаар тогтносон улсын төрийн тэргүүнийг Монгол Улсын Их Хурал гэдэг чинь өөрөө төр. Дэд даргыг улсын харъяаллыг тэгж андуурч бичсэн байна гэдэг чинь энэ маш том алдаа л даа. 4 жил тэгж явсан байгаа юм. Энэ л хамгийн том засаж болшгүй алдаа гэж байгаа юм. Энэ утгаараа харах юм бол та энд суух эрх байхгүй л дээ.

За тэгээд ер нь түүх эргүүлээд ярих юм бол өнгөрсөн сонгуулийн сүүлээр, би тухайн үедээ Ёс зүйн дэд хороон даргаар ажиллаж байхад 6 гишүүний

хөрөнгө орлогын мэдүүлэг будлиантай байна гээд Ёс зүйн дэд хороон дээр асуудал ярьж байсан. Тэр гишүүдийн зарим нь ч одоо энд сууж байгаа. Тэгэхээр хөрөнгө орлогын мэдүүлэгт асуудал ярих юм бол ер нь бол энд тухайн үед нь сууж байсан тэр яригдаж байсан гишүүдийн асуудлыг ч бас хамт ярих ёстой гэдгийг би бас дурьдаж хэлмээр байгаа юм. Өмнөх Их Хурал дээр би Д.Дэмбэрэл даргатай, Их Хурлын даргатай санал бодлоо солилцож байсан. Монгол Улсын Их Хурлын гишүүдийн хөрөнгө орлогын мэдүүлэгт мониторинг, хяналт шалгалт бүгдэд нь хийе, 76 гишүүнд. Тэгэхэд надад юу гэж хэлж байсан бэ гэвэл Г.Баярсайхан гишүүн ээ, наадах чинь зөв. Гэхдээ их бартаатай байна даа гээд надад ийм үг хэлж байсан. Өнөөдөр бид бүгдээрээ хөрөнгө орлогынхоо мэдүүлэгт Ёс зүйн дэд хороо өөр хууль, хяналтын байгууллагууд юу байна, мониторинг хяналт шалгалт хийлгэх ёстой гэж бодож байгаа. Их Хурлын гишүүний цалинтай мөртлөө хэдэн миллиард төгрөгийн хаусанд амьдарч байгаа гишүүд байна. Үүнийг бид шалгах ёстой.

За тэгээд Ёс зүйн дэд хороо бол цөөнхөд байх ёстой. Бичигдээгүй хууль байгаа. Өнөөдөр Ёс зүйн дэд хорооны гаргасан шийдвэр би бол хувьдаа бол .... бус гэж бодож байгаа. Өмнөх Ёс зүйн дэд хороон дээр би бол цөөнхөд байсан. Цөөнхөд бол олонхи цөөнхөд өгч байсан Ёс зүйн дэд хороогоо. Тэгээд бас нэг Их Хуралд бичигдээгүй хуулиудаа бас дагаад явах нь бол зөв зүйтэй болов уу гэж би хувьдаа бодож байна. За анхаарал тавьсанд баярлалаа.

**3.Энхболд:** - Ө.Энхтүвшин гишүүн асууя.

**Ө.Энхтүвшин:** - Сая гишүүд нэг асуулт асуугаад тэгээд хариулт нь тодорхойгүй л байна л даа. Ийм асуудал гарчээ. Тодорхой боллоо гээд ингэхээр Улсын Их Хурлын дэд дарга биш хүмүүс байвал одоо ямар албан тушаал өгөх вэ? Байнгын хороон дарга байвал Байнгын хороон даргаа өгчих юм байна. Энэ жишээгээр бол тэгж ойлголоо. Дэд хороон дарга байх юм бол дэд хороон даргаа өгчих юм байна. Тэр Тэр Мянганы хөгжлийн зорилтыг хангах дэд хороон дарга ч гэдэг юм уу ингээд. Тэгээд тэрийгээ өгчих юм байна. Одоо та хэд дотор чинь бол дарга биш хүн байгаа билүү? Байхгүй. Р.Амаржаргал гишүүн ганцаараа дарга биш байгаа. Тэгэхээр бүгдээрээ ийм хамгаалалттай юм байна. Тэгэхээр ер нь ийм өгчих албан тушаалгүй гишүүд жишээлэх юм бол яах вэ гэдгийг нэг ийм асуудал гарлаа гэхэд Ёс зүйн яаж хандах вэ? Энийг нэг тодруулж өгөөч. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ Виржини, Бермут, Кайманы арлууд дээр ер нь Монголын 215 ийм тусгай зөвшөөрөл эзэмшсэн ийм компанийн бүртгэлтэй гээд ингээд яриад байна. С.Баярцогт гишүүнийх бол анхных нь ч биш, эцсийнх нь ч биш. Тэгэхээр энийг ер нь одоо энэ дотор сууж байгаа улсууд холбоотой байна уу, үгүй юу энэ татваргүй бүс дээр. Компанид данстай ийм улсууд энэ дотор байгаа юу, үгүй юу гэдгийг ер нь Их Хурал өөрөө нэг анхаарал хандуулах ёстой биш үү. Зөвхөн энэ асуудлыг яриад өнгөрөх бол их жижигхэн болно. Энийгээ ер нь тавибал яасан юм бэ? Энэ Их Хурлын удирдлага энийг хариулах юм уу? Хаагуур шалгуулах юм? Зөвхөн олон улсын сэтгүүлчдийн байгууллага л одоо илрүүлбэл тэр үед нь ярина гэх юм уу? Бид нар өөрсдөө энэ талаар ажиллахгүй юм уу? Тэгэхгүй бол энэ олон нийт чинь ер нь учрыг нь ойлгохоо больж байгаа юм биш

үү. Авлигатай тэмцэнэ гээд олон жил ярилаа. Яг үнэн хэрэгтээ яриад байгаа болохоос биш иймэрхүү бодитой ажлуудыг хийсэнгүй шүү дээ. Энийг ер нь одоо ярих цаг нь болсон биш үү. Их Хурлын даргаас энийг асууя даа.

**3.Энхболд:** - Их Хурлын дарга хариулах боломжгүйг өөрөө мэдэж байгаа Ө.Энхтүвшин гишүүн. Бид бол хуультай. Хөрөнгө орлогын мэдүүлэг мэдүүлдэг, ашиг сонирхлын мэдүүлэг мэдүүлдэг. Тэр дээр бүгдийгээ бичих үүрэгтэй. Тэр нь шалгадаг байгууллагатай. Тэр журмаараа л явна. Ц.Оюунбаатар гишүүн асууя.

Өөрийг чинь нэр зааж асуусангүй л дээ. За М.Батчимэг гишүүн хариулъя. Ц.Оюунбаатар гишүүн түр байж бай.

**М.Батчимэг:** - Тэгэхээр Ө.Энхтүвшин гишүүн сая асуудлыг шийдээгүй байна гэж хэллээ л дээ. Би бол тэгж бодохгүй байна. Яагаад гэвэл Ёс зүйн дэд хороо Улсын Их Хурлын чуулган тухайн гишүүний одоо өөрийнх нь тавьсан өргөдлийн дагуу ямар шийдвэр гаргах. Ер нь С.Баярцогт гишүүний асуудлыг авч хэлэлцэж байгаа нь би бол Ёс зүйн дэд хорооны энэ үйл ажиллагаанаас тусдаа асуудал гэж харж байгаа.

Ерөөсөө Ёс зүйн дэд хороо өөрөө Улсын Их Хурлын нэгдсэн чуулган авч хэлэлцээд энэ хүнийг ийм албан тушаал дээр байлгах асуудлыг шийдээ гэж чуулганд ийм чиглэл өгөх эрх байхгүй. Ёс зүйн асуудал нэгэнт яригдаж байгаа учраас тухайн хүний асуудлыг чуулганд оруулж ирээд нийтээрээ энэ 76 хүн дундаа ёс зүйн асуудлыг авч хэлэлцэх, энэ дээр шүүмж, санал бодол, асуулт хариулт явагдах нь өөрөө хариуцлагын нэг хэлбэр гэж харагдаж байгаа юм. Харагдаж байгаа биш ерөөсөө тийм Ёс зүйн дэд хорооны дүрмийн одоо логик бол тийм байгаа.

Тийм учраас өнөөдөр С.Баярцогт гишүүний асуудал тэртээ тэргүй нэгдсэн чуулганд орж ирээд яригдаад явж байгаа учраас хүмүүст энэ хөнгөхөн юм шиг харагдаад байгаа болохоос биш өнөөдрийг хүртэл Улсын Их Хурал нэг ч гишүүнийхээ ёс зүйн асуудлыг нэгдсэн чуулган дээр авч орж ирж хэлэлцэж байгаагүй. Нэгдсэн чуулганд асуудал нь яригдах тухай одоо ийм асуудал орж ирээгүй байсан бол энэ өөрөө анхны ийм том тухайн гишүүнд бол их ноцтой хариуцлагын төрөл байх байсан гэдэгт би эргэлзэхгүй байна. Их Хурал хэлэлцээд албан тушаалын асуудал ярих уу, ямар хариуцлага ярих уу гэдэг бол энэ бол Ёс зүйн дэд хорооны яг гаргаж байгаа дүгнэлт биш ээ. Тусдаа асуудал. Тийм учраас Ёс дэд хороо боломжийнхоо хүрээнд өөрсдийнхөө хариуцлагыг дүрмийнхээ хүрээнд хүлээлгэсэн гэдгийг дахиж хэлмээр байна.

За дараа нь бол тэр Г.Баярсайхан гишүүний хөндсөн асуудалтай холбоод Ө.Энхтүвшин гишүүний сүүлийн асуултад одоо хариулт болгож хэлэхэд ер нь бол та хэллээ. Тэр гадна офшор компаниуд их бүртгэлтэй байна. Энэ дотор бас манай гишүүдийн асуудал хөндөгдөх юм биш биз ээ. Хэзээ нэгэн цаг энэ хэвлэлээр гарч ирэхээр ярих юм уу гэж. Би бол үнэхээр өнөөдөр энэ асуудал бол бид нар Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд хамгийн түрүүнд бид нар бас дор бүрнээ бодох ёстой. Ёс зүйн дэд хороо ч тэр, Улсын Их Хурал өөрөө бүрэн бүрэлдэхүүнээрээ анхаарч ажиллах ёстой асуудал гэж бодож байгаа.

Та бүхэн санаж байгаа бол С.Баярцогт гишүүний асуудлыг одоо өнгөрсөн долоо хоногт нэгдсэн чуулганаар хэлэлцэж эхлэхэд Ёс зүйн дэд хороо гишүүддээ мэдээлэл болгож, санал зөвлөмж болгож холбогдох хуулийн заалтуудыг тараасан байгаа. Энэ дотор гишүүд хуульд заасан хугацаанд хөрөнгө орлогоо гадаад байгаа ямар нэгэн бүртгэлтэй данс юу байдаг юм тэр болгоныгоо үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй шүү гэдгийг тэр санал зөвлөмжинд тусгасан байгаа. Би бол Ёс зүйн дэд хороо хийх ёстой хамгийн чухал ажил бол энэ юм байна гэж ойлгож байгаа. Тийм учраас гишүүд цаашдаа дэмжиж хамтарч ажиллах байх гэж бодож байна.

За Ёс зүйн дэд хороо олонхид байх уу, цөөнхөд байх уу гэдэг бол нээлттэй асуудал. Би бол энэ Ёс зүйн дэд хороо легитент биш ээ гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй. Энэ бол өөрөө байгаа хуулийнхаа хүрээнд байгуулагдсан байгууллага. Хуулийнхаа хүрээнд, дүрэм журмынхаа хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа гэдгийг хэлмээр байна.

**3.Энхболд:** - Ц.Оюунбаатар гишүүн асууя.

**Ц.Оюунбаатар:** - Тэгэхээр хэлэлцэж байгаа асуудал нь нэг хүний тухай асуудал биш л дээ. Энэ бол Монголын төр ёс зүйтэй байх, сахилгатай байх, хариуцлагатай байх. Үндсэн хуулинд зааснаар жирийн иргэн төрийн өндөр албан тушаалтан хуулийн өмнө адил тэгш байх энэ зарчимтай л холбогдож байгаа. Ийм байр сууринаас Ёс зүйн дэд хороо маань асуудлыг авч хэлэлцээсэй гэдэг үүднээс хандаж байгаа юм.

М.Батчимэг дарга мэдэж байгаа болов уу, үгүй болов уу. 1991 онд Улсын Бага Хурлын гишүүн асан, гишүүн Дамдин гэж хүн 500 төгрөгийн үнэтэй диктафоныг бусдад худалдсан гэдгээр Бага Хурлын гишүүнээс прокурорын дүгнэлт авч байгаа одоо гаргаж байсан. Өөрөөр хэлбэл хасаж байсан. Ёс зүйн хариуцлага хүлээж байсан. Одоогоор бол 20 мянган төгрөгийн л диктафон шүү дээ. Тэр үед ч бас сахилга хариуцлага, хууль арай чанга байсан, шударга байсан юм шиг байгаа юм. Одоо ийм ноцтой асуудал яригдаж байхад Ёс зүйн байнгын хороо маань асуудалд хир шударга, хир зарчим ч хандсан юм бэ. Энэ чинь улс төрийн байр сууринаас хандаад байна уу, үгүй юу. Ийм асуудал байна.

Хоёрдугаарт, энэ асуудалтай холбогдоод цаашдаа Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүд, төрийн өндөр албан тушаалтантай ёс зүйн ямар нэгэн асуудал яриад байх юм байхгүй сайндаа Их Хурлаар хэлэлцүүлж болох юмаа Их Хурлын гишүүнийг. Ийм л ойлголт төрж байна шүү дээ. Энийг одоо бид энэ презедентыг цаашид баримтлах уу? Ёс зүйн дэд хороо энийг ингэж баримталж ажиллах юм уу гэж би асууж байна.

Гурав дахь бол, ер Ёс зүйн дэд хорооны даргын хувьд л би одоо асууя. Энэ сөрөг хүчиндээ өгдөг дэлхийн нийтийн ч практик байгаа, бидний ч бүрдэж ирсэн практик байгаа. Ёс зүйн дэд хорооныхоо удирдлагыг сөрөг хүчиндээ өгөх нь зүйтэй юм уу? Энэ дээр хувийн бодол санаагаа хэлж өгөөчээ гэж хүсэж байна.

**3.Энхболд:** - М.Батчимэг гишүүн хариулъя.

**М.Батчимэг:** - Ц.Оюунбаатар гишүүний эхний саналтай би одоо асуулт гэхээсээ илүү санал, байр суурь байлаа гэж ойлгож байна. Санал нэг байна. Би бол өнөөдөр нэг хүний асуудал гэхээсээ илүү энэ танхимд сууж байгаа 76 гишүүн нэг бүрийн ёс зүйг хандаж хөндөж байгаа ийм асуудлыг ярьж байгаа гэж ойлгож байгаа. Тийм учраас бид нар бас энд дор бүрдээ өөрсдөө бас дүгнэлтээ хийж байх ёстой байх аа.

Хоёрдугаарт нь, улс төрийн байр сууринаас субъектив хандчихав уу. Өөрөөр хэлбэл өөрийнхөө намын гишүүн учраас зөөлөн дүгнэлт хийж байна уу гэж хэлж байх шиг байна. Санал нэгдэхгүй байна. Би бол Ёс зүйн дэд хороо аливаа асуудалд. Ер нь өнөөдөр бид нар нэг гишүүнийхээ асуудлыг ярьж байна. Маргааш хэнийхээ ч асуудлыг ярих шаардлага гарахыг мэдэхгүй. Тийм учраас энэ бол аль нэг намын гишүүний тухай яриа биш ерөөсөө Улсын Их Хурлын гишүүний тухай яриа гэж ойлгож байгаа.

Тэгэхээр энд одоо ямар нэгэн байдлаар эхлээд нэг субъектив одоо зарчим юм уу одоо байр суурь тодорхойлоод энэ хүнийг өрөвдөнө хамгаална юм уу, эсвэл шийтгэл түлхэнэ гэдэг энэ байр сууринаас Ёс зүйн дэд хороо хандах нь өөрөө ёс зүйгүй үйлдэл гэж ойлгож байгаа. Тийм учраас Ёс зүйн дэд хороо бид нар энэ зарчмаа ярьж байгаад хуралдсан, ярьсан. Тэгээд өнөөдөр бид нар энд хариуцлагатайгаар хэлж байгаа Ёс зүйн дэд хорооны гишүүд бид нар дотроо итгэл үнэмшилтэй байгаа зүйл бол энд тавьсан байгаа дүрмийн хүрээнд оногдуулж болох Ёс зүйн дэд хорооны эрх мэдлийн хүрээнд хамгийн хүнд гэж үзэх энэ хариуцлагын хэлбэрийг оногдуулсан гэж ойлгож байгаа. Дахиад би түрүүний хэлсэн үгээ давъя. Хэрвээ өнөөдөр Их Хурлын нэгдсэн чуулганаар асуудал нь хэлэлцэгдэхээр шийдэгдсэн байгаа биш хэн нэг гишүүний асуудал өөрөө Их Хурлын нэгдсэн чуулганд орж ирээд ёс зүйн асуудлыг 76 хүн тойроод ярьж байгаа бол хүмүүс энийг мэдрэх байсан. С.Баярцогт гишүүний асуудал яригдаад эхэлсэн учраас хүмүүс энийг бол шийтгэл биш юм аа гэж хараад байх шиг байна. Дэд хороо бол өөрийнхөө дүрмийн хүрээнд хангалттай шийдвэр гаргасан гэж ойлгож байгаа. Ийм итгэл үнэмшилтэй байгаа гэдгээ хэлмээр байна.

За гурав дахь асуудал бол энэ миний хувь хүний хувьд хариулах асуудал гэж бодохгүй байна. Тэр тусмаа өнөөдөр би жишээлбэл хувь гишүүнийхээ хувьд хариулж байгаа бол өөр нэг хэрэг. Би өнөөдөр Ёс зүйн дэд хороог ахалж байгаа хүний хувьд энэ бол би түрүүн хэлсэн. Олонхиороо ярилцаад шийдэх ёстой нээлттэй асуудал гэж.

**3.Энхболд:** - Ц.Нямдорж гишүүн асууя.

**Ц.Нямдорж:** - Түрүүчийн хурал дээр энэ асуудлыг Ёс зүйн хороогоор хэлэлцүүлж, тэгээд эцсийн шийдвэр гаргая гэдэг саналыг хэлж. Тэр саналыг хүлээж авсан удирдлагуудад талархал илэрхийлж байна. Одоо энэ зөв жишиг тогтож эхэлж байна.

Хоёрдугаарт, миний хэлэх гэсэн юм бол Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь заалт гэж бий л дээ. Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдвол эгүүлэн татна гэсэн ганцхан заалттай юм. Үүнтэй холбогдуулаад би Ёс зүйн хорооноос нэг зүйл асуух гэсэн юм. Энэ хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбогдолтой Их Хуралд албан тушаалгүй гишүүний асуудал дараа нь ороод ирэх юм бол яана гэж ярилцсан бэ?

Цаана чинь зарим нь халуурч байгаад энэ С.Баярцогтын асуудал яригдаж байх үед би 5 данстай байж байгаад 3-ыг нь мартаад нуучихсан. Тэгээд сүүлд нь тэрийгээ мэдсэн гээд нотлох баримтаа хэлээд өгчихсөн гишүүн байгаа шүү дээ энэ дотор чинь. С.Баярцогтыг өмөөрч байгаа ухаан нь тэр л дээ зайлуул. Одоо энэ 3-ыг нуусан этгээдийг яах юм. Албан тушаал байхгүй. Энийг хэрхэн шийдэх нь зүйтэй гэж үзсэн юм бэ? Энэ асуудлаар ярьж байж нэгдсэн ойлголтод хүрэхгүй бол энэ Үндсэн хуулийн 29.3-тай холбоотой төвөгтэй асуудал бий л дээ.

Одоо тэр 3-ыг нуусан гэдгээ шударгаар илчилсэн хүний асуудал ороод ирвэл яах вэ. Одоо би жишээ нь нуусан бол яах вэ. Надад Их Хурлын гишүүнээс өөр албан тушаал алга л даа.

**3.Энхболд:** - М.Батчимэг гишүүн хариулъя.

**М.Батчимэг:** - За Ц.Нямдорж гишүүн бол манай хамгийн туршлагатай хуульчдын нэг. Д.Арвин гишүүн ээ, би асуултад хариулчих уу.

Тэгэхээр Ц.Нямдорж гишүүн бол манай хамгийн туршлагатай хуульчдын нэг. Би бол энэ логикоо ойлгож байгаа гэж бодож байна. Яагаад гэвэл өнөөдөр Ёс зүйн дэд хороо энэ асуудлыг оруулж ирж байгаа нь хэн нэгний албан тушаал, ерөөсөө албан тушаалын хариуцлага тооцох эсэхтэй холбоотой асуудал ерөөсөө биш. Нэгдсэн чуулганаар шүүн хэлэлцэж байгаа нь өөрөө ёс зүйн шийтгэл гэж ойлгож байгаа. Ёс зүйн дэд хорооны дүрэм өөрөө ийм логикоор бичигдсэн.

6 гишүүний асуудал, эсвэл өөр бусад гишүүдийн асуудлыг та хөндлөө. Би зүгээр түрүүн хариулагдаагүй өнгөрсөн байна. Үнэхээр өнгөрсөн Улсын Их Хурлын чуулганы хугацаанд сонгуулийн өмнө 6 гишүүн, нэр бүхий 6 гишүүн тодорхой шалтгаанаар за мартсан юм уу, яасан юм мэдэхгүй одоо бас хөрөнгө орлогоо гүйцэд мэдүүлээгүй гэсэн ийм асуудал гарсан юм билээ. Тэгэхдээ Ёс зүйн дэд хорооны дүрэмд бас ёс зүйтэй асуудал байх. Сонгуулиас 45 хоногийн өмнөх энэ хугацаанд Улсын Их Хурлын гишүүд бие биенийхээ ёс зүйг шүүн хэлэлцэхгүй ийм дүрэм байна. Ёс зүйн дүрэмд. Тийм учраас тухайн үед тухайн 6 гишүүний асуудал хэлэлцэгдээгүй өнгөрсөн юм билээ. Энийг одоо ямар дүрэм журам, ямар хуулиар шүүн хэлэлцэх шаардлагатай бол одоо яах ёстой юм бэ. Одоо бол хариулж мэдэхгүй байна. Манай Ёс зүйн дэд хорооны дүрэмд энэ талаар заалт байхгүй байгаа.

Танд би бараг буцаагаад хуульч хүний, туршлагатай хуульч хүний чинь



хувьд асуулт тавимаар байгаа юм. Та сая одоо албан тушаалгүй хүн байвал яах юм. Ахиад асуудал гарч ирээд байвал яах юм гэж хэлж байна. Тэгэхээр би танд Улсын Их Хурал өөрөө өөртөө мөрдөн шалгах энэ одоо чиг үүргээ одоо манай бусад парламентын засаглалтай орнуудад байдаг шиг тийм мөрдөн шалгах хүчтэй эрх мэдэл бол манай парламентэд байхгүй. Ёс зүйн дэд хороонд байхгүй. Тийм учраас таны сүүлийн шаардлага бол би хэрвээ Ёс зүйн дэд хороо тэрийг биелүүлнэ гэж үзэх юм бол Их Хурал өөртөө тэр тусмаа Ёс зүйн дэд хороонд тэр илүү нарийн зүйлийг мөрдөж шалгах эрх мэдэл, чиг үүргийг нь олгож байж биелэх зүйлээ гэж бодож байна. Тэрнээс биш өнөөдрийн дүрмийн хүрээнд бид нар энэнээс илүү шийдвэр гаргах боломж байхгүй байна.

**3.Энхболд:** - За гишүүд асуулт асууж дууслаа. Дэд хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

***Дөрөв. Улсын Их Хурлын дэд дарга С.Баярцогтыг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудал (үргэлжлэл)***

Дараагийн асуудал энэтэй холбоотой асуудал байгаа. Улсын Их Хурлын дэд дарга С.Баярцогтыг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Улсын Их Хурал дахь Монгол Ардын Хувьсгалт Нам – Монгол Үндэсний Ардчилсан Намын “Шударга – Ёс” эвслийн бүлэг 4 дүгээр сарын 18-ны Пүрэв гаригт завсарлага авсан. Завсарлагын хугацаа өнөөдрөөр дуусч байгаа. Завсарлагын талаар бүлгийн дарга Н.Батцэрэг танилцуулна.

**Н.Батцэрэг:** - За баярлалаа. Манай бүлгийн авсан завсарлага хуулийн хугацаагаараа ч тэр цааш нь сунгахгүй завсарлага дуусч байна.

Зүгээр завсарлага авсан үндэслэл бол сая зарим гишүүдийн хэлээд байгаа шиг С.Баярцогт гишүүнд давхар хариуцлага оногдуулах асуудал яригдах вий. Улсын Их Хурлын дэд даргаасаа чөлөөлөгдөх тухай хүсэлтээ өөрөө гаргачихсан байсан. Энийгээ өөрөө бол өөртөө одоо сонгож авч байгаа ёс суртахууны хариуцлага гэж хэлсэн байсан. Тэгэхдээ Ёс зүйн дэд хороо хуралдаагүй байсныг та бид бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ тэр үед. Тийм учраас Ёс зүйн дэд хороо хуралдаж өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд ямар хариуцлага байх ёстой юм. Энэ талаараа ярилцах бололцоо олгох үүднээс завсарлага авсан юм. Тэгээд завсарлага авсан үндэслэл хангагдсан.

**3.Энхболд:** - За манай дээд талын удирдлагын хэсэг түрүүчийн хэлэлцэж байсан компьютерээ сэргээж гаргахыг хүсье. Түрүүн бол үг хэлж байгаад зогссон байгаа.

За гишүүдийг үг хэлэхээс өмнө энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүдэд төрсөн өдрийн мэнд хүргэж эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Нэг дэх өдөр Ч.Улаан гишүүний төрсөн өдөр өнгөрсөн байна. 4 дүгээр сарын 22-ны өдөр. За гурав дахь өдөр 4 дүгээр сарын 24-ны өдөр Цэвэлмаагийн Баярсайхан гишүүний төрсөн өдөр өнгөрсөн байна. Өнөөдөр С.Одонтуяа

гишүүний төрсөн өдөр болж байгаа юм байна.

Тэгээд энэ гурван гишүүндээ эрүүл энх, сайхан сайхан бүхнийг хүсэн ерөөе.

За одоо дараалал ёсоор С.Бямбацогт гишүүн үг хэлнэ. Ботьсон уу. Энэ хоёр дараалал өөрчлөгдсөн байна. Г.Баярсайхан гишүүн өмнө нь байсан. Г.Баярсайхан гишүүн үг хэлнэ. Г.Баярсайхан гишүүн алга байна. Нэрийг нь хаслаа. С.Баярцогт гишүүн үг хэлнэ.

**С.Баярцогт:** - За хөрөнгө орлогын мэдүүлэгтээ дутуу мэдүүлсэн энэ шалтгаанаар ёс зүйн хариуцлага хүлээх нь зүйтэй гэж үзсэн. Одоо мөрдөгдөж байгаа Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм, Улсын Их Хурлын Ёс зүйн хороо, Улсын Их Хурлын дэгийн тухай хууль, за Авлигатай тэмцэх тухай хууль, Нийтийн болон хувийн ашиг сонирхлын хуулиудыг ингээд хараад үзэх юм бол сануулах, цалинг нь тодорхой хувиар бууруулах ийм арга хэмжээнүүдийг Улсын Их Хурлын гишүүн авахаар байгаа юм билээ.

Тийм учраас ийм хариуцлага хүлээлгэх ёстой юм байна. Гэхдээ Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын дэд даргынхаа хувьд би энэнээс илүү ёс суртахууны хариуцлага хүлээж үлгэр дууриалал үзүүлэх ёстой гэсэн үүднээс Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлж өгөөчээ гэсэн ийм хүсэлтийг гаргасан.

Би шүүмжилж болон дэмжиж хэлсэн олон гишүүдийн үгийг бол тунгааж бодож хүлээж авч байгаа. Би Ц.Даваасүрэн гишүүний хэлсэн хэд хэдэн зүйлийг нэлээн нухацтай ингээд судалж үзсэн. Үнэхээр энэ ICIJ /The International Consortium of Investigative Journalists/ гэдэг байгууллага бол би түрүүн хэлсэн намайг бол татвараас зугтаасан, мөнгө угаасан гэдэг асуудлаар ерөөсөө яриагүй. Та энэ хөрөнгө орлогын мэдүүлэгтээ энийгээ тусгасан уу л гэж асуусан. Ирсэн захиа нь ч тэр. Дараа нь хэвлэл мэдээлэл дээр тавьсан ч тэр. Энэ асуудал хэвлэлийн бага хурал хийсний дараа надад бас захиа ирсэн. Даргаас Тэр захиан дээр танд одоо ийм юм болжээ. Та одоо энэ ёс зүйтэй холбоотой юмаа давж гарна гэдэгт би итгэж байна гэсэн ийм захидлууд ирүүлсэн. Тийм учраас би бол энэ байгууллагыг шүүхэд өгөх ч юм уу, энэ байгууллагатай зардал шаардлагагүй гэж үзэж байгаа.

Г.Баярсайхан гишүүний хэлсэн, за мөн Ёс зүйн дэд хороон дээр Д.Тэрбишдагва гишүүний сануулж хэлсэн тэр бүртгэлийн баримт бичиг дээр одоо Хятад гэдэг үг яригдсан нь бол тэр байгууллагын цэвэр алдаа байсан учраас би бол хувь хүн талаасаа уучлал гуйхыг нь харин тэр байгууллагаас шаардана. Энийгээ нийт иргэддээ бас мэдээлнэ. Энэ үйл ажиллагаа бол цэвэр бизнесийн орлогоос бүрдсэн, Сангийн сайд болохоос өмнө, өөрөөр хэлбэл Оюу Толгойн гэрээ байгуулахаас жилийн өмнө болсон ийм явдал. Тэгэхээр энэ үйл явдлуудтай холбож үзэхгүй байхыг та бүхнээс хүсэж байна. За би зориуд Г.Уянга гишүүнд хандаж хэлж байгаа. Бас тэгж ойлгож байгаа хүмүүс байгаа бол энэ бол тийм зүйл байхгүй гэдгийг бас хариуцлагатайгаар мэдэгдэж байна.

Монгол Улсынхаа нэр төрийг өндөрт өргөж цаашдаа улам их илүү хичээж ажиллах болно гэдгийг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

**З.Энхболд:** - Хэлэлцэж байгаа асуудлаар гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна.

С.Баярцогтыг Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

64 гишүүн оролцож, 56 гишүүн зөвшөөрч, 87.5 хувийн саналаар С.Баярцогтыг Улсын Их Хурлын дэд даргын ажлаас чөлөөлж байна.

Тогтоолыг уншиж өгье. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай. Монгол Улсын Үндсэн хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Улсын Их Хурлын гишүүн Сангажавын Баярцогтыг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Хоёр. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Тогтоолын эцсийн найруулгыг сонссоноор тооцлоо. Үүрэгээр энэ асуудал дуусч байна.

***Тав. Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах эсэх тухай асуудал  
(үргэлжлэл)***

Дараагийн асуудал. Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах эсэх тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцье.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлэг 04 дүгээр сарын 18-ны Пүрэв гарагт завсарлага авсан. Завсарлагын талаар бүлгийн дарга Нямаагийн Энхболдыг танилцуулахыг хүсье.

**Н.Энхболд:** - Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Их Хурал дахь Ардын намын бүлэг Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг хэлэлцэх явцад завсарлага авсан. Тухайн үед бид ямар шалтгаанаар завсарлага авав гэдгийг бүгдийг нь тайлбарласан. Дахиад сануулчихъя. Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар ярьж байх явцад асуудал боловсруулж санаачилж оруулсан гишүүд Засгийн газрын холбогдох байгууллагуудын хоорондын тоо мэдээ энэ дээр маш их хэмжээгээр зөрж байсан. Энийг лавлах тодруулах шаардлагатай. Үүнийхээ дараа юмаа ярилцъя гэдгийг Ерөнхий сайд ч тэр үедээ хэлж байсан. Бид ч бас энийг цэгцэлсэн тоо

баримттай ярихгүй бол болохгүй юм байна гэдгийг харж үзээд Төрийн албаны зөвлөлтэй хамтарч зарим тоо баримтуудыг шалгах шаардлага гарсан.

Бас мөн хэлэлцүүлгийн явцад бизнес мэдээллийн Bloomberg телевизээр Монгол Улсын алтны нөөц сүүлийн үед эрс нэмэгдлээ гэсэн ийм мэдээлэл гарсан. Анхаарч үзүүштэй зүйл нь юу байсан бэ гэхээр зэрэг Чингис бондыг оруулж ирснээс хойш энэ алтны үнэ урьд өмнө жилүүдэд байгаагүй хэмжээгээр нэмэгдсэн байсан. Алтны хэмжээ. Худалдаж авсан алтны хэмжээ. Энийг бас тодруулах шаардлага гарсан. Яагаад гэвэл бидний Ерөнхий сайдыг огцруулах үндэслэлийн нэг нь Чингис бондын зарцуулалттай холбоотой асуудал байсан. Чингис бонд угаасаа батлагдахдаа Улсын Их Хурлаас тодорхой зориулалтууд заасан байсан. Ийм ийм зориулалтаар энэ бондын мөнгийг ашиглана гэж. Алт авах тухай асуудал тэнд байхгүй. Тэгэхээр энэ их хэмжээний мөнгө орж ирсний дараа их хэмжээний алтны нөөц нэмэгдсэн байгаа нь шалгаж үзвэл зохих асуудал байна гэж үзээд нэг үндэслэлээ болгосон.

Гурав дахь нь мөн Ерөнхий сайдын асуудлыг хэлэлцэх явцад Эрдэнэс Тавантолгой компанийн үйл ажиллагаатай холбоотой нягталбал зохих зүйлүүд гарч ирсэн. Ялангуяа томоохон хэмжээний үйл ажиллагаа явуулах тендерт Ерөнхий сайдын ойрын хамаатан садны хүмүүсийн оролцоо байгаа тухай мэдээлэл ирсэн. Үүнийг мөн шалгаж үзэх шаардлага гарсан. Түүнээс биш Ардын намын бүлэг огцруулах үндэслэл нь мухардаад ирэхээр завсарлага авсан асуудал огт байхгүй.

Шалгалтын явцаар шалгалт судалж үзсэн. Боллоцооныхоо хэмжээнд ажилласан. Энэ талаар манай ажлын хэсгүүд ярих учраас би цөөхөн хэдэн зүйл хэлчихье гэж бодож байна. Төрийн албан хаагчдын тоо ихээхэн хэмжээгээр хэтэрсэн байгаа нь тодорхой болсон. Энэ талаар бид нар ярина. Бондын мөнгийг зориулалтын бусаар зарцуулж байгаа асуудал бас асуудал гарсан. Энд тодруулж хэлэхэд Монголбанк дээр Улсын Их Хурлын гишүүдийг очоод тодорхой асуудлуудтай танилцъя гэхэд танилцуулахгүй гэсэн. Их Хурлын гишүүн ямар асуудалтай танилцах ёстой. Нууцын асуудал байсан ч гарынхаа үсгийг зурж байгаад танилцах ёстой. Энэ дээр танилцуулахгүй гэсэн. Бид нар өөрсдийнхөө боломжийн хэмжээнд мөн материалаа олж аваад дүгнэлт хийсэн байгаа. Бондын мөнгийг буруу зарцуулж байна. Монголбанк Засгийн газрын хоорондын үйл ажиллагаа хэт сүжирсэн байдалтай байна гэсэн дүгнэлт хийж байгаа.

Тавантолгойтой холбоотой асуудлаар их ноцтой зүйлүүд илэрсэн. Энэ талаар бид нар их дэлгэрэнгүй ярина. Тавантолгойн тендерыг хойшлуулсан. Тэр хооронд компани байгуулсан. За дараа нь тэр компани нь тендерт ялсан. 17.0 тэрбум төгрөгийн тендерт ялсан. Тэр компанид нь Ерөнхий сайдын ойр дотнын хамаатан саднууд байдаг. Төрийн албан хаагчид хүртэл энд нь оролцсон байж болзошгүй тухай.../минут дуусав/

**3.Энхболд:** - Завсарлага дууссан эсэх талаараа үг хэлэх ёстой, Нямаагийн Энхболд гишүүн ээ. Одоо бол үг хэлэх гишүүдийг бүртгэнэ шүү дээ. Тэр үед ярьж болно наадахаа. Харин минут нь дуусчихаад байна л даа. Завсарлага дууссан юм байна. Тийм ээ. За одоо ингэнэ. Өмнөх хуралдаанаар

асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо үг хэлэх Улсын Их Хурлын гишүүдийг бүртгэнэ. Үг хэлэх гишүүд саналаа өгнө үү.

За тэгвэл хамгийн сүүлчийн. За юу ч гэсэн ингэе. Үг хэлэхийг би хаагаагүй байгаа. Н.Батцэрэг гишүүний асуултыг үргэлжлүүлээд дуусгаад. Хамгийн сүүлчийн гишүүн байсан асуулт асуух. Тэгээд тэр дээрээ завсарлага авсан байгаа. Ямар асуулт асуусныг одоо санаж байгаа гишүүд байна уу? Давтаж асуух уу? За Н.Батцэрэг гишүүн асуугаад. Үүнээс хойш үг хэлнэ. Н.Батцэрэг гишүүний микрофоныг нээчихье. Би хаагаагүй байгаа. Кнопоо чөлөөтэй дарж болно. Н.Батцэрэг гишүүн асуултаа асуучих.

**Н.Батцэрэг:** - Би 3 асуулт асуусан байсан юм. Эхний хоёр асуулт маань бол Ерөнхий сайдыг огцруулах тухай асуудал оруулж ирж байгаа Монгол Ардын Намын бүлгийн удирдлагуудаас асуусан байсан. Тэгэхээр тэр үедээ ерөнхийдөө бас хариулт авагдчихсан гээд. За тэр асуултаа авчихаад би ганцхан Ерөнхий сайд руу хаягласан асуултаа асууя.

Ерөнхий сайд Н.Алтанхуягийн тэргүүлсэн Засгийн газрыг бид нар шинэчлэлийн Засгийн газар гээд нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээнд томоохон шинэчлэл хийнэ гээд зорилт тавиад хэрэгжүүлж эхэлж байгаа гэсэн ийм ойлголттойгоор ажиллаж байгаа. Тэгэхдээ улс төрийн хүрээний шинэчлэл гэдэг дотор Ерөнхий сайд яг юу харж байгаа вэ? Та Улсын Их Хуралд одоо хамгийн олон суудал бүрдүүлээд Засгийн газар байгуулаад ажиллаж байгаа намын тэргүүний хувьд жишээ нь намуудын тухай хуулийн өөрчлөлтийг яаж харж байна.

Цаашид Үндсэн хуулийн нэмэлтийн тухай явбал аль хүрээнд, ямар хэмжээний нэмэлт байх ёстой гэж харж байгаа вэ? Тэгэхээр Засгийн газрынхаа улс төрийн шинэчлэлттэй холбоотой асуудлаар байр сууриа илэрхийлэхгүй юу гэж асууж байгаа юм.

**З.Энхболд:** - Ерөнхий сайд хариулъя, Н.Батцэрэг гишүүний асуултад.

**Н.Алтанхуяг:** - За Их Хурлын гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. Н.Батцэрэг гишүүн улс төрийн шинэчлэлийн асуудал, намуудын байдал, тэгээд цаашаагаа Үндсэн хуулийн асуудлыг хөндөж байгаа. Тэгэхээр ер нь Үндсэн хуулийн шинэчлэлийн асуудлыг бол нэлээн олон жил ярьж байгаа л даа. Би бол хувьдаа ямар байр суурьтай байдаг юм гэхээр яг болохгүй байгаа асуудлаа эхэлж гаргаж тавих нь зүйтэй юм. Миний харж байгаагаар Үндсэн хуульд зарим өөрчлөлт оруулах нь зүйтэй гэвэл зүйтэй. Тэгэхдээ асуудлаа бусадтайгаа бүгдээрээ энэ чинь их өндөр босготой шүү дээ. Нийлэх юм уу, үгүй юм уу гэдэг дээр би мэдэхгүй юм. Жишээлэх юм бол одоо энэ аймаг, орон нутгийн Засаг даргыг сонгож байгаа байдал, хот тосгоны тухай асуудлаар Үндсэн хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай юм. Иргэдийн эрхийг, иргэд өөрсдөө нэг Засаг даргаа сонгочихдог ийм байхгүй бол хэтэрхий намуудын тоглоом болж хувираад байгаа учраас энэ чиглэлээр өөрчлөлт оруулах нь зөв гэж үздэг.

Улс төрийн намуудын хувьд ч гэсэн бид нар бас ойлголцож чадах юм уу,

үгүй юу мэдэхгүй байгаа. Бас тодорхой өөрчлөлтүүдийг оруулах ёстой. Тухайлах юм бол энэ сүүлийн үед мөнгө төгрөг бас ихдэж байгаа учраас энэ улс төрийн намуудыг, улс төрийг энэ мөнгө төгрөгийн нөлөөллөөс жаахан ангид байлгах, багасгах чиглэлээр тодорхой ажлуудыг хийх ёстой. Энэ дээр Ардчилсан Нам бас санал санаачлага гаргаад улс төрийн намуудын санхүүжилтийг ил тод болгоё, хөрөнгө мөнгөний асуудлаар хөөцөлддөггүй болгоё гэсэн ийм байр сууриар ажлуулаад эхлүүлээд намуудтай хэлэлцүүлэг явуулж байгаа. Баярлалаа.

**3.Энхболд:** - За би үг хэлэх гишүүдийг хаагаагүй байгаа. Гишүүд сүүлд үг хэлэх гээд ингээд өрсөлдөөд орж гараад байна. Би одоо алх тогшино. Алх тогшиход хэний нэр хамгийн сүүлд орсон байна. Тэр хүнээр дуусна шүү. С.Эрдэнэ гишүүнийх байна. Би алх тогшлоо одоо.

Би дэлгэц дээр харагдахгүй байгааг уншаад өгье. Тэгэх үү. Дэлгэц дээр харагдахгүй байгаа нэрийг уншаад өгье. Ч.Хүрэлбаатар гишүүнээс хойш уншъя. А.Бакей, Ц.Нямдорж, Д.Ганхуяг, О.Содбилэг, Ц.Баярсайхан, Д.Лүндээжанцан, Ц.Оюунгэрэл, М.Сономпил, Н.Батбаяр, Ж.Батзандан, Д.Бат-Эрдэнэ, Ж.Энхбаяр, Р.Гончигдорж, М.Энхболд, О.Баасанхүү, Г.Баярсайхан, Я.Содбаатар, С.Бямбацогт, Ж.Эрдэнэбат, Ч.Сайханбилэг, Б.Бат-Эрдэнэ, Г.Батхүү, С.Эрдэнэ, С.Дэмбэрэл, Х.Тэмүүжин, Н.Номтойбаяр, Ө.Энхтүвшин. За алхаа тогшлоо. Ө.Энхтүвшин гишүүнээр хаагдлаа. С.Эрдэнэ гишүүн дээшилчихлээ л дээ сая. Би алх тогших үед л гэсэн шүү дээ. Одоо Дамдины Дэмбэрэл гишүүн үг хэлж эхэлнэ. 4 минут. Хугацаа өөр сонгохгүй. Та дахиж дарахгүй л бол алга болохгүй. Компьютерын зүгээс ямар ч үйлдэл хийгээгүй.

За Д.Дэмбэрэл гишүүн үгээ хэлье.

**Д.Дэмбэрэл:** - За энэ Ардын Намын бүлэг завсарлага аваад 3 асуудлыг тодруулсан л даа. Энэ 3 асуудлыг тодруулсан байдлаас ингээд харахад өчигдөр намын бүлэг дээр бид тодорхой ярьсан юм. Гурвууланд нь ч маш их эргэлзээтэй асуудлууд гарч ирсэн байна лээ. Энэнээс үзэхэд бас Ерөнхий сайдын энэ үйл ажиллагаанд бас дутагдлууд байгаа юм байна гэж би хувь гишүүний хувьд ойлгосон. Бодит байдал дээрээ Ерөнхий сайд хууль зөрчсөн шүү дээ. Юмны чинь бодит байдал нь гэж нэг юм байна шүү дээ. Үйлдэл нь нэг юм байна шүү дээ. Тэр үйлдлээрээ бол хууль зөрчсөн.

За эрх зүйн хувьд шийдвэр гаргах шатны асуудал дээр янз бүрийн баримт сэлт ярьж байгаад өнгөрч байгаа юм. Ард түмэн бол бид би хувьдаа ч гэлээ гэсэн. Таныг бол хууль зөрчдөг юм байна. Үндсэн хуулийг үл ойшоодог. Үндсэн хуульд заасан хууль дээдэлж ажиллах Үндсэн хуулийн зарчмыг гажуудуулж ажиллаж байгаа Ерөнхий сайд аа гэж би бол яг ний нуугүй хэлэхэд ингэж үзэж байна.

За энэ хууль дээдлэхгүй байгаа явдал нь бол өөрөө орон зайг нь юу эзлэх ёстой вэ гэхээр та бол дураараа авирладаг. За ер нь дураар авирлах явдал бол өөрөө цаашдаа юу харуулж байгаа юм бэ гэхээр улс төрийн дарангуйлал явах л нөхцөлийг бүрдүүлж өгдөг. Энэ улс төрийн дарангуйлал бол нийгмийн сэтгэл зүйд ноцтой нөлөөлж байгаа. Түүгээр ч барахгүй манай намын бүлгийн анхны

дүгнэлтэд орсон зүйл бий. Нийгмийг айдас хүйдэст автуулах ийм нөхцөл бололцоог бий болгож байна гэж. Энэ бол өргөн утгаараа яг ийм байгаа юм. Энэний хариуцлагыг хэн хүлээх ёстой вэ. Таны үйлдлүүдтэй ихээхэн холбоотой гэж би бол ингэж л үзэж байгаа хүн л дээ. Цөөнхийг үл ойшоохоос эхлээд ер нь энэ улс төрийн энэ дарангуйлалын шинж байдал чинь өөрөө яваа яваандаа. За манай олонхи анхаарч үзнэ биз дээ. Засахгүй юм бол өнөөдрийн Ерөнхий сайдыг огцруулахаас их ноцтой байдлууд дараа нь гарахыг үгүйсгэхгүй гэдгийг би энд зориуд тэмдэглэе.

За бондын тухай асуудлаар шалгасан дүнгээс харахад бас л Улсын Их Хурлын гаргасан тогтоол зөрчигдөж байгаа юм билээ. Тодорхой ашигтай төсөл хэрэгжүүлэх асуудалд энэ мөнгийг зарна, оруулаарай гээд бонд зөвшөөрөөд өгөхөөр авчраад арилжааны банкуудад тарааж өгчихөөд сууж байгаа. Арилжааны банк болон Монголбанк энэ мөнгийг юунд ашигласан байж болох вэ гэдгийг шалгаад үзэхэд үнэн хэрэг дээрээ алт худалдан авах ажиллагаанд орсон байхыг үгүйсгэх аргагүй тийм тооцоо гарсан байна лээ. Түүгээр ч барахгүй Монголбанкны Засгийн газартай энэ гэрээ байгуулж орсон энэ мөнгө бол цаанаа алтны үнэ өндөр байхад алт худалдаж авч, алтны үнэ буухад ихээхэн алдагдалд оруулж байгаа ноцтой үр дагаврыг бий болгож байгаа юм билээ шүү. Энэ байдлаас нь аваад үзэхэд ч гэлээ гэсэн аливаа хууль, тогтоол, шийдвэрийг зөрчиж эхэлнэ гэдэг бол муу үр дагавартай гэдгийг Ерөнхий сайд ойлгож байгаа байх гэж би бодож байна.

За мөн алттай холбоотойгоос гадна таны хувийн компанитай холбоотой асуудлууд чинь ноцтой ёс зүйн үр дагавартай гэж ойлгогдохоор ийм баримт материал бидэнд цугласан байгаа шүү гэдгийг зориуд энд тэмдэглээд хэлчихье. Хууль зөрчсөн үйл ажиллагааг Монгол оронд засахгүй юм бол энэ Монгол төр цаашдаа ардчилсан төр гэж өөрийгөө хэлэхэд хүнд болно гэдгийг бас Улсын Их Хурал өөрөө анхаарах ёстой. Гишүүд ч анхаарах ёстой. Ингэж асуудалд хандах ёстой гэж үзэж байна. Баярлалаа.

**3.Энхболд:** - С.Батболд гишүүн үгээ хэлнэ.

**С.Батболд:** - За Монголын Ардын Намын бүлэг 3 асуудлаар завсарлага аваад дүгнэлтээ намын бүлгийн дарга, за мөн одоо манай ажлын хэсгийн нөхдүүд нэлээн тодорхой хэлнэ л дээ.

Энд гарсан зөрчлүүдийг ярихын зэрэгцээ бас өмнө нь тавигдсан үндэслэлүүд бол хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлууд тавигдсан байгаа. Би бас Ерөнхий сайдын ажлыг хийж байсан л даа. Ерөөсөө сөрөг хүчнээс Сонгуулийн хороо ажлаа хийхгүй байхад л Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хууль хэрэгжүүлэх ажлыг Ерөнхий сайд хариуцдаг юмаа, та үүнийхээ төлөө хариуцлага хүлээх ёстой гээд надад асуудлыг тавьж байсан л даа. Тэгэхээр бүхэлдээ бол энэ хууль хэрэгжүүлэх асуудал бол Ерөнхий сайд дээр гарцаагүй одоо хариуцагдаж байдаг ажил. Тэгэхээр энэ зүйл дээр бидний эхний тавьсан үндэслэлүүдээр бас зөрчилтэй зүйлүүд байгаа гэдгийг дахин тэмдэглэж хэлэх нь зүйтэй гэж бодож байгаа юм. Нэгдүгээрх нь.

Ер нь энэ яригдаад байгаа асуудлууд би бүхэлдээ ямар зүйлүүдээс болоод ингээд гараад байна гэж үзэхээр энд бас гажуудал байна гэж хараад байгаа юм.

Бидний үед Засгийн газар бол шүүмжлэлд их өртдөг байсан л даа. Гэхдээ ямар зүйл маш нээлттэй байсан гэхээр ямар ч байсан хоёр улс төрийн хүчин бол бие биеэндээ хяналт тавьж үйл ажиллагаагаа явуулдаг байсан. Иргэний нийгэм бол маш идэвхтэй байсан. Одоо бол би сонсохгүй байгаа. Иргэний нийгэм илүү оролцоотой байсан. Хяналт тавьдаг байсан. Мөн оролцоог бид хангаж өгдөг байсан. Тэр бүх зөвлөлүүдээр нь. Гэтэл одоо бол энэ явж байгаа үйл ажиллагаан дээр бол нэг тал руугаа, нэг нам руугаа ийм хяналт, нээлттэй байдал алдагдсан ийм гажуудал гарч байна л даа. Тэрний үр дагавараар л энэ ажлын хэсгүүд гараад бас алдаа онооны тухай асуудал гарч ирээд ингээд яригдаж байна шүү дээ.

Тэгэхээр бүхэлдээ өөрөө энэ тогтолцоо маань хяналттай байх ёстой юм. Нээлттэй байх ёстой юм. Үүнийг төр засаг нь хангаж өгөх ёстой юм. Үүнийг нь сөрөг хүчин шаардаж байх ёстой юм. Иргэний нийгэм нь өөрөө идэвхтэй оролцож байх ёстой юм гэдэг энэ зарчим, энэ төлөвшлийг, ардчиллын төлөвшлийг бид нар өөрсдөө яриад ингээд шаардаад яваад ирсэн шүү дээ. Энэ процесс маань өөрөө харамсалтай нь зогсонги байдалд юм уу, ойлгомжгүй байдалд орсон байна гэж гарч байгаа юм. Тийм учраас энэ алдаа нь одоо ийм хурдан гарч ирж байна.

Бүтээн байгуулалтын ажлуудыг ярих ёстой гэж ярьж байгаа. Үнэхээрийн ярих ёстой ажил. Энийг бид нар бүр хамгийн түрүүн ярих ёстой. Гэхдээ яг хаанаас нь юу ярих вэ гэхээр бидэнд одоо дахиад л нөгөө нээлттэй байдлын үүднээсээ ч тэр бидэнд мэдээлэл бас алга байна л даа. Тэгээд одоо ямар сайндаа Bloomberg-ийн мэдээллээр алтны хэмжээ одоо нэмэгдсэн байна, Монголбанк одоо төсвийн гадуур Засгийн газрын агентлагийн түвшинд ажиллаж байгаа юм шиг. Одоо төсвийн гадуур дахин төсөв бий болгож хэдэн зуун тэрбумаар нь мөнгө гаргаж байна гэсэн энэ зүйл маань.

За мөн одоо өмнө нь Хөгжлийн банкинд бид нар тодорхой хэмжээний санхүүжилт хийгээд л үлдээсэн шүү дээ. 570.0 гаруй сая доллар. Энэний зарцуулалт маань ямар байдалтай явсан юм. Одоо 1.5 тэрбумын зарцуулалт, хяналт нь ямар байдалтай явах юм. Энэ бүх зүйлүүд маань ойлгомжгүй, нээлттэй бус. Яг үнэндээ хяналт байгаа, нээлттэй гэж хэлж байгаа боловч ямар механизмаар хянагдах юм, хяналт нь тавигдах юм гэдэг нь ч ойлгомжгүй байж байгаа. Тийм учраас энэ асуудлууд нь цаашдаа өнөөдөр яригдаж байгаа асуудлаас илүү том асуудлууд болоод, илүү улс оронд хохиролтой ийм зүйл битгий болоосой гэж ингэж үзэж байгаа юм.

Тийм учраас цаашдаа бол энэ байдал дээр дүгнэлттэй байх ёстой. Бид дүгнэлт хийх ёстой. Хяналтыг гаргаж тавих ёстой. Маш ил тод ийм нээлттэй хяналтын механизм байлгах ёстой. Тэгж байж энэ том төслүүдийн ажлуудаа явуулах ёстой гэж үзэж байгаа юм. Том төслүүдийн ажлыг бид нар дэмжиж байгаа шүү дээ. Өмнөх засгийн үед бол удсан гэж ярьж байгаа. Гэхдээ энэ



удсандаа гол нь биш. Бид нар энэ асуудлыг шийдвэрлэх гэж Улсын Их Хурлаар харин томоохон шийдвэрүүдийг амжилттай гаргуулж чадсан нь нэг том амжилт. 7, 8 жилээр гацсан байсан төслүүдийг хөдөлгөж эхэлсэн. Санхүүжилтийг нь бид нар хавар 4 сард эхний санхүүжилтийн мөнгийг дөнгөж одоо Хөгжлийн банкаар 570.0 сая долларыг нь босгож ирсэн шүү дээ. Тэрний өмнө бидэнд тэр санхүүжилтийг нь хийх боломж байгаагүй. Бид нар хуулиар хамгийн түрүүн Хүний хөгжлийн сангийн мөнгөө л хийх ёстой байсан.

Тэгэхээр энэ ажлыг бид нар явуулахыг нь бүх талаар нь дэмжиж байгаа юм. Энэ санхүүжилт нь, энэ үйл ажиллагаа нь нээлттэй явах ёстой гэж бодоод байгаа юм. Тэгэхээр энийг ярьж гээд байдаг. Яг ярьж гэхээр юу ярих вэ, ямар хэлбэрээр ярих вэ, ямар механизмаар оролцох вэ, хяналт тавигдах вэ гэдэг зүйлүүд маань маш ойлгомжгүй байгаа учраас энэ гарч байгаа, өнөөдрийн яригдаж байгаа энэ алдаануудыг эртхэн сэрэмжилж, зохих арга хэмжээнүүд нь авагдаад цаашдаа бидний хувьд, улс орны хувьд маш ойлгомжтой явах нь нийтлэг эрх ашиг шаардсан зүйл юм гэж хэлмээр байна.

**3.Энхболд:** - Д.Оюунхорол гишүүн үг хэлнэ.

**Д.Оюунхорол:** - За ингээд манай бүлгээс бас энэ завсарлага авсан хугацаанд ажлын хэсгүүд байгуулагдаж ажилласан. Бид бол Төрийн албаны зөвлөл дээр одоо очиж ажил байдалтай нь танилцаж бодитой мэдээллүүдийг гаргуулж авахаар ажилласан.

Ингээд Төрийн албаны зөвлөл дээр одоо бид нэлээн хэдэн зүйлийг одоо гаргаж өгөөчээ гэж шаардсан. За бидний тавьсан асуудлуудад тодорхой байдлаар асуудалд хариулт гаргаж өгч чадаагүй. За энэ асуудалтай тэр хүмүүс ямар хариулт хийж байгаа вэ гэвэл одоогийн байдлаар бид аймаг, орон нутгаас төрийн албатай холбоотой тодорхой мэдээллүүдийг авч гүйцэж чадаагүй байна. 2013 оны байдлаар шинэ мэдээллийг өгөх боломжгүй байна. Яг өнөөдрийн байдлаар Төрийн албаны зөвлөл зөвхөн яамдын агентлагуудын түвшинд одоогийн байгаа тоо, судалгаануудыг гаргаж өгсөн нь харамсалтай байсан. Аймаг, нийслэл, дүүргүүдийн төрийн албан хаагчдын халагдсан болон гарсан орсон орон тооны тухай асуудлаар мэдээлэл өгч чадаагүй. За ийм байдалтай байгаа. За үргэлжлүүлж бид нар материалаа гаргаж авна гэж бодож байгаа.

Төрийн албаны зөвлөлөөс гаргаж өгсөн мэдээллээс харахад зөвхөн төрийн захиргааны байгууллага, яам, албан хаагчдын тооцооноос харахад өнөөдөр байдал бол одоо манай Ерөнхий сайдын ярьж байснаас нэлээн өөр тоо байгаа. Тэгэхээр энэ тоонуудыг бас зарим нэгийг нь би танилцуулъя гэж бодож байна. Жишээлбэл, 2008-2012 онд 11 яаманд 871 төрийн албан хаагч ажиллаж байсан бол 2012-2016 онд 16 яам болж 1663 хүн ажиллах ёстой гэж Монгол Улсын Их Хурлаас баталсан бүтцийн дагуу Засгийн газраас орон тоогоо баталсан юм байна. Гэтэл өнөөдрийн байдлаар 1707 хүн төрийн албанд ажиллаж байна гэсэн ийм тоо судалгааг Төрийн албаны зөвлөлөөс гаргаж өгсөн.

Мөн 2008-2012 онд газар, хэлтэс, яамдын жишээлбэл 102 байсан бол 2012-2016 онд бол 183 болж 81 хүнээр буюу 80 хувиар нэмэгдсэн байна. Энэ

бол өнөөдөр бидний хэлдэгээр хурган дарга нарын маань тоо 80 хувиар нэмэгджээ. Төсвөөс цалин авдаг хүмүүсийн тоо нэмэгдэж байна. Хүнд суртал нэмэгдэж байна. Төрийн албыг чадварлаг, цомхон болгох асуудал маань бүтэл муутай явж байна. Нөгөө талаас гэвэл улс төрчид бидний байнга ярьдаг төрийн албыг улс төрөөс ангид байлгая, мерит зарчимд үндэслэн томилох тухай одоо байнга бид нар ярьсан. Гэтэл энэ зарчмаасаа ухарч төрийн албаны шинэтгэл хийх энэ асуудалтай олигтой дорвитой өөрчлөлт хийж чадахгүй, төрийн албыг танилын, ах дүүсэг, намчирхсан байдлаар нэлээн их өөрчлөлтүүдийг хийсэн байна гэдэг нь Төрийн албаны зөвлөлөөс гаргаж өгсөн тооцоо судалгаагаар харагдаж байгаа юм.

Бидний ажлын хэсгийнхэн маань бас одоо Төрийн албаны зөвлөлийн тайланг уншиж танилцсан. Ер нь энэ асуудалд манай нөхдүүд яаж хандсан юм бэ гээд. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 410 тоот албан бичгээр ирүүлсэн танилцуулга, мэдээ материалаас гадна одоогийн байдлаар ийм асуудлуудыг шийдэж чадахгүй байгаад нийгэмд их бухимдалтай байдаг юм байна. Жишээлбэл, их дээд сургуулиудын захирлуудын томилгоо одоо болтол шийдэгдэж чадаагүй түр орлон гүйцэтгэгч гэдэг албан тушаал дээр хүмүүсийг тавиад ажиллуулж байна. Эрүүл мэндийн салбар дээр мөн бас одоо түр орлон гүйцэтгэгч гэж эмнэлгийн дарга нарыг ажиллуулж байна. Энэ бол өнөөдөр эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааг доголдолтой ажиллах нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзэж байна. За дараа нь мөн бас одоо төрийн албаны түр орлон гүйцэтгэгч нэртэй үйлдвэр аж ахуйн газар нэртэй байгууллагуудыг шинээр олноор байгуулсан юм байна. Төв гэж нэртэй байгууллагуудыг олноор байгуулсан байна. Тэнд одоо төрийн албан хаагчдыг маш олноор төрөөс цалин авдаг ийм албан хаагчид олноор нэмэгдсэн байна. Энэ тоонуудыг нийт дүнгээр нь авч үзэх юм бол төрийн албан хаагчдын орон тоо ойролцоогоор 7 мянга орчим тоогоор нэмэгдсэн байх боломж байна гэж бид үзэж байгаа юм. Халагдсан хүмүүсийн орон тоо, нэмэгдсэн хүмүүсийн орон тоо хоёрыг хооронд гүйлгэхдээ зөвхөн төв байгуулсан тэр байгууллага руугаа шилжүүлж байгаа нь төрийн албаны орон тоог цөөрүүлсэн биш нэмэгдсэн гэдэг үндэслэлүүд гарч ирж байна. Тийм учраас одоо Ерөнхий сайд энэ асуудлуудад нэлээн бодитой дүгнэлт хийж төрийн албыг цаашдаа ингэж их данхайлгаж орон тоогоо нэмэх ийм зарчмаар явах юм уу, үгүй юу гэдэг асуудал манай намын бүлгийн ажлын хэсгээс хийж байгаа дүгнэлтэд нэлээн дорвитой дүгнэлтийг хийх шаардлага гарсан байна гэдэг нь бол энэ удаагийн шалгалтын дүнгээс харагдаж байгаа юм. Тийм учраас энэ асуудлуудыг илүү гүнзгийрүүлж лавшран мэдээллээ гаргуулж авна. Төрийн албаны зөвлөл бол маш бодитой гаргаж өгөх ёстой тооцоо, судалгаа, мэдээллүүдийг ийм богино хугацаанд гаргаж өгч чадахгүй байна гэдэг... /минут дуусав/

**3.Энхболд:** - Нямаагийн Энхболд гишүүн үг хэлнэ.

**Н.Энхболд:** - За баярлалаа. Ажлын хэсэг гараад 3 газар манайх шалгалт хийсэн. Яг ажлын хэсэг орсон хүмүүс мэдээ материалуудаа их нарийн танилцуулна. Тийм учраас би ерөнхий хэдэн зүйл хэлье.

Ардын Намын бүлгээс Ерөнхий сайдыг хууль зөрчсөнийх нь төлөө

огцруулах шаардлагатай гэж үзээд асуудлыг Улсын Их Хуралд тавьсан. Энэ асуудлыг хэлэлцэх явцад зайлшгүй тодруулах шаардлагатай хэд хэдэн ноцтой мэдээ мэдээлэл, баримтууд орж ирсэн. Яг бидний ярьж байгаа асуудалтай уялдаатай. Түүнээс бид нар нэг асуудал тавьчихаад огт өөр асуудлаар одоо зарим хүний хэвлэл мэдээллээр яриад байгаа шиг үндэслэл нь буруу байсан болохоор завсарлага авсан хэрэг огт биш ээ гэдгийг бүр албан ёсоор хэлэх хэрэгтэй байна. Ингэж ажлын хэсэг байгуулж зарим зүйлүүдийг нягталж шалгаж үзсэний үр дүнд үнэхээр бид нарын тавьж байсан асуудал зөв, хууль зөрчсөн. Үндсэн хууль, бусад хууль, Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль, Авлигалын тухай хууль, энэ зүйлүүдийг зөрчсөн нь нотлогдохоор ийм баримт материалууд гарч ирсэн.

Энэ үүдний танхимд бид нар бас материалынхаа зарим хэсгийг тавьсан байгаа. Улсын Их Хурлын гишүүдийг очиж бас тэрэнтэй танилцахыг хүсэж байна. Шийдвэрээ гаргахаас өмнө. Яагаад гэвэл Монгол Улсын Ерөнхий сайд байтугай аль ч хүн зөрчиж болохгүй олон хуулийг зөрчсөн. Энэ хуулийг хуулийн хэрэгжилтүүдийг зохион байгуулж чадаагүй ийм баримт материалууд илрээд байна. Засгийн газар байгуулагдаад 8-хан сар болж байна гээд зарим хүн яриад байх юм. Тийм учраас огцруулах асуудал тавьж болохгүй, Ерөнхий сайдын асуудал ярьж болохгүй гэсэн утга цаана нь байх шиг байна л даа. Нэг өдөр ч гэсэн хууль зөрчвөл тэгээд тэр асуудлыг бид нар чинь ярьж л таараа шүү дээ. Уг нь бол ганц сөрөг хүчний ч хийх ёстой ажил биш л дээ. Улсын Их Хурлын бүх гишүүд энэ асуудлыг тавих эрхтэй, үүрэгтэй. Харамсалтай нь олонхийн маань дотроос энэ асуудлыг нэг ч тавихгүй байна. Тийм учраас бид манай намын бүлгийн гишүүд энэ асуудлыг тавьсан юм. 8 сарын хугацаан дотор хууль зөрчиж болно. 8 сараас цааш бол яах вэ зөрчсөн байвал хэлэлцэж болно гэсэн асуудал байхгүй шүү дээ.

Монголбанктай холбоотой асуудал байна. Тоо баримт юм нь дэлгэрэнгүй байх. Ер нь зарчмын хувьд бол Засгийн газар, Монголбанк хоёр тусдаа тусдаа үүрэгтэй, улсын юм нь тусдаа тусдаа хариуцлага хүлээдэг ийм байгууллагууд. Гэтэл сүүлийн үед Засгийн газар, Монголбанкны хооронд явагдаж байгаа үйл ажиллагаа, харилцаа, за тэр санамж бичгүүд энэ тэр бол үндсэндээ Монголбанкны биеэ даасан урт хугацааны бодлого тодорхойлох нөхцөл болзлыг нь алдагдуулсан ийм үйл ажиллагаа явагдаж байна. Манай намын бүлэгт энэ туссан байгаа.

Монголбанк бол Засгийн газрын хий гэсэн зүйлийг нь дуртай цагт нь хийж өгөөд явж байдаг ийм байгууллага огт биш. Монголбанкны Засгийн газартай хэт сүжирч байгаа энэ үйл ажиллагаанаас болоод урт хугацаанд засаж залруулахад хэцүү ийм нөхцөл байдал улс орны санхүү, нийгэм, эдийн засгийн байдалд үүсдэг.

Үнийг тогтворжуулах талаар хийсэн томоохон санамж бичиг энд зориулж зарцуулсан. Ихээхэн хэмжээний мөнгөний үр дүн харагдахгүй байна. Энэ бол энэ хоёрын өнөөдөр явж байгаа харилцаа бол буруу байгаа гэдгийг харуулж байгаа. Өөрөөр хэлбэл цаагуур нь дахиад Монголбанкны тухай хууль, Засгийн газар Монголбанкны хоорондын харилцааны тухай хууль тогтоомжууд

зөрчигдөж байна гэсэн үг.

Хамгийн ноцтой нь тэр ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой хэсэг байна. Энэ дээр дахиад энэ асуудлыг шалгаж байх явцад Улсын бүртгэлийн ерөнхий газрын ажилтнууд хэн нэгний заавар, дохиогоор төрийн албан баримт бичиг, мэдээ мэдээллийг хуурамчаар үйлдэж өөрчилсөн явдал байгаа. Бид нар бол энэ асуудлуудыг зөвхөн энэ Ерөнхий сайдыг огцруулах асуудалтай холбож тавиад орхихгүй. Авлигатай тэмцэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсын Ерөнхийлөгчид манай бүлгийн гишүүд хандсан байгаа. Албан бичгээ, холбогдох материалуудтай нь явуулсан. Энэ хууль зөрчиж байгаа үйлдлүүдээ шалгаачээ. Шалгаад олон нийтэд мэдээлээчээ. Манайд эргээд мэдээлээчээ. Энэ бүхний дээр Монгол Улсын Ерөнхий сайд байж байгаа. Монгол Улсын хэмжээнд хууль тогтоомжийг нэгдсэн журмаар биелүүлүүлэх, сахиулах, өөрөө сахих үүрэгтэй. Энэ бүгд зөрчигдөөд байгаа учраас л манай бүлэг энэ асуудлыг тавьж байгаа. 8 хоносон ч тавина.

**3.Энхболд:** - Мэндчилгээ дэвшүүлье. Боловсрол, шинжлэх ухааны яамны харъяа Шинэ эхлэл олон улсын лаборатори дунд сургуулийн 10 дугаар ангийн сурагчид, багш нар нийт 50 хүн Төрийн ордон, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Та бүхний хичээл сурлага, ажил хөдөлмөрт өндөр амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Ц.Цолмон гишүүн үг хэлнэ.

**Ц.Цолмон:** - За баярлалаа. Тэгэхээр Ерөнхий сайдыг огцруулах асуудлаар 6 үндэслэлээр асуудал тавьсан байгаа. Тэгээд одоо энэ 6 үндэслэлийн би 5 дээр нь санал нэг, ярьж болох зүйлүүд байгаа юм. Бас нэг зүйл дээр санал нийлэхгүй байгаа. Тэрийг дараа ярья.

Тэгэхээр Үндсэн хууль зөрчсөн. Гол асуудал боловсон хүчний асуудал л даа. Урдах намууд маань Монгол төрийг ганцхан намын боловсон хүчнээр авч явна гэж тийм бодлого, одоо буруу бодлого барьж олон жил явсан. Гэтэл Ардчилсан Нам маань гарч ирээд энийг засахын орон бас одоо нөгөө замаар нь яваад. Ер нь л Монгол төрийг ганцхан намын боловсон хүчнээр авч явах бололтой. Тийм одоо инерцид автагдсан ч гэх юм уу даа бодлого явж байгаа. Тэрийг бид нар шүүмжлэлтэй хандаж байгаа. Ард түмэн ч гэсэн шүүмжилж байгаа гэдгийг мэдэж байгаа. Тэгээд хууль зөрчсөн зарим зүйлийг бол уг нь Ерөнхий сайдын өмнө бол Хууль зүйн сайд хариуцах ёстой. Тэгэхээр энэ асуудлаар жишээлбэл Засгийн газар дээр ярилцаад Хууль зүйн сайд юм уу, одоо хуулийн албаныхантайгаа хариуцлага тооцсон барьсан, эсвэл тооцох гэж байгаа тийм мэдээлэл бол одоохондоо байхгүй байгаа.

Тэгэхээр Монгол бол үнэхээр боловсон хүчний нөөц багатай, цөөн хүн амтай улс. Тийм учраас улс төрийн намууд бол хэн нь ч яллаа гэсэн зөвхөн өөрийн намын улсуудаар ажил хийлгэнэ. Бусдыг нь ажлаас хална гээд явж байгаа нь үнэхээр буруу байгаа юм.

Одоо энэ танхимд сууж байгаа бид нар бол Монголын улс төрийн шигшээ

баг. Тэгээд олон улсын тэмцээнд ороход нэг намын л баг явуулж байгаатай. Одоо жишээлбэл биеийн тамираар зүйрлэж хэлэх юм бол нэг олон улсын тэмцээнд л одоо нэг аймгийн баг явуулаад байдаг. Тэгээд ямар амжилтанд хүрэх юм билээ. Яг л тийм бодлого явж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр бол аль аль нам нь дүгнэлт хийгээд боловсон хүчнийхээ хүч чадвар, нөөцийг нэгтгээд тодорхой тодорхой асуудал дээр сөрөг хүчний ч бай хүмүүсийг тавиад. Тэр нь гол нь төрийн шалгуур, төрийн ажлын чадвар, шалгуур энэ талаас нь харж ажиллъя гэдгийг одоо энэ асуудал хөндөж байгаатай холбогдуулж бас нэг шинэ тийм хандлага төрийн албанд оруулж ирэх ёстой. Энэ дээр олон хүн санал нийлэх байх гэж ингэж бодож байна.

За бусад асуудал бол яриад байвал бас ярьж болохоор асуудал байгаа. Тэгэхээр би бол өөр нэг. Одоо энэ үндэслэлийн 5 дугаар зүйлийг жаахан дэлгэрүүлж ярьж гэж бодож байна. 5 дугаар зүйл дээр болохоор товчоор хэлэх юм бол Ерөнхий сайд хоёр хөрштэй харилцах асуудал дээр одоо хайнга хандсан, болгоомжгүй үг хэрэглэсэн гэсэн үндэслэл байгаа л даа. Тэгэхээр зүгээр ер нь одоо энэ шинэчлэлийн Засгийн газар 9 сар болохдоо хойд урд хөрштэйгээ томоохон төсөл эхлүүлж чадсангүй, томоохон асуудал шийдэж чадсангүй гээд шүүмжилвэл шүүмжлэлтэй зүйл байгаа. За ОХУ-д гэхэд удахгүй Ерөнхий сайд айлчлах гэж байгаа. Тэгэхээр энэ төмөр замын гүнзгий шинэчлэл, за бусад энэ уул уурхай, дэд бүтцийн олон асуудал дээр хоёр хөрштэйгээ харьцаж байгаа дээр шүүмжлээд байвал шүүмжлэх зүйл байгаа. Энэ дээр бол Ерөнхий сайд, Засгийн газар бол бас анхаарах ёстой байх гэж бодож байна.

Гэтэл ийм асуудлаар жишээлбэл одоо хөрш хөрштэйгээ муу харьцлаа, хоёр хөрштэйгээ харьцаж чадсангүй гэдэг асуудлаар Монголчууд бие биенийгээ шийтгээд, бие биенийгээ огцруулаад эхлэх юм бол энэ бол зөвхөн Ерөнхий сайдын асуудал биш бүр Ерөнхий сайдаас давсан Монгол төрийн хувь заяаны асуудал юм.

Өнөөдөр бид нар одоо Н.Алтанхуяг гэдэг хүнийг хоёр хөрштэйгээ муу харьцлаа гээд огцруулж болно. Дараа нь нэг Ерөнхий сайдыг энэ нөхөр ерөөсөө хоёр хөрштэйгээ хэтэрхий сайн харьцаад байна гээд багц огцруулах уу. Эсвэл одоо гурав дахь дөрөв дэх хөрштэйгээ тэгж харьцлаа гээд. Тэгэхээр энэ нөгөө сайхан. Сайхан ч юу байх вэ 5 асуудлыгаа энэ 5 дугаар зүйл нь бол унагачихаж байгаа юм. Ийм байдлаар гадаадын ямар нэгэн улс оронтой сайн муу харьцсан гэдэг үндэслэлээр ямар нэгэн Ерөнхий сайдыг шийтгэж юм уу, одоо зэмлэж. За зэмлэж болно. Шийтгэж болохгүй. Яллаж болохгүй. Тэгэхээр энд бол гашуун туршлага байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг бол ингээд Улсын Их Хурлаар за одоо Н.Алтанхуяг гэдэг хүн Орос, Хятадтай сайн юм уу, муу юм уу. Сайн ажиллаж байгаа юм уу, муу ажиллаж байгаа юм уу гээд. Тэгээд огцруулна, шийтгэнэ гээд ингээд ярих нь бол үнэхээр... /минут дуусав/

**3.Энхболд:** - Ё.Отгонбаяр гишүүн үгээ хэлнэ.

**Ё.Отгонбаяр:** - Энэ асуудлыг хэлэлцэж эхэлснээс хойш янз янзын л юм

дуулдаж байна даа. Санаа зовмоор ч юм сонсогдож байна даа. Цэцийн хурал болохоос нэг өдрийн өмнө журмаа өөрчлөөд хүчингүй болгоод хаячихдаг юм байна.

Асуудал нь хэлэлцэгдэхээс нэг өдрийн өмнө тендерийг нь хүчингүй болгоод тавьчихдаг юм байна. Тэгээд энэ бол баригдахгүй бол хулгайч биш гэдэг ийм жишиг Монгол төр тогтоож байгаа юм болов уу гэж санаа зовж байна.

Байнгын хорооны хурал дээр баахан телевиз хаачихаад байна гэсэн чинь Засгийн газар мэдэхгүй гэдэг хариулт өгдөг юм байна. Тэр Мэдээлэл харилцаа холбооны зохицуулах газар гэдэг нь Засгийн газартаа харъяалагддаггүй юм байна.

Мэдээгүй байхад нь хамаатанд нь 17.0 тэрбум төгрөгийн тендер өгчихсөн явдал гарч байна. Одоо мэдээгүй байхад нь байхдаа бодвол. Тэр одоо дүүгийнх нь авгайг өөр авгайгаар солиод тавьчихлаа. Мэдээгүй л байгаа байх. Энэ бүхэн энэ одоо ажлаа хийж чадаж байгаа юм уу. Ерөнхий сайд ажлаа хийж чадаж байгаа юм уу гэдэг асуудлыг тавихаас өөр замгүй юм байна. Сөрөг хүчин энэ асуудлыг тавих нь ер нь зөв юм байна гэж ингэж бодоход хүргэж байгаа юм. Бид иймэрхүү байдлаар асуудал тавьж алдаа дутагдлыг 1, 2-оор нь засаж залруулаад явах биш цаашдаа энэ асуудлаа дотроо яриад заавал огцрох барих дээрээ хүрэлгүйгээр сөрөг хүчнийхээ шүүмжлэлийг сонсоод алдаа оноо байвал засаад явж байх нь зөв байна.

Энэ төрийн албан хаагчдын асуудлыг сая Д.Оюунхорол гишүүн бодитой баримттай, тоотой ярьж байна л даа. За яах вэ энэ дээр халаагүй, солиогүй, халсан сольсон гээд хоорондоо маргалдах нэг хэрэг. Газар дээрээ халагдсан солигдсон улсууд нь бүгдээрээ энэ хуралдааныг сонсоод сууж байгаа байх. 1996 онд анх ийм юм болсон. 2000 онд энэ үргэлжилсэн. 2004, 2008 онд харьцангуй гайгүй тогтворжиж байсан. Энэ хооронд төрийн албан хаагчдыг намын харъяаллаас нь түдгэлзүүлсэн энэ хуулиа бид баталсан. Одоо адуу мал шиг угшил гэдэг юмаар ангилж ялгадаг болж байна. Ингээд төр засаг солигдох болгонд бужигнуулдаг энэ жишиг чинь улсыг хүчгүйдүүлэх энэ том процесс яваад байна шүү. Урт удаан хугацаанд аль нэг намын эрх ашиг гэхээсээ энэ улс орны чинь эрх ашигт сөрөг үр дагавар авчирч байна шүү гэдгийг бид аль аль талдаа дүгнэхгүй бол болохгүй байх гэж бодож байна.

Тэр гадаад харилцааны асуудал хөндөгдөж байна л даа. Бид ер нь хөрш улсууд маань өчнөөн олон жилээр бодлогоо тодорхойлдог улсууд гэдгийг бодох ёстой. Эртээд энэ 1 сард байх, Элчин сайд нарын зөвлөгөөн дээр Ерөнхий сайд үг хэлж байхдаа уламжлал гэдэг үгээ одоо орхио гэж хэлж байдаг юм. Гадаад бодлого уламжлалаар явах ёстой. Засаг солигдох болгонд гадаад бодлого солигддог байх юм бол энэ хөрш улсууд бидэнтэй харилцаж байгаа найрамдалт харилцаатай улсууд бидэнд итгэхээ болино.

Эдийн засагт итгэх итгэл муудаад байна шүү дээ гээд баримттай ярихаар зэрэг чуулган дээр Ерөнхий сайд уул уурхайг шүтэж амьдармааргүй байна гээд ингэж хариулж байна лээ. Эдийн засгийн өсөлт энэ салбараас гарч байгаа. Энэ

өсөлтийг харин бид нар бусад салбар луу зөв чиглүүлэх бодлогоо барих ёстой болохоос биш өсөлт гарч байгаа салбарынхаа хүзүүг нь хуга мушгичихаад сууж байхыгаа энэ бол болж байна гэж ингэж үзэж болохгүй байх гэж бодож байна.

Тэгээд яах вэ ерөнхийдөө хоорондоо ингэж яриад халаагүй халсан, эдийн засаг өссөн өсөөгүй гээд Ерөнхийлөгчийн хэлдэгээр гөлдийлдсээр байгаа нэгийгээ аваад үлдэж болох л байх л даа. Түүрүүн С.Баярцогт даргыг тэгээд гөлдийж байгаад аваад өнгөрлөө. Одоо Ерөнхий сайдыг гөлдийж байгаад аваад өнгөрөх байх. Зүгээр энэний цаад талд нь бид нар ёс зүйгээ бодох, энэ улсынхаа хөгжлийн асуудлыг бодох асуудал маань үлдчихээд байгаа нь харамсалтай байна гэдгийг зориуд хэлье гэж ингэж бодсон юм.

Боловсролын шинэ стандартад шилжих ажил удааширч байна гэж багш нар шүүмжилж байна. Өнгөрсөн оны 8 сараас хойш сургалт явуулаагүй гээд хөдөө орон нутагт явж байхад багш нар ярьж байна. Энэ аливаа нэг намын асуудал биш ээ. Та бидний хамтарсан Засгийн газрын үед гарсан асуудал. Явж өгөхгүй байна. Их сургуулийн хотхоны нэг хэдэн төгрөг байсныг төсөв дээр хасаад хаячихсан. Хятадын Засгийн газартай санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурсан. Энүүгээр урагшаа явахгүй байна. Өнөөдөр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн удирдлагын түр томилогдсон гэж байгаа боловсон хүчин чинь их сургуулийн хотхонд очихгүй Баянголын хөндийд очино ухааны юм яриад явж байна. Энэ одоо удирдлагуудаа томилоод. Ерөнхий сайд та өөрөө их сургуулийн хотхоны ажлын хэсгийн ахлагч шүү дээ. Тэр журам нь өөрчлөгдөөгүй байх. Энийгээ бас эрчимжүүлэх асуудал дээр Засгийн газар анхаарлаа хандуулмаар байна.

Тэгээд яах вэ одоо энэ огцрох асуудлыг бид өргөн барьж байгаа учраас бид эсрэг санал, огцруулахын төлөө санал өгнө байх. Энийг бол том сануулга гэж Засгийн газар, Ерөнхий сайд хүлээж аваасай гэж ингэж бодож байна.

**3.Энхболд:** - А.Тлейхан гишүүн үг хэлнэ.

**А.Тлейхан:** - За баярлалаа. Төрийн албанаас гаргасан 2012 оны жилийн эцсийн байдлаар албан хаагчийн бүрэлдэхүүний мэдээг судлаад үзэхэд 2012 онд 25 мянга 170 албан хаагч хөдөлгөөнд орсон байна гэж дүгнэжээ. Эдгээрээс 4887 хүн өөрийн хүсэлтээр халагдсан. 5361 хүн өөр ажилд шилжсэн ийм мэдээ гарсан байна.

2008 оны сонгуулийн сонгуулийн жилд халагдсан хөдөлгөөнийг 2012 онтой харьцуулахад шал өөр тоо гарч байна л даа. 2008 онд хөдөлгөөн 5.6 хувь байсан бол 2012 онд төрийн албан хаагчдын хөдөлгөөн 9.2 хувь болж эрс өөр олон хүн өөрчлөгдсөн тоо мэдээ гарч байна. Өөрөөр хэлэх юм бол 7 мянга орчим хүн, албан хаагч одоо хоморголон халсан гэдэг энэ тоо баримтаас нотлогдож байна.

Ерөнхий сайд хэлж байсан. Хэнийг би халсан юм бэ. Нэг ч хүн халаагүй шүү. Нэг ч хүн халсан бол, хууль бусаар халсан бол би огцорно гэж хэлж байсан. Гэтэл өчигдөр Стандарт хэмжил зүйн газрын дарга асан н.Гантөмөр

гэдэг хүн том хэвлэлийн хурал хийлгэснийг бид бүгдээрээ харсан. Таныг өнгөрсөн Засгийн газрын үед Тэргүүн Шадар сайд байхдаа тэр хүн халагдаж 3 шатны шүүхээр заргалдаж байж, маргалдаж байж эргээд томилогдсон хүн байна лээ. Гэтэл та Ерөнхий сайд болонгуутаа дахиж ажлаас халж одоо бас шүүхээр сэргээлгэж ингэж байж байгаа юм байна. Энэ нотлох баримт биш үү. Та нөгөө хүн халахгүй гэсэн юм чинь хаана байна. Энэ н.Гантөмөр жишээ болохгүй юм уу. Тэгэхээр таны одоо ажлаас хүмүүсийг хоморголон халсан. Хууль зөрчиж төрийн албан хаагчдыг халсан гэдэг нь ингээд нотлогдож байна гэж хэлэх байна.

Хоёрдугаарт, төсвөөс гадуур асар их хэмжээний мөнгө эргэлдэж байна. Манай төсөв маань орвонгоороо 7.0 их наяд. Энэнээс дутахааргүй хэмжээний хөрөнгө Монгол Улсад эргэлдэж байна. 1.5 тэрбум долларын бондын хөрөнгө байна.

Хоёрдугаарт нь, үнэ тогтворжих нэрээр Монголбанктэй Засгийн газар хамтарч хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хүрээнд 1.9 их наяд хөрөнгө эргэлдэж байна.

Гуравдугаарт, Монгол Улсын Хөгжлийн банкны 580.0 сая америк доллар гээд ийм том том гурван жишээ хэлэхэд нийлээд 5.0 их наяд хөрөнгө хяналтгүй эргэлдэж байна.

Монгол Улсын Их Хурал өөрийнхөө эрх мэдлээ алдаж байгаа юм биш үү. Энэ эргэж төсөв дээрээ суух мөнгө. Тийм учраас Улсын Их Хурлаас тодорхой ажлын хэсэг гаргаж эдгээр мөнгөнүүдийн байдалд нь дүгнэлт хийж, шалгалт хийх ёстой. Сая манай ажлын хэсгийнхэн Монголбанк дээр очиж тодорхой мэдээлэл гаргуулж авч чадсангүй. Тийм учраас цаашдаа энэ их мөнгө чинь одоогийн Засгийн газрын толгойг ороох том юм болж мэднэ шүү гэдгийг зориуд анхааруулж хэлэх ёстой.

Дараагийн асуудал Эрдэнэс Тавантолгой гэдэг компанийг өнгөрсөн Их Хурлаар байгуулсан. Засгийн газар байгуулсан. 6.0 тэрбум тонн нүүрсний нөөцтэй дэлхийн хамгийн том ордын нэг. Энэ компани бол хувьцаат компани. Монгол Улсын 2.0 сая орчим иргэн хүн болгон 1072 хувьцаа эзэмшиж байгаа. Монголын 1500 аж ахуйн нэгж хувьцаа эзэмшиж байгаа. Цаашдаа гадаадад IPO хийж хөрөнгө босгох гэдэг юм уу даа одоо хувьцаагаа худалдах ийм том компани. Бид энэ компанийг ашигтай ажиллуулж, цаашид хүн болгон ногдол ашиг хүртэх ийм хүлээлттэй байж байгаа.

Өнөөдөр Эрдэнэс Тавантолгой компани 1 тонн нүүрсийг 41 мянган төгрөгөөр олборлодог юм билээ. Гэтэл хажууд нь байгаа Шивээ Овоо компани 18 мянган төгрөгөөр олборлож байх жишээтэй. Багануур уурхай 23 мянган төгрөгөөр 1 тонн нүүрсийг олборлож байх жишээтэй. Яагаад ийм их хэмжээний өртөг зардлаар нүүрс гарч байгаа юм бэ? Харин Багануурыг бодвол Тавантолгойн геологийн байдал шал өөр. Илүү бага хэмжээний өртөг гарах ёстой гэсэн ийм тооцоо байдаг. Хажууд нь байж байгаа хувийн Тавантолгой компаниуд нь мэдээж бага өртгөөр 1 тонн нүүрс гаргаж байгаа. Зардал бууруулах талаар тодорхой ажил хийх ёстой.



Нөгөө талд нь таны хамаатнууд 1 сая төгрөгийн компанийг нэг өдрийн дотор 1 тэрбум болгож хувиргадаг. Гэрэлхүүгийн Уянга нэг хоногийн дараа Чулуунбаатарын Уянга болж хувирдаг. Тэгээд одоо энэ компаниас 17.0 тэрбум төгрөгийн тендерийг одоо авч байдаг ийм мэдээлэл одоо гарч байна. Энэ бол үнэхээрийн дүгнэлт хийх ёстой зүйл. Ингээд харахад та үнэхээрийн огцрох үндэслэл байна гэж.. /минут дуусав/

**3.Энхболд:** - Д.Хаянхярваа гишүүн үг хэлнэ.

**Д.Хаянхярваа:** - Зүгээр яах вэ сүүлийн үед би ингээд сонин хэвлэл уншаад, хэвлэл мэдээллээр хараад байхад үгүй ер нь одоо энэ цөөнхийн бүлэг бид нар чинь их том буруу юм хийгээд байгаа юм уу гэдэг бодол төрөөд байдаг болчихлоо. Яагаад гэж. Яагаад гэхээр энэ чинь Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг гэж хүн байхад энэ цөөнхийн бүлэг нь огцруулна гэж тавиад байдаг чинь дэндүү ёс зүйгүй юм болж байна гэж би хувь хүнийхээ хувьд бодох боллоо л доо. Өөрөөр хэлэх юм бол ерөөсөө энэ чинь одоо 6 үндэслэл гараад тавьсан. Өнөөдрийн энэ 6 үндэслэлийг аваад үзэх юм бол энэ сонин хэвлэл, олонхийн бүлгийн гишүүдийн яриад байгаа, Засгийн газрын гишүүдийн яриад байгаа юмыг сонсох юм бол тэнд ерөөсөө нэг ч огцруулах үндэслэл байхгүй. Бүх юм сайн сайхан байхад, бүх юм гоё байхад эднийхэн ерөөсөө энэ төрийн ажлыг боох гэж, төрийн ажлыг саатуулах гэж нэг ийм ёс зүйгүй юм хийгээд хэдэн долоо хоногоор ажил аваад хаячихлаа гэхээр нь би одоо бүр санал нэгдээд байгаа юм.

Ер нь одоо энэ Ерөнхий сайд чинь Н.Алтанхуяг гэдэг энэ Ерөнхий сайд байхад бид нар энэ хүний талаар муу хэлэх ёсгүй байхгүй. Одоо л би тэрийг сайн ойлгож байна. Энэ бол үнэхээр бид нар ёсгүй юмыг ёстой болгож яриад байгаа нь харамсалтай байна.

Үндсэн хуулийг бол энэ хүн зөрчиж болно. Яагаад гэвэл энэ хүн чинь Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг гэдэг хүн учраас Үндсэн хууль зөрчих эрхтэй. Тэр эрхийг нь бид нар нээлттэй тавьж өгөх ёстой юм байна. Төрийн албаны болоод бусад хуулиудыг зөрчиж болно. Яагаад гэвэл энэ хүн бол Ардчилсан намын дарга. Энэ хүн Монгол Улсын Ерөнхий сайд. Тийм учраас энэ хүн хууль зөрчих эрхтэй. Тэрийг нь бид нар хязгаарлаад байна. Гадаад дотоод харилцааны асуудал дээр бодлого гэж юм хэрэггүй юм байна. Ерөөсөө манай Ерөнхий сайд санаандаа орсныгоо ярьж байх ёстой юм байна. Тийм учраас энэ гадаад дотоод бодлогын тал дээр Ерөнхий сайдынхаа ярьсан юмыг бид энд шүүмжлээд сууж байдаг нь бол хэтэрхий өрөөсгөл байна. Хэтэрхий өрөөсгөл байна. Яагаад гэвэл энэ чинь Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг гэдэг хүн хэлчихээд байхад бид нар энд эсэргүүцээд сууж байна гэдэг чинь бол арай л дэндүү больчимгүй үйлдэл хийгээд байна уу даа гэж би бодож сууна.

Дөрөвт нь бол энэ бизнесийн хүрээллийн асуудлаар бол ерөөсөө энэ бизнесийн чиглэлийн юмнуудыг өөрийнхөө ойр тойрны хүрээллийн улсууд руу томоохон бизнесүүдийг чиглүүлж байх нь үгүй Ерөнхий сайдын зөв шүү дээ. Юу гэж бид нарын одоо энэ тавиад байгаа шаардлага зөв байх юм. Ерөнхий сайд Н.Алтанхуяг Ерөнхий сайд юм чинь ингэж л одоо энэ хуулиа зөрчиж, ингэж л энэ

бизнесийнхээ чиглэлийнхээ юмнуудыг өөрийнхөө ойр тойрны хүрээллийн хүмүүст өгч авч байх нь зөв шүү дээ. Тийм болохоор би ер нь энийг бид нар их л том буруу алхам хийчихлээ гэж бодоод гэмшиж сууна.

Тавд нь бол энэ Төсвийн тухай хууль. Төсвийн тухай хуулийг Ерөнхий сайд хүн бас зөрчих ёстой. Энэ Засгийн газар, Ардчилсан намын эрх барьж байгаа Засгийн газар учраас энэ хуулийг бас зөрчих ёстой. Өнөөдөр төсвөөс гадуур Монголбанкнаас 2.0 тэрбум гаруй төгрөгийг төсвөөс гадуур, 2.0 их наяд орчим төгрөгийг одоо төсвөөс гадуур зарцуулахаар шийдвэр гаргачихаад эхнээс нь зарцуулаад явж байна.

Их Хурал гэдэг чинь өнөөдөр энэ орж гардаг мөнгө төгрөгийг чинь баталдаг барьдаг хуультай билүү гээд бодоод байсан чинь үгүй тэр хууль бол хамаагүй. Яагаад гэвэл энд чинь Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг гэдэг хүн байгаа болохоор энэ хүн бол энэ хуулийнхаа гадуур хүрээн дотроо л ажиллах ёстой байдаг юм байна. Тийм болохоор ер нь бол энэ Ардын намынхны тавиад байгаа тэр 6 үндэслэл, энэ хүнийг огцруулах гэж шаардаад байгаа шаардлага бол буруу юм байна. Ардчилсан намынхан минь та нар өршөөгөөрэй. Энэ хүнийгээ хамгаалаад авч үлдээд цааш нь дур зоргоороо явахгүй бол ёстой болохгүй юм байна.

Нэг Солонгосын кинон дээр хаан та түм наслаа гэдэг шүү дээ. Түүнтэй адилхан Ерөнхий сайд минь та түм насал, үйл ажиллагаагаа бол сайхан цааш нь ингэж үргэлжлүүлэх ёстой юм байна гэдэг үгийг би хэлмээр байна.

Ер нь бол энэ дээр бас бодох зүйлүүд бол их байгаа юм. Үнэхээр өнөөдөр би эртээд нэг хил хальтраад нэг зүйл хэлсэн л дээ. Шударга бус гэх гэж байгаад би шударга юманд дургүй гээд хэлчихсэн чинь өнөөдөр бол би ёстой Ерөнхий сайдтай туйлын үнэн үг хэлсэн байна. Яагаад гэвэл үнэхээр одоо би шударга юманд дургүй шүү Ерөнхий сайд минь, би таны талд гэж хэлсэн байна л даа. Энэ бол одоо миний хувьд үнэхээр одоо өнөөдөр ёстой аврал болж байна. Би одоо өөртөө баярлаж сууна. Энэ муу махан хэл хальтарсанд үнэхээр одоо баярлаж байна. Тийм болохоор энэ бүхнийг бид нар бодож тунгаах ёстой байх. Монголын ард түмэн гэдэг бол өнөөдөр тэнэг биш. Өнөөдөр энэ дээр ярьж байгаа, хэлж байгаа юмыг, энэ хамгаалж байгаа үг хэлийг бүгдийг нь ойлгож байгаа гэдэгт би огтхон ч эргэлзэхгүй байна.

Ер нь тийм учраас манай намын бүлгийн гишүүд бол өнөөдрийн энэ тавьсан 6 үндэслэл дээрээ бид нар энэ Монгол Улсынхаа эзэн Ерөнхий сайдаас уучлал хүсээд та минь дур зоргоороо бай гэдэг үгийг хэлээд гарах нь бол зүйтэй юм болов уу гэсэн ийм бодол миний санаанд бууж байна.

Тэгээд сая бид нар энэ твитер дээр харж байсан нэг ийм сайхан үг байдаг юм байна л даа. Ерөнхий сайд нь ашиг сонирхлын зөрчилгүй бол Засгийн газар нь тогтвортой байдаг гэж Маргарет Тэтчер гэж тэр аугаа эмэгтэйн хэлсэн үг байдаг юм байна. Энийг яах вэ бодож л бай. Одоо ер нь бодох нь зөв байх. Тэгэхдээ энэ хэнд хамааралтай болохыг нь би яаж мэдэх вэ. Ухаантай улсууд иймэрхүү үг хэлсэн байдаг юм байна. Баярлалаа.

**3.Энхболд:** - Ч.Хүрэлбаатар гишүүн үг хэлнэ.

**Ч.Хүрэлбаатар:** - Би нэг 4 асуудал ярих гэсэн юм. Манай намын бүлгээс Монголбанкин дээр очиж тодорхой асуудлуудыг хянаж үзээ гээд ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг Монголбанкин дээр очоод бүтэн өдөржин хүлээсэн. Мэдээлэл гаргаж өгч байна. Бэлтгэж байна гээд байсан. Төгсгөлд нь Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал орж ирээд уучлаарай та бүгдэд өгч чадахгүй. Та бүгд Ардын намын гишүүн учраас өгч чадахгүй гэдэг юм хэлсэн. Бодоод үзэхээр энд тэндээс авсан мэдээллийг нь аваад үзэхээр Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал гэдэг хүн бол нуух юмтай, бусдад ил тод болохоос айдаг ийм юм хийчихсэн хүн учраас тэр хүн тэнд тэгээд сууж байгаа юм билээ.

Яагаад вэ гэхээр 3 сарын 26-ны Bloomberg-ийн мэдээн дээрээс үзэхээр Монгол Улс алтныхаа нөөцийн хэмжээг эрс нэмэгдүүлсэн. Дараа нь алтны үнэ унанаас Монгол Улс ихээхэн хэмжээний мөнгө алдлаа гэсэн юм байсан. Очоод үзэхээр нь энэ мэдээллээ өгдөггүй. Улсын нууц гээд өгдөггүй. Гэтэл тэр бүх мэдээнүүд нь Олон Улсын Валютын Сангийн сайт дээр байдаг Bloomberg дээр тоо хэмжээтэйгээ гарчихсан байдаг. Ардын намын Их Хурлын гишүүд очихоор өгдөггүй тэрийг нь.

Монголбанкны Ерөнхий зөвлөх байх аа, эдийн засагч гэдэг хүн нь мэдээлэл дээрээ, сонинд өгсөн ярилцлага дээр тэр тоог нь хэлчихдэг. Монгол Улсын нууц мөртлөө. Гэтэл Ардын намын гишүүдэд өгдөггүй. Ингээд Монгол Улс алтны нөөцөө эрс хэмжээгээр нэмэгдүүлсэн. Нэмэгдүүлэх үндэслэл нь юу байдаг юм бэ гэхээр ихээхэн хэмжээний доллар ороод ирэхээр, Монголбанкны дансанд ороод ирэхээр Монгол Улсын валютын хэмжээ, нөөцийн хэмжээ өсдөг. Үүний тодорхой хувиар нь алт байршуулдаг. Алт болгодог. Ингээд болгочихсон. Уг нь алтны үнэ дээшээ явах уу, доошоо явах уу гэдгийг Монголбанкны Ерөнхийлөгч сайн мэдэж байх учиртай. Гэтэл Засгийн газрын нэг агентлагийн дарга шиг ажиллаад, ажилладаг болсон шүү дээ.

Засгийн газрын хөтөлбөрт нөгөө анхаарлаа тавиад, өөрийнхөө үндсэн ажлаа ерөөсөө хийхээ больчихсон учраас энэ дээр ийм том алдаа гарч ирж байгаа юм. Ихээхэн хэмжээний алдагдал үүссэн. Энэ алтны хэмжээ алдагдлын хэмжээг нь хэлэх юм бол удахгүй нөгөө улсын нууц задруулсан гэдгээр нь чирээд явчих байхгүй юу. Ийм учраас энэ үгийг нь хэлэхгүй байгаа юм. Монгол Улс алтны нөөцөө их хэмжээгээр нэмэгдүүлсэн. Ихээхэн хэмжээний алдагдал хүлээсэн.

Хоёр дахь асуудлыг нь би энэ дээр хэлмээр байгаа юм. Чингис бондыг анх гаргахдаа энэ Улсын Их Хурлын 52 дугаар тогтоол гэж бий. Тэр тогтоол дээрээ юу гэж заасан юм бэ гэхээр Монгол Улсын эдийн засгийн үр ашиг бүхий томоохон төслүүд. Томоохон төслүүдэд хөрөнгө оруулалт хийхийг Монгол Улсын Засгийн газар хаалтад Н.Алтанхуягт гээд заачихсан байгаа. Томоохон төслүүдэд. Гэтэл үнэн хэрэг дээрээ юу болж байна вэ гэхээр тэр сонин дээр ярилцлага өгсөн тэр Монголбанкны Ерөнхий эдийн засагч байх аа, С.Болд гэдэг хүний ярилцлагаар бол энэ мөнгийг бид нар арилжааны 5 банкинд байршуулж

байгаа. 1 жилийн хугацаанд хүү нь 7.0 хувь. Энэ нь эргээд цаашаагаа тэр бодит эдийн засаг руугаа орохгүй байгаа байхгүй юу. Орохгүй байгаа. Арилжааны банкууд нь юу хийж байна вэ гэхээр 3 зүйл хийж байгаа юм энэ мөнгөөр.

Нэгдүгээрт нь, Монголбанкны үнэт цаасыг эргээд худалдаж авч байгаа юм. Монголбанкны үнэт цаасыг эргээд худалдаж авч байгаа юм. Монголбанкны 7.0 хувьтай өгсөн мөнгөөр эргүүлээд Монголбанкны 11.0, 12.0 хувийн хүүтэй үнэт цаас худалдаж авч байгаа юм.

Дээр нь Сангийн яам долоо хоног болгон үнэт цаас гаргаж явдаг болсон шүү дээ. Засгийн газрын үнэт цаасыг худалдаж авдаг болсон. Дээр нь арилжаа нь, алтны валютын арилжаанд оролцож эхэлсэн. Ийм гурван зүйл. Өөрөөр хэлбэл бодит эдийн засгийг тэтгэ гээд Их Хурал дээрээс тогтоол гаргаад энэ бондыг нь шийдэж өгөхөд мөнгө хүүлэх ажиллагааг хийж эхэлж байгаа юм. Түүгээр үл барам Засгийн газрын үнэт цаас гэдэг бол орлогоо олж чадахгүй. Орлого нь орж ирэхгүй байгаа учраас тэр орлогыг нөхөх гэж авч байгаа үнэт цаас. Үүнийг Чингис бондын мөнгө орж байх магадлалтай байгаа юм. Тийм учраас айгаад тэд нар материалаа өгөхгүй байгаа юм. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр мөн ялгаа байхгүй тэр Улсын Их Хурлын тогтоолыг зөрчиж байгаа байхгүй юу. Яагаад вэ гэхээр төсвийн орлогын алдагдлыг нөхөх зорилгоор энэ бондын мөнгийг зарцуулж болохгүй гэсэн. Арилжааны банкинд өгөөд. Арилжааны банк нь эргэж Засгийн газрын үнэт цаасыг худалдаж аваад явж байгаа юм. Энэ дээрээ анхаарал тавьж ажиллахгүй байна. Мэдсэн ч мэдээгүй юм шиг царайлаад сууж байгаа байхгүй юу.

Гурав дахь асуудал, үнэ тогтворжуулах хөтөлбөр гээд хэрэгжиж байгаа юм. Үүнийг яаж хэрэгжиж байгаа гэдгийг та нар Монголбанкны тайлангаас нь аваад үз. Мөнгө хэвлээд энийг хэрэгжүүлж байгаа. 2.0 их наяд орчим төгрөгийг төсвөөс гадуур оруулж ирээд явж байгаа. Уг нь энэ мөнгийг Их Хурал дээр хэлэлцүүлээд. Буруу биш. Хэлэлцүүлээд улсын төсөвтөө суулгаад үүнийгээ хэрэгжүүлээд явж болно оо доо. Гэтэл тэр дээр дахиад 2.0 тэрбум, их наядыг нь, төгрөгтэй төсөв бий болгочихсон. Энэ Засгийн газар хоёр талаасаа төсөв аваад ажиллаж байгаа.../минут дуусав/

**3.Энхболд:** - А.Бакей гишүүн үг хэлнэ.

**А.Бакей:** - За баярлалаа. За ер нь Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг сүүлийн 16 жилийн дотор нийтдээ 7 удаа хэлэлцсэн байна. Өнөөдрийн хувьд бол ингээд 8 дахиа хэлэлцээд бүтэн одоо 2 долоо хоног сунжруулж эрхэм гишүүдийн үнэтэй цагийг авч хэлэлцэж байна.

Тэгэхээр би бол бас нэг юманд гайхаад байгаа. Сүүлийн 16, 17 жил. За цаашилбал сүүлийн 22 жилд бид бол Засгийн газрыг огцруулах асуудлыг тавихдаа маш их нухацтай ярьсан мөртлөө Монгол хүний нүдэнд харагдахаар жишээлбэл Эрдэнэт үйлдвэр шиг бүтээн байгуулалтын ганц зүйл бүтээж чадсан уу, үгүй юу. За ядаж нэгийг ч гэсэн. Тэгж чадаагүй байна. Тэгэхээр энэ маань юу харуулж байна вэ гэхээр зэрэг бид бол одоо ер нь зарим талаар бол бүтээн байгуулалт, улс орны эрх ашиг гэхээсээ илүү хэтэрхий улс төрийн ашиг хонжоо

олох үүднээс асуудалд хандаад байгаа юм биш үү гэж би хувь гишүүнийхээ хувьд бас хандаад байгаа.

Тэгэхээр өнөөдөр бол улс орны нөхцөл байдал, эдийн засгийн байдал бол хүнд байна. Та бүгд бүгдээрээ мэдэж байгаа. Алт зэсийн, уул уурхайн бүтээгдэхүүний үнэ уначихсан. Энэтэй холбоотойгоор улсын төсөвт орж ирэх орлого буурчихсан байж байгаа. Гэхдээ энэ хүнд нөхцөл байдал гэв гэнэт өнөөдөр бий болоогүй. Өнөөдөр гэдэг маань өчигдрийг үргэлжлэл. Өчигдөр бид өөрсдөө юу хийсэн бэ. Жишээлбэл өнгөрсөн 4 жилд юу хийсэн бэ. Нэг хөнжил доор ороод хамтдаа байхаараа бие биеэндээ юу ч хэлэхгүй. Тэр үедээ энэ одоо болохгүй байгаа, бүтэхгүй байгаа, өнөөдөр одоо гарч ирж байгаа асуудлын эх үүсвэрийн талаар, болохгүй байгаа асуудлын талаар яагаад та нар амаа үдээстэй байлгасан юм бэ?

Жишээлбэл, Тавантолгойн орд газартай Чалко [Aluminum Corporation of China Limited (CHALCO)]-той байгуулсан гэрээ бол үнэхээр Монгол Улсын эрх ашгийг зөрчсөн гэрээ шүү дээ. Гэтэл тэр үедээ энэ асуудлыг яагаад та нар яриагүй юм бэ? Аль аль талд нь би хэлж байгаа юм шүү. Тэр халуун хөнжил доор л та бүхэн тавтай хэвтэж байсан биз дээ. Гэтэл өнөөдөр болохоор цоо шинэ хүн болоод ерөөсөө ямар ч байсан эвгүй ийм маягтай ярьж болохгүй шүү нөхөд минь. Эхлээд тэр Тавантолгойн Чалкотой байгуулсан гэрээг албан ёсоор ярих хэрэгтэй.

Дараагийн нэг асуудал бол энэ Үндсэн хуулийн цэцээс одоо Үндсэн хууль зөрчсөн талаар шийдвэр албан ёсоор гараагүй байхад хариуцлага тооцох үндэслэл бодитой одоо хууль зүйн хувьд үүсээгүй байгаа. Энийгээ бас бодитой ярих ёстой шүү.

Дээр нь одоо бондын тухай асуудал яригдаж байна. Өнөөдөр энэ улс орны эдийн засаг хүнд байгаа нөхцөлд дэлхийн зах зээлээс олж ирсэн энэ бондын хөрөнгийг маш богино хугацаанд зөв зарцуулж шийдэхгүй бол энэ өөрөө эгзэгтэй асуудал байгаа. Улс төрийн тогтворгүй байдал чинь эдийн засагт тусаад байна. Ард түмний аж амьдралд тусаад байна. Тийм учраас энэ олж ирсэн мөнгийг богино хугацаанд үр бүтээлтэй зарцуулах асуудал дээр та бид анхаарах хэрэгтэй.

Энэ Ардын намын бүлгийн хүсэлтэд бол энэ Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал тодорхой хариулт ирүүлсэн байна шүү дээ. Би уншаад өгье. Засгийн газрын үнэт цаасыг олон улсын зах зээлд арилжаалах замаар бүрдүүлсэн 1.5 тэрбум долларын хөрөнгийн эх үүсвэрт Монголбанк санхүүгийн зуучлалын үүргийг гүйцэтгэх ажлын хүрээнд тус хөрөнгөөр олон улсын зах зээлээс нэг ч грамм алт худалдаж аваагүй бөгөөд Чингис бонд эх үүсвэрт аливаа төрлийн алдагдал хүлээгээгүй болно гэж. Тэгээд одоо Н.Золжаргал Ерөнхийлөгч гарын үсэг зурсан байна. Энэ хүн эрх биш улаан цайм ингэж худлаа хэлэхгүй байлгүй дээ. Үнэхээр худлаа хэлсэн бол тэгээд хариуцлагаа хүлээлгэнэ шүү дээ бид нар албан ёсоор. Тийм учраас энэ дээр бол бас төрийн ажилд бид бие биеэндээ итгэж сурах хэрэгтэй.

За тэгээд төгсгөлд нь хэрэг дээрээ юу ч хийдэггүй хүн алдаа гаргадаггүй

гэж байгаа. Мэдээж Засгийн газар бол өө сэвгүй, ямар ч алдаагүй гэж би үзэхгүй байгаа. Тийм учраас Засгийн газар Ардын намын зүгээс тавьж байгаа эдгээр асуудал, 6 асуудлын дотор үнэхээр одоо ажил хэрэгчээр хандаж засах ёстой зүйлээ богино хугацаанд засах хэрэгтэй гэдгийг би хэлмээр байна.

**3.Энхболд:** - Ц.Нямдорж гишүүн үг хэлнэ.

**Ц.Нямдорж:** - За баярлалаа. Ерөнхий сайдыг огцруулах санал тавих үед би бас цаг хугацааны хувьд ч тэр эргэлзэж л байсан хүн л дээ. Ямар шийдвэр гарахыг би мэдэхгүй байна. 42 гишүүний эрх барьж байгаа эвслийн 20-иод нь сайд учраас хармаандаа нэг нэг гишүүн хармаалчихсан байгаа учраас хамгаалаад үлдэх байх. Гэхдээ энэ хэлэлцүүлэг ач холбогдолтой боллоо гэж би бодож байгаа юм.

Ямар ч байсан Н.Алтанхуяг гэдэг хүнийг, цаад талд нь байгаа Ардчилсан намыг, энэ Ардчилсан намын эрх баригчдыг энэ ард түмэн нэг хагас нүцгэн биеэр нь үзэж ойлголоо гэж би мэдэрч байгаа юм. Та нар хичнээн их худал хэлэх тусам ард түмэн төдийчинээ үнэний ойлгох болно гэдгийг би бас хэлье.

Орон тоо нэмээгүй гэдэг суртлыг бүтэн 8 сар хийлээ. Орон тоо нэмэгдсэн гэдгийг чинь Ц.Элбэгдорж зөвшөөрсөн. Нэг.

Хоёрдугаарт, та нар Их Хуралд танилцуулахдаа төрийн захиргааны байгууллага, албан хаагчдын тоог хэлээд байгаа юм. Цаад талд нь улсын үйлдвэрийн газрууд нэртэй болгочихсон хуучин агентлаг чинь улсын төсвөөс санхүүжээд явж байгаа.

Одоо энэ Засгийн газрын үйлчилгээ, аж ахуйн газар гэж байсан. Хуучин агентлаг байсан. Одоо улсын үйлдвэрийн газар болсон. 230-аад орон тоотой. 3.0 тэрбум төгрөгөөр санхүүждэг газар. Тэр санхүүжилтээ авч байгаа. Одоо энэ Л.Болдын хажууд байгаа дипломат үйлчилгээний газрынхан 140-өөд орон тоотой, 3.0 тэрбум төгрөг авдаг газар одоо авчихаж байгаа. Энийг төрийн албан хаагчдын орон тоонд оруулахгүйгээр хасаад яваад байгаа чинь хөөрхийлөлтэй л харагдаж байгаа байхгүй юу. Орон тоотой холбоотой юм чинь энэ.

Хоёрдугаарт, Тавантолгойн асуудал. Тавантолгойтой холбогдуулаад өмнөх Засгийн газар баахан балиар юм хийчихсэн. Баасыг нь цэвэрлэнэ гэж их зовж байна гэж Ерөнхий сайд Байнгын хорооны хурал дээр хэлсэн. 2010 оны 8 сарын 20-ны өдөр Ерөнхий сайд С.Батболдын захирамжаар Тавантолгойн ажлын хэсэг гэж ажлын хэсэг байгуулагдсан юм. Энэ ажлын хэсгийн ахлагчаар тэргүүн Шадар сайд Н.Алтанхуяг, гишүүдэд Сангийн сайд С.Баярцогт, Х.Баттулга, Д.Зоригт, нарийн бичгийн дарга Ч.Хүрэлбаатар томилогдож энэ Тавантолгойг хөдөлгөөнд оруулах ажлыг зохион байгуулсан. Хэрвээ энэ тийм их бохир юм байсан юм бол энэ бохир юмыг гардан зохион байгуулж хэрэгжүүлсэн хүн нь Н.Алтанхуяг гуай та шүү. Наад ажлын чинь хүрээнд тэр гэрээ хийгдсэн. Чалкотай хийсэн гэрээ гэдгийг би бас хэлье.

Чалкотай хийсэн гэрээг улс төрийн зорилгоор хувьдаа энэ Тавантолгойг

эзэмших зорилгоор, далдуур. Бүтэн 5 сар зогсоогоод гэрээнд нь ямар ч өөрчлөлт оруулахгүйгээр нүүрсээ гаргаж эхэллээ. Энэ тухай ажлын хэсэг орсон гишүүд хэлэх байх.

Гуравдугаарт, ер нь энэ Засгийн газар бол дандаа худлаа хэлдэг Засгийн газар. Одоо жишээ нь энэ Ардчилсан намын бүлэг дээр танилцуулаад Эрдэнэтийн үйлдвэр 150.0 сая долларын зээл авсныг дөнгөж сая мэдлээ. Х.Тэмүүжингээр шалгалт хийлгэнэ гэж Ардчилсан намын бүлгийн дарга Их Хуралд мэдээлсэн. Олон нийтэд мэдээлсэн. Энэ зээлийг хэзээ авсан байна гэж. 2012 оны 11 сарын 14-нд Советыг хуралдуулаад, тэрэнд нь Чемезов [Сергей Викторович Чемезов]-ыг оролцуулаад энэ 155.0 сая долларын урьдчилгаа зээл авахыг зөвшөөрөөд, энэнийх нь дагуу Төрийн өмчийн хорооны дарга байсан Ц.Нанзаддорж гэдэг хүн ийм зээл авахыг зөвшөөрнө гээд гарын үсэг зурчихсан тогтоол одоо миний гар дээр байж байна. Ийм юм хийчихээд өмнөх рүүгээ дайрдаг. Ийм муухай худалч, хулхи, бохир Засгийн газар, түүний Ерөнхий сайд байна гэхэд би харамсаад байгаа нь тэр.

Ардчилсан намынхан энэ хүнээ сайн хамгаалцгаа. Хамгаалах тусам та нарын үнэн нүүр царай чинь Монголын ард түмэнд харагдах болно шүү гэдгийг хэлье.

Гаалийн агуулгынх нь үйлчилгээний эрхийг авчихаад. Цаад талд нь. Наад талд нь компанийнх нь гүйцэтгэх удирдлагыг дандаа өөрийн хүмүүсээр тавьчихаад. Багануур дээр.../минут дуусав/

**3.Энхболд:** - Д.Ганхуяг гишүүн үг хэлнэ.

**Д.Ганхуяг:** - За баярлалаа. Улсын Их Хурал дахь цөөнх бүрэн эрхийнхээ хүрээнд Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг тавьж байна гэж ингэж үзэж байна. Тэгээд Ерөнхий сайдыг огцруулах хангалттай үндэслэл харагдахгүй байна. Тийм учраас огцруулахыг дэмжихгүй байгаа гэж ингэж хэлэх байна. Ардчилсан намын бүлэг дээр ч гэсэн ийм шийдвэр гарсан.

Гол шалтгаан нь Улсын Их Хурлын сонгууль 2012 онд болсон. Шинэчлэлийн Засгийн газар байгуулагдаад ажиллаад 8 сар болж байна. Засгийн газрынхаа үйл ажиллагааны хөтөлбөрийг дөнгөж амьдрал дээр хэрэгжүүлэх тэр тийм боломжтой. Одоо дулааны улирал нь эхлэх гэж байна.

Тэгээд би хууль санаачилсан цөөнхөд хандаж нэг хэдэн үг хэлэх гэсэн юм. Энэ хоёр хөрштэй харилцах харилцаан дээр бидэнд баримтлах бодлого байгаа. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал байгаа. Шинэчлэлийн Засгийн газрын Ерөнхий сайд ганц л удаа Шанхайн хамтын ажиллагааны хүрээнд хоёр орны холбогдох төрийн тэргүүнүүдтэй уулзсан. Тэр уулзалт нь байгаа. Наана нь зүгээр. Тэрнээс хойш нийлмэл хоёр өгүүлбэрээс хоёр хэсгээс бүрдсэн нэг өгүүлбэр хэлэхээр нэг өгүүлбэрийг нь аваад ингээд дайраад байдаг нь утгагүй байна.

Ер нь дотоод гадаад улс төрөө хольдог улс орон бол хөгждөггүй ээ. Хүнд

байдалд ордог. Ард түмнээс сонгогдсон бодлого тодорхойлох бидэнд байтугай Монгол Улсын иргэн бүрд хар хайрцгийн бодлого байгаа. Бид эх газарт хүн ам ихтэй хоёр гүрний завсар байдаг. Тийм учраас энэ дээрээ бол бас бодитой хандах шаардлагатай байна. Улс төрийн гадаад бодлогын асуудлыг улс төржүүлэх, оноо авах ийм хэрэгсэл болгомооргүй байна гэж ингэж хэлэх байна.

За хоёр хөрштэй харилцаан дээр яриад байдаг. Тэгвэл өмнө нь жишээлбэл юуны, Дэд бүтцийн хөгжил гэж компани төмөр замын талаар баримтлах бодлого байгуулаагүй байхад байгуулаад л бөөн асуудал үүсгэж байсан. Тавантолгойг өгнө гээд л амалж байсан. Чалкогийн гэрээ. Аливаа гэрээ бол хэдээр аваад эцсийн хэрэглэгчдээ хэдээр өгч байгаа вэ гэдэг нь ойлгомжтой байдаг. Зах зээлийн үнийг хоёр гурван жилийн өмнө одоо шууд тогтоогоод тэгээд хямдхан байхаар ийм байдалтай тогтоож болохгүй нь ойлгомжтой.

Гуравдугаарт, жишээлбэл бусад оронд худалдах нүүрсийн эрхийг нэг компанид өгчихсөн. Нэг компанийн гаргах бүтээгдэхүүний үнийн 80.0 хувийг хүртэл өгчихсөн. Ийм л байдалтай, ийм л гэрээ байгаа шүү дээ. Эцсийн эцэст худалдан авагчийн өрсөлдөөнөөр л энэ зах зээлийн нийгэмд аливаа орны бүтээгдэхүүн бол үнэтэй борлогддог. Тэгээд одоо бие бие рүүгээ шахаад л ингээд л өмнөх нь буруу, одооных нь буруу гээд байгаа. Уг нь энэ асуудал дээрээ бол гадаад улс төрийн асуудал учраас бид нар нэгдсэн бодлого гаргах боломжтой ийм л асуудал шүү дээ.

2012 оны төсвийн төслийг хэлэлцэж байхад бид хэлэлцэж байсан. Хамтарсан Засгийн газартай байсан. Тоохгүй л байсан. Жишээлбэл, Улсын Их Хурлын 57 дугаар тогтоол байгаа. Оюу Толгойн гэрээтэй. 34.0 хувийг шууд эзэмш гэхээр зээл аваад эзэмшихсэн. Ийм их баялгаа ашиглаж байж зээл аваад зээлийн хүү нь өдөрт явж байгаа ийм улс орон байгаа билүү. Энэ бол өөрөөр хэлбэл бид бүхэн бас нэгийг санах шаардлагатай. Олонхи цөөнхи гэлгүйгээр. Ийм л асуудал шүү дээ.

Одоо зүгээр ашиглалтын лицензтэй Монгол Улсын үндэсний компани байх юм бол хэнтэй ч мөнгө гаргахгүйгээр ашиглаад явчихаж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ бол бас урьд өмнөхөөсөө угшилтай ийм асуудал байна. Харин шинэчлэлийн Засгийн газар бол Улсын Их Хурал дээрээ, Засгийн газар дээрээ, Улсын Их Хурлаас гарсан шийдвэрийн хүрээнд хоёр хөрштэйгээ баримтлах бодлогыг яг ил тод. Цаасан дээр бичээд ингэж явж байгаа гэдгийг хэлмээр байна.

Дараа нь бонд гэж мөн ч их ярьж байна даа. Биднийг яг шинэчлэлийн Засгийн газар байгуулагдах үед төсвийн орлого нэг их наяд төгрөгөөр буурсан. Хүний хөгжил сангийн өр нь бол 1 их наяд төгрөг бараг болчихсон ийм байдалтай авсан. Дэлхийн зах зээл, хөрөнгийн зах зээл энэ бүхэн эрэлт нийлүүлэлтээс хамаардаг хүнд байсан. Тийм учраас энэ бондыг гаргая гээд. Бонд босгосоноор олон үр дүн гарч байгаа. Нэгдүгээрт, гадаадын шууд хөрөнгө оруулалтын зээлийн хүү буурч байгаа. 10, 13 хувийн хүүтэй гэрээ хүртэл байгуулж байлаа шүү дээ бид нар.



Хоёрт нь, өнөөдөр олон түмэнд бид яах вэ янз янзын бэлэн мөнгө өгдөг ч гэсэн энэ зээлийн хүүгийн асуудал, арилжааны банкны зээлийн хүүгийн асуудал чинь маш хүндрэлтэй байдаг шүү дээ.

За бидний ярьдаг тэр Япон, Америкт бол төсвийн орлогын 40, 50 хувийг Засгийн газрын бондоор.../минут дуусав/

**3.Энхболд:** - О.Содбилэг гишүүн үг хэлнэ.

**О.Содбилэг:** - Би нэг хоёр зүйл хэлэх гэсэн юм. Нэгдүгээрт нь, нийгэм, эдийн засгийн байдал сайхан байна. Боломжтой. Хөгжиж байна. Дөнгөж одоо хэдхэн сар болж байна гэж байна. Миний бодлоор бол ямар нэгэн Засгийн газар ажилдаа ороод тийм хүлээх, хэдхэн сар, нэг жил хүлээх ч гэдэг юм уу тийм цаг хугацаа байхгүй. Энэ өөрөө тийм хугацаатай. 4 жилийн хугацаатай. Тэгээд одоо тэр хугацаандаа эхэлсэн өдрөөсөө л ажилдаа орох ёстой гэж бодож байгаа.

Нийгэм, эдийн засгийн байдал бол үнэхээр хүнд байна. Үндэсний компаниуд маш хүнд нөхцөлд ажиллаж байна. Бүгд өр авлагын дарамт одоо хүндрэлтэй болсон байна. Томоохон үндэсний компаниуд бүгдээрээ төлбөрийн чадваргүй болчихсон, өнөөдөр суучихсан байна. Энэ нь юунаас үүдэлтэй вэ гэхээр Засгийн газрын бодлого тодорхой бус байгаа. Хийж байгаа үйлдлүүд нь бизнес эрхлэгч үндэсний компаниудад тодорхой бус. Бас намын харъяаллаар нь ялгаварлан үзэх байдал их газар авч байна.

Ингээд манай огцруулах үндэслэлийн 6-д орсон байгаа. Нийгэм, эдийн засгийн байдал дордож байгаа болохоор энэ Ерөнхий сайдтай хариуцлага тооцье гэсэн дээр бас би гарын үсэг зурсан юм.

Хоёрдугаарх нь бол Монгол Улсын Үндсэн хуулиар Монгол Улсын иргэн одоо үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энийг бол хааж байна. Хэвлэл мэдээллийн байгууллагуудыг дарамталж хааж байгаа байдал их харагдаж байна. Зүгээр нэг жишээ гэхэд манай нэг найз надад тоглож ярьж байсан юм л даа. Энэ өнгөрсөн нам. Энэ шинэчлэлийн Засгийн газрын хамгийн их эмээдэг юм нь юу вэ Содоо чи мэдэх үү гээд. Тэгж байхад би асуусан чинь онлайн коммент гэж байсан юм. Тэр үед би бас зүгээр шоолоод л өнгөрч байсан. Зүгээр тоохгүй өнгөрөөж байсан. Одоо болохоор энэ маш их ноцтой хянадаг болсон байна. Интернэтээр хүмүүс юу гэж хэлж байна, юу гэж шүүмжилж байна. Энэ бүгдийг бас харж хянаж одоо хязгаарладаг болсон байна. Харилцаа холбооны зохицуулах хорооноос бүх интернэт хэрэглэгчдийг өнөөдөр хянаж байгаа. Бүх иргэдийг, бүх хэрэглэгчийг хянаж байгаа. Тэр хүн юу үзэж байна, ямар сайт руу орж байна, хаанаас юунд хандаж байгааг нь хянаж байгаа. Энэ бол бас манай Үндсэн хуулиар бид нарт олгогдсон иргэний нууцлалын ч байдаг юм уу, бүх эрх рүү ингээд зөрчиж орж байгаа юм.

Тэгээд хэвлэлийн хэд хэдэн байгууллагуудыг бас хаасан. Хэд нь хаагдсан юм. Яагаад хаагдсан юм гэдэг асуултад бас одоо хүртэл хариулт өгөөгүй байгаа юм. Энэ бүгд ингээд манай дээр, манайх өнөөдөр чөлөөт нийгэмд, ардчилсан чөлөөтэй нийгэмд амьдарч байна уу гэдгийг бас бодогдуулах, эргэлзээ төрүүлэх

юм үүсгээд байгаа юм. Дэлхийн хил хязгааргүй сэтгүүлчдын байгууллага гэж байгаа. Тэд нар рейтинг гаргасан байна. Монгол хэвлэлийнхээ эрх чөлөөний рейтингээрээ 98-д орсон байна. Муудаж байгаа гэсэн ангилал руу орсон байна. Энэ бол бас ноцтой анхаарах зүйл мөн гэж би бодож байгаа юм. Яагаад гэвэл ардчилсан чөлөөт нийгэмд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь байх ёстой.

Бидний цөөнхийн бүлгийн хийж байгаа ажлуудыг ч гэсэн хэвлэлээр тэр болгон нэвтрүүлж гаргахгүй байна. Хэдхэн телевиз, интернэт сайтууд л гаргаж байна. Бусдынх нь бүгдийнх нь амыг хаасан бололтой байна. Манай хэвлэлд гаргаж байгаа зүйлийг хааж боож байгаа гэж сэтгүүлчдээс бас хэлж л байна л даа. Нэрээ хэлээд ил гарахаас бас айж байгаа бололтой. Яагаад гэвэл харилцааны холбооны зохицуулах хорооноос шууд хаалгуулна гэсэн тийм, одоо бичигдээгүй тийм дарамт байгаад байна. Энэ болгоныг одоо анхаарч харж үзэж цаг нь болсон гэж бодож байна.

**3.Энхболд:** - Д.Лүндээжанцан гишүүн үг хэлнэ.

**Д.Лүндээжанцан:** - За би асуулт дээрээ Байнгын хороо болоод нэгдсэн хуралдааны асуулт дээрээ ерөнхийдөө хэлэх зүйлээ хэлсэн юм. Хуулийн талаас нь голцуу ярьсан юм. Энэ Засгийн газар маш сайн ажиллаж байгаа гэж бодъё. Түрүүчийн хэний хэлдэгээр. Бид андуурсан байж болно. Ганцхан хууль зөрчсөн гэдгээрээ л Ерөнхий сайд огцрох үндэслэл болчихоод байна. Ерөнхий сайдыг огцруулах үндэслэл болчихоод байна гэдгийг л асуусан.

Тэгэхээр би энэ, одоо харин ингээд харж байхад энэ бидний тавьсан 6 үндэслэл бол ер нь цөм үндэслэл нотлогдож байгаа юм байна гэж ингэж одоо ойлгогдож эхэллээ. Тэгээд санал шүүмжлэл хэлсэн хүмүүс рүү болохоор энэ Засгийн газар, бүх хүчний байгууллагаа арай захиалга өгдөг нь ямархуу юм. Одоо нүд үзүүрлэх. Багаар хэлбэл. Цаашилбал одоо хяхаж мөрдөх ийм ажиллагаа руу орж байна гэсэн ийм шүүмжлэл байна. Энийг одоо бас анхаарах шаардлагатай байна. Би хууль л ярья.

Бондын асуудлыг ярьж байхад энэ Төсвийн хороон дарга Ц.Даваасүрэн хоёр төсөвтэй болох гээд байна. Заавал одоо төсөв дээрээ бичилт хийх ёстой юм. Хуулийн заалт нь ийм байна гээд ишлээд байсан. Тэгээд ерөөсөө энэ бол олохиороо хүч түрээд л явсан. Энэ гэхэд л хуулийн зөрчил болчихоод байна шүү дээ. Тэгэхээр энэ Засгийн газар хууль дээдэлж ажиллахгүй бол одоо Монголд хэн ажиллах юм бэ? Хууль дээдлэх ёсон бол төр барих урлаг гэж. Засгийн газар олонхи төр барьж байгаа шүү дээ. Ингээд Үндсэн хуулиа бид дээдлэх ёстой. Үндсэн хуулийн асуудлыг сая орж ирээд сая ярилаа. Сүүлийн 2 долоо хоног ажил хийлгэхгүй ингэж цаг барж байна. Шал дэмий юмаар гэж ингэж зарим нь шүүмжилж байна л даа.

Тэгэхээр Байнгын хорооны, Төрийн байгуулалтын хорооны нэг үдээс хойшхи хуралдаан, түрүүчийн Пүрэв гарагийн хагас хуралдаан, өнөөдрийн Пүрэв гарагийн хагас хуралдаан л байгаа юм. Харин 14 хоног бол Ардын намын нэр бүхий 25 гишүүний тавьсан асуудал үндэслэлгүй. Энэ Засгийн газар бол ёстой нөгөө алтан цээжтэй, мөнгөн бөгстэй, хуучин хэзээ ч байгаагүй

шинэчлэлийн Засгийн газар, их зүйлийг хийж байгаа гэдэг ийм PR, шоугаа бүтэн харин 14 хоног бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулж цаг алдаж байгаа юм харин.

Тэгэхээр би энэ Засгийн газрын, Шинэчлэлийн Засгийн газар гэж нэр зүүсэн энэ Засгийн газрыг юуг нь яагаад шинэчлэл гэдэг нэр авав гэдгийг нь бодоод л сууж байна л даа. Ерөөсөө өмнөхөө муучлах, муу шаах, ажлын зарим нэг эхлэл байх шиг байна. Тэрийгээ бол гуадах, шоудах, PR хийхийгээ бол шинэчлэл гэж ойлгоод байна. Тэгэхээр энэ шинэчлэлийн Засгийн газрын шинэчлэл гэдэг үг бол үнэндээ таарахгүй байна нөхөд минь.

Урьдах Их Хурал, Засгийн газрын үед бүтээн байгуулалт, хөгжлийн асуудал яригдаад тэгээд 2 лав том үхэр чулуу байсан. Хад байсан. Ямар ч байсан энийг бол бид энд байгаа хүмүүс, аль ч нам нь оролцоод, ярилцаад байрнаас нь хөдөлгөж чадсан. Энэ бол том алхам гэж бодож байгаа. Засаж залруулах юм бол хангалттай байгаа.

Намар Н.Алтанхуяг Ерөнхий сайд бүлгийн хурал дээр орж ирээд би асуулт тавьсан. Орон тоо энэ данхгар Засгийн газар байгуулагдлаа. 19 гишүүнтэй асар том Засгийн газар байгуулагдлаа. Танхим. Ингээд энэ бүтэц, зохион байгуулалт чинь энэ олон яам гарлаа. Та юу гэж үзэж байна вэ гэсэн чинь нэг орон тоо нэмэгдэх юм бол би огцроход бэлэн гэсэн. Сая манай хүмүүсийн яриад байгаагаар бол одоо энэ олон орон тоо нэмэгдсэн байна. Барилгын хөгжлийн төв, Тээврийн хөгжлийн төв, хуучин агентлагууд бол дан төв нэртэй болоод тэгээд одоо данхайсан орон тоо бол хэвээрээ үлдэж. Би бол орон тоон дээр бол нэг их юм ярьдаггүй. Цаана нь хүмүүсийн амьдрал байдаг учраас. Төрийн албан хаагчдыг ажлаас халсны ард хичнээн хүний аж амьдрал байгаа. Ийм учраас тэр олон хүнийг харин аж амьдралаас нь салгасан. Энэ чинь юу болж байгаа юм бэ?

Айдас хүйдэсний дунд байна гэдгийг зарим хүмүүс шүүмжилсэн. Өнөөдөр ажлын байраа алдах вий гээд маш олон хүн айж байна. Эдийн засгийн нөхцөл байдлын үед. Энийг одоо бид урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ёстой юм гэж ингэж ойлгож байгаа юм. Хатуу үг ажилд тустай. Ядахдаа бид одоо та бүгдийн минь ажил сайн байгаасай гэж хатуу үг хэлэх ёстой юм. Харин зөөлөн хэлж байгаа юм. Ерөнхий сайдын маань үйлдэл нь.../минут дуусав/

**3.Энхболд:** - Ц.Оюунгэрэл гишүүн үг хэлнэ.

**Ц.Оюунгэрэл:** - За их баярлалаа. Сөрөг хүчний зүгээс ингэж эрх барьж байгаа талдаа шаардлага тавьж олон зөрчлийг өөрсдийнхөө харж байгаа өнцгөөс бас гаргаж ирж байгаа нь нэг бодлын бас зөв зүйтэй үйл ажиллагаа. Нөгөө бодлын одоо яг өнөөдрийн тавигдаж байгаа асуудлын хувьд ярих юм бол бид одоо ардчиллын түүхэнд, одоо ардчилал эхэлснээс хойш анх удаа Засгийн газрыг гадаад харилцааны асуудалтай холбож огцруулах асуудал орж ирж байгаа нь би бол ноцтой асуудал гэж бодож байна.

Ер нь 1930-аад оноос хойш А.Амар гуай, П.Гэндэн гуай. Одоо тэр

хүмүүсээс хойш бол гадаад харилцаанаас шалтгаалж засаг дотроо ингэж бие биенийгээ огцруулах асуудал бол яригдаж байгаагүй байх.

Тэгэхээр гадаад харилцааг бол аль болохоор бид нар дотоодынхоо улс төрөөс салгаж сурмаар байгаа юм. Аль ч нам нь засгийн эрхэнд гарсан бүгд гадаад харилцаатай тулгарна. Аль ч асуудал нь орж ирсэн бүгд бид нар гадаад асуудлаа тусад нь ярих хэрэгтэй. Гэтэл энэ Ерөнхий сайдыг огцруулах асуудал дээр гадаад асуудал, гадаад харилцаа орж ирэхийг бол би одоо эрс буруушааж байна. Энэ бол манай Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд нэн ноцтой асуудал гэж бодож байна.

Нөгөө талаас бондтой холбоотой асуудлыг маш их тавьж байна. Бондтой холбоотойгоор бид нар нээлттэй хөрөнгийн зах зээл дээр Монгол Улс гарч ирж байгаа анхны тохиолдол учраас энэ Монгол Улсаас гарч байгаа, зах зээлд гарч байгаа үнэт цаасны үнэ ханшийг бид нар бас давхар бодож байх ёстой. За одоо бид нар энэ асуудлыг бондтой холбож энд ингэж энэ өрөөнд одоо ингэж хэдэн долоо хоногоор сунжруулж ярьснаар юу болж хувирч байгаа вэ гэхээр Монголын компаниудын, Монголтой холбоотой аливаа нэгэн компаниудын хувьцааны үнийг шууд унагаж байгаа. Дээр нь бид нар одоо бондын үнэнд ч нөлөөлж байгаа. Зүгээр Засгийн газрыг огцруулах асуудлыг ярьснаараа бид нар гадаадын зах зээл дээр, нээлттэй зах зээл дээр гарсан бүх компаниуд зэрэгцээд ингээд хорлож байгаа юм. Ийм үйл ажиллагаа бол давхар явагдаж байгаа л даа. Тийм учраас энэ гадаадын мэдээллийн эх сурвалжыг бид нар иш татахдаа энэ яг жинхэнэ мэдээллийн ил тод байдлын үүднээс гарсан мэдээлэл байна уу, эсвэл бондын зах зээлд буюу олон улсын хөрөнгийн зах зээл дээр нөлөөлөх зорилготой мэдээлэл байна уу гэдгийгээ ялгаж салгаж сурмаар байгаа юм. Жишээлбэл, Bloomberg бол та бүхэн бүгдээрээ мэднэ. Зөвхөн хөрөнгийн зах зээл дээр одоо чиглүүлсэн мэдээллүүдийг маш их тавьдаг одоо эдийн засгийн сонин, эдийн засгийн сэтгүүл, эдийн засгийн хэвлэл мэдээлэл.

Тэгэхээр эдийн засгийн хэвлэл мэдээллүүд дээр гарч байгаа хэвлэл мэдээллийг бид нар одоо үнэ ханшинд нөлөөлөх мэдээлэл, яг чөлөөт сурвалжлага гэдгийг нь ялгаж салгаж уншиж үзэх хэрэгтэй.

За манай Монголын үнэ ханшийг бол ямар нэгэн байдлаар унагаагаад, нүүрсийг нь хямдхан болгоод, баялгийг нь хямдруулаад, хөрөнгө оруулалтыг нь хямдруулчихаад дараа нь Монгол Улсаас энэнээс өөр гарцгүй болохоор нь одоо хямдхан наймаа хийх сонирхолтой бизнесийн талууд бол байгаа шүү дээ. Тэгэхээр энэ талуудын гаргаж байгаа, одоо энэ талуудаас системтэйгээр гаргадаг мэдээлэл гэж байдаг. Тэр системтэй мэдээлэл нь дандаа хөрөнгийн зах зээл дээр нөлөөлдөг нөлөө бүхий хэвлэл мэдээллүүдээр гардаг. Цаашлаад энэ хэвлэлийг хэн бичээд байна, энэ мэдээллийг яг Монголын зах зээлийг одоо хүнд байдалд оруулсан мэдээллүүдийг яг яаж гаргадаг юм бэ гээд үзэхээр ихэвчлэн нэг хоёрхон блок дээр бичсэн судлаачдын мэдээлэл дээр энэ олон синдикатжсан [фр. syndicat] хэвлэл мэдээллүүд бол аваад аваад цааш нь ингээд тавиад явдаг.

Тэгэхээр зэрэг бид нар үнэхээр сөрөг хүчний авсан тэр мэдээлэл бол

үнэхээр чөлөөт сурвалжлага байсан уу, эсвэл үнэхээр синдикатын шугамаар тараахаар бэлтгэсэн одоо бас хөрөнгийн зах зээлд нөлөөлөх мэдээлэл байсан уу гэдгийг ялгах салгах аргагүй байна.

За гурав дахь асуудал нь бол одоо шинэчлэлийн Засгийн газрыг их олон нийтийг дарамталж байна гэж дахин дахин одоо сөрөг хүчний зүгээс ярьж байна. За тэгэхээр зэрэг Соёл, аялал жуулчлалын яамны зүгээс үнэхээр бид нар Монгол Ардын Намд бол хэрэг үүсгүүлээд явж байгаа нь үнэн. Энийгээ бид нар одоо олон нийтэд бас нээлттэй хэлж байгаа. Бид нар Лениний музейн бүх үзмэрүүдийг хүлээлгэж өгөөгүй байна. Лениний музейн соёлын өв тэр чигээрээ алга болсон байна. Мөн одоо тэр соёлын өвийг бүртгэдэг музейн дэвтрээ одоо болтол Соёлын яаманд хүлээлгэж өгөхгүй байна гэдэг асуудлаар цагдаад хандсан. Эрүүгийн хэрэг үүсээд явж байгаа. Тэгэхээр энийг бол бид нар одоо бас дарамт гэж үзэхгүй байна. Яагаад гэвэл аль ч Засгийн газар байсан үнэхээр Соёлын яамаа байгуулсан л бол соёлын өв сан хаачсан бэ гэдэг асуудлыг мөрдөж таараа. Энийг мөрдөхөд Монгол Ардын Намын одоо удирдах хүмүүс нь асуугдаж таараа, байцаагдаж таараа. Та бүхний хадгалж хамгаалж байсан байранд одоо тооллого орох нь зайлшгүй болж байгаа.

Тэгэхээр зэрэг энийг бас дарамт үзэж гэж үзэж бас энэ дарамт учруулж байгаа жагсаалтдаа битгий оруулаарай гэж хэлмээр байна. Яагаад гэх юм бол энэ бол үнэхээр аль ч төрийн үед байх ёстой зүйл явагдаж байгаа. Ийм тайлбар өгөхийг хүсэж байна.

**3.Энхболд:** - Н.Батбаяр гишүүн үг хэлнэ.

**Н.Батбаяр:** - За эрхэм гишүүдийн амрыг эрье. Өнөөдөр тэгээд энэ асуудлыг тавьсан хүмүүсийн маань үйлдэл ямар үр дүнд хүргэж байна вэ гэдэг асуудал үнэхээр өөрийн эрхгүй хэлэхгүй бол болохгүй нь. Сая Ц.Оюунгэрэл гишүүн хэллээ.

Энэ Их Хурлын зааланд болж байгаа үйл явдлаас Монгол Улсын олон улс дахь болон дотоодох нөхцөл байдал тодорхойлогдож байдаг. Тэгвэл сүүлийн хоёр долоо хоног бид нар Засгийн газрын тэргүүнийг огцруулах асуудал ярилаа. Үр дүн нь юу болж байна вэ гэх юм бол хувьцаа ханш унаж байна. Валютын ханш өсөж байна. Нуухыг нь авах гээд нүдийг нь сохлоно гэж та нар ийм юм хийгээд ямар хэрэгтэй байсан юм бэ гэж.

Ер нь манай Ардын намынханд сөрөг хүчин болох чадварыг эзэмших цаг нь уг нь болсон л баймаар юм. Өнөөдөр та нар хоёр дахь удаагаа сөрөг хүчин болж байгаа. Түрүүчийн удаа 1996-2000 онд сөрөг хүчин байсан. Тэгэхдээ юу хийсэн. Ардчиллын 4 Засгийн газрыг огцруулах ажлыг хийсэн шүү дээ. Тэрнээс хэн хожсон юм. Хэн ч хожоогүй. Монгол Улс л хохирсон. Сөрөг хүчний ажил гэдгийг Засгийн газрыг огцруулж байх, энэ төр засгийг үйлмүүлж байх, Монголын эдийн засгийг унагааж байх, нийгэм улс төрийн уур амьсгалыг дордуулж байх гэж үздэгээ болих цаг чинь болсон гэж хэлмээр байна.

Сая манай нөлөө бүхий улс төрч хэлэхдээ бид нар сөрөг хүчин юм чинь

үндсэн үүргээ биелүүлж байна, бид нарын үндсэн үүрэг бол Засгийн газрыг огцруулах асуудал гэж хэлж байгаа байхгүй юу даа. 6, 7 удаа сонгогдсон гишүүн маань тэгж хэлж байгаа байхгүй юу даа. Бид харамсаж байна.

Бид сөрөг хүчин байхдаа яадаг байсан юм. Зөвийг нь дэмжээд, бурууг нь засаад явдаг байсан. Нөгөө талдаа гэх юм бол 3 үндэслэлээр юм хэлж байна л даа. Тэр Монголбанкны асуудал, за тэр нэг тендерийн асуудал, төрийн албан хаагчийн асуудал гэж байна. Төрийн албан хаагчийн асуудал дээр юу ч гарч ирсэнгүй гэдгийг чинь хүлээн зөвшөөрлөө шүү дээ. Тэр дээр асуудал алга гэж. Монголбанк дээр асуудал байхгүй гэдгийг хүлээн зөвшөөрлөө шүү дээ. Та нар харж бай. Одоо Монголбанкнаас ирүүлсэн зүйл дээр гэх юм бол Чингис бондын хөрөнгөөр алт авсан юм байхгүй гээд тов тодорхой хэлсэн байж байгаа.

Би тэгээд одоо энэ Ч.Хүрэлбаатар гишүүнд хэлмээр байна. Хамтарсан шалгалт хийе л дээ. Их Хурлаас ажлын хэсэг томилж байгаад үнэхээрийн Монгол Улс алт гадаадаас тийм үү, валютаар худалдаж авсан байна уу, үгүй юу гэж. Буруу мэдээлэл өгснийхөө төлөө хариуцлага хүлээх чадвартай юу. Хэрвээ Ч.Хүрэлбаатарын хэлж байгаа Монголбанк валютаар алт худалдаж авсан гэдэг нь нотлогдох юм бол нэг асуудал. Хэрвээ нотлогдохгүй бол Ч.Хүрэлбаатар гишүүн хариуцлага хүлээж чадах уу гэдгийг бас ярьж байгаад оч л доо. Зөвхөн улаан цайм гүтгэж ингэж зах зээл дээр буруу мэдээлэл өгч Монголын эдийн засгийг унагаадагаа хэзээ болих юм бэ та нар. Монгол Улсын эдийн засгийг, энэ улс орноо гэсэн сэтгэлтэй та нар хэзээ болох юм бэ. Аль болгон тийм үү, бүх юмыг харлуулах гэж боддог байх юм бэ. Энэ цагаа болиоч.

Ч.Хүрэлбаатар аа, би чамд хэлж байна. Тийм үү. Хамтарсан шалгалт хийлгээд тийм үү, хамтарсан шалгалт хийгээд алт тийм үү худалдаж авсан гэдэг нь нотлогдохгүй бол та Их Хурлын гишүүнээс өргөдлөө өгөөд гарч чадах уу гэж би асуумаар байна. Тэгээд хэлж байна.

Цаашид нарт би сөрөг хүчин шиг байхыг бас хэлж өгье. Бид нар сөрөг хүчин байж..

**3.Энхболд:** - Нэгнийгээ үг хэлж байхад давхар ярихгүй.

**Н.Батбаяр:** - Бид нар сөрөг хүчин байхдаа яаж ажилладаг байсан юм. 2006-2008 онд бид нар сөрөг хүчин байхдаа энэ татварын тогтолцоо өөрчилье гээд дөрвөн аравын хувийг санаачлаад энэ Монголын татварын тогтолцоог өөрчилж хувийн хэвшлээ дэмжих бодлого бид нар хийлгэж чадаж байсан юм. 2006 онд Миеэгомбын Энхболдыг Ерөнхий сайд байхад бид нар Засгийн газартаа, төрдөө мөнгө олоод ирлээ гээд Гэнэтийн ашгийн 68 хувийн татварыг санаачлаад 1.0 тэрбум долларын эх үүсвэрийг энэ Засгийн газарт бүрдүүлж өгч байсан юм. Тэр үедээ бид нар тийм үү, Монгол төрөө, Монгол Улсаа, эх орноо гэсэн сэтгэлээр ажиллаж чаддаг байсан. Та нар тийм болж сураач гэж хэлмээр байна. Аль болгон ингэж тийм үү, сөрөг хүчин гэдгийгээ тийм үү энэ төрийн дайсан гэдэг байр сууринаас хандах юм бэ. Боль л доо.

Бид нар чинь Монголын ард түмний нэгээхэн хэсэг шүү дээ. Сонгуульд

орохдоо бид нар намаар талцаж ордог байх. Сонгуульд ороод гарсан хойно тийм үү энэ та нар өөрсдөө нэг талаас намын гишүүд гэдгээ бодож байгаа бол нөгөө талаасаа ард түмнээс сонгогдсон гишүүд гэдгээ хэзээ санах ёстой юм бэ. Энийгээ санаач гэж би та нарт хэлмээр байна. Хэрвээ та бүгдийн зүгээс энэ эдийн засгийг зөв авч явахын төлөө сайн сайхан санаачлага гаргах юм бол хамтран ажиллахад бэлэн байна гэдгээ урьд нь ч хэлж байсан. Танай бүлэг дээр би хүсэлт хэд хэдэн удаа тавьсан. Танай бүлэг дээр очоод эдийн засгийн асуудлуудаараа, бондын асуудлаар, бусад бүх асуудлаараа мэдээлэл өгье гэхэд хүлээж авахгүй л байгаа шүү дээ. Би одоо энийг дахиад хэлж байна. Танай бүлэг дээр очиж мэдээлэл өгье, хамтарч ярилцъя гэхээр та хүлээж авахгүй зүгээр л шоу хийгээд яваад байгаа шүү дээ. Энийгээ боль л доо. Хамтарч ажиллах юм бол хамтарч ажилласан шиг ажиллацгаая л даа. Юу нь болохгүй байгаа юм.

Би танай бүлэг дээр очъё гэж тийм ээ өөрийн биеэр та нарт хэлсэн. Их Хурлын хуралдаан дээр хэлсэн. Байнгын хорооны хуралдаан хэлсэн. Өнөөдөр хүртэл тэр хүсэлтийг хүлээж аваагүй байгаа. Маргааш ч гэсэн би танай бүлэг дээр очоод мэдээлэл хийхэд бэлэн байна. Хамтарч ажиллана.../минут дуусав/

**3.Энхболд:** - Ж.Батзандан гишүүн үг хэлнэ. Нэгийгээ үг хэлж байхад давхар ярилцахгүй. Одоог хүртэл давхар яриагүй байсан. Ч.Хүрэлбаатар гишүүн давхар ярьсан. Болохгүй. Өөрөө үгээ аваад ярь.

**Ж.Батзандан:** - За би ярих уу?

**3.Энхболд:** - Ж.Батзандан гишүүн.

**Ж.Батзандан:** - За Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг сөрөг хүчний зүгээс оруулж ирсэн. Ерөнхий сайд огцорвол Засгийн газар огцорно гэсэн үг. Өөрөөр хэлбэл Засгийн газрыг огцруулах асуудлыг сөрөг хүчин МАН-ынхан ярьж байгаа. Дөрөв таван үндэслэл гаргаж ирсэн байгаа. Энэ үндэслэлээ МАН-ынхан бол их хангалттай үндэслэл гэж тайлбарлаад байгаа юм. Гаднаас нь дотроос нь харсан МАН-ын тавьж байгаа үндэслэл шүүхээр нотлогдоогүй. Шүүхээр батлагдаагүй ийм үндэслэлүүд байгаа.

Ер нь 23 жилийн хугацаанд Засгийн газрыг огцруулах асуудлыг 7-гоос 8 удаа тавьсан гэж туршлагатай парламентч ярьж байна. Дундажлаад аваад үзэх юм бол Засгийн газрыг огцруулах асуудлыг 3 жилдээ нэг удаа л тавьдаг байсан байгаа юм. Гэтэл манай сөрөг хүчин МАН-ынхан 8 сарын өмнө ялагдсан хүмүүс Засгийн газартай өш хонзон тооцох гэж байгаа юм шиг утгагүй байдлаар хандаж байгааг би хараад гайхаж байна. 8 сар гэдэг бол ажил дүгнэх хугацаа биш. 8 сар гэдэг бол улс орныг хөгжүүлэх хугацаа биш. Энийг ойлгоочээ. Энийг ойлгооч. Ер нь аль ч үеийн Засгийн газрын ажил амархан байгаагүй. Аль үеийн Ерөнхий сайдын ажил амархан байгаагүй гэдгийг ойлгоё. 23 жилийн хугацаанд харах юм бол сайн нэртэй Ерөнхий сайд Монголд нэг ч байгаагүй.

Өнөөдөр Н.Алтанхуягийг энд суулгачихаад хамгийн адгийн Ерөнхий сайд МАН-ынхан гоочилж байгаагаа бас нэг эргэж хараачээ. Танай нам олон Ерөнхий

сайдыг төрүүлсэн. Улс төрийн туршлагатай нам. Гэхдээ ингэж битгий улс төржөөчээ гэж би та бүхэнд бас хэлмээр байна. 23 жил МАН-ынхан ч бай, манайхан ч бай засаг барихдаа энэ Ерөнхий сайд сайн байсан шүү гэж магтаж байсныг би ер нь хараагүй. Тэр Ардчилсан нам ард түмэн итгэл өгөөд дөнгөж 8-хан сар болж байна. Ажил хийх бололцоо боломжийг нь сөрөг хүчин нь бас олгоочээ. Битгий өс хонзон авах сэдэлтээр ингэж дайрч нэг хүн боорлоочээ гэдгийг би бас та бүхэнд сануулмаар байна. Магадгүй жил 6 сарын дараа, 2 жилийн дараа энэ асуудлыг ярьж байгаа бол би дэмжихэд бэлэн байна.

Шүүхээр Н.Алтанхуягийн буруутайг нотлоод оруулаад ирж байгаа бол бид дэмжихэд бэлэн байна. Бид алдаатай хүнийг хамгаалдаг нам биш Ардчилсан нам бол. Алдаа завхралын эсрэг МАН-ынхантай бас хамтдаа явмаар байна. Танай намыг би цэвэр тунгалаг нам гэж ойлгохгүй байна. Танай дотор олон авлигачид байгааг би мэднэ. Танай дотор олон хулгайчид байгааг би мэднэ. Та бүхний ярьж байгаа асуудал бас итгэл үнэмшилтэй сонсогдохгүй байгаа шүү. Асуудлыг ярих гэж байгаа бол бодитой ярья. Монголын улс төрийг цэвэрлэе, цэвэршүүлье гэж байгаа бол та бүхэнтэй бас бүх салбарт бүх талаар хамтран ажиллахад бэлэн байгаагаа бас илэрхийлье.

**3.Энхболд:** - Өглөө 9 цаг 22 минутаас эхэлсэн. Одоо цаг сунгах эсэх тухай ярья. 13.00 цаг хүртэл үг хэлчихээд 14.00 цагт хоолоо идчихээд орвол болж байна уу. 13.00 цаг хүртэл сунгачихъя даа. Д.Бат-Эрдэнэ гишүүн үг хэлнэ. Алга байна. Ж.Энхбаяр гишүүн. Бас алга байна. Р.Гончигдорж гишүүн.

**Р.Гончигдорж:** - За баярлалаа. Цөөнхөөс Ерөнхий сайдыг Ерөнхий сайдаар дамжуулж Засгийн газрыг огцруулах тухай асуудлыг 6 үндэслэлээр тавьсан. Энэ 6 үндэслэл нь үнэхээр огцруулах үндэслэл болохгүйг та бүхэн ч гэсэн бүрэн дүүрэн ойлгож байгаа. Ойлгож байгаагийн үндэслэл нь бол энэ асуудлаар завсарлага авч завсарлага авах хооронд дахиж өөр огцруулах үндэслэлүүдийг хайсан. Тэгээд хайгаад олсон зүйлүүдээ өнөөдөр эхэндээ дурьдаж байна л даа.

Юуг ярьж байна вэ. Монголбанкин дээр очиж шалгах гээд бид нарт шалгуулсангүй гэж. Монголбанкны тэр баримт бичгүүдтэй танилцдаг, шалгадаг, шалгах эрхийг авдаг, тогтоодог шийдвэр, шалгалтын шийдвэр гаргадаг энэ бүх зүйл чинь бид нарт хуулиараа нарийвчлагдсан зүйл шүү дээ. Энэ Монголбанкнаас ирүүлсэн бичигт их тодорхой байгаа. Их тодорхой байгаа. Өөрөөр хэлэх юм бол Монголбанкны тодорхой мэдээллүүд нь санхүүгийн зах зээл, олон улсын зах зээл, хэрэглэгчдийн эрх ашиг, юу юунд ямар эмзэг байдаг учраас яагаад бид нар шалгах асуудлыг нарийн дэглэмтэй болгох тухай асуудал байна вэ.

Тэгээд өөр нэг зүйлийг. Өөр Н.Алтанхуяг хууль бус шинэ баримтууд дэлгэгдлээ гэж байна. Гэж сонингуудаар бичээд өнөөдөр Н.Алтанхуягийн хамаатан нь одоо гэм буруутай үйлдэл хийсэн тухай асуудал ярьж байна л даа. Үндсэн хуулийн заалт дээр 16.14 дээр гэмт буруутай нь хуулийн шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт буруутай үйлдэл хэмээн тооцож үл болно гэж. Бид энэ далимаараа тодорхой иргэдийг Үндсэн хууль зөрчсөн гэмт буруутан



гээд зарлачихлаа. Дараагийн өгүүлбэр нь гэмт буруутны ял зэмлэлийг гэр бүлийн гишүүд төрөл саданд нь халдаан...

**З.Энхболд:** - Р.Гончигдорж гишүүн ээ. Ганцхан минут. Ж.Энхбаяр гишүүн микрофонгүй орилохгүй байхыг хүсье. Би өөрийн чинь нэрийг зарласан. Микрофоныг чинь нээсэн. Өөрөө хуралдаа байгаагүй. Дүрэм бол дүрэм. За үргэлжлүүлье.

**Р.Гончигдорж:** - Та миний 30 секундыг сунгаж өгөөрэй. Ингэж гэм буруу нь ялзмыг түрүүний гэр бүлийн гишүүн, төрөл саданд халдаан хэрэглэхийг хориглоно гэсэн ийм заалт Үндсэн хуульд байх юм. Үндсэн хуульд байх юм. Ингээд иргэний төдийгүй, тэрийг нь хамаатуулаад бусдад гэм бурууг нь халдаах гэсэн оролдлогоор хайлт хийж л дээ. Тэрийгээ том зүйл оллоо гэж.

Ер нь тэгээд зорилгодоо хүрэв үү манай Ардын намынхан. Магадгүй хүрсэн байж магадгүй. Яагаад. Өнөөдөр бондыг гутаах замаар бондын нэр хүндийг. Тэр нэр хүндээрээ дамжуулаад бондын хүү, бусад арилжаалал дээр саад болж чадсан уу. Чадсан байх аа. Үүгээр дамжуулаад Монголын бизнес эрхлэгчдийн олон улсын зах зээл дээрх хувьцааг унагаж чадав уу, чадлаа. Өөрөөр хэлэх юм бол эдийн засгийн хямралд хүрч болзошгүй, хямралыг зогсоох, хямралаас сэргийлэх чиглэлд бонд гүйцэтгэж байгаа үүргийг үнэхээр энэ эдийн засгийн энэ хямралаас ангижруулж чадаж байгаа Засгийн газрын үйл ажиллагааны нэг бүрэлдэхүүн хэсэг болохоор нь зэрэг түүнийг нь өнөөдөр тэр ач холбогдлыг нь алдуулах гэсэн үйл ажиллагаа явууллаа. Тэр зорилгодоо хүрч байх шиг байна.

Монгол Улсын гадаад нэр хүндийг унагаж энэ замаар энэ Засгийн газартай хамтарч ажиллах тэр үйл ажиллагаанд саад больё гэж хүсэв үү. Хүрсэн. Хүрч байх шиг байна зарим талаар. Өөрөөр хэлэх юм бол улс төрийн тогтворгүй байдлыг бий болгох замаар. Энэ эдийн засаг, гадаад харилцааны үр дагаврын хувьд. Мөн хоёр болон олон талт улсын харилцаанд эргэлзээ төрүүлэх тэр зорилготойгоор тавьсан тэр асуудлууд. Бас магадгүй. Энэ өнөөдөр эмзэглэл тодорхой үр дүнгийн байдал нь Монголын гадаад харилцаа, Монголын эдийн засаг, нийгмийн харилцаанд бас нэлээн сигнал, сөрөг сигнал өгөх шиг боллоо. Энүүгээрээ та нар зорилгодоо хүрч байх шиг байна.

Мөн энд нэг зүйлийг би бүр онцолж хэлье. Дахин хэлье. Энэ 6 зүйлээрээ үндэслэл болж огцруулж чадахгүй 6 хоногийн дараачаар дахиж шинэ үндэслэж оруулж ирээд тэрийгээ бичгээр биш өнөөдөр янз янзын хайлт хийлээ, хайлаа гээд ингэж оруулж ирж байна. Гэтэл Монгол Улсын хууль Үндсэн хуульд ямархуу агуулга байдаг юм. Засгийн газрыг огцруулах тухай асуудлыг хэлэлцсэнээс 6 сарын дараа дахин энэ асуудлыг хэлэлцэж болдоггүй гэдгийн агуулгыг манай албан ёсоор хуулийн боловсрол олсон хуульч гишүүд, олон жил энэ улс төрд явж байгаа гишүүд агуулгыг нь ойлгож байгаа. Гэтэл 6-хан өдрийн дараа дахиж нотлох баримт олох гэж, өөр үндэслэлүүд олох гэж ингэж явж байгаа асуудал нь бол өнөөдрөөс Монголын улс төрийн.../минут дуусав/

**Р.Гончигдорж:** - Ж.Энхбаяр гишүүн ээ, жаахан тавьтартай байя. Та лут

сургамж өглөө. Би тавьтартай байна гэж хагас жилийн, жилийн өмнө надад амласан шүү. Тийм ээ. Нүдэндээ нулимс гүйлгэнэж байгаад. Их сайхан боллоо ах аа. Танаас том сургамж авлаа. Би хэзээ ч ахиж алдаа гаргахгүй гэж хэлж байсан. Миний дүү ахиад алдаа гаргаж байна шүү. Ийм байдлыг бид нар бодох ёстой. Хууль номоороо л байх ёстой. Хууль зөрчлөө гэдэг асуудлыг ярих гэж хууль зөрчиж, Монгол Улсын төрийн тогтвортой байдлаар тогтоогдсон хэв хэмжээнүүдийг зөрчиж болохгүй. Энийгээ та бүхэн бодох ёстой.

Зургаа зургаан сараар сунгаад тавиад бай л даа. Та нарт 3 жилийн хугацаанд 5 удаа Засгийн газрыг огцруулах тухай асуудал тавих эрх чинь байж байна шүү дээ. Мөн үү дээ. Сонирхол нь байвал. Сонирхол харин Монгол Улсын эдийн засаг, нийгэм гадаад харилцаанд аюул учруулсан, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулсан байдлаар битгий дахин дахин хөндөгдөөсэй гэж би хүсэж байна. Баярлалаа.

**З.Энхболд:** - Миеэгомбын Энхболд гишүүн үг хэлнэ.

**М.Энхболд:** - За баярлалаа. Тэгэхээр нэгдүгээрт бол ер нь Монголд парламентын ардчилал устаж үгүй болжээ гэдэг энэ нэг үгийг саяхан нэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хуучин Улсын Их Хурлын дарга байсан нэгэн улс төрч хэлсэн байсан.

Тэгээд энэ бол та бидний энэ асуудлыг хэлэлцэж байгаа асуудалтай уялдуулаад бодоход бас гарцаагүй үнэн байна гэж ингэж бодогдож байна. Нэгдүгээрт бол Ерөнхий сайдыг огцруулах тухай тавьсан асуудлыг тэр асуудал санаачилсан хүмүүсийн ямар ч тайлбар илтгэл байхгүйгээр Улсын Их Хурал хэлэлцэж байна. 2006 он, 2007 онд тухайн үеийн Засгийн газрыг огцруулахад тухайн Ардчилсан намын зөвлөлийн ахлагч Гансүх гэдэг хүн алд алд дэлэм урт илтгэл докладыг энэ индэр дээрээс тавьж байсан. Дэгийн тухай хуульд энэ хугацаанд ямар нэгэн тэр зүйл заалттай холбоотой өөрчлөлт бол ороогүй.

Хоёрдугаарт, яг энэ асуудлын өмнө хэлэлцэж байгаа Улсын Их Хурлын дэд даргатай холбогдолтой асуудлыг хэлэлцэхэд Ёс зүйн дэд хороон дээр цөөнхийн ямар ч төлөөлөл байхгүй. Монголын парламентын 20 жилийн түүхэнд Ёс зүйн дэд хороон дарга нь цөөнхөөс, сөрөг хүчнээс байсан ийм уламжлалтай. Тэгтэл өнөөдөр олонхи Ёс зүйн дэд хороогоо өөрсдөө аваад цөөнхийн нэг ч хүн байхгүй ийм Ёс зүйн дэд хороогоор гишүүний ёс зүйн холбогдолтой асуудлыг хэлэлцээд явж байх жишээтэй байна.

Хоёрдугаарт, энд ярилцаж байгаа, ярьж байгаа гишүүд бол ерөөсөө 9-хөн сар болсон, 8-хан сар болсон Засгийн газрыг огцруулах гэж байна гэж ингэж ярьж байна.

Гурав дөрөвхөн жилийн өмнө та бүхэн өөрсдөө бас 8 сар, 9 сар болсон Засгийн газрыг огцруулах бичиг оруулж байсан. 2006 оны 1 дүгээр сард байгуулагдсан Засгийн газрын 2006 оны 9 дүгээр сард огцруулах бичгийг өргөн барьж байсан. Тэгэхдээ тэр үеийн тэр 9 сар одоогийн 9 сар хоёрын ялгааг би хэдэн зүйлээр хэлье гэж бодож байгаа юм. Тэр 9 сарын хугацаанд тухайн үеийн

Засгийн газар бол иргэдийнхээ цалин тэтгэвэр тэтгэмжийг 3 дахин нэмчихсэн. 3 дахин нэмэх бодлогоо гаргачихсан. Түрүүчийн 30 хувийг нь нэмчихсэн. Хүүхдийн мөнгийг өмнөх Засгийн газар нь ялгаварлаж олгож байсныг нийтээр нь олгодог болгоод сая 46 мянган хүүхдийн мөнгийг нь өгчихсөн. Үдийн цай хөтөлбөр гэдэг хөтөлбөрийг Монголд анх удаа шинээр хэрэгжүүлчихсэн. Гадаад валютын нөөцөө 3 дахин нэмэгдүүлчихсэн. Гадаад худалдааг Монголд анх удаа ашигтай болгочихсон. Ядуурлыг 4 хувиар бууруулчихсан байхад өнөөдрийн Засгийн газар энэ 9 сарын хугацаанд төсвийн орлого нь ч 86.0 тэрбум төгрөгөөр тасарчихсан. Хүний хөгжил сангийн орлого нь 11.0 тэрбум төгрөгөөр тасарчихсан. Хөрөнгө оруулалтад 1 дүгээр улиралд төлөвлөж өгсөн 277.0 тэрбум төгрөг нь 28.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй, ерөөсөө 10.0 хувийн биелэлттэй. 580 гаруй төсөл арга хэмжээ хэрэгжих боломж бололцоо нь алдагдчихсан. Иймэрхүү байж байх жишээтэй.

Цаг хугацааны хувьд адилхан байхад хийсэн ажил өнөөдөр улс орны эдийн засагт бий болж байгаа энэ хүндрэл бэрхшээл хоёр нь өдөр шөнө хоёр шиг л байгаа. Энэ хугацаанд нэг ч төгрөгийн цалин нэмсэнгүй. Нэг ч төгрөгийн тэтгэвэр нэмсэнгүй. Харин үнийн хөөрөгдлийг барьж байх хөтөлбөр хэрэгжүүлнэ гэдэг нэрийдлээр 300 орчим тэрбум төгрөг гаргаж зарцуулчихаад үр дүн нь өнөөдөр мах мянган төгрөгөөр үнэ нь өсчихсөн, гурил 350 төгрөгөөр өсчихсөн, нефть бүтээгдэхүүн 100 гаруй төгрөгөөр үнэ нь өсчихсөн л байж байгаа.

Ийм байгаа тохиолдолд одоо бид нар энэ огцруулах асуудлыг тавих ёстой. Тавьсан 6 үндэслэл бол хууль зөрчсөн нь маш тодорхой ийм зүйлүүд байгаа. Үндсэн хууль зөрчсөн нь нотлогдсон. Тавьсан 6 үндэслэл ямар нэгэн байдлаар одоо хүч нь мохосдоод шинэ үндэслэл хайхаар явлаа гэдэг байдлаар ярьж байгаа юм. Энд огтхон ч тийм юм байхгүй. Ерөнхий сайдтай холбоотой шалгаж тодруулах юм байвал Улсын Их Хурал, түүн дотроо сөрөг хүчин бол шалгах л ёстой.

Ажилласан хугацаандаа бол энэ Засгийн газар өмнө нь хийж байсан зүйлүүдээ үгүйсгэсэн ийм л зүйлийг ярьж байгаа. Ерөнхий сайд өөрөө гар өргөж баталж байсан 6 хувийн хүүтэй зээл олгож иргэдэд орон сууцтай болгох хөтөлбөрөө өнөөдөр өмнөх Засгийн газрын бодлогын алдаа байсан гэж ярьж байгаа юм. 4 жилийн дотор 10 мянган бага орлоготой иргэдийг 55 метр квадратаас доош талбайтай орон сууцтай болгоё. 400.0 тэрбум төгрөгийг нь энэ 4-өөс 5 жилийн дотор Хөгжлийн банкнаас эх үүсвэрийг нь гаргая. 40 тэрбум төгрөгийг нь зээлийн хүүгийн зөрүүг улсын төсөв дээр тавьж өгье гэдэг ийм л хөтөлбөр байсан. Энд ямар нэгэн тийм Засгийн газрын бодлогын алдаа байгаагүй.

Өнөөдөр эдийн засагт бий болсон өсөлтөө өөрсдөө хөөс болгочихсон сууж байгаа. 485 мянган тонн улаан буудай аваад дотоод хэрэгцээгээ хангадаг боллоо. Малын тоо толгой 55 саяд хүрлээ. Тавьсан замын хэмжээ жилдээ 1000-д хүрч байгаа. Барьсан орон сууц жилдээ 9800-д хүрч байгаа. Ийм байхад энэ бүгдийг хөөс гэж яриад сууж байгаа. Энэ бүтээн байгуулалтыг хийхэд бас өөрсдөө хамт оролцож байсан. Ийм учраас энэ.../минут дуусав/

**3.Энхболд:** - О.Баасанхүү гишүүн үг хэлнэ. О.Баасанхүү гишүүн байхгүй байна. Г.Баярсайхан гишүүн үг хэлнэ. Г.Баярсайхан гишүүн байхгүй байна. С.Бямбацогт гишүүн үг хэлнэ.

**С.Бямбацогт:** - Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах асуудал тавьсан үндэслэлүүд нь ерөөсөө үндэслэлгүй болоод өөр үндэслэл хайлаа гэж яриад байх юм. Бүгдээрээ нотлогдож байгаа л даа. Хууль зөрчөөд хэрэв үндэслэлгүй байсан юм бол хууль зөрчсөн шийдвэрээ яагаад хүчингүй болгоод байсан юм бэ. Монгол Улсын Үндсэн хуулийг удаа дараа зөрчсөн шүү дээ. Удаа дараа зөрчсөнийг Монгол Улсын Үндсэн хуулийн хэлэлцээд шийдвэрээ гаргасан байж байгаа. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн магадлал байж байна. 2013 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн дугаар 5 тоот магадлалаар Монгол Улсын Ерөнхий сайд хууль зөрсөн үндэслэлээ хүчингүй болгосон учраас өөрөөр хэлэх юм бол хууль зөрчсөн үйлдлээ алдаагаа зассан учраас гэдэг шийдвэр гаргачихсан байж байгаа шүү дээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний тогтоол байж байгаа. 2013 оны 03 сарын 04-ний өдөр гарсан. Дугаар 16 тоот тогтоол. Тэрүүгээр нотлогдож байгаа. За иргэн Ламжавын тавьсан Тагнуулын ерөнхий газрын дэд даргын асуудалтай холбогдуулан Үндсэн хуулийн цэц гаргасан мэдээллийг хянан шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн бас магадлал байж байна. Удаа дараа, нэг биш, хоёр биш, гурван удаа, дөрвөн удаа Үндсэн хуулийг зөрчсөн байна гээд цэц нь өөрөө шийдвэр гаргаад байна шүү дээ. Монгол Улсын Ерөнхий маань өөрийнхөө гаргасан шийдвэрийг хүчингүй болгоод байна шүү дээ. Энэ чинь хууль зөрчсөн гэдгийг нотлоод байгаа юм. Үндэслэлгүй биш ээ.

Дээрээс нь Төрийн албаны зөвлөл дээр бид нар ажилласан материал энэ байж байна. Төрийн албаны зөвлөлөөр яамдын орон тоо нэмэгдсэн, агентлагийн орон тоо нэмэгдсэн. Төрийн албанаас олон хүмүүс хоморголж халсан гэдэг юмнууд чинь бүгдийг нь бас нотлоод байгаад байгаа шүү дээ. Түрүүн Д.Оюунхорол гишүүн хэлсэн. Өнөөдөр яамд 871 хүнтэй байсан бол 1663 орон тоотой ажиллах ёстой. Гэтэл өнөөдөр 1707 хүн ажиллаж байна. Агентлагууд нь бүгд орон тоогоо нэмсэн. Оюуны өмчийн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Архивын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхэлсэн газар бүгд орон тоогоо нэмсэн байгаа шүү дээ. Нөгөө татан буугдсан орон тоог бууруулсан гээд байгаа агентлагууд нь төр засгийн аж ахуй үйлчилгээ эрхлэх газар, дипломат байгууллагын аж ахуйн үйлчилгээ эрх газар гээд бүгд улсын үйлдвэрийн газар нэртэй улсын төсвөөс санхүүжээд байж байгаа шүү дээ. Энэ баримтууд нь байгаад байна шүү дээ энд. Энийг хааш нь хийх гээд байгаа юм бэ? Хааш нь хийгээд байгаа юм. Бид баримтгүй юм ярьсангүй, үндэслэлгүй юм тавьсангүй. Бүгд үндэслэлтэй. Хэрвээ үндэслэлгүй гэж хэлж байгаа бол биднийг гүйтгэсэн гээд тийм асуудлаа ярь л даа.

Дээрээс нь дахиад нэг юм хэлэхэд хэт их улс төржиж байна бид нар бас. Өнөөдөр улс төржиж өөрсдөө иргэдээ бухимдуулж, иргэдээ хооронд нь талцуулж, зодолдуулж, ноцолдуулж, дээрээс нь эдийн засгаа унагаж байгаа шүү

дээ. Тэрнийхээ бурууг Монгол Ардын Нам ерөөсөө энэ их сайн ажиллаж байгаа, сайн Засгийн газрыг, хууль зөрчдөггүй Засгийн газрыг огцруулах асуудал тавьснаас болж иргэд бухимдаж байна, эдийн засаг унаж байна гэж ярих юм. Үгүй.

Сая М.Энхболд дарга хэллээ. Махны үнэ өсөж байна, гурилын үнэ өсөж байна, шатахуун нь өссөн. Үнэ тогтворжуулах хөтөлбөр гэж 2.0 их наяд төгрөг зарцуулсан. Ард иргэдийнхээ цалинг нэмээгүй, тэтгэврийг нэмээгүй. Иргэд чинь энэнээс бухимдаж байна. 2012 оны 6 сард сонгуулиар хэт их улс төржиж цөөхөн суудлаар ялсан мөртлөө иргэдийг үзэл бодлоор нь ялгаварласан, улстөржсөн. Үүнээс чинь болж гаднын хөрөнгө оруулалтууд буурсан, эдийн засаг унасан. Энийгээ яагаад өнөөдөр бидэнтэй холбох гээд байгаа юм бэ? Өнөөдөр. Ийм байдлаар асуудалд бид нар хандмааргүй байна.

Дээрээс нь Монголбанкинд бид нар шалгалт хийсэн. Очсон шалгалт хийхээр. Улсын Их Хурлын хуулийн 13.1, Улсын Их Хурлын тухай хуулийн 27.1.9-д заасны дагуу Улсын Их Хурал шалгалт хийх эрхтэй. Улсын Их Хурлын гишүүнээс нуух ямар ч асуудал байхгүй. Тэгж байхад Улсын Их Хурлын бүтцийн байгууллага, Улсын Их Хурлаас томилогддог албан тушаалтан Улсын Их Хуралдаа шалгуулахгүй, Улсын Их Хурлын гишүүдэд шалгуулахгүй гээд сууж байна. Өнөөдөр Улсын Их Хурал маань өөрсдөө өөрсдөө ийм хүндэтгэлгүй хандаад байхаар, Засгийн газар нь хууль зөрчөөд байхаар тэрийг дагаад шат шатандаа бүгд Улсын Их Хурлыг үл хүндэтгэж байна. Улсын Их Хурлын гаргаж байгаа шийдвэрийг тоохгүй байна шүү дээ.

Ийм байдлаар одоо ард түмний төлөөлөл хууль тогтоох дээд байгууллагад үл тоодог болох юм бол цаашдаа бид яаж явах юм бэ? Засгийн газрын гишүүд нь 19 нь бүгд, ихэнхи нь сайд. Улсын Их Хурлынхаа толгой дээр гараад суучихсан. Засгийн газар нь. Хууль зөрчдөг. Тэрийгээ хамгаалдаг. Одоо шатандаа. Би түрүүн хэлсэн хоморголж халдаг. Тэр Засаг дарга нь, агентлагийн дарга нь хүмүүсийг хоморголж ажлаас нь халдаг. Ерөнхий сайд маань хууль зөрчихөөд болдог юм чинь бид нар яадаг юм, хамаа байхгүй. Ерөнхий сайдтайгаа барьцаж эхэлж байна шүү дээ. Монголбанкны Ерөнхийлөгч нь Улсын Их Хурлаа үл тоож байна шүү дээ бас. Ийм байдлаар бид нар явах юм уу цаашаагаа.

**З.Энхболд:** - Ж..Эрдэнэбат гишүүн үг хэлнэ.

**Ж.Эрдэнэбат:** - За тэгэхээр энэ Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг бас манай намын 25 гишүүн тавьсан. Тавьсантай холбогдуулаад хэвлэл мэдээллийн байгууллага болоод вэбсайтуудын сэтгэгдэл юмнуудыг харж байхад энийг одоо нөхдүүд одоо ажилгүй юм уу, хаашаа юм гэж энэ тэр гэдэг. Өнөөдөр бас чуулганы танхимд дотор хүртэл яригдаж байна л даа. Эрхэм гишүүдийн үнэтэй цагийг аваад байна гэж. Уг нь энэ эрхэм гишүүд бол улс орныхоо хөгжлийг л яриад хөгжүүлэхийн төлөө л байж байх ёстой эрхэм гишүүд гэж би бодож байгаа юм л даа. Ярьж хэлж, бодлогоо тодорхойлж, боловсруулж байх ёстой.

Одоо зарим нэг гишүүд нь бас яриад байгаа юм. 8-хан сарын хугацаа гэж.

8 сарын хугацаанд аливаа улс орны болоод аж ахуйн нэгж, байгууллага, гэр бүлийн ч гэсэн эдийн засгийг унагаая гэвэл энэ шиг урт хугацаа бол байхгүй. Доороо унагаана шүү дээ. Хөгжүүлэе, өөд нь татъя гэвэл энэ шиг богино хугацаа байхгүй гэдгийг би мэдэж байгаа. Өнөөдөр хүн болгон ярьж байна шүү дээ. Цалин тэтгэвэр нэмэгдэхгүй байна. Улс орны эдийн засаг доройтлоо, уналаа гээд.

Би Ерөнхий сайдад асуулт асуучихаад дараа нь тэр бид нарт тарааж өгсөн материал дээр би хэлсэн шүү дээ. Хэлж байсан шүү дээ. Үйлдвэрлэлийн хэмжээ бол буурчихаад байна Ерөнхий сайд аа. Зөвхөн алтны үйлдвэрлэл өсчихөөд байна. Бусад нь бүгд буурчихаад байна. Үйлдвэрлэл буурна гэдэг маань дагаад борлуулалт буурна. Борлуулалт буурахаар яах вэ орлого буурна шүү дээ. Иргэдийн орлого буурна. Орлого буураад ирэхээр худалдан авах чадвар бас адилхан дагаад буурч л байгаа шүү дээ. Өнөөдөр жирийн жижиг худалдаа наймаа эрхэлж байгаа улсууд энэ хоолны газрууд бүх эздүүд нь бүгдээрээ мэдэж л байгаа шүү дээ. Ерөөсөө хүн худалдан авалт хийхээ больчихлоо гэдгийг. Тэгэхээр энэ маань хүмүүст одоо тодорхой хэмжээнд өөрчлөлт орчихоод байгаагийн нэг илэрхийлэл гэж би хувьдаа бодож байгаа.

Зүгээр гадаадын улс орнуудад бол иргэд нь орлогынхоо тодорхой хувийг бас зугаа цэнгэлдээ зориулж зарцуулж энд тэндхийн улс орноор явж аялдаг юм гэсэн. Монголд бол цөөхөн тийм хүн байдаг байх. Ихэнхи нь бол өөрийнхөө зүгээр ахуйн хэрэглээндээ зориулах байдлаар орлогоо хуваарилдаг. Тэгвэл энэ ахуйн хэрэглээндээ зориулах байдлаар хуваарилж байгаа орлого чинь өнөөдөр бага ч гэсэн өмнө нь нэг тодорхой хэмжээнд юу гэдэг юм энд тэнд ороод орой үдэш үр хүүхэдтэйгээ хоол ундаа өөр газраа очоод идчихдэг энэ нөхцөл бололцоо нь байхгүй болчихоод байна шүү дээ. Байхгүй болчихоод байгаа учраас энэ жижиг бизнес эрхлэгчдийн орлого нь буурчихаад байгаа байхгүй юу. Энэ маань эдийн засаг унаад байгаагийн нэг тодорхой илэрхийлэл, жишээ. Энийг л засаж залруулъя гээд тавихаар л Монгол Ардын Нам одоо ярьсаар байгаад эдийн засгийг унагааж байгаа юм шиг. Одоо сүүлдээ бүр Монгол Ардын Намын тавьсан санал дээр үндэслэж энэ Монголын гадаадын хөрөнгийн биржүүд дээр ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдийн хувьцааны үнэ унаж байгаа юм шиг юм ярьж байна шүү дээ. Энэ чинь бүр аль 2, 3 сараас, 1 сараас өгсүүлээд унаад эхэлсэн нь тодорхой болсон шүү дээ. Ямар сая сүүлийн тавигдаж байгаа, бид нарын тавьсан 14-хөн хоногийн хугацаанд тавьсан асуудалтай холбогдож үүсэж байгаа асуудал биш байхгүй юу.

Энийг ингээд хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглаад Монгол Ардын Намын явуулж байгаа үйл ажиллагаатай, Монгол Ардын Намтай холбох гээд байх бол шаардлагагүй гэж бодож байгаа юм. Зарим нэг сайдууд нь бас энийгээ хүлээн зөвшөөрсөн. Монгол Улсын эдийн засаг хүнд байдалд орсон байгаа гэдгийг хүлээн зөвшөөрсөн байгаа шүү дээ. Энэнээсээ гарахын тулд ажиллаж байгаа гэдгийг бас бүх хүн мэдэж л байгаа. Тэгэхдээ ажиллаж байгаа үйл ажиллагаа нь болохгүй байна гэдгийг бид нар хэлээд байгаа байхгүй юу. Тийм учраас энэ үйл ажиллагаанууд дээрээ дүгнэлтээ хийгээд манай олонхийн одоо манай зарим Их Хурлын гишүүд маань бас ямар ч байсан шударгаар хандана байх гэж бодож байгаа. Шударгаар.

Бид өнөөдөр улс орныхоо хөгжлийн төлөө л ажиллана гэж ард түмэндээ амалж байгаад энэ суудалд сууж байгаа улсууд шүү дээ. Тийм учраас энэ суудал дээр ард түмэндээ амалсан амлалтаа бид нар хэрэгжүүлж Монгол Улсынхаа эдийн засгийг өөд нь татахын төлөө л бүгдээрээ хамтарч чармайж ажиллах ёстой юм. Тэрнээс биш хэн нэгэндээ хандаж хатуу үг чулуудаж улстөржөөд байх шаардлага байхгүй юм.

Тэгээд одоо саяны зарим нэг улсуудын хэлсэн шиг энэ улс оронд үүсээд байгаа нөхцөл байдал жаахан тааруухан юм болохоор бүгдийг нь Монгол Ардын Нам руу жихдэгээ болих хэрэгтэй байх гэж бодож байгаа юм. Энэ танхимд бол нэг их тэгж улстөржөөд бие биеэн рүүгээ хэрүүл уруулын үг шидээд байх шаардлагагүй байх гэсэн ийм саналыг хэлэх байна.

**3.Энхболд:** - Ч.Сайханбилэг гишүүн үг хэлнэ.

**Ч.Сайханбилэг:** - Байнгын хороон дээр бол ерөнхий чиглэлүүдээр үг хэлсэн. Өнөөдөр бас нэг хэд хэдэн үндэслэлтэй холбоотой асуудлуудаар нь бас нэг тайлбар өгөхгүй бол болохгүй. Тэгээд эхлээд би энэ тайлбараа өгчихөөд цаг үлдвэл бас бусад асуудал руу орёе.

Ер нь бол одоо 2012 онд энэ засаг хүлээж авахад төрийн яамд 930 хүний орон тоотой. Агентлагууд 3494 хүний орон тоотой. Нийтдээ төрийн захиргааны албан хаагч бол 4424 байсан. Бид нар бол шинэ Засгийн газар гараад энэ хүрээнд авч хэрэгжүүлсэн ажлын хүрээнд яамдууд 1707 болсон, агентлагууд 3494 нь 2333 болж буурсан. Нийт төрийн захиргааны албан хаагчдын тоо 4424-өөс 4040 болж нийтдээ ингээд 384 хүнээр буурсан байгаа.

За яамдаас бол Төрийн албаны зөвлөл, одоо энэ Хэрэг эрхлэх газар, Сангийн яаман дээр гарсан энэ тоонуудын зөрөлцөөн бол дахиад аргачлалын хувьд ялгаанууд дээр гарч байгаа. Жишээлбэл, зарим яамд өөрийн үндсэн бүтцээс гадна төсөл хөтөлбөр дээр болон гэрээгээр ажиллаж байгаа хүнийхээ тоог бол Төрийн албаны зөвлөлд гаргаж өгсөнтэй энэ холбоотой. Агентлагуудын хувьд гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа албан хаагчдынхаа тоог бас нэмж гаргасан. Жишээлбэл, Улсын бүртгэлийн ерөнхий газар гэхэд сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой гэрээгээр ажиллаж байгаа хүнийхээ тоог, Гаалийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар нь харъяа байгууллагууд, орон нутгийн салбарт ажиллагсдынхаа тоог гаргаж өгсөнтэй холбогдуулаад энэ тооны наана цаана байгаа.

Тэгээд энэ байгууллагууд бол эцэслээд суухад энэ тоонууд бол бүгд үндсэндээ бол гарна. Дээрээс нь бол 2013 онд нэмэгдэж байгаа болон нэмэгдүүлэхээр тооцож төсөвт суулгасан орон тооны өсөлттэй холбоотойгоор төрийн үйлчилгээний байгууллагууд дээр орон тоо нэмэгдэж байгаа юм. Одоо ингээд шинээр байгуулж байгаа ерөнхий боловсролын сургуулиуд, цэцэрлэгүүд, мөн эрүүл мэндийн салбарын байгууллагууд, биеийн тамир, спортын хороо, клубууд гээд энэ хүмүүсийнхээ төсөвт суулгасан дүнг нь нэмэхээр тэртээ тэргүй нэмэгдэж байгаа юм.

Ер нь бол нэг юмыг хаа хаанаа ойлгох хэрэгтэй. Бид нар бол ингээд нэг талаасаа бол цомхон бүтэцтэй, хэмнэлттэй ажил гэдэг шүүмжлэлийг байнга манай сөрөг хүчин хүчин гаргадаг. Нөгөө талаасаа хоморголон халлаа гээд ингээд унадаг. Энэ хоёр галын хайчийн дунд нэг ч Засгийн газар, нэг ч юм бол тэсч үлдэхгүй шүү дээ. Яагаад гэхээр хоорондоо боломжгүй хоёр зүйлийг шаардаж байгаа учраас. Тэгэхээр энэ хоорондоо бид нар чинь бас нэг хоорондоо учир утгаа олж ажиллах тухай асуудал байна уу гэхээс биш өөрөөр бол энэ нэг талаас цомхон бай, нөгөө талаас бөөнөөр нь хоморголон халж байна гэдэг хоёр дотроос чинь нэг үнэн олдох тухай асуудал бол ерөөсөө гарахгүй шүү дээ. Тийм учраас хаа хаанаа энийгээ бүгдээрээ ойлголцож ажиллах ийм шаардлага байгаа юм.

Ер нь яриад байвал жишээнүүд их олон ярьж болно. Одоо жишээлбэл, хуучин Хууль зүйн яамтай харъяатай нөгөө Гадаадын иргэн, харъяатын асуудал дээр 117 хүн нэмэх энэ асуудал явж байсан. Бид нар Засгийн газар дээрээ ярьж байгаад 117 биш ээ. 17-гоор энэ үйл ажиллагааных нь чиглэл өөрчлөгдөж байгаа учраас нэмэхгүй бол болохгүй гээд нэмсэн иймэрхүү жишээнүүдийг ярьдаг. Гэхдээ энэ бүгд дахиад эргээд хоосон улс төржилт болно. Бид нар урд талын Засгийн газар 2000-2004 оны энэ бүх зүйлүүдийг бол ярьж хэлж байсан шүү дээ. Ер нь бол ингээд 2004 онд хийсэн томилгоо, 2004-2008 онд хийсэн томилгоо гээд 45 удаагийн томилгоо, 20 нь түр хугацаагаар, 22 нь явцын дунд гээд.

Ер нь энэ сонгуулийн үр дүнгээс шалтгаалаад энэ процессууд ерөөсөө яваад байна. Тийм учраас Төрийн албаныхаа хуулийг өөрчилъе. Одоо Ардын намын нэр бүхий гишүүд Төрийн албаны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ хуулийн төслөө санаачилсан байгаа. Өнөөдрийг хүртэл хэлэлцэхгүй байна. Даргын зөвлөлийн хурал дээр байнга санал тавьдаг. Энэ асуудлаа долоо долоо хоногоор хойшлуулаад л яваад байгаа. Асуудлаа ийм байна гээд тэгэх юм бол хоёр талаасаа ярьж байгаа энэ асуудлуудаа уг нь цэгцлээд, хууль эрх зүйн орчингоо боловсронгуй болгох энэ зүйлүүдийгээ хаанаа хаанаа яриад явах энэ шаардлага байгаа гэвэл байгаа шүү дээ. Энийгээ сууж байгаад ярья. Хоосон улс төрждөгөө больё. Гэнэт саран дээрээс буугаад ирсэн юм шиг. Эсвэл хуучин цагаан байснаа өнөөдөр хар болж байгаа юм шиг, хар нь цагаан болж байгаа юм шиг ийм зүйлүүд яриад байхаар хаанаа ч итгэл үнэмшил төрөхгүй, хаанаа ч хоосон улс төржилт л гэж харагдана. Тийм учраас төрийн алба энэ чиглэлийнхээ зүйлийг хаана хаанаа улс төрийн хүчнүүд, намын бүлгүүд сууж байгаад хамтдаа хийх ёстой.

Одоо С.Бямбацогт гишүүний ярьж байгаа Үндсэн хуулийн, энэ бол цэцийн дүгнэлт биш. Дүгнэлт бол Их Хурлаар хэлэлцдэг. Наадах чинь зүгээр магадлал байхгүй юу. Би дахиад хэлж байна. Магадлал. Наадах чинь албан бичиг гэсэн үг. Тэр албан бичиг дээрээ жишээлбэл Үндсэн хуулийн энэ зөрчлийн асуудал байхгүй байгаа учраас бид нар энэ цэцийн хуралдаанаа хийхгүй гэдэг ийм л зүйл бичсэн бичиг шүү дээ. Та тэрийг нь бүтнээр нь уншихгүй байгаа байхгүй юу.

Тэгээд энэ яагаад гэхээр зэрэг өнөөдөр Үндсэн хууль зөрчсөн тухай асуудал байхгүй. Би урьд нь ч гэсэн хэлж байсан. Улсын Их Хурал хууль



гарчихаад нэмэлт, өөрчлөлт хийдэг. Урьд нь гаргасан хуулиа хүчингүй болгодог. Яг тэрэнтэй адилхан энэ хооронд хэн хохирсон юм гэдэг асуудлыг хэзээ хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр ярьж байсан юм. Тухайн үедээ тухайн хууль, тухайн эрх зүйн акт, журам үйлчлээд явдаг. Энийгээ нэмэлт, өөрчлөлт хийдэг эрх бүхий субъект нь хийгээд явсан бол хийгээд л явсан. Хуулийнхаа хуульд бол ийм л ойлголт байдаг шүү дээ. Тэгээд Улсын Их Хурал дээр өөр, Засгийн газар дээрээ шал өөр талаар ингэж харж.../минут дуусав/.

**3.Энхболд:** - Б.Бат-Эрдэнэ гишүүн үг хэлнэ.

**Б.Бат-Эрдэнэ:** - За их баярлалаа. Би үг хэлж болох уу Ч.Сайханбилэг дарга аа. За би нэг санал хэлье. Ер нь олон саналууд гарсан учраас.

Тэгэхээр би бол энэ амлалт нэхэх гээд байна л даа. Амлалт нэхэх ард түмний холбоо гэдэг шиг. Одоо тэр үргэлжлүүлээд бид шаардаж шахахаас өөр үггүй байна. Энэ бол нөгөө 1.5 сая төгрөгтэй холбоотой асуудал. Та бүхэн хамтарч одоо Засгийн газар байгуулаад тэгээд хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрт энэ сонгуулийн өмнө дэвшүүлсэн 1.0 сая төгрөг, 1.5 сая төгрөгөө нэгтгээд 1.5 сая төгрөг одоо иргэддээ олгоно гэж ийм зорилт тавьсан. Тэгээд энэ зорилтоо хэрэгжүүлэхийн төлөө нэлээн олон зорилт, ажлуудыг хийсэн.

Тэгэхээр нэгэнт энэ хамтарсан Засгийн газрын энэ дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр учраас энийгээ одоо бодит хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Энэ хэрэгжилт чинь одоо өнөөдрийн яригдаж байгаа энэ бүх юм нь дотор чинь мартагдаад алга болчихоод байна. Одоо 2 сая 700 мянган иргэндээ сая 72 ширхэг хувьцаа эзэмшүүлнэ гээд. 1072 ширхэг хувьцаа. 1500 аж ахуйн нэгжүүдэд 29.0 тэрбум төгрөгөөр энэ Тавантолгойн 29.0 хувийг нь эзэмшүүлсэн байгаа. Гэтэл энэ тухай асуудал ерөөсөө хаана ч яригдахгүй, хөндөгдөхгүй байна. Тийм учраас одоо энэ асуудлаа яаралтай шийдэж өгөх хэрэгтэй.

Та бүхэн маань энэ 8 сарын хугацаанд ерөөсөө энэ Тавантолгойн орд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажил бол одоо өмнөх Засгийн газар. Өөрсдийгөө хэлээд байгаа юм л даа. Энэ чинь хамтарсан Засгийн газар. Бүр одоо Ерөнхий сайд Н.Алтанхуяг сайд одоо Шадар сайд байхдаа тэр ажлын хэсгийг ахалсан. Ардчилсан намын одоо энд сууж байгаа олон хүмүүс Засгийн газрын бүрэлдэхүүнд байж байхдаа тэр ажлын хэсэгт орж ажиллаад ингээд одоо энэ Тавантолгой, Чалкотой гэрээ байгуулсан юм байна шүү дээ. Тэгээд энэ гэрээ байгуулсныхаа дагуу бол одоо тодорхой ажлуудыг хийгээд 350.0 сая долларын урьдчилгаа аваад, ард иргэддээ нөгөө Хүний хөгжил сангаар дамжуулаад мөнгийг нь өгөөд. Тодорхой ажлуудыг хийсэн юм байна. Энд одоо судлаад гаргаад ирсэн материал дээрээс харах юм бол тэр тухайн үедээ бол одоо бололцоотой ийм одоо шийдвэр арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байсан юм байна. Харамсалтай нь энэ сүүлийн 4, 5 сарын хугацаанд Тавантолгойтой холбоотой асуудлыг ерөөсөө одоо өмнөх Засгийн газрын асуудал. Эд нар л одоо буруу юм хийсэн гэж баахан хараар будаад Тавантолгойн энэ хэвийн явах энэ үйл ажиллагааг нь 4, 5 сараар зориуд зогсоогоод цаад талд нь одоо өөр ашиг сонирхлын олон зүйлүүдийг оруулаад

ингээд гацаачихсан байна шүү дээ. Яг бодит байдал дээрээ эргээд дахиад одоо бид нар Чалкотай гэрээ хэлэлцээрээ дахиж шинэчилж байгуулаад ингээд одоо Тавантолгойгоос нүүрс ачлаа гэж ярьж байгаа бол яг бодит амьдрал дээр тийм биш юм байна шүү дээ. Энэ чинь тендерээр одоо тодорхой юмнуудаа зарлаж шийдүүлж авчихаад тэгээд Тавантолгой бол яг Чалкотай хийсэн гэрээнийхээ дагуу 53 доллараар гаргаж байсан бол одоо үнийн индекс, биржүүдийн үнэ дээр суурилсан үнээрээ энэ хоёрдугаар улирлаас эхлээд 56 доллар, 3 доллараар ахиулаад ингээд одоо гаргаж байгаа юм байна шүү дээ.

Ингээд ийм бодит амьдрал юм нь дээрээ суурилж байж одоо ажлаа яримаар байна. Өнөөдөр одоо ойлголт өгч байгаа бол яг миний түрүүний хэлдэгээр Тавантолгойтой холбоотой юмнууд чинь ингээд замхраад байна шүү дээ. Тэгээд тийм учраас хэрвээ одоо энэ 4 сарын хугацаанд зориудаар одоо энэ Тавантолгойн нүүрс экспортлох ажлыг ингэж зориудаар гацаагаагүй байх юм бол тэр авсан 350.0 сая доллараас чинь энд бид нарт ирүүлсэн энэ тоо материал дээр бол 171.0 сая долларынхаа өрийг бол гаргачихсан. Дахиад одоо нэг 3 сая тонн нүүрс гаргачихад бол үлдсэн өрөө дараад тэгээд одоо Тавантолгой компани бол цаашдаа хэвийн ажиллах ийм бололцоотой юм байна шүү дээ. Тэгээд тэрийг нь зориудаар таслуулчихсан учраас одоо тэнд чинь өчнөөн олон алдагдал гараад тэгээд энэ бүх ажлууд чинь гацчихаад байна шүү дээ. Тэгэхээр тийм учраас одоо энийгээ тодорхой шийдвэр гаргаад Засгийн газар одоо энэ иргэддээ амалсан.

Энэ чинь бол одоо танай Ардын намынхан амласан гэж үзэж болохгүй шүү дээ. Хамтарч одоо та нөхөд минь болно бүтнэ гэж хамтарч байхдаа Засгийн газрынхаа мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн тэр зорилтоо хэрэгжүүлж энэ одоо нийт иргэдээ, 2 сая 700 мянган иргэддээ тэр 1072 ширхэг хувьцаа, тэр 1500 аж ахуйн нэгжийн асуудал.../минут дуусав/

**3.Энхболд:** - Я.Содбаатар гишүүн үг хэлнэ.

**Я.Содбаатар:** - Гишүүдийн энэ өдрийн амар амгаланг эрье. Тэгээд завсарлага авсан хугацаандаа Монгол Ардын Намын бүлгээс 3 ажлын хэсэг гарсан. Нэг нь бол Эрдэнэс Тавантолгой компанитай холбоотой гарсан. Нэг зүйлийг бид нар их тодорхой ойлгох хэрэгтэй. Эрдэнэс Тавантолгой гэдэг компани бол Монголын ард иргэдэд 1072 хувьцаагаар очсон ард түмний компани. 1500 аж ахуйн нэгж 29.0 тэрбум төгрөгөөр энэ компанийн хувьцааг эзэмшиж байгаа юм. Энэ телевиз үзээд, хэвлэл мэдээлэл хараад сууж байгаа бүх хүмүүс таны өмч рүү гар дүрсэн байна. Энэ Эрдэнэс Тавантолгойн удирдлага, зохион байгуулалтад дандаа Ардчилсан намын парламентэд байгаа хүмүүсийн ах дүү нар битүү шигсэн байна. Бүх алба хэлтсийн дарга нар нь дандаа эд нарын үр хүүхдүүд болсон байна. Энийгээ больмоор байна.

Үнэхээр тэр хувьцаа эзэмшиж байгаа 2.5 сая иргэний минь төлөөлөл алга. 1500 аж ахуйн нэгжийн төлөөлөл, хяналт алга. Энийг яаралтай хяналттай болгож өгөөчээ гэдгийг нэгдүгээрт хүсмээр байна.

Хоёрдугаарт, Эрдэнэс Тавантолгой компани Чалкотай байгуулсан

гэрээний асуудлыг ярьж байна. Бид нар шалгасан. Үзсэн. Чалко компанитай ямар нэгэн гэрээний өөрчлөлт хийгдээгүй. Улирлаар үнэ тохирч байгаа. Нэгдүгээр улирлын үнэ нь 53-аар ирсэн. Энэ хоёрдугаар улирлын үнэ 56-гаар ирж байгаа. Тэгээд л 56-гаар гаргаж байгаа. Тэр хооронд 100-д хоног тодорхойгүй шалтгаанаар зогсоосон. Тэгээд энэ шалгалтын хүрээнд гарсан нэг томоохон зүйл бол Говь пауэр компани буюу гаалийн үйлчилгээ үзүүлэх тендертэй холбоотой асуудал. Энэ асуудлыг бид нар Их Хурал дээр гаргаад тавихынхаа өмнө бүх бичиг баримтыг авсан байсан. Энэ компани бол 1 сарын 7-ны өдөр Гэрэлхүүгийн Уянгын нэр дээр Дашзэвэг гэдэг хүнээс шилжиж очоод 8-ны өдөр 1.0 тэрбум төгрөгийн үнэлгээтэй болоод. Долоо хоногийн дараа 17 тэрбум 700 сая төгрөгийн тендер авч байгаа юм. Чуулган дээр энэ асуудлыг хөндөж тавьсны маргааш Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Ц.Пүрэвдоржийн гарын үсэгтэй нөгөө Гэрэлхүүгийн Уянга маань Чулуунбаатарын Уянга болж орж ирсэн.

Одоо эхлээд нэг хулгай хийдэг, худлаа ярьдаг байсан бол одоо энэ Улсын Их Хурлыг худлаа мэдээллээр хангадаг, худлаа баримт бичиг бүрдүүлдэг. Түүнийг бүрдүүлэхгүй гэсэн төрийн албан хаагчдыг халдаг ийм зүйл гарч байна. Энийг Ерөнхий сайд анхааралдаа аваачээ. Тийм зүйл хийхээ болиочээ гэж гуймаар байгаа юм. Энийг бид нар Монгол Улсын Ерөнхийлөгч холбогдох хуулийн байгууллагуудад нь Хууль зүйн яам, байгууллагуудад тавьсан. Асуудал хуулийн дагуу явах байх гэж харж байгаа.

Авлигал, хээл хахуулийн шинэ торыг Н.Алтанхуяг та сүлжиж эхэллээ. Авлигал, хээл хахуулийн шинэ торыг, шинэ сүлжээг Н.Алтанхуяг та сүлжиж эхэлсэн байна. Шалгалтын явцад ийм тодорхой баримтууд гарч ирж байна. Хэрэг эрхлэх газар дээрээс чиглэл өгөөд баригдаж байгаа 27 давхар байшингаас эхлүүлээд олон зүйлийг ярьж болж байна. Өнөөдөр энд гарч ирж байгаа энэ компанийн тендертэй холбоотой асуудал гарч ирж байна.

Тэгээд энэ асуудлууд чинь бол тодорхой гаргаж тавина аа дарга аа. Энийг чинь тавихгүй бол дахиад та наанаа гоё ярьдаг, цаанаа ийм худлаа ярьдаг зүйл чинь болохгүй. Худлаа ярьдаг, хууль зөрчдөг Ерөнхий сайдтай баймааргүй байна. Хууль зөрчсөн бол нэг өдөр ч, 8 сар ч байж болохгүй. Хугацаа сүүлийн үед Ардчилсан намаас тавьж байгаа хүмүүсийн санал хэлээд байна. 8-хан сар болсон юм. Хууль зөрчсөн бол 1 минут ч гэсэн тэр хүн болсны дараа хариуцлагаа хүлээх учиртай. Тийм учраас Ерөнхий сайд та хууль зөрчиж худлаа ярьдагаа больчихмоор байна. Нэг зүйлийг гуйя. Ардчилсан намынхнаас ч гэсэн нэг л зүйлийг гуймаар байна. Ард түмний нэрийн өмнөөс танаас ганцхан зүйлийг гуйя. Энэ танхим дотор үнэн мэдээлэл өгч байгаачээ. Энэ танхим дотор үнэн ярьдаг байгаачээ.

Зарим орны парламентэд байдаг шиг парламентэд үг хэлж байгаа албан тушаалтнууд зөвхөн үнэнийг хэлнэ гэдэг тангараг өргөдөг болбол бас зүгээр юм шиг байгаа юм. Тэгэхгүй бол Ерөнхий сайдаасаа эхлүүлээд хүн болгоны амнаас гарч байгаа үг нь худал болоод байна. Сая Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг бас худлаа мэдээлэл өгчихөөд гараад явчих юм. Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргахдаа хоёрхон хэлбэрээр гаргадаг. Нэг нь тогтоол, нөгөөдөх

магадалгаа.

Энэ Н.Алтанхуяг даргын Үндсэн хууль зөрчсөн 3 асуудал дээр магадалгаа гарсан. Үндсэн хуулийн цэцийн гаргадаг шийдвэрийн нэг хэлбэр. Гэтэл энэ албан бичиг албан тоот явсан юмаа гээд Ч.Сайханбилэг энд яриад сууж байдаг. Ийм нэг үнэгэн зальтай байж болмооргүй байгаа юм.

Дахин хэлэхэд үнэхээр энэ ард түмний энэ компани цаашдаа компанийн цэвэр засаглалтай энэ хувьцаа эзэмшиж байгаа ард иргэдийнх хяналт доор, энэ компаниудынх нь хяналт доор ингэж явуулж ... /минут дуусав/

**3.Энхболд:** - Г.Батхүү гишүүн алга байна. С.Дэмбэрэл гишүүн үг хэлнэ.

**С.Дэмбэрэл:** - За баярлалаа. Н.Алтанхуяг Ерөнхий сайдыг анх томилогдож байхад нь би таны хэрэглэхгүй байх, эсвэл маш их бага хэрэглэх болон аягүй их хэрэглэж байх ёстой үгнүүдийг хэлж байсныг санаж байна. Энийг одоо арай өөр утгаар дахиж давъя даа. Өөрөөр хэлбэл цаашдын чинь үйл ажиллагаанд хэрэг болох болов уу гэж.

Нэгдүгээрт, хэрэв бусад чинь дандаа нүүрс ярьж байвал та нүүрс ярьдаг баймааргүй байна. Хэдийгээр шуудайтай нүүрсний үнийн учрыг гинжин хэлхээнд олох гээд явж байгаа таны энэ тодорхой үйлдэл чинь Ерөнхий сайдын хувьд хэрэгтэй ч гэсэн макро алсын хараа дутагдаад байна. Өөрөөр хэлбэл та сайд нартай хэт их итгэх гэж томъёолох юм уу, ямар ч гэсэн эдийн засгийн хөгжлийг эдийн засгийнхаа хөгжлийн сайд. Гэтэл Ерөнхий сайдын макро алсын харааг илэрхийлсэн ийм үйлдлүүд дутагдаад байна гэдгийг анхаарна уу.

Хэрэв бүгд нүүрс ярьж байвал та ногоон хөгжил ярьж байх ёстой. Хэрэв бүгд Сайншанд, төмөр зам ярьж байвал та эрүүл мэндийг ярьж байх ёстой. Одоо миний энэ ширээн дээр 2012 оны энэ номыг та бүр авч үзээрэй. Эрүүл мэндийн салбар 2012 гээд энэ ном байна. Дээр нь уржигдархан авч хэлэлцсэн Монгол Улсын байгаль орчны төлөв байдлын илтгэл гээд. Энэ хоёр номыг Ерөнхий сайдын хувьд та уншаад. Тэрний дээр нь ноднин жил гарсан Монгол Улсын эмзэг байдлаас тогтвортой байдал руу гэсэн энэ илтгэлийг уншихаар таны лидерын, манлайлагчийн үүрэг чинь өнөөдөр арай хэт нийтийн бусдаас ялгарч чадахгүй байгаа гэдэг тийм дүр зураг гарч ирнэ. Тэрийг би танд Ерөнхий сайдын чинь хувьд одоо зөвлөж хэлж байгаа юм.

Өнөөдөр та энэ макро алсын хараа гэдэгт би юуг хэлээд байна вэ гэхээр энэ Сангийн сайдын ч юм уу, Эдийн засгийн сайдын ярьдаг тэр тоонуудыг биш тэрний цаадах агуулга буюу хүн ардынх нь амьдрал бодит байдал дээр ямар тоо баримтууд дээр тэр хүмүүсийн хэлдэггүй үзүүлэлтүүдээр нь илэрхийлэгддэг юм бэ гэдгийг та уул нь бол сайд нартаа хэлээд энэ чиглэлээрээ та нар анхаараачээ гэж хэлэх гол тийм Ерөнхий сайдын үүрэг чинь байгаа.

Би таныг Н.Удвал сайд болон С.Оюун сайдад онцгой анхаараасай гэж бодож байна. Тэр хоёртой сард ядахдаа хоёр уулзаад эрүүл мэндийн салбарын санхүүжилт нь, чанар нь, хүртээмж нь байгаль орчин болон ногоон хөгжлийн

өнөөгийн байдал нь ямархуу явж байна. Ярианаас хэтрэхгүй байна уу, эсвэл миний оролцоо дутагдаж байна уу гэдэг нь манлайлагчийнхаа үүргийг биелүүлээсэй гэж хүсэж байна.

Хэрэв инфляци 9.8 гээд нэг оронтой тоонд орсон гэдэг хэлж байгаа бол та битгий тэрэнд үнэмш. Би таныг өөр талаас нь хандаасай гэж бодож байна. Өөрөөр хэлбэл тэр инфляцийн сагс гэдэг дотор нь юу юу ордог юм. Тэгээд ардын амьдрал дээр энэний нийт тооцоогоор нь махны үнэ болон бусад хүнсний гол зүйлүүдийн үнэ дээр энэ шинэтгэлийн чинь процесс яаж явж байна.

Ч.Сайханбилэг ээ, таны үйл явц чинь яаж явж байна гэдэг дээр та илүү анхаараасай гэж бодож байна. Би таныг мэднэ. Сүүлийн үед олон сайхан ажлууд хийж байгаа танай Засгийн газар. Тэгэхдээ нэг гараараа реформын багцыг атгачихаад нөгөө гараараа реформдоо саад болох юмнуудыг бас атгаад байна. Тэгэхээр зүүн гартаа байгаа зүйлээ унагаагаачээ. Өөрөөр хэлбэл энэ төрийн сайн засаглалыг бий болгох энэ үйл явцад та илүү анхаарал хандуулаасай. Энэ чинь энэ өнөөдрийн ярьж байгаа энэ сэдэвтэй ч гэсэн хамааралтай зүйл болчихоод байна. Сайн засаглалгүйгээр ард түмэн хэзээ ч хувьцаа эзэмшигч болж чадахгүй. Сайн засаглалгүйгээр хувийн хэвшил хэзээ ч жинхэнэ ёсоор хөгжиж чадахгүй. Сайн засаглалгүйгээр зээлийн хүү нэг оронтой тоонд бодитойгоор орж чадахгүй.

Тийм учраас Н.Батбаяр сайдыг би магтаж байна. Гэхдээ Н.Батбаяр сайдын одоо хийж байгаа зүйл бол дутуу байгаа. Та энийг илүү олж харах үүрэгтэй. Энийгээ хэрэгжүүлээсэй гэж бодож байна. Учир нь бол зээлийн хүүг нэг оронтой тоонд үнэхээр бодитойгоор оруулахын тулд та мөнгөний бодлогыг өөрчлөхөд онцгой анхаараасай гэж бодож байна. За баярлалаа.

**3.Энхболд:** - За 13.00 цаг боллоо. Сунгасан цаг дуусч байна. Одоо 3 гишүүн үг хэлнэ. Дараа нь хэрвээ Улсын Их Хурал дахь намын бүлгүүд дүгнэлттэй бол танилцуулж болно. Одоогоор Ардын Намын бүлэг, Ардчилсан Намын бүлэг дүгнэлтээ танилцуулна гэсэн хүсэлтээ илэрхийлсэн байна.

Тэгээд үдээс хойш 14.00 цагаас Н.Номтойбаяр гишүүнээр эхэлж үг хэлээд намын бүлгүүд үг хэлэх бол үгээ надад мэдэгдэх хэрэгтэй. Цайны завсарлага. 14.00 цагаас. Үг хэлэх юм байна. Тийм ээ. За.

**Хуралдаан 13 цаг 00 минутад завсарлаж, 14 цаг 24 минутаас үргэлжлэв.**

**Тав. Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах эсэх тухай асуудал**  
(үргэлжлэл)

**3.Энхболд:** - За гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Суудалдаа сууцгаая. Үдээс хойшхи хуралдаанаа үргэлжлүүлэе. Гишүүд үг хэлж байгаад завсарласан байгаа. Н.Номтойбаяр гишүүн үг хэлнэ.

**Н.Номтойбаяр:** - За баярлалаа. Тэгэхээр энэ үг маань миний гэхээс илүү Монгол Ардын Намын дэргэдэх Нийгмийн ардчилсан, Монголын залуучуудын

холбооны 70 мянган залуусын төлөөлөл болгож энэ үгийг хэлж байгаа юм.

Улс төрчид эрх мэдэл, эд мөнгөнд шунавал улс орон сүйрдэг гэдэг үг олны дунд байдгийг юуны өмнө танд. Ерөнхий сайд Н.Алтанхуяг аа. Ерөнхий сайд аа. Би танд л хандаж хэлээд байгаа юм л даа. Та түр анхаарлаа хандуулахыг хүсье.

Улс төрчид эрх мэдэл, эд мөнгөнд шунавал улс орон сүйрдэг хэмээг үг байдгийг юуны өмнө танд уламжлая.

Засгийн газрынх тэргүүн та эрх мэдлийн болон эд мөнгөний шуналтай гэдгээ удаа дараа нотоллоо. Үүнд,

Нэг. Таны эрх мэдлийн төлөөх шунал. Ерөнхий сайд Н.Алтанхуяг тэргүүтэй Засгийн газар шинэчлэл хийх нэрийдлээр төрийн албыг төрлийн алба болгов. Төрд ажиллах сэтгэлтэй, чадалтай, зүтгэлтэй гэх зэрэг шалгууруудыг урьтал болголгүй та өөрийн хамаарал бүхий этгээдүүдийг төрийн албанд шургуулснаар Монгол төрийнх залгамж чанарыг алдагдуулж төрийн байгууллагуудын бүтцийг данхайлгаж төрийн чадамжийг сулруулж байна.

Та өөрийн эрх мэдэлд үгүй дуугүй шууд захирагдах хүнийг хүсэмжилж, эрх мэдлээ илүү дүйцэн эрх мэдлийнхээ цар хүрээг тэлж байгаа нь төр биш та хүчирхэг байгааг үнэхээр харуулж чадаж байна.

Товчхон дүгнэхэд аливаа өөртөө итгэлгүй удирдагч чадварын хувьд өөрөөсөө илүү гаргахгүй, үгүй дуугүй дагагч нараар өөрийгөө хүрээлүүлж дуугүй сууж дарга аа гэж далдганадаг хүмүүсээр бүрдүүлдэгийн адил та хуулиас илүү хувь хүнийхээ хүслээ урьтал болгон дураараа авирлаж эдгээр үйлдлүүд нь байгаа үйлдлүүд нь санамсаргүй биш санаатай үйлдэл ба эрх мэдэлдээ бат суух гэсэн таны эрх мэдлийн төлөө шунал тэмцэл мэт харагдаж байна.

Хоёрт, таны эд мөнгөний талаарх шунал. Хүний хөгжил сангийн хуулийн дагуу Монгол Улсын иргэн бүр стратегийн ордоосоо хувь хишиг хүртэх, үр өгөөжийг иргэдэд хувьцаа эзэмшүүлж, ногдол ашгийг хуваарилж, иргэнээ дэмжиж байх зорилгоор байгуулагдсан Эрдэнэс Эм Жи Эл төрийн өмчит компани байгуулсан ба Монголын нийт 2.8 сая иргэдийн төлөө ажиллах үүргийг хүлээсэн. Монгол Улсын иргэн бүр Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн сая төгрөгтэй тэнцэх нэрлэсэн үнэ бүхий 1072 ширхэг хувьцааг иргэн бүрд Монгол Ардын Нам, Ардчилсан Намын хамтарсан Засгийн газрын үед шийдвэрлэсэн. Ингэснээр тус компанийн үр ашгийг иргэд ногдол ашгаар хүртэхээр иргэн тус бүр 1072 ширхэг хувьцаагаа уг компанийн хувь эзэмшигч болсон ба Монголчуудын эрх ашиг энэтэй шууд холбоотой.

Монгол өрх гэр маань маш олон хүнд асуудлаар баян байна. Ажилгүйдэл, ядуурал газар авч байна. Иргэд маань Эрдэнэс Тавантолгой үр ашгаасаа гэж хүсэж, мөн түүнээс горьдож байна. Гэтэл Засгийн газрын тэргүүний хувьд үйл ажиллагааг нь аль болох дэмжихийн оронд хувийн болон хамаатан садныхаа эрх ашгийн төлөөх хувийн компанийг хууль бусаар 17.0 тэрбум төгрөгийн

өртөгтэй тендерт ялуулснаар эд мөнгөнд ямар их шуналтайг эрх мэдлээ ашиглан юуг ч түрэмгийлэн оролцож чаддагийг та маш тодоор харууллаа.

Гаалийн хяналтын үйлчилгээ үзүүлэх нэрийдлээр Эрдэнэс Тавантолгой компанийн тээврийн үйчилгээ үзүүлэх Говь пауэр компаниар дамжуулан хамаарал бүхий этгээдүүдээр эрх ашгийг урьдал болгосон та хожиж ард түмэн хохирох ёстой юм уу. Та өөрийн эрх ашгийн төлөөх өөрийн зээ дүү 23-хан настай Гэрэлхүүгийн Уянга, мөн тендерт хуурамч материал нэр нь хавчуулагдсан Чулуунбаатарын Уянгын ирээдүйг булингартуулж энэ асуудалд золиосолж байгаад залуучууд бид маш их харамсаж байна.

Таны энэ хууль бус үйлдэл, хулгайч шиг үйлдлүүдээ улайран хамгаалах биш учрыг нь тайлбарлах ухамсар танд ер нь бий юу. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал хүндэрч ард түмний амьдралын төвшин доогуур байгаа цаг үе мөчид ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, цалин тэтгэврийг нэмэгдүүлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах ажлуудыг хийхээсээ илүү амин хувийнхаа ажлыг урьтал болгосон шунахай сэдэлдээ хөтлөгдсөн үйлдлүүдийг ард түмэн нийтээрээ харж байна.

Таны энэ шунахай сэдэлтэй үйлдэлд залуучууд бухимдаж жигшиж, мөн ичиж байна. Танд бас гомдож байна. Үнэнийг хэллээ гээд та хөмхий зуугаад өс санаад байх ямар ч шаардлага байхгүй. Харин хүүхэд залуучууд, хүн ардаа бодож зөв шунаж ажил хэрэгчээр асуудалд хандаж чадахгүй бол та өөрийнхөө ёс суртахуун байдаг юм бол ухамсраар ажлаа хүлээлгэн өгөхийг танаас хүчээнгүйлэн хүсэж байна.

Монголын залуусын зүрхэнд тархинд Монгол эх орны маргаашийн хувь заяа зураастай.

Нийгмийн ардчилал, Монголын залуучуудын холбоо.

Хувийг нь танд хүргүүлье. Таны твиттер хаяганд ч гэсэн бас тавъя. Баярлалаа танд.

**3.Энхболд:** - Ө.Энхтүвшин гишүүн үг хэлнэ.

**Ө.Энхтүвшин:** - За энэ хооронд бас нэлээн зүйлийг тодруулах гэж оролдлоо л доо. Ерөнхий сайд маань ч хэлсэн. Түрүүчийн долоо хоногийн хэлэлцүүлэг дээр. Тоонууд зөрөөд байна. Тийм учраас тал талаасаа тавиад ярилцъя гэсэн. Нягталмаар юмнууд байна гэсэн. Тийм ч асуудлууд гарсан. Ингээд завсарлага авсан. Завсарлага аваад ажиллалаа. Та бас тэгж хэлсэн.

Тэгээд энэ бол Ардын нам, олонхийг бүрдүүлсэн Ардчилсан намын Засгийн газрыг л бүр унагах гээд л хонзон санаад хийгээд байгаа ажил бол биш ээ. Зарим хүний амнаас ийм хариуцлагагүй үг өнөөдөр дуулдаж байна. Тийм санаа огт байхгүй. Та бүхний ажилд л туслах гээд байгаа юм энэ бол. Ер нь шүүмжлэлтэй хэлсэн хүн бүхэн бол та нарын дайсан бас биш шүү дээ. Ажлыг чинь сайжруулъя гэж бид нар хандаад байгаа хэрэг байгаа юм.

Дөнгөж Засгийн газар байгуулаад бид нар та нарыг, танай Ерөнхий сайдыг, аль нэгэн сайдыг огцруулъя гэдэг саналыг тавиагүй. Ажиллах боломжийг хангаж өгье гэж 8 сар илүү харсан. Бүхий батлах ёстой хууль, төсөв хөтөлбөр юмнууд дээр оролцсон. Дэмжих юм нь дээрээ дэмжсэн. Ирц бүрдүүлэх зүйл дээрээ бүрдүүлсэн. Ингэж ажилласан. За гэтэл энэ хооронд гарч байгаа зүйл бол төрийн ажлыг 14 хоног гацаалаа гэсэн тийм зүйл ярьж байна. Төрийн ажил ерөөсөө гацаагүй. Засгийн газрын ажил гацаагүй. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд ажилладагаараа л ажиллаж байгаа. Энэ 14 хоногт бид нар ямар асуудал ярисан гэхээр Үндсэн хууль зөрчсөн асуудлыг ярьж байгаа юм. Төрийн албыг тогтвортой ажиллуулах тухай ярилаа. Ард түмний аж байдлыг дээшлүүлэх тухай ярилаа. Ийм л зүйлүүдийг ярьсан байхад яагаад төрийн ажил гацдаг билээ. Энэнээс илүү чухал асуудал гэж жишээ нь одоо хаана юу байдаг юм. Энэ үгийг бас өнөөдөр нэлээн хариуцлагатай хүн сонин дээр ярилцлага өгөхдөө хэлсэн байна лээ. Ийм байдлаар хандаж болохгүй юм.

Үндсэн хуулийг зөрчлөө гэдэг бол хамгийн том зөрчил Ерөнхий сайд аа. Нэг удаа биш, хоёр удаа биш, гурван удаа зөрчлөө. Бусад 4, 5 хуулийн 30 гаруй заалтыг зөрчлөө. Энэ бас Үндсэн хуулийн зөрчил мөн. Яагаад гэвэл хууль дээдлэх явдал төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим гээд Үндсэн хуульд заачихсан байгаа учраас та 3 удаа ч биш ер нь 30, 40 удаа зөрчихөөд байгаа юм. Тэгэхээр энийгээ бол Засгийн газрыг, Ерөнхий сайдыг огцруулах үндэслэл биш ээ гэж зарим нь хамгаалаад сууж байна шүү дээ.

Өнөөдөр хууль зөрчихөөд Улсын Их Хурлын өмнө төрийн хуулийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй Ерөнхий сайд хууль зөрчөөд ингээд явахад бид нар ард иргэддээ юу гэж хэлэх вэ. Хууль зөрчиж байгаа иргэн хүнд одоо бид нар үг хэлэх, хэлэх үг юу байх вэ. Та нар өөрсдөөсөө эхлээрэй. Өөрсдөө хичээгээрэй гэж ингэж л хэлнэ шүү дээ. Энэ хамгийн том зөрчил.

Төрийн албаны талаар бид нэлээн маргалаа. 7 мянга гэлээ. Эртээд Р.Гончигдорж гишүүн бол 3-хан хүний талаар л маргаан, 3-хан хүнийг л хамгаалж энэ асуудлыг тавьж байгаа юм гэсэн. 15 мянган хүн хөдөлгөөнд орчихсон байна. Энэний нэлээд нь өөрийн хүсэлтээр буюу өөр ажилд шилжсэн гэдэг байдлаар өөрчлөгдсөн байна. Энэ чинь бол шахаж байгаа юм. Шахаад гаргачихаж байгаа юм. Өдөр шөнөгүй дуудаад айлгаж байгаад өргөдлийг нь гаргуулчихаж байгаа юм. Зардал ихэсч байгаа юм. Зардал ихэссэн гэдэг чинь төрийн албаны зардал ихэссэн гэдгийг эртээд Монгол Улсын Ерөнхийлөгч хаврын чуулганы нээлт дээр хэлсэн. Бүр тодорхой хэлсэн. Тэр хүнтэй очиж маргах хэрэгтэй. Хэрвээ тэр хүний хэлснийг зөвшөөрөхгүй байгаа бол тэр хүнтэй очиж маргах хэрэгтэй.

Чадалтай боловсон хүчнүүдийг хоморголон халчихаад найз нөхөд, нутаг ус, амраг садан, бизнесийн түнш, ийм шалгуураар улсуудыг тавьчихсан. Өнөөдөр төрийн ажил тэнд үндсэндээ эзэнгүй байна. Ажлаа мэддэг хүнд энэ байхгүй байна гэж байна. Та бүхнийг дэмжиж явсан хүн хүртэл ирээд тэгж байна. Энэ Ардын намын Засгийн газрыг л өөрчлөх юм бол хүнд суртал арилах юм байна гэж би бодож явсан чинь хэд дахин хүнд сурталтай болчихсон байна.



Би одоо ингээд үнэхээр гайхаж сууна гээд танай намыг 90 оноос хойш дэмжсэн хүн ирээд ярьж байна.

Бондыг өнөөдөр, өнөөдөр бондын талаар та бүхэн хамгаалаад л байна. Гэтэл Монголбанк дээр очоод үзчихье гэхээр үзүүлэхгүй байна. Улсын Их Хурлын дарга үзүүлэхгүй гэсэн. Эртээд тэр зөвлөлийнхөө хурал дээр. Олонхийн бүлгийн дарга бас үзүүлэхгүй гэсэн. Үнэхээр л тийм ийм байгаа бол биш юм бол тэрийгээ үзүүлчих хэрэгтэй шүү дээ. Тийм учраас бид нар хууль зөрчдөггүй Ерөнхий сайдтай больё. Хууль зөрчдөггүй. Хууль зөрчсөн хүнд хууль битгий зөрч гэж хэлэх ийм нүүртэй Ерөнхий сайдтай больё гэж.

**3.Энхболд:** - За мэндчилгээ дэвшүүлье. Монголын Хүний нөөцийн удирдлага, шинэчлэлийн академийн Хүний нөөцийн удирдлага, нягтлан бодох бүртгэлийн ангийн багш, оюутнууд нийт 60 хүн Төрийн ордон, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Та бүхний хичээл сурлага, ажил хөдөлмөрт өндөр амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

С.Эрдэнэ гишүүн үг хэлнэ.

**С.Эрдэнэ:** - За баярлалаа. Өглөөнөөс хойш Засгийн газартай холбоотой асуудлыг зөндөө сонслоо. Өнөөдөр би үг хэлэхдээ эхлээд нэг хоёр гуравхан зүйлийг зүгээр түүхийн баримтыг хэлье гэж ингэж бодож байгаа юм.

Нэгдүгээрт, өнөөдөр сөрөг хүчний үүрэг гүйцэтгэх гээд сөрөг хүчнийхээ үүргийг гүйцэтгэж ядаж байгаа манай Монгол Ардын Намын нөхдүүдийн ярьж байгаа яриа, гаргаж тавьж байгаа баримт материал бол үнэхээр. Зүгээр л нөгөө нэг аливаа нэг юмны шалтаг, шалтгааныг эрж хайсан нэг арга ядсан ийм л хэлбэрийн үг хэл баримт материал гаргаж тавиад байгаа нь үнэхээр инээдтэй байна.

Сая манай Ө.Энхтүвшин дарга ярилаа л даа. Хууль дээд зарчим бол Үндсэн хуулийн зарчим гэж. Өнөөдөр яг л энэ зарчмаараа л бид нар явах ёстой. Өнөөдөр Үндсэн хуулийг зөрчсөн гээд би одоо өнөөдөр Ерөнхий сайдыг хамгаалах гээд байгаа ч юм алга. Зүгээр Үндсэн хууль зөрчсөн гэсэн тэр Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт хаа байна. Албан ёсны дүгнэлт нь хаана байгаа юм. Өнөөдөр шүүхээр хэн нэгнийг гэм буруутайг тогтоогоогүй тохиолдолд хэн нэгнийг гэм буруутайд тооцож үл болно гэсэн Үндсэн хуулийн харин алтан зарчим байгаа.

Өнөөдөр манай Ц.Нямдорж гишүүн бол их шударга сайхан ярьж байна. Би өнөөдөр бас ийм одоо дүрээ хувиргаад ингээд төрөлж арилчихаад сууж байгаад нь үнэхээр баяр хүргэмээр байна. Та өнөөдөр их олон хүнийг луйварчин, хулгайчаар нь дуудлаа. Нэг олсны үзүүр арай гэж олж аваад татахаар цаад тал нь алга болчихоод байх юм гэж. Та ч гэсэн бас тийм олсны үзүүрт явж л байсан.

Тэгээд өнөөдөр та тэр өчнөөн зуун сая төгрөгийн үнэтэй тэр түрээсийнхээ байранд өнөөдөр байгаа юу, байхгүй юу. Одоо байж байгаа хэвээрээ юу та. Тийм

ээ. Гээд яриад байвал олон юм ярьж болно.

Бид өнөөдөр зүгээр нөгөө нэг ямарваа нэгэн шалтаг, шалтгаан хайж, хэн нэгний муу муухайг дуудах гэж байгаа бол баримттай, нотолгоотой бас нэг төрийн түшээдийн хувьд бас нэг жаахан зангаргатай үгээ хэлж баймаар байна. Арга ядсан, нэг юм хайсан, өө хайсан ийм байдлаар яримааргүй байна.

Би өнөөдөр Нямаагийн Энхболд даргад хэлмээр байна. Танай нам өнөөдөр түүхийнхээ бараг 90 жил, 100 жилийн түүхэнд Монголын ард түмэнд ямар олон арван хүний амь нас, эд хөрөнгө, улс орны хувь заяагаар тоглочихоод өнөөдрийг хүртэл танай нам нэг удаа уучлалт гуйсан уу. Өнөөдөр тэр 30, 40 мянган хүнийг хоморголж буудаж алчихаад 2008 оны 7 сард 5 хүний амь насаар тоглочихоод өнөөдөр танай нам уучлалт гуйсан уу. Өнөөдөр харин тэр өчнөөн 700, 800 залуучуудыг хоморголж аваачиж шоронд хорьчихоод 5 хүний амь насаар тоглочихоод түүнийхээ төлбөрт шагналд гэх юм уу даа бараг. Тэр үед одоо манай С.Дэмбэрэл дарга, Их Хурлын дарга байсан. Тэр шагналд нь харин өнөөдөр та нар төсвийн 11.0 тэрбум төгрөгөөр өөрсдөдөө ордон барьчихаад тэр дотроо хурал, концерт, одоо хошин шоу тоглолтын төв театр болж хувирсан шүү дээ танай ордон. Ингээд байж байгаа шүү дээ. Тэгээд энэ чинь өнөөдөр шударга ёс уу.

Өнөөдөр яривал олон юмыг ярьж болно. Бид нар бие биенийхээ өө хар муухайг дуудалцаад суух юм бол өнөөдөр энд эцэс төгсгөлгүй юм болно. Бид нар энд яах гэж суусан. Яах гэж сонгогдсон юм. Бид өнөөдөр Монголын ард түмэнд амлалт өгч гарч ирсэн. Та нар өнөөдөр энд Монгол төрийн ажлыг зогсоогоод сөрөг хүчин гэдэг нэрийн доор Монгол төрийн нэр хүндийг унагаах гэж энд сонгогдож орж ирээгүй байх. Та нарыг Монголын ард түмэн сонгохдоо бид нарын төлөө, Монголын ард түмний төлөө, Монголын сайн сайхны төлөө юм хийнэ гэж та нарыг сонгосон. Одоо энд та нар зөвхөн улс төр ярьж байгаа. Та нар өнөөдөр Ерөнхийлөгчийн сонгуульд зориулсан улс төрийнхөө шоу тоглолтыг хийж байна. Энэ чинь зүгээр илт байгаа шүү дээ яг ний нуугүй хэлэхэд.

Тэгэхээр ийм байдлаар бид нар өнөөдөр Монгол төрийн бодлогыг явуулна гэж бодож байгаа бол үнэхээр Монголын ард түмэнд бол энэ хохиролтойгоор тусна уу гэхээс сайнаар дуусахгүй.

Бонд яриад л байна. Өнөөдөр 1.5 тэрбум долларын бондын асуудал. Өнөөдөр энэ бонд орж ирээгүй бол Монголын эдийн засаг өнөөдөр ямар байдалд байх байсан юм бэ. Өнөөдөр Оюу Толгойн асуудлыг би өмнөх парламентэд байнга тавьдаг байсан. Одоо манай Б.Бат-Эрдэнэ гишүүн мэдэж байгаа. Оюу Толгойн асуудал анх 2.8 тэрбум долларын өртөгтэйгээр босохоор орж ирж байсан. Өнөөдөр 7.0 тэрбум долларын өртөгтэйгээр босохоор болчихоод байж байна. Энэний хариуцлагыг хэн хүлээх юм. Юун 1.5 тэрбум доллар. Цаана чинь 5.0 тэрбум доллараар тэр Оюу Толгойн чинь өртөг нэмэгдчихээд байна шүү дээ. Тэрийг хэн хөлөх вэ, Монголын ард түмэн төлнө. Монголын ард түмэн, Монголын байгалийн баялгаараа төлнө. Энийг хэн хийсэн юм. Өнөөдөр эзэд нь энд сууж байна. Тэр үед Их Хурлын дарга байсан, Ерөнхий

сайд, Хууль зүйн сайд байсан, гишүүн байсан бүх хүн энд сууж байна. Нэг их энхийн цагаан тагтаа шиг юм битгий ярь.

**3.Энхболд:** - Гишүүд үг хэлж дууслаа. 1 минут дотор нь орчихсон 5 минутаар үг хэлүүлсэн. Гишүүд үг хэлж дууссан.

Одоо санал, дүгнэлтээ танилцуулах нам, эвслийн бүлгүүд үг хэлнэ. Хамгийн эхлээд Ардчилсан Намын бүлгийн Д.Эрдэнэбат, дараа нь Монгол Ардын Намын бүлгийн дарга Н.Энхболд үг хэлнэ. Д.Эрдэнэбат гишүүнийг урьж байна.

**Д.Эрдэнэбат:** - Улсын Их Хурлын дарга,

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгийн нэр бүхий 25 гишүүнээс Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягийг огцруулах саналыг Улсын Их Хуралд гаргажээ.

Ардчилсан Намын бүлэг хуралдаанаараа уг асуудлыг нухацтай хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг гаргаж байна. 2012 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээрээ Ардчилсан Нам, Иргэний Зориг Ногоон Нам, Монгол Ардын Хувьсгалт Нам, Монголын Үндэсний Ардчилсан Намын Шударга Ёс эвсэл, бие даагчид хамтран ардчилал, хүний эрх, эрх чөлөө, Монгол эх орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөө нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт хийх шинэчлэлийн үзэл санаанд нэгдэн шинэчлэлийн Засгийн газрыг байгуулсан.

Монгол оронд шинэчлэл хийх, шударга ёсыг тогтоох үүрэг Норовын Алтанхуягийн тэргүүлсэн шинэчлэлийн Засгийн газарт оногдсон юм. Ардчилсан хувьсгалаас хойш сэргэж эхэлсэн өөрийн гэх өмчтэй, өөрийн бизнестэй болоод өөрийнхөө хүчээр амьдарна гэж итгэж байсан Монголын ард түмний итгэл үнэмшил сүүлийн жилүүдэд аажмаар алдарч бэлэнчлэх хандлага газар авч түмний баялгаас сорон амьдрагсад энэ нийгэмд олширсон.

Дэлхий дахинд эдийн засгийн эрч саарч Европын орнуудын өрийн хямрал хурцдаж, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт буурсан цаг хугацаа давхцаж дотоодын эдийн засаг тэнцвэргүй, эмзэг, хөрөнгө оруулалт саарсан улс орныг 8 сарын өмнө энэ засаг хүлээж авсан.

Шинэ Засгийн газар ажлаа эхлэхэд улсын санхүү, эдийн засаг, ямар байсныг дурьдахад 2012 оны төсвийн тэнцэл 600.0 тэрбум төгрөгийн алдагдалтай, төсвийн орлого 1 их наяд 500 төгрөгийн тасалдалтай. Инфляцийн 15.0 хувьтай. Төлбөрийн тэнцэл 160 орчим сая ам.долларын алдагдалтай. Хүний хөгжлийн санд их наяд төгрөгийн хуримтлагдсан өртэй байлаа. Үр ашиг муутай гэрээ авлигын сүлжээ, алсын хараагүй эдийн засгийн бодлогоос үүссэн уул уурхайн үйлдвэрлэлийн бууралтай жил байлаа. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 800.0 сая ам.долларын алдагдал, нийтдээ 2.2 тэрбум долларын гадаад худалдааны алдагдалтай. Хүний хөгжлийн сангийн хүлээгдэж байгаа

34.5 сая ам.долларын зээлийн хүүний өртэй хүлээн авчээ. Өөрөөр хэлбэл Монгол Улсын нэг жилийн төсөвтэй тэнцэх эдийн засгийн тааламжгүй нөхцөлийг өнөөгийн Засгийн газар нуруун дээрээ давхар үүрсэн нь бодит үнэн зүйл юм.

Гарц болох бүх хүндрэлийг зөв тооцоолж, дэлхийн санхүүгийн зах зээлд 5.0 тэрбум ам.долларын бонд гаргах шийдвэрийг Улсын Их Хурал гаргаж эхний 1.5 тэрбум долларын санхүүжилтийг босгосон нь улс орныг эдийн засгийн бодит хямралаас гаргахад онцгой үүрэг гүйцэтгэж байна. Бондын хөрөнгө орж ирснээрээ үндэсний гадаад валютын нөөц 2 дахин нэмэгдэж, эдийн засгийн тогтвортой байдлын баталгаа буй болсон нь үнэн. Улмаар төгрөгийн ханш тогтвортой түвшинд хадгалагдах бодит нөхцөл бүрдэж сүүлийн 5 жилд анх удаа эдийн засаг дахь инфляцийн хүлээлт тогтворжиж байна. Энэ нь Монголбанкнаас бодлогын хүүг бууруулах, төгрөгийн нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн, эдийн засгийг эрчимжүүлэх боломж, орон зайг үүсгэж өгсөн төдийгүй уламжлалт зах зээлийн эх үүсвэрийг өсгөх хүчин зүйл нь болжээ. Мөн нийгмийн даатгалын сан мөнгөжүүлэх суурь нөхцөл болон моргэйжийн тогтолцоог бүрдүүлж орон сууцны зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх эдийн засгийн боломжийг буй болжээ.

Энэ богино хугацаанд Норовын Алтанхуягийн Засгийн газар анх удаа орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын захиран зарцуулах хөрөнгийн хэмжээг 2.3 дахин нэмэгдүүлж бие даан ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. Хүүхдийн мөнгө олгож 1990-ээд оны эдийн засгийн шилжилтийн үед ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй байсан иргэдэд ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцож, арьс шир боловсруулах, түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчид хөнгөлөлттэй зээл олгож, үндэсний үйлдвэрт малын арьс ширээ тушаасан малчин, мал бүхий иргэдэд урамшуулал олгох зэрэг иргэдийнхээ амьдралын баталгааг хангахтай холбогдсон олон асуудлыг шийдвэрлэж чадсан.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бизнесийн эрх зүйн орчныг хамгаалж, тоног төхөөрөмжийг гааль, НӨАТ-аас чөлөөлөн банкны тогтвортой байдлыг хангах, харилцагч, хадгаламж эзэмшигчдийн банкинд итгэх илтгэлийг нэмэгдүүлэх, улсын төсөвт учирч болзошгүй дарамтыг бууруулахад чиглэсэн мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийг батлуулжээ.

Өмнөх Засгийн газруудын үед хийгдэж чадаагүй шүүхийн шинэчлэлийн багц хуулийг батлуулж өргөн хэрэгцээний бараа, импортыг багасгах зорилгоор Монгол брэнд хөтөлбөрийг эхлүүлж үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих бодлого явуулж эхэлсэн байна.

Газрын тосоо экспортолж, борлуулт хийн, Монгол 93 маркийн үндэсний шатахуун брэнд буй болгож байгаа нь шатахууны хараат байдлаас гарах анхны чухал алхам болсныг бид тэмдэглэх ёстой. Мөн сум төсөл, гудамж төсөл, авто зам, төмөр замын төслүүдийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлуудыг бүрэн хангаж олон жил саатсан Хөшигийн хөндийд барих шинэ нисэх онгоцны буудлын ажлыг эхлүүлэхэд бэлэн болгосон байна. Намар ажлаа эхэлсэн шинэчлэлийн Засгийн газар өвлийн хүнд ачааллыг амжилттай туулж анхны их бүтээн байгуулалтын гараанд ирэх энэ үед Засгийн газрын тэргүүнийг огцруулах нийгэм, эдийн

засгийн алдаа гараагүй гэж үзэж байна.

Гэвч Шинэчлэлийн Засгийн газрын Тавантолгой, Оюу Толгойн гэрээг засаж сайжруулахаар гадаадын хөрөнгө оруулагчидтай ажиллаж байгаа үйл ажиллагаанд Улсын Их Хурал саад учруулах үгүй гэдгийг тэмдэглэж байна. Гэвч Засгийн газрын дотоод гадаад хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, суурь нөхцөлүүдээ эрсдэлээ хамгаалж, бодлого зохицуулалтын тогтвортой орчныг буй болгож, бизнес дэх төрийн оролцоог бууруулах, зайлшгүй шаардлагатай дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг босгохын төлөө ажиллаж байгаа энэ эгзэгтэй үед Монгол Ардын Нам улс төрийн өчүүхэн ашиг хонжоо хайж, хөрш орнуудын уламжлалт харилцаанд санаатай сэв суулгах гэсэн уйгагүй оролдлого хийж байгаад Ардчилсан Нам харамсаж байна.

ОХУ, БНХАУ нь бидний мөнхийн найрсаг харилцан ойлголцон хамтран хөгжих хөрш орнууд байсан, байрсаарч байх болно.

Ардчилсан Нам ардчилсан хувьсгалаас хойш төрж бойжсон хэвлэлийн эрх чөлөөг цаг ямагт хамгаалсаар ирсэн бөгөөд хэвлэлийн эрх чөлөөний баталгаа нь байсан. Цаашид ч бас байх болно. Орон нутагт очсон, мөн Засаг даргын халаасанд ордог үе дуусч иргэд төсвөө өөрсдөө захиран зарцуулах эрхээ эдэлж эхэллээ. Халамжид дулдуйлддаг амьдрал дуусч бүтээн амьдрах цаг Монгол орны өнцөг булан бүрд эхэлж байна.

Энэ шинэ цагийг зогсоох аливаа оролдлоготой Ардчилсан Нам эвлэрэхгүй гэдгээ мэдэгдэх нь зөв.

Боловсон хүчний томилгооны асуудал дээр Үндсэн хуулийн маргаан үүсгэх гэж байгаа оролдлого нь Монгол Улсын үндэсний эрх ашигт харш, нийгмийн зөрчилдөөн үүсгэж болзошгүй үйлдэл рүү түлхэж байгаа хариуцлагагүй үйлдэл мөн. Арван хэдэн жилийн өмнөх сөрөг хүчнийхээ улс төрчдийг сайн муугаар нь хагаралдуулдаг, Улсын Их Хурлын үйл ажиллагааг намын явцуу эрх ашигт нийцүүлэн олон сараар гацаадаг, авлигачдаа ямар үнээр хамаагүй хамгаалдаг ялзарсан улс төрийн арчаагүй арга мэхийг өнөөдөр Монгол Ардын Намаас илэрч байна.

Ардчилсан Нам засгийн эрх барьж байх хугацаанд Засгийн газрыг Монгол Ардын Нам ээлж дараалан яаж огцруулж байсныг ард түмэндээ би дахин сануулъя.

1997 оны 10 дугаар сарын 16-н М.Энхсайханы тэргүүлсэн Засгийн газар, 1998 оны 7 дугаар сарын 21-н Ц.Элбэгдоржийн тэргүүлсэн Засгийн газар, 2006 оны 01 дүгээр сарын 11-н Ц.Элбэгдоржийн тэргүүлсэн Засгийн газар, 2013 оны 04 сарын 25-н буюу өнөөдөр. Норовын Алтанхуягийн тэргүүлсэн Засгийн газрыг унагах ээлжит оролдлогоо хийж байна.

Энэ түүхэнд бидэнд Монгол Ардын Намаар дахин тоглуулахгүйг хатуу сануулж байна. Улс төрийн явуургүй тоглолтын өртөг ард иргэдэд ямар үнэтэй

тусдагийг Ардчилсан Нам мэддэг болсон.

Монгол Ардын Нам юу хийхгүй гэж хэлж байгаа үгний цаана юу ч хийлгэхгүй гэдэг санаа нуугдаж байгааг ч гэсэн бид мэддэг болсон.

Авлига бол Монголчуудын сайн сайн амьдрах гэсэн, эрх чөлөөтэй амьдрах гэсэн тэр хүсэл мөрөөдөл бодлыг..., ард түмнийг зуд мэт ядууруулах бүх юмыг арчин хаяж байна. Тогтворгүй байдлын үнийг хэн төлдөг юм бэ. Тогтворгүй байдлыг бий болгож байгаа албан тушаалтан, ирж байгаа цөөхөн хүнээс бусад нь бүх ард түмэн төлдөг юм. Тогтворгүй байдлыг ард түмэн төлдөг учраас тэд нар дургүй байдаг юм. Энэ үгийг 7 жилийн өмнө Цахиагийн Элбэгдоржийн Засгийн газрыг Монгол Ардын Намын удирдах зөвлөлийн шийдвэрээр огцруулах асуудлыг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж байх үед түүний хэлсэн үг юм. Энэ үгийг бид дандаа санаж явах учиртай.

Ардчилсан Нам парламентэд цөөнх байсан он жилүүдэд улс төрийн тогтвортой байдлыг эрхэмлэж улс орныхоо эрх ашгийг урьтал болгон бүтээлч, санаачлагатай ажилласан хэдий ч нөгөө талдаа төрд шигдсэн хогийн ургамлуудад амьдрал боломж олгож байсан нь бидний алдаа байлаа.

Ардчилсан Нам тодорхой асуудалтай салбаруудыг шүүмжилж байснаас хэзээ ч Засгийн газрыг бүхэлд нь огцруулах саналыг гаргаж ард түмний нийтлэг эрх ашгийн эсрэг зогсож байгаагүйг түүх гэрчилнэ.

Төсвийн хөрөнгийг хувьдаа завшсан, ах дүү хамаатан садныхаа дансанд хэдэн тэрбумаар байршуулсан, гадаад руу гуйвуулсан, чанарын шаардлага хангаагүй бараа материалыг хэдэн арван тэрбумаар шахсан, ашигт малтмалын лицензийг хэдэн зуугаар нь арилжсан зэрэг гутамшигт үйлдлүүд ар араасаа хөвөрсөөр байна. Авлигын сүлжээ, уул уурхайн үйлдвэрүүд, төрийн албаны бүх шатанд бэхжиж өнөөдрийн байдлаар авлигынх нь өртөг 1.0 доллар руу дөхөж байна.

Ард түмэнд айдас байхгүй. Шударга иргэдээ айдастай амьдруулах эрх Ардчилсан Намд ч байхгүй. Авлигачдад бол харин айдас бий. Харин түүнийг хамгаалах гэж ардчиллын үнэт зүйлийг харлуулах хэрэггүй гэдгийг бид дахин сануулж байна.

Монгол Ардын Намын гишүүдийн өргөн бариад байгаа огцруулах саналын цаад мөн чанар нь үнэн хэрэгтээ Засгийн газрын тэргүүний нэр төрд хууль бусаар нотлогдоогүй баримтаар эрээ цээргүй халдаж улмаар Засгийн газрын нэр хүндийг унагах, Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөх ашиг хонжоогоо хайж намын явцуу эрх ашгаа хамгаалсан төрийн албанд байгаа авлигачдыг өмгөөлөх гэсэн санаархлаа хэрэгжүүлэхийг эрмэлзсэн Монголын ард түмний эрх ашгийг умартан улсынхаа эдийн засгийг сөхрүүлэх гэсэн далд оролдлого гэж Улсын Их Хурал дахь Ардчилсан Намын бүлэг дүгнэж байна.

Өнөөдөр иргэдээ чинээлэг амьдруулж хараахан чадаагүй хэдий ч

өнөөгийн энэ бохир орчноос салсан хөдөлмөрч, боловсролтой, чинээлэг иргэдтэй хариуцлагатай ардчилалтай Монгол орныг ирээдүйн хойч хүлээлгэн өгөхөд Ардчилсан Намын эрхэм зорилго оршиж байна.

Эрхэм гишүүд ээ,

Зорилгодоо хүрэхэд учрах саад бүхнийг даван туулж, түмнийхээ төлөө сэтгэл гарган ажиллах эрмэлзлэл Норовын Алтанхуягийн тэргүүлсэн Засгийн газарт байгаа гэж бид итгэж Монгол Ардын Намын бүлгийн Улсын Их Хурал дахь нэр бүхий гишүүдээс өргөн барьсан Монгол Улсын Ерөнхий сайд Норовын Алтанхуягийг огцруулах саналыг Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан Намын бүлэг хүлээн авах боломжгүй гэж үзэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**З.Энхболд:** - Одоо Монгол Ардын Намын бүлгийн дарга Нямаагийн Энхболд гишүүн үг хэлнэ.

**Н.Энхболд:** - Улсын Их Хурлын дарга,

Эрхэм гишүүд ээ,

Монгол Ардын Намын бүлгийн гишүүд бид Ерөнхий сайд Н.Алтанхуяг Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хууль, тогтоомжийг удаа дараалан зөрчиж төрийн албан хаагчдыг хоморголон халж нийгэмд шударга ёс тогтоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх тал дээр Улсын Их Хурлын өмнө хүлээсэн үүргээ туйлын хангалтгүй биелүүлж харин ч хууль зөрчих асуудлыг өөрийн биеэр үлгэрлэн улс орон хуулийг хэрэгжүүлэх үндсэн үүргээ биелүүлж чадахгүй байна гэж үзэж түүнийг огцруулах асуудал тавьсан.

Түүний энэ байдлыг иргэд, төрийн болон төрийн бус байгууллагууд ч шүүмжлэн Үндсэн хуулийн цэцэд хандсанаар тэрээр үнэнд гүйцэгдэн өөрийн хууль бус шийдвэрүүдийг хүчингүй болгож өөрөө нотолсоор байгаад өнөөдрийг хүрлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн. 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн Ерөнхий сайд Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан ёсоор Засгийн газрыг удирдаж төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна гэсэн заалтуудыг дагаж хэрэгжүүлэхийн оронд тэрээр Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал дээр хууль хэрэгжүүлэх шаардлага тавьсан гишүүдэд би хууль мэдэхгүй ээ гэж хариулж байгаа нь улстөрждөггүй соёлтой нийгэмд бол хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Улсын Их Хурал түүнтэй зайлшгүй хариуцлага тооцох шаардлагатайн нотолгоо юм.

Ерөнхий сайд Н.Алтанхуягийн хууль зөрчсөн шийдвэрүүдийн улмаас төрийн албаны мэргэшсэн байдал алдагдаж төрөл садан, нам, үзэл бодлын шалгуураар хүмүүсийг ажил албанд томилж хууль ёсыг хэрэгжүүлэх ажлыг завхруулж байгаа энэ буруу жишиг шатлан өргөжиж хөдөө орон нутагт ч давтагдаж хүний эрх, эдийн засгийн эрх чөлөө хумигдан ард түмний амьдрал өдрөөс өдөрт унасаар байна.

Ер нь төрийн алба, тендерийн ажлыг төрлийн хэрэглэж болгож буйтай огтхон ч санаа зовохгүй байгаа нь асуулт хариултын явцаас олон нийтэд тодорхой харагдлаа. Хууль зөрчсөн үйлдлээс улбаалан гарсан дараа дараагийн олон хууль зөрчсөн шийдвэрээс нь болж хохирсон иргэдийн хохирлыг яаж арилгах, түүнээс нийгэмд үлдсэн урт богино хугацааны сөрөг үр дагаврыг яаж арилгах нь тодорхой биш үлдлээ.

Хуулийн хэрэгжилт хаа саагүй хангалтгүй байгаагаас шалтгаалж иргэд баялаг бүтээгчдийн ирээдүйдээ итгэх итгэл алдрахад хүрч улмаар нь энэ нь эдийн засагт шууд нөлөөлөн улс орны урьд нь олсон ололт амжилтууд үгүй боллоо.

8-хан сарын өмнө дэлхийд тэргүүлж байсан манай эдийн засгийн өсөлт бараг 2 дахин буураад байна. Цагийг нь олоогүй алсын хараагүй бодлогоор шинээр их өр бий болгож, түүнийхээ хариуцлагаас мулттрахаар Монголбанкинд байршуулсан нэрээр бултан зайлах болов. Хаана ч байрлуулсан, ямар ч менежмент хийсэн энэ мөнгийг Монголын ард түмэн төлөх нь үнэн юм.

Түүнчлэн Ерөнхий сайд Н.Алтанхуяг Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлого аюулгүй байдлын үзэл баримтлал зэрэг Улсын Их Хурлаас баталсан тогтоол шийдвэрүүдтэй зөрчилдсөн, улс орны хөгжил, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй хариуцлагагүй мэдэгдлүүд хийж байгаа нь түүний болчимгүй олон үйлдлийн нэг жишээ юм.

Энэ мэтчилэн түүний хууль тогтоомж зөрчиж, нийгэм эдийн засгийг удирдаж буй алдаатай бодлого нь түүнтэй Улсын Их Хурлын зүгээс өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд зайлшгүй хариуцлага тооцох үндэслэл болж байна.

Ерөнхий сайд Н.Алтанхуягийг огцруулах асуудлыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал дээр Монгол Ардын Намын бүлгийн гишүүд бид олон талаас нь нухацтай шүүн хэлэлцүүлсэн боловч олонхи асуудлыг хүч түрэн шийдвэрлэснийг энд онцлон тэмдэглэж байна.

Мөн Н.Алтанхуягийг огцруулах тухай Улсын Их Хурлын гишүүдийн тавьсан саналыг чуулганы хуралдаанд танилцуулахыг хааж дэг зөрчсөн энэ хэлэлцүүлгийг явуулж байна. Сүүлийн өдрүүдэд Ерөнхий сайдыг огцруулах бодит үндэслэл шалтгааныг ард түмэнд хүргэхгүй зөвхөн өөрсдийгөө магтан дуулсан, үнэнийг олон нийтээс нуун дарагдуулах гэсэн суртал ухуулгыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрээ цээргүй явууллаа. Түүнтэй холбогдох бодит



мэдээллийн араас хүмүүсийн орсон сэтгэгдлүүдийг сайтуудаас арчин арилгаж байгааг арай бас худлаа гэж хэлэхгүй байлгүй дээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэн энийг өөрийн биеэр үзэн шалгаж бас болно. Энэ бол эрх баригчид үнэнд гүйцэгдэж ард түмнээс айж байгаагийн үнэхээр тодорхой илрэл юм аа. Гэвч ард түмэн өөрийн дүгнэлтээ нэгэнт хийсэн нь олон нийтийн санал байдлаас харагдаж байна.

Хуулийг хэрэгжүүлэх үүрэгтэй Монгол Улсын Ерөнхий сайдын энэ үйл ажиллагааг засахад хүнд, урт хугацааны хор уршиг тарихаас нь өмнө зогсоохгүй бол ардчилсан Монгол Улсад хууль тогтоомж хэрэгжихгүй байж болдог, нийгмийн амьдрал, хуулийн зохицуулалтгүй, эмх замбараагүй байдалд хүрэх аюултай гэж үзэж байна. Хуулийг оройлон зөрчдөг Ерөнхий сайдыг албан тушаалд нь хэвээр нь үлдээх нь хуулийг дагахгүй байж болно гэсэнтэй дохио болно. Үүнээс үүдэн гарах сөрөг үр дагаврын хариуцлагыг эцсийн дүнд Монгол Улсын Их Хурал өөрөө хүлээх болно гэдгийг Улсын Их Хурлын гишүүд та бүхэн ойлгож байгаа гэж найдаж байна. Учир нь бидний шаардлага бол зөвхөн Ерөнхий сайд Н.Алтанхуягийг огцруулахдаа ч биш ер нь хуулийн доор амьдрах нь энэ нийгмийн дээд зарчим гэдгийг итгэл үнэмшлээ болгосон хүнийг Ерөнхий сайдаар ажиллуулаачээ гэж олонхид хандсан алхам юм.

Ерөнхий сайд огцорсноор Засгийн газар огцорно гэдэг нь ойлгомжтой. Гэхдээ Ерөнхий сайдыг огцруулчихаад Засгийн газарт орох гэсэн зорилго бидэнд байхгүй гэдгийг албан ёсоор дахин мэдэгдэж байна.

Иймд Улсын Их Хурлын олонхи асуудалд улс орны эрх ашгийг урьтал болгон өргөсөн тангарагтаа үнэнч байж хууль дээдлэх үндсэн хуулийн зарчмаа удирдлага болгон шийдвэр гаргана гэдэгт итгэлтэй байна.

Ерөнхий сайд Н.Алтанхуягийг огцруулах нь харин Засгийн газрын харин ч Засгийн газрын айлыг сайжруулах нөхцөл байдал үүснэ гэж бид үзэж байна. Ерөнхий сайд Н.Алтанхуягийг огцруулах асуудлын хэлэлцүүлэг нийгэм бүхэлдээ дүгнэлт хийж, түүний шинэчлэл хийх нэрийн доор хуулийг уландаа гишгин туучиж явааг ойлгосон. Цаашид Монголчуудын ёс суртахуун, улс төрийн төлөвшил, ухааралд тус нэмэр болсон сөрөг хүчний зүгээс тавихгүй байхын аргагүй алхам гэдэгт бид бас эргэлзэхгүй байгаа.

Харин Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг хэлэлцэх явцад яригдсан ноцтой баримтууд, тухайлбал Монголбанк бондын мөнгөөр алтны наймаа хийж алдагдал хүлээн шинэ алт дилерын хэрэг гаргасан эсэх, зориулалтын бусаар зарцуулсан эсэх, Ерөнхий сайдын хамаатан садангийн хүмүүс хууль бусаар тендер зохион байгуулж Гоби Пауэр компанид ашигтай шийдвэр гаргасан эсэх. Улсын бүртгэлийн ерөнхий газрын ажилтнууд гэмт явдлыг нуун дарагдуулах зорилгоор төрийн бүртгэлийн баримт бичгийг хуурамчаар үйлдсэн мэдээлэл зэрэг нь ашиг сонирхлын зөрчлийн талаарх хууль тогтоомж, ёс зүйтэй нийцэж буй эсэхийг шалган олон нийтэд болон Улсын Их Хуралд мэдэгдэх шаардлагатай байгааг Авлигатай тэмцэх газар, Хууль зүйн яам, Монгол Улсын Ерөнхийлөгчид хандан сануулж байна. Үүнд туйлын анхааралтай хандаж зохих

арга хэмжээ авна гэж итгэж байна.

Улсын Их Хурлын гишүүд ээ,

Та бүхэн ард түмэнд өргөсөн тангарагтаа үнэнч байж, хууль дээдлэх ёсыг баримтлан энэ асуудлыг шийдвэрлэхэд саналаа өгнө гэдэгт итгэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**З.Энхболд:** - Одоо чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38.5-д заасны дагуу Ерөнхий сайд Норовын Алтанхуяг үг хэлнэ. Ерөнхий сайдыг индэрт урьж байна.

**Н.Алтанхуяг:** - Улсын Их Хурлын эрхэм дарга аа,

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Миний бие Улсын Их Хурлаас хэдхэн сарын өмнө баталсан Ардчилсан Нам, Иргэний Зориг-Ногоон Нам Шударга Ёс эвслийн Шинэчлэлийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн төлөө Шинэчлэлийн Засгийн газрын гишүүдийн хамт, мөн та бүхний дэмжлэгтэйгээр энийг хийх юмсан, босгочих юмсан гэсэн чин хүсэл эрмэлзлэл дүүрэн, тэвчээр, итгэл сэтгэлээр жигүүрлэж бас ч гэж цаг наргүй ажиллаж байна.

Нэг талаас нь харахад богино юм шиг хугацааг эрчимтэй ажил, арвин үр өгөөжөөр дүүргэх гэж зогсолтгүй ажиллах энэ явцдаа авсан ажлыгаа ял болгож арагшаа харж цэцэрхэхийг ерөөсөө хүсээгүй. Муулж муулсан нэгэнд цаг үрж, гүтгэсэн үгийг нь бас үг гэж авсангүй. Шүүмжилсэн олсноосоо харин ухаарал авч дэмжсэн түмнээсээ урам сэлбэж Монгол хүний өмнө тулгамдаж байгаа асуудал байвал том жижиг, мөнгөн дүн, хүнд хэцүүгээр нь ялгалгүй шийдчих юмсандаа гэж цаг нартай уралдсаар байгаад 8 сар болжээ.

Монгол Ардын Намын бүлэг маань 14 хоногийн өмнө Ерөнхий сайдыг огцруулъя гэдэг энэ санал санаачлагийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Энэ бол хууль зүйн дагуу Монгол Улсад ардчилсан төр засаг бий болсны бас нэг илрэл нь бол цөөнх нь бас өөрийнхөө үгийг хэлж засгийг болоод засгийн тэргүүнийг огцруулах асуудлаа тавьдаг нь би буруу зүйл гэж үзэхгүй байгаа. Энэ бол 23 жилийн өмнө Монголын ард түмэн, тэр дотроо ардчиллын төлөөх олон зуун мянган хүний амиа золиослож явж зүтгэж явж олж ирсэн энэ ардчиллын үр дүн юм аа гэж би ингэж ойлгодог. Энд ямар ч эмзэглэх зүйл байхгүй байгаа юм.

Та бүхэн маань 4 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын даргад Монгол Улсын Ерөнхий сайд Норовын Алтанхуягийг огцруулах тухай гэсэн ийм 6 зүйлтэй бичгийг өргөн барьсан байгаа. Бид нар уг нь 14 хоногийн 6 зүйлтэй бичгийн тухай бас нэлээн сайн ярих ёстой юм. Харамсалтай нь долоо хоног 6 зүйлээ яриад дараачийн долоо хоногт шинээр 3 зүйлийн эрэлд гарсан. Би энэ 6 зүйл тус бүрээр нь бас хэлэх нь зөв гэж бодож байна. Яагаад гэвэл нэгэнт та бүхэн 6 зүйтэй асуудал тавьсан.

За та бүхний Н.Алтанхуягийг огцруулах 6 зүйлийн хамийн эхний үндэслэл бол хоёр аймгийн Засаг даргыг томилсон явдал бол Үндсэн хууль зөрчсөн юм гэдэг асуудал байгаа. Энийг бид нар хангалттай, ханаталаа ярьсан. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт бол гараагүй байна гэдгийг тал бүрдээ хүлээн зөвшөөрсөн учраас би нэгдүгээр асуудлыг энэ бол хууль зөрчсөн үйлдэл биш юм аа гэдгийг одоо бүгд талдаа ойлгосон. Нотлох баримт материал байхгүй зүйл юм.

Хоёр дахь нь бол Тагнуулын ерөнхий газрын дэд даргыг одоо өөрчилсөн явдал бол Үндсэн хууль зөрчсөн байна гэсэн. Энэ дээр Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт бас гараагүй юм. Тэгэхээр 14 хоногийн өмнө бид нар ямар асуудал ярьж эхэлсэн билээ гэдгээ эргэн санах нь илүүдэхгүй юм.

Та бүхний огцруулъя гэж байгаа гурав дахь үндэслэл бол төрийн албан хаагчдыг одоо хоморголон халж байгаа юм гэж. Ийм үндэслэл байгаа юм. Тэгэхээр эртээдийн хурал дээр бид нар ярьсан. Хоморголон халж байгаа асуудал байна уу? Ажлын хэсэг гаргах уу. Тал талаасаа тоогоо нийлье гэсэн. Өнөө өглөө гарч ирж байгаа тоогоор бол хоморголон халсан зүйл бол байхгүй юм. Төрийн алба данхайсан зүйл байхгүй юм аа. Нийтдээ 8 сарын хугацаанд төрийн албан хаагчдын тоо 384-өөр багассан байна гэсэн ийм дүгнэлт тоо бол гарсан байна.

Дөрөвдүгээр үндэслэл байгаа. Дөрөвдүгээр үндэслэл нь бол хэвлэл мэдээллийн хэрэгслийг одоо Засгийн газар хаасан гэсэн. Би эртээд ч Н.Энхболд дарга, за Ц.Нямдорж сайд мэдэж байгаа, С.Батболд сайд ч байгаа. Бид нар нэг Засгийн газарт байсан хүмүүс. Засгийн газар хэзээ ч хэвлэл мэдээллийг хаадаг шийдвэрийг гаргадаггүй гэдгийг бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Та бүхний энэ дөрөвдүгээр үндэслэл бол үндэслэл биш байна. Засгийн газар ямар ч хэвлэл мэдээллийн хэрэгслийг хаах тухай шийдвэрийг гаргадаггүй бөгөөд бид бас гаргаагүй.

Тавдугаар зүйл нь бол хоёр улсын харилцааны асуудлыг хөндсөн. Энэ дээр би та бүхэнтэй Байнгын хороон дээр ярихдаа хэлсэн. Хоёр улсын харилцааны асуудлаар Их Хурал дээр хэдүүлээ хаалттай хэлэлцүүлэг зохион байгуулъя. Энийг нээлттэй ярилцах зүйл биш юм аа гэж. Би та бүхний манай Ардын намынхан гэж хэлснээрээ би Ардын намын гишүүн болчихоогүй, болох ч үгүй.

Зургадугаар зүйл бол Бурхан халдун уулын асуудал байгаа юм. Энд бас үнэхээр нэг 70 гаруй хүн яваад төөрсөн. Байгалийн онцгой нөхцөл байдалд орсон. Би харин нэг юманд баярлаж байгаа. Үнэхээр бурхан аварлаар 70 гаруй хүн эсэн мэнд ирсэн. Хөл гараа гэмтээсэн юм байхгүй ирсэн. За энэ дээр бас та бүхний зургадугаар үндэслэл дээр байгаа зүйл л дээ. Тэгээд би зүгээр ганцхан жишээ хэлэхэд надтай хамт явсан 53 хүнээс миний таньдаг 10-аад хүн байна лээ. Хэнтий аймгийн онцгойгийнхон болоод тагнуулынхан болоод бусад албаны хүмүүс 30-аад хүн байна лээ. Багануураас тэр өдөр бас ууланд гарч байсан 5 залуу байна лээ. Жи Си Ай-гийн хэдэн залуучууд байна лээ. Бид тэгээд

тохиолдлоор ингээд нэг баг болоод, тэгэхдээ бүгдээрээ эсэн мэнд аврагдсан. Сүүлдээ энэ явж байгаа хар сурталчилгааг хараад тэр залуучууд тэсэхээ байгаад хэдэн төгрөг мөнгө гарсан болоо төлье гэсэн. Энийг яг Онцгой байдлын ерөнхий газартай албан ёсоор санал тавиад авсны дагуу 14 сая гаруй төгрөгийг энэ явсан хүмүүс маань Төрийн албан хаагчдыг оролцуулахгүй төлөөд дуусгасан байгаа.

Энэ миний хэлж байгаа 6 зүйл бол та бүхний 14 хоногийн өмнө Н.Алтанхуягийг энэ Засгийн газрын Ерөнхий сайд тэргүүнийг огцруулах тухай тавьсан 6 үндэслэл юм. Энэ 6 үндэслэлийг би нэг бүрчлэн бас хэллээ. Манай Улсын Их Хурлын гишүүд, Ардчилсан Намын бүлгийн гишүүд, бусад бүлгийн гишүүд ч гэсэн энэ тухай нэлээн дэлгэрэнгүй ярилаа.

Энэний дараа та бүхэн 3 асуудлыг хөндсөн. Завсарлага авахдаа. Нэгдүгээр асуудал нь бол Монголбанк алт авсан юм шиг байна. Бондын мөнгөөр гэж. Би Монголбанкны Ерөнхийлөгчийн Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгийн дарга Н.Энхболдод 4 сарын 24-н гэдэг чинь өчигдрийн өдөр байна. Өчигдрийн өдрөөр хаягласан бичгийг би уншъя. Монголбанкны алтны тухай асуудал бол Н.Алтанхуягт хамаагүй. Энэ бол Монголбанкны бодлогын асуудал. Энэ дээр юу гэж хариу өгсөн гэхээр Засгийн газрын үнэт цаасыг олон улсын зах зээлд арилжаалах замаар бүрдүүлсэн 1.5 тэрбум америк долларын хөрөнгийн эх үүсвэрт Монголбанк санхүүгийн зуучлалын үүргийг гүйцэтгэж ажлын хүрээнд тус хөрөнгөөр олон улсын зах зээлээс нэг ч грамм алт худалдаж аваагүй бөгөөд Чингис бондын эх үүсвэрт аливаа төрлийн алдагдал хүлээгээгүй болно. Энэ бол та бүхэн дээр байж байгаа бичиг. Энэ бичиг бол Монголбанкны Ерөнхийлөгчийн Н.Золжаргалын нэг бичиг байна.

Тэгэхээр нэмж тавьсан 3 асуудлын нэг нь бол ийм. Би тэгээд бас дахиад хэлсэн шүү дээ. Хэрвээ ингээд алт дээр асуудал үүсээд байгаа бол энэ бол Их Хурлын субъект учраас ажлын хэсэг байгуулаад албан ёсоор шалгаж болно. Түүнээс биш Ардын Намын бүлгийн гишүүд гүйж очоод Монголбанкийг шалгадаг юм бас байдаггүй. Өглөө манай Р.Гончигдорж дарга хуулийн ишлэл татаж байна лээ. Тэгэхээр энэ дээр бол албан ёсоороо дэг журмаараа ажлын хэсгээ байгуулаад очоод үзээд хараад ингэхэд болохгүй юм байна.

Та бүхний нэмж тавьсан 3 асуудлын нэг нь бол энэ алт. Хоёр дахь нь бол мөн төрийн ажилтан, албан хаагчидтай холбоотой асуудал байгаа. Бас дахиад энэ асуудлаа тавьсан. Хоморголж халсан. Энийгээ дахиж үзье гэсэн. Энэ дээр үзээд 7 мянган хүн гэдэг тоо та бүхэн ярьсан. Тэр 7 мянган хүний тухай тоо ойлголт бол огт байхгүй гэдгээ одоо энэ хэд хоног ажиллахдаа бүгдээрээ ойлголцсон.

За ингээд одоо нэг л асуудал үлдэж байгаа юм. Тэр нь илүү би. Манай Ардчилсан Намын гэхээсээ илүү, Засгийн гэхээсээ илүү Н.Алтанхуяг гэдэг хүнтэй холбоотой нэг асуудлыг та бүхэнд маш ноцтой асуудал байна гээд гаргаж тавьж байгаа. Тэр нь бол 9 дэх асуудал. Н.Алтанхуягийг огцруулах үндсэн 6 үндэслэл дээр нэмж 3 үндэслэл гаргасны би одоо хамгийн сүүлчийнх нь миний нэр хүндтэй холбоотой, Н.Алтанхуяг гэдэг хувь хүнтэй холбоотой асуудал

учраас би тогтож бас гурав дөрвөн үгээр тайлбар хийе гэж бодож байна. Энд ямар нэгэн маргаан тэмцэл хэрэггүй. Хэн нэг нь намын бүлэг шүүгчийн үүргээ гүйцэтгэхгүй. Бүх зүйл бол хууль хяналтын байгууллагуудаараа эцэслэгдэж гарах учиртай юм.

Тэгээд би бодож байна л даа. 9 үндэслэлээс ингээд 8 үндэслийг би хэллээ. Манай гишүүд ч хэллээ. Бүгдээрээ үзлээ. Энэ дээр үндэслэл алга.

9 дэх үндэслэл нь бол Тавантолгойн тендер гэдэг юмыг Н.Алтанхуяг гэдэг хүн хамаатныхаа хүүхдэд өгөөд ялуулчихаж гэж. Энэ бас ямар ч үндэслэл байхгүй юм аа гэдгийг би та бүхэнд хэлье.

Энэ дээр бол ямар нэгэн тендер тэнд болж байгааг надад мэдэж байгаа ч юм байхгүй. Улс орон даяар бол өчнөөн тендер болж байгаа байх. Энийг би энэ хүндэт индрээс юу гэж хариуцлагатайгаар мэдэгдэж байна вэ гэхээр Н.Алтанхуяг гэдэг хүний оролцоотой юм ширхэг ч байхгүй. За нэгдүгээрт.

Хоёрдугаарт, 16 насанд хүрээгүй хэдэн охидууд бий. Би түүнийхээ өмнө өнөөдөр хариуцлага хүлээхэд бэлэн байна. Эцгийн хувьд. Гэрийн эзний хувьд. Ямар нэгэн хүмүүс, ойр хавын надад ах дүү хамаатан садан олон бий. Би эхээс наймуулаа. Миний төрсөн ах, эгч 7 хүн байгаа. Надтай. Тэгэхээр бүх хүн бол, тэр байтугай аав хүүхэд хоёр бол, аав хүү хоёр бол хуулийн өмнө тус тусдаа л хариуцлага хүлээх учиртай. Энэ агуулгаараа би юу гэж байна вэ гэхээр өөр газар ярих ёстой юмыг надад хамаатуулаад байгаа юм биш үү. Ер нь зүгээр Н.Алтанхуягийг л жаахан харлуулъя гэсэн энэ агуулгаар арай хэтэрхий улайраад байгаа юм биш үү. Энэ дээрээ жаахан учир начиртай хандаж болдоггүй юм уу.

Н.Алтанхуягийг гутаан доромжилж болно. Н.Алтанхуягийн ойр хавьд байгаа ах дүү, хамаатан садан ямар нэгэн хүмүүс гутаан доромжлолд автаж болохгүй. Тэр нь үнэхээр хэрэг хийсэн юм бол хууль хяналтын байгууллага энийг нотолно.

За яг энэтэй холбоотой Дэнзэн гэдэг хүний нэрийг ярьж байгаа. Би энэ дээр та бүхэнд бас тайлбар хэлье. Би бол их тэвцээртэй. Би үгийнхээ эхэнд та нарт хэллээ. Ямар нэгэн гүтгэлгийг няцаахчих юмсан. Тэгэх юмсан. Ингэчих юмсан. Хэвлэл мэдээлэл ингэчих юмсан. Сая хэн хэлэв. Н.Энхболд дарга хэлж байна. Хэвлэл мэдээлэлд мөнгө өгөөд. Тийм юм огт байдаггүй.

Тэгэхээр хамгийн төгсгөлийн асуудал бол хүний асуудал хөндөөд байгаа юм. Ер нь олон сарын өмнөөс юу гэдэг асуудлыг гаргаж тавьсан гэхээр Н.Алтанхуяг гэдэг хүн бол төрийн албыг төрлийн алба болгож байна. Би энэ ардчиллын нэр хүн, Ардчилсан намын нэр хүнд, олон түмний итгэлтэй холбоотой учраас заавал тайлбарыг хийе гэж бодсон. Тэгэхээр хүргэнээ аваачаад даргаар тавьчихаж гэдэг яриаг гаргасан. Тодорхой зорилготой хүмүүс гаргасан.

За тэгэхээр би энэ дээр 3 зүйл хэлнэ. Нэгдүгээрт бол 2006 онд Дэнзэн

гэдэг хүнийг МУИС-ын математикийн багш байхад Оюу Толгой, Тавантолгойн тооцоог хийлгэх зорилгоор бид нар авчирсан. 7 жил болж байна. Энэ хүн 7 жил энд ажиллаж байгаа. 7 жил хамтраад ажиллаж байх хугацаандаа туслахаар эхэлсэн. Дараа нь намайг Тэргүүн шадар сайд болоход зөвлөхөөр ажилласан. Улмаар ахлах зөвлөхөөр ажилласан. Нэг ийм л залуу байгаа. Энэ хүнийг сая Засгийн газар бид одоо олонхи болсныхоо дараагаар манай Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Хяналт, мониторинг орон нутаг хариуцсан энэ ажлыг ч хийгээчээ гэдэг ийм санал тавиад ажиллуулсан. Энэ ажлыг хийх чадвар боломжтой учраас.

Энэ хугацаанд энэ ажлыг хариуцаж хийгээд маш олон зүйлийн болохгүй зүйлүүдийг бол гаргаж тавьсан. Нэгдүгээрт, Иргэний нисэхийн ерөнхий газар, Гаалийн газар, Татварын Ерөнхий газар, Төрийн банкны нөгөө удирдах зөвлөлийн гишүүдийн авсан мөнгөний асуудал, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар, Газрын тосны хэрэг эрхлэх газар, Хөвсгөл аймаг, Булган аймаг. Энэ бүх газруудад хяналт мониторингийнхон явж юуг илрүүлсэн гэхээр үнэхээр Монгол Улсын энэ татвар төлөгчдийн төлж байгаа ард иргэдийн мөнгө бол үрэгдэж байна. Үр ашиггүй зарцуулагдаж байна. Мөнгө төгрөгийг хувааж авч байна. Ийм зүйлүүд бол маш их өргөн хүрээтэй дэндүү тархчихаж. Бүр хэтэрчихэж. Хэрээсээ хэтэрчихэж. Та нар мэдэж байгаа. Гадаадад одоо зугаалуулах тухай, аяллуулах тухай гэдэг тушаал хүртэл гардаг болжээ. Хөвсгөл аймагт очоод энэ болохгүй шүү гэж хэлсээр байхад одоогийн Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Цэрэнжав маань төрийн албаныхаа Тамгын газрын хэлтсийнхээ 5 даргыг 37.0 сая төгрөгөөр Франц руу явуулчихаж. Дандаа бүгд цаасан дээр байгаа фактай зүйл. Энийг энэ Дэнзэн гэдэг хүн ч хийгээгүй. Энэ хяналт мониторингийнхон хийсэн. Хяналт мониторингийнхон энэ их олон ажлыг хийгээд над дээр хоёр гурван удаа орж ирсэн байна. Үнэхээр хэцүү юм байна. Бид энэ ажлыг цаашид хийх боломжгүй юм байна. Яадаг юм бэ гэхээр маш их дарамттай, маш их шахалттай. Үнэхээр хүнд хэцүү юм байна. Ийм нөхцөл байдал үүссэн.

Тэгэхээр энэ хүн бол энд ирээд бид нар бол баг болж хамтраад 7 жил болж байгаа. Энэ ажлыг хийсэн хүн байгаа юм. Н.Алтанхуягийн яагаад хүргэн болчихоод байгаа юм бэ гэхээр би бол амин зуулга, энэ хувийн юм, хувьсгалын юм хоёрыг бол маш сайн ялгадаг. Би энэ Монголын улс төрд 23 жилийн өмнө их сургуулийнхаа багшийнхаа ажлыг орхин орхин орсон. Орохдоо би ийм муу муухай юмны төлөө явна гэж ороогүй. Гэрэл гэгээтэй болгоно. Миний Монголын ирээдүй сайхан болно. Одоо энд орж ирээд зогсож байгаа залуучууд бүгдээрээ сайхан гэрэлтэй гэгээтэй сайхан нийгэмд амьдарна. Тэрний төлөө би өөрийнхөө чадах бүхнийг зориулна гэж орж ирсэн. Би өнөөдөр ч гэсэн энэ чиг шугам дээрээ тууштай байгаа.

Тэгэхээр надтай яагаад хамаатан садан болоод байгаа вэ гэхээр жилийн өмнөөс эхлээд манай хамаатны охинтой үерхэж байгаа юм билээ. Залуу хүмүүсийн хэн нь хэнтэйгээ үерхэх, хэн нь хэнээсээ болихыг би бас зохицуулах боломжгүй юм билээ. Тэгээд 7 жилийн өмнө хамтарч ажиллаж эхэлсэн. Жилийн өмнөөс хэн нэгэн охин одоо явсан гэдэг бол хоёр өөр асуудал шүү. Н.Алтанхуяг бол хүргэнээ бол ажилд тавиагүй шүү. Энэ өөр шүү. Та нарт ч гэсэн иймэрхүү юм түм бумаар тохиолдоно шүү. Ер нь бол олон талын юмыг олон талаасаа

хараачээ гэж би ингэж хэлж байгаа юм. За би ийм зүйлийг би хэлье. Энэ бол та бүхний тавиад байгаа 9 зүйлийн тайлбартай холбоотой учраас би энийг хэлж байгаа юм.

За ингээд би 3-хан зүйл дээр товчхон юм хэлчихье. Шинэчлэлийн Засгийн газар маань иргэдийнхээ ахуй амьжиргааг дээшлүүлэх чиглэлээр үнэхээр цаашдаа ч гэсэн хүчин чармайлт гаргаж ажиллана. Бид нарт нэг минут, нэг цаг ингэж одоо цаг алдаж суух боломж бол байхгүй юм аа.

Айл өрхийн ахуй амьжиргаа гэдэг бол тэр чигээрээ тэр айлын орлогоос шууд хамаардаг юм. Мэдээж Засгийн газар Монгол айл бүрийн орлогыг нэмэгдүүлж, цалинг өсгөж, ажлын байртай болгох нь бидний нэн тэргүүний зорилт. Гэхдээ энэ орлогыг хулгайлдаг хулгайч болох үнийн өсөлт, инфляцитай сайн зохион байгуулалттайгаар тэмцэхгүйгээр энэ орлогуудыг нэмэгдүүлсний үр дүн гарахгүй юм. Тийм учраас шинэчлэлийн Засгийн газар үнэхээр инфляцитай тэмцэхэд, үнийн хөөрөгдөлттэй тэмцэхэд онцгой анхаарал хандуулсан. Би энэ дээр бол хичээл зүтгэл гаргасан манай Засгийн газрын гишүүд, энийг дэмжиж ажилласан Улсын Их Хурлын гишүүд, энд бас үнэхээр зүрх сэтгэл гаргаж ажилласан Монголбанкны Ерөнхийлөгч, бүгдэд нь би талархал илэрхийлье.

Ядаж нэг удаа манайхан болж байгаа юмыг болж байна гэж хэл л дээ. 16 хувьтай байсан инфляци чинь өнөөдөр 9.8 хувьтай байна шүү дээ. Яаж ч хэмжсэн. Дээр нь бид нар нүүрсний үнийг 200 мянган төгрөг байсныг тонныг нь 80 мянган төгрөг болгож чадлаа. Бодитой үнэн юмыг ядаж дуугүй өнгөрөө л дөө. Муулдаггүй юм аа гэхэд.

За нефтийн үнийг бид нар ирэх сараас эхлээд 50-иас 60 төгрөгөөр хямдруулах энэ боломж нөхцөлийг оллоо. Манайхан Д.Ганхуяг сайдаар толгойлуулсан энэ яамныхан бол үнэхээр бас зүтгэл гаргаж, сэтгэл гаргаж ажилласны үр дүнд энэ боломжийг олж ирж байгаа юм. Махны үнэ бол бидний хүссэн хэмжээнд хүртэл буулгаж чадаагүй. Тэгэхдээ өмнөх үетэй харьцуулахад нэг дэвшлийг хийж чадлаа. Тээврийг бол бид нар 24 цагийн дотор Замын-Үүдээс Улаанбаатарт ирдэг болголоо. Орон сууцны бодлого дээр С.Батболд сайд нарын хамтраад суугаад гаргаж байсан 6 хувийн хүүтэй зээл амьдрал дээр хэрэгжихгүй, болохгүй байна. Энийг 8 дээр нэмэх хасах нь 1 хувийн хүүтэй зээл болгоё. Тэгээд маш их өргөн хүрээнд. Ажил хөдөлмөр хийж байгаа хүн бүхэн энэ зээлээс авдага байхаар энэ бодлогыг гаргаж тавилаа. Энэ бодлого дээр манай Н.Батбаяр сайд, Хөгжлийн сайд, Барилгын сайд Ц.Баярсайхан сайд, манай Засгийн газрынхан маш их сэтгэл зүтгэл гаргаж ажилласан.

Буруу хийсэн юмыг засаж залруулахад маш их хугацаа шаарддаг юм байна. Тэгэхдээ худлаа хөнгөн гоомой хандаж бас худлаа буруу юмыг хийж болохгүй гэдэг учраас бас хугацаа шаарддаг юм байна.

Энэ хавар 7 мянган хүнийг бодитой ажлын байртай болоод гарч байна. 24-өөс дээш насны залуучуудыг ярьж байна. Тавантолгойг та бүхэн сая зөндөө ярилаа. Би дахиж яриад яах юм бэ. Та нар бас нэг юмыг хүлээн зөвшөөрчих л дөө. Ц.Нямдорж гишүүний хэлж байгаа үнэн. Гэрээнд бол өөрчлөлт ороогүй.

Тэгэхдээ алдагдалгүй байхаар тээврийн хөлс дээрээ тэдний тодорхой хэмжээний авч байсан тээврийн хөлсийг Монголын талд шилжүүлж өгөх байдлаар энэ жилийн хувьд одоо ингээд алдагдалгүй байхаар наймаа тохирчихлоо. Энэ чинь та бүхэн маань бид нар хамт байхдаа гаргах тусам килограммаас нь алдагдал хийгээд байсан юмыг чинь алдагдалтай гаргаж болохгүй учраас энийг нэг хэсэг хугацаанд болилоо. Одоо алдагдалгүй болсон учраас гаргаад эхэллээ.

Оюу Толгойн гэрээг Улсын Их Хурал дээр бид нар бүгдээрээ тал талаасаа яриад нэгдсэн ойлголттой боллоо. Оюу Толгойгоо бид нар дэмжиж явуулах учиртай юу, учиртай. Тэгэхдээ анхны хөрөнгө оруулалтад нь нэмэгдчихээд байгаа 2.0 тэрбум америк долларынхаа учрыг олох ёстой юу олох ёстой. Энэ дээр Улсын Их Хурал бүгдээрээ санал нэгдсэнд би баяртай байна.

Бүтээн байгуулалтын ажил одоо ид өрнөж эхэллээ. 2012 оны 8 сард түрүүчийн Засгийн газар маань Хүний хөгжил санд бол 700.0 тэрбум төгрөгийн өртэй. 430 гаруй тэрбум төгрөгийн төсвийн алдагдалтай ийм байсан. Энэ дээр одоо мэтгэлцэх шаардлагагай. Би цэвэр факт тоо ярьж байгаа юм. Тэр ч байтугай Дархан аймаг, Дундговь аймаг, Архангай гэсэн 3 аймагт, зөвхөн энэ 3 аймагт ахмад настан болоод хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мөнгийг тавьсан. Бусад 18 аймагт нь энэ мөнгийг өгөөгүй байсан. Энэний 300.0 гаруй тэрбум төгрөгийн хариуцлагыг бид нар өмнөх Засгийн газар өгнө гэж амлчихаад өгөөгүй. Бид өгөхгүй гэж хэлээгүй. Энийг уламжилж аваад тарааж өгсөн байгаа.

Эдийн засаг мөнгөгүй болсон тэр цаг мөчид үнэхээр энэ 1.5 тэрбум америк долларын Чингис бонд бид нар бол аминд орсон шүү. Одоо бид нар Чингис бондоороо Тавантолгой дээрээ цахилгаан станц баръя. 50 сая доллар гаргая. Улаанбаатарынхаа гэр хорооллыг янзалъя. Гудамж төслөө хэрэгжүүлъя. 200.0 сая доллар. Шинэ төмөр замаа урд талдаа барьж эхэлье. 200.0 сая доллар. 6 аймгийн төвийг засмал замаар холбоё 570.0 тэрбум төгрөг. Ноолуурынхаа үйлдвэрүүдийг сэргээе. Экспортоо дэмжъя. 68.8 сая доллар. Ноосны үйлдвэрүүдийг дэмжъя. 45.0 сая доллар. Сүү Улаанбаатар хотод бид нар өнөөдрийг хүртэл бид нар хуурай сүүгээ уусаар байна. Энэ уруу 27.7 сая долларыг гаргая. Сүүний аж ахуйгаа хөгжүүлъя. Өвлийн хүлэмж баръя, монголдоо. Өвөл бид нарт иддэг ногоогүй болчихоод байна. Ялангуяа нарийн ногоо. Энд 17.7 сая доллар гаргая. Оёдлыгоо дэмжъя, нэхмэлийгээ дэмжъя. Энд 13.5 сая доллар гаргая. Ийм тодорхой зорилтууд, тодорхой шийдвэрүүдийг бас нэлээн их цаг хугацаа гаргаж байж яриад хийгээд шийдээд явж байна.

Энэнээс гадна үнэхээр олон жил зовсон 3 дугаар цахилгаан станцыг 50 мегаваттаар өргөтгөе. 4 дүгээр цахилгаан станцыг бид нар 100 мегаваттаар өргөтгөе. 5 дугаар цахилгаан станцыг цоо шинээр баръя. Газрыг нь шийдлээ. Хийгээд эхэлж байна. Амгаланд дулааны станц баръя. Дарханы нефтийн үйлдвэрийг босгоё. Аймгуудын эмчилгээ оношилгооны төвүүдийг бий болгоё. Энэ олон асуудлуудыг бондын мөнгөгүйгээр тусад нь хийхээр боллоо.

Төгсгөлд нь би та бүхэнд нэг юм хэлье. Авлигал хүнд суртал, хууль бус үйлдэл. Бид нар заримдаа их адилхан юмыг ярьдаг болж. Тэгэхдээ их өөрөөр



ойлгодог болж. Шинэчлэлийн Засгийн газрын хамгийн их чихээ халууцуулж байгаа. Их олон газар, тэгэхдээ ард түмэн их сайн дэмжиж байгаа. Цөөхөн хүмүүс маш ихээр эсэргүүцэж байгаа зүйл. Тэр байтугай айсан хүнд аргал хөдөлж харагдаж байгаа зүйл бол авлига хээл хахуулийн асуудал байгаа. Шинэчлэлийн Засгийн газар хүнд сурталтай бас дайн зарласан. Энийгээ ч цааш үргэлжлүүлнэ. Хээл хахууль, авлигыг бид устгана.

Угтаа энд хүнд суртал гээд байгаа зүйл бол бүх ажлын гол гацаа нь болчихоод байгаа юм. Тэгээд ч шалтгаан нь авлигыг төрүүлдэг хамгийн башир арга бол хүнд суртал болсон. Монголын жирийн иргэд, бизнес эрхлэгчид өмгөөлөл тусламж хүсэхийн тулд танил тал, авлигалч хүнд сурталтнуудад хандах нь илүү болчихсон ийм цаг үе байсан юм. Энийг бид өөрчилье гэсэн юм. Тэгэхдээ хамтдаа өөрчилье гэж хэлсэн. Харин өнөөдрийн шинэчлэлийн Засгийн газрын үед хууль зүйн систем, манай Х.Тэмүүжин сайдаар толгойлуулаад ямар ч байсан цэгцэд ороод, шударга байрандаа ороод, хүмүүсийн шүүхэд итгэх итгэл, хуулийн байгууллагад итгэх итгэл нэмэгдэж эхэлж байна. Битгий энийг нураачих.

Иргэний нисэхийн, татварын ашигт малтмалын маш олон саларын том том олон тэрбумын луйврууд бол захаасаа гараад эхэлж байна. Энд бас битгий сандарч тэвдээд бай. Хүнд суртал, авлигатай тэмцэх асуудал иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ил тод байдлыг дархлаажуулах, хариуцлагыг сайжруулах шаардлагатай байгаа. Татварын 17.0 тэрбум төгрөг нэг хүний сейфэнд явж байна. Хадгаламж банкны 15.0 тэрбум төгрөг алга болсон. Одоо тэрийг идсэн хүмүүс нь өнөөдөр эрх чөлөөтэй болоод гараад явчихаж байна. Хадгаламж зээлийн хоршооны 72.0 тэрбум төгрөгийн 36-г нь бид нар яг ингэж сууж байгаад улсын төсвөөсөө төлсөн. Дахиад 36-г төлнө. Дахиад 36-г нь яах юм. Татвар төлөгчдийнхөө мөнгөнөөс ингээд төлсөөр байх юм уу. Ийм ийм олон асуудлыг бид хамтран шийдэх шаардлагатай болоод байна.

Төгсгөлд нь бас нэг гурав дөрөвхөн үгийг хэлье. Ардчилсан намыг олонхи болоход нь, тэр байтугай Улсын Их Хурлынхаа даргыг сонгоход, Засгийн газрыг байгуулахад нь анхнаас нь эсэргүүцэж байсан манай Ардын намынханд зориулаад хэдэн үг хэлье. Битгий эмзэглээрэй.

Ард түмэн та биднийг хамтраад Монгол Улсаа хөгжүүл ээ. Улс үндэстнийхээ эрх ашгийн төлөө олонхи нь хариуцлагаа хүлээ. Цөөнх нь ташуур болж ажил гэж сонгосон шүү дээ. Тиймээс та бүхнийг бүтээлч сөрөг хүчин байгаачээ гэж би хүсэж байна. Худал үнэн, бодитой бодьгүй, албан бус үнэ ханш, хов жив ярьж олныг төөрөгдүүлж байхын оронд аливаа үүссэн асуудлыг хамтдаа шийдэж хамтдаа урагшлахыг уриалмаар байна. Намын нэр барьж улс төрийн зорилготойгоор олныг төөрөгдүүлэх нь өнөөдөртөө нэг хэсэгхэн хүнийг хорлож байгаа юм шиг боловч угтаа өөрсдийнхөө ирээдүйг төөрүүлж байгаа алхам гэдгийг бид үргэлж санаж баймаар байна.

Би та бүхнийг шүүмжилье. Тэр байтугай 11-ээр ирж байгаа, өдөр тутам, цаг тутам ирж байгаа бүх хүний шүүмжлэлийг эрдэнэ гэж үзэж хүлээж авдаг. Харин гүтгэлийг бол үргэлж няцаах болно гэдгээ дахиад би энэ индэр дээрээс

нотлон хэлье. Гүтгэлгийг няцаасны төлөө намайг бас гүтгэж хэрэггүй шүү. Энэ цаг үед нэн хэрэгтэй, маргааш гэж хойшлуулчихвал бас алдагдчихаж магадгүй. Нөгөөдөр бол бүр арилчихаж магадгүй тийм боломж өөрчлөлт шинэчлэлийг цаг алдалгүй сатааралгүй хурдан хэрэгжүүлмээр байна. Ард түмэн маань сайхан амьдарвал бидний ирээдүй хойч үе үр хүүхэд маань сайхан амьдрах учраас ядуу орны баян нэгэн байсанд орвол би баян орны дундаж иргэн байхыг илүүтэйд үздэг хүн. Монгол хүн бүрийн сэтгэлд дассан 8-хан сартай итгэлийн галыг бөхөөхгүй баймаар байх юм. Тиймээс харанхуй гэж та нар минь зүхэж суухын оронд ганц ч гэсэн лаа асаагаад өг л дөө. Арай гэж асаж байгаа иргэдийн итгэл хөгжлийн гал руу ус битгий цацаачээ гэж та бүхэндээ би уриалмаар байна.

Ахан дүүсээ Шинэчлэлийн Засгийн газар, зөвхөн Шинэчлэлийн Засгийн газар ч биш энд байгаа Улсын Их Хурлын гишүүд, төрийн түшээд та бүхэн би нар эх орноо сөхрөхөөс, эдийн засаг нурахаас, элэг нэгт Монголчууд минь муу амьдрахаас эмээж байгаа. Энэ бол ганцхан Н.Алтанхуягийн хүсэл зориг биш. Тийм учраас бид нар хамтдаа ард олныхоо итгэл дэмжлэгээр зогсолтгүй зүтгэж байгаа. Цаашдаа ч зүтгэх болно.

Ардчилсан намынхан, Иргэн Зориг-Ногоон Намынхан, Монгол Үндэсний Ардчилсан Нам, Монгол Ардын Хувьсгалт Нам шударга ёс эвслийнхэн, бие даагчид нар цаашдаа ч нягт хамтран зүтгэж ажиллана гэдэгт би эргэлзэхгүй байна.

Манай Ардын Намынхан та бүхэн маань ч гэсэн бид нар чөдөр биш. Бид нар чөдөр биш ташуур болж хамтран ажиллахыг би уриалж байна. Бидний Монгол үүрд мадан бадраг. Хүн шиг амьдаръя. Улс шиг хөгжье. Баярлалаа.

**3.Энхболд:** - Ерөнхий сайдад баярлалаа. Хоёр мэндчилгээ дэвшүүлье. Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, С.Эрдэнэ нарын урилгаар Баянгол дүүргийн Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн багш сурагчид нийт 60 хүн Төрийн ордон, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Та бүхний сурлага хөдөлмөрт өндөр амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Хоёр дахь мэндчилгээ. Америкийн Нэгдсэн Улсын Жорж Вашингтоны их сургуулийн улс төрийн менежментийн багш, профессор Нэнси Фоскор Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцаж байна.

Улаанбаатар хотод энэ сарын 29, 30-ны хооронд зохион байгуулах залуу эмэгтэйчүүдийн манлайлал семинарын багийн ахлагч байгаа юм байна. Баяр хүргэе.

За чуулганы хуралдаан бүлгүүд үг хэллээ, Ерөнхий сайд үг хэллээ. Одоо санал хураалт явуулна.

Ерөнхий сайдыг огцруулах саналыг Байнгын хороо дэмжээгүй тул огцруулах шаардлагагүй томъёоллоор санал хураая. Санал хураалт. Санал хураалт явагдаж байна.

Санал хураалтад 69 гишүүн оролцож, зөвшөөрсөн гишүүн 46, 66.7 хувийн саналаар Ерөнхий сайд Норовын Алтанхуягийг огцруулах шаардлагагүй гэж үзлээ. Үүгээр энэ асуудал дуусч байна.

***Зургаа. Маршалын албаны тухай хуулийн төсөл, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд (хэлэлцэх эсэх)***

Дараагийн асуудал Маршалын албан тухай хууль. Гүйцэтгэлийн ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэж эхлэх. Хэлэлцэх эсэхийг хэлэлцэж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүйн Х.Тэмүүжин танилцуулна. Индэрт урьж байна.

**Х.Тэмүүжин:** - Улсын Их Хурлын дарга,

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан Монгол Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Эрх чөлөөтэй Монгол хүн гэсэн 5 дугаар бүлэгт шүүгч, шүүхийн хамгаалалт, шүүгдэгчийг албан авчрах, гэрч хохирогчийг хамгаалах, шүүх хорихоос оргон зайлсан этгээдийг эрэн сурвалжлах, хуяглан хүргэх зэрэг чиг үүрэг бүхий тусгай албыг бий болгохоор заасан.

Монгол Улсад шүүн таслах үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хамгаалах, түүнчлэн яллагдагч ялтныг хуяглан хүргэх хязгаарлах, шүүх хуралдаанд албадан ирүүлэх, оргон зайлсан этгээдийг эрэн сурвалжлах зэрэг ажиллагааг цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлж тодорхой зарим чиг үүрэг хариуцах эзэнгүй, тухайн зохицуулалтгүй байна.

Цагдаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад өөрт харъяалагдаж буй чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өөр өөр эрх хэмжээний хүрээнд тус тусын журмаар зохицуулж ирсэн бөгөөд зохицуулалт хангалтгүй, тодорхой чиг үүрэг эзэнгүй улмаас гүйцэтгэх үүргийн талаар маргаан гарах, шүүх

хуралдаан удаа дараа тасалдах зэрэг хүндрэлүүд гарч, үүнийг цаашид нарийвчлан хуульчлах шаардлага үүсэж байна.

АНУ-ын болон Европын орнуудын туршлагаас үзэхэд дээрх чиг үүргийг мэргэшсэн тусгай албаар гүйцэтгүүлдэг бөгөөд ингэснээр шүүн таслах үйл ажиллагааны хэвийн нөхцөл бүрдэж шүүгчийн хараат бус байх зарчим бодит утгаараа хэрэгжиж, улмаар хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хангах үндэс бүрэлддэг байна. Иймээс шүүгч, шүүгчийн аюулгүй байдлыг хамгаалах чиг үүрэг бүхий мэргэшсэн тусгай албыг байгуулж, түүний эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ алба нь шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүнд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, шүүх хуралдааны журам сахиулах, шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдлыг хамгаалахаас гадна шүүн таслах үйл ажиллагаанд гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Гэмт хэргийг шалган тогтоох, нотлох ажиллагаа нь үндсэндээ гэр хохирогчийн мэдүүлэгт үндэслэдэг бөгөөд тэдний аюулгүй байдлыг хамгаалах, шударга ёсыг хангах гол баталгаа болж байна. Гэрч хохирогчийг хамгаалах талаар төрийн бус байгууллагууд үйл ажиллагаа явуулахаар оролдож ирсэн боловч хүчирхийлэл, дарамт зэрэг хүч хэрэглэсэн хууль бус хэлбэрээр үйлдэгдэж, зүй бус ажиллагаатай тэмцэхэд төрөөс эрх олгогдсон албадлага хэрэглэх эрхтэй хүч хэрэгслээр хангагдсан байгууллага ажиллахгүй бол үр дүнд хүрэхгүй болох нь харагдаж байна.

Гэрчийг хамгаалалтад аваагүйгээс амь насаа алдах тохиолдол нэг бус удаа гарснаас гадна хохирогчийг дарамтлах, гэрч хохирогчоор худал мэдүүлэг өгүүлэх зэрэг хууль бус үйлдлүүд олноор гарч байна. НҮБ-ын санхүүжилтээр гэрч хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал сэдэвт судалгааг Хохирогчийн эрхийн судалгааны төвөөс 2010 онд хийсэн бөгөөд судалгаанд тусгагдсан баримтаас үзэхэд гэрч хохирогчийг хамгаалах, түүнчлэн шүүхийн хуяглан хүргэлтийг эрх зүйн орчинг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага бидний өмнө тулгамдсан асуудал болсон байна.

Дээр дурьдсан шаардлагуудыг үндэслэн Маршалын албаны тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Хууль зүйн салбарын шинэчлэлийн цогц бодлогын хүрээнд Засгийн газраас өргөн мэдүүлсэн Маршалын албаны тухай хуулийн төслийг дагалдах хуулиудын төслийн хамт хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээс хүсье.

**3.Энхболд:** - Хуулийн төслүүдийн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсьё. Хууль зүйн байнгын санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Түвдэндорж танилцуулна. Индэрт урьж байна.

**Ш.Түвдэндорж:** - Улсын Их Хурлын дарга,

Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай, Цагдаагийн албаны тухай, Мөрдөх албаны тухай, Маршалын албаны тухай, Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцаа тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн төслүүдийг санаачлан боловсруулж 2013 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ. Үүнээс Маршалын албаны тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2013 оны 04 дүгээр сарын 17-ны хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Маршалын албаны тухай хуулийн төсөл болон гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаар. Маршалын албаны тухай хуулийн төсөлд шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч хохирогчийг хамгаалах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах чиг үүрэг бүхий Монгол Улсын Маршалын албаны тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох, албан хаагчийн эрх зүйн байдлыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахаар тусгажээ.

Уг хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан Маршал гэсэн нэр томъёонд тохирох монгол нэрийг олох. Маршалын алба нь мөрдөн шалгах чиг үүрэгтэй байхаар төсөлд тусгасан байгаа нь үүнтэй ижил чиг үүрэг бүхий цагдаа, мөрдөх алба, тагнуул зэрэг байгууллагуудын үйл ажиллагаатай хир нийцэж байгааг анхаарах. Маршалын алба гэж дотроо нэлээд олон албатай том байгууллага байгуулагдахаар байгаа нь эдийн засгийн хувьд хэрэгжих боломжтой эсэх. Мөн Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан одоогийн тогтолцоогоор шүүх, гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх зэрэг асуудлыг цагдаагийн байгууллага хариуцаж байгаа бөгөөд ийнхүү өөр өөр ашиг сонирхолтой этгээдүүдийн аюулгүй байдлыг нэг байгууллага дангаараа хариуцах нь энэ талын үйл ажиллагааны үр дүнд нөлөөлж байгаа. Гэтэл одоо эдгээр асуудлыг цаашид мөн Маршалын алба дангаараа хариуцахаар төсөлд тусгасан нь хир оновчтой байх зэрэг асуудлуудыг хэлэлцүүлгийн явцад анхаарах нь зүйтэй гэсэн саналуудыг тус тус гаргаж байсан болно.

Ийнхүү Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи Маршалын албаны тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулан хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Маршалын албаны тухай болон дагалдах бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**З.Энхболд:** - Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлтээс асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Асуух юм байхгүй юм уу? Нэг ч хүн байхгүй юм уу? За асуулттай гишүүд алга байна.

Одоо үг хэлсний дараа санал хураана. Гадаа байгаа гишүүд, тэр ярилцлага өгөөд байгаа гишүүдийг орж ирэхийг урьж байна. Олон эзэнгүй кноп бол эсрэг гарах учраас болохгүй байх аа.

За одоо хэлэлцэж байгаа асуудлын талаар үг хэлэх гишүүд байна уу? Ш.Түвдэндорж гишүүнээр үг тасаллаа. Д.Лүндээжанцан гишүүн үг хэлнэ.

**Д.Лүндээжанцан:** - За би энэ Маршалын алба гэж гадаадад бол байдаг. Ялангуяа Америкт очиж манайхан газар дээр нь туршлага судлаад ирсэн хүмүүс байгаа л даа. Шүүхийн аюулгүй байдлыг хангах, яллагдагчийг хуяглан хүргэх, гэрч хохирогчийг хамгаалах гээд. Энэ чиг үүргүүд нь бол байх л ёстой ийм зүйлүүд. Гэхдээ энэ бол манай улсад бол яваад ирсэн. Болоод л ирсэн гэдэг шиг зүйл л дээ.

Гэлээ гэхдээ энэ доторхи тэр Байнгын хорооны дүгнэлт дотор ч хэлсэн байгаа. Гарч байна. Бидний тавьсан асуудал. Жишээ нь, миний тавьсан асуудал. Ингэж байгаа юм. Маршалын албаны шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх үндсэн бүтэц нь дараах албатай байна гэж байгаа юм. Шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх үндсэн бүтэц гэж хэлж байгаа юм.

Нэг. Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах алба. Хоёр. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах алба. Гурав. Мөрдөн шалгах, эрэн сурвалжлах алба. Дөрөв. Яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах алба. Дараа нь бол тусгай бүлэг, бусад алба нэгж гээд. Ингээд одоо би энэ дээр бол энэ чинь ялтныг, одоо оргочихсон ялтныг, хоригдлыг бол одоо эрэн сурвалжлах үйл ажиллагаа гээд ингэхээр энэ чинь шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба одоо жишээ нь юу хийх юм. Мөрдөн шалгах алба бол гарцаагүй байхаас арга алга гээд байгаа юм. Мөрдөн шалгах алба бол одоо олон газар байна.

Ингээд би энэ зохион байгуулалт, бүтцийн хэсэг дээр их давхардал үүсэх. Энэний дагуу тэр алба чинь даргатай, цэрэгтэй. За ингээд цаашаа ингээд хөврөөд хөврөөд явчих ийм зүйлүүд болох гээд байгаа юм. Ийм учраас тэгээд тойргийн Маршалын алба байна гэж байгаа юм. За тэгэхэд одоо яах вэ давж

заалдах шатны шүүхүүд дээр тэр Маршалын ажиллах юм шиг байна. Сум дундын шүүх дээр хорих ял оноож болно шүү дээ. Энийг ер нь яах юм. Ингээд ирэхээр улс орны хэмжээнд маш том агентлаг гарах гээд байгаа юм л даа. Хууль зүйн сайдын мэдэлд бол одоо энэ юугаар бол нийтдээ нэг Мөрдөх алба биеэ даагаад том агентлаг, Цагдаагийн байгууллага том агентлаг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар том агентлаг, за энэ Маршалын алба том агентлаг. За тэр Гадаадын харъяат, иргэний харъяаллын асуудал эрхэлсэн нь бол арай жижгэвтэр юм байх байлгүй дээ. Тэгээд одоо олон улсын харилцаа хөгжиж байгаа үед их л том. За тэгээд хилийн алба гээд.

Ер нь бол Хууль зүйн сайдын мэдэлд маш хүчтэй хүчний байгууллагуудын төвлөрөл бий болоод Хууль зүйн сайдад ажлаа шууд хариуцан тайлагнахаар ийм зүйлүүд болоод байгаа нь бас одоо хир зохимжтой юм бэ гэсэн ийм эргэлзээнүүд үүсээд байгаа юм. За яах вэ тэр Маршал гэдэг үгийг солих бол одоо дахар махар гэдэг үгээр нь солино уу, тэр бол өөр хэрэг.

Энэ арай нэг жаахан Монголынхоо нөхцөлд таарсан, цомхон, чадварлаг, мэргэшсэн ийм даруухан тусгай алба байвал одоо арай дээргүй юу. Энэ Маршалын хуулиар бол маш их л том одоо нүсэр алба бий болох гээд байгаа учраас Маршалын албаны хууль дээр бол би цөөнх болоод гараа өргөөгүй юм. Энэ үндэслэлээ л одоо хэлье гэж ингэж бодож байна.

**3.Энхболд:** - Хууль санаачлагч Х.Тэмүүжин гишүүн асуултад хариульъя. Түрүүн асуух асуулт гараагүй шүү дээ. С.Баярцогт гишүүн үг хэлье.

**С.Баярцогт:** - Би энэ Маршалын албаны тухай хууль болон энэ хууль сахиулах албаны нийт институци, байгууллагуудын тухай хуулиудыг бол бүхэлд нь дэмжиж байгаа юм.

Бид нар бол өөрсдийгөө бол роман, германы эрх зүйтэй. Энэнээсээ уламжлаад социалист эрхзүй дээр үндэслэж явж ирсэн гэж өөрсдийгөө үздэг. Мэдээж Маршалын алба гэхээр хамгийн сонгодог хэлбэр нь бол АНУ-д байгаа. АНУ-ын ерөөсөө төр улс нь байгуулагдаад хамгийн анх байгуулсан хууль сахиулах байгууллага нь бол Маршалын алба юм билээ. Маршалын алба нь юутайгаа холбоотой вэ гэхээр шүүхтэй маш их уялдсан. Өөрөөр хэлбэл шүүхийн байшин дотроо үйл ажиллагаа явуулдаг. Шүүхийн аюулгүй байдал, шүүгчийн аюулгүй байдал, гэрч, хохирогчийн аюулгүй байдал. Дээрээс нь сэжигтэн ялтнуудыг хүргэх, хуяглаж хүргэх, за оргон зайлсан хүмүүсийг бол эрж хайх гэсэн ийм үндсэн функцтэй юм билээ.

Тэгээд сүүлийн үед бол энэ роман, германы болон англи саксоны гэсэн энэ хуулийн том ангилал бол үндсэндээ холилдоод ийм холимог системийг бол аль аль улс нь хүлээн зөвшөөрч авдаг ийм болчихсон. Энэ утгаараа бол мэдээж хэрэг одоогийн байдлаар манайд энэ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба тодорхой хэмжээний функцийг нь гүйцэтгэж байгаа юм. Цагдаагийн алба бас яг энэ тодорхой хэмжээний үүргийг нь гүйцэтгэдэг юм байна.

Шүүхийн байр нь хүртэл өөрөө анхнаасаа бодож зохион байгуулаад

Маршалын алба нь хаана байрлах юм, шүүгч нь өөрөө хаана байх юм, гаднаас орж ирсэн хүмүүс нь аль хүртэл нэвтрэх юм, гэрч хохирогч нь яаж ирэх юм, сэжигтэн, яллагдагч гэж байгаа хүмүүсийг хаанаас яаж авчрах юм гэдэг зохион байгуулалтын асуудал нь хүртэл өөрөө их нарийн юм билээ. Тийм учраас шүүхийнхээ одоо бүгдийг нь тойргийн системээр байгуулаад шинэ шүүхийн байр байшин, барилга зохион байгуулалтаа хийгээд энэ албыг байгуулаад ажиллуулах юм бол бүрэн цогцоороо зөв зүйтэй болох юм байна гэж үзэж байгаа.

За өнгөрсөн энэ чуулганы завсарлагааны хугацаанд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны гишүүдийг ахлаад би энэ АНУ-ын хүчний байгууллагуудаар бүгд дээр нь очиж туршлагыг нь судалсан. Өөрсдийнхөө энэ боловсруулсан хуулийн төслүүд, бид нартай хүмүүс нь цуг явж байсан. Бид нар бол Монголын онцлогтой холбогдуулаад маш олон зүйлийг харж ярилцаж байсан.

Дараа нь Монгол Улсын хүчний байгууллагын удирдлагууд бас энэ байгууллагуудаар ороод тодорхой хэмжээний туршлага зүйлүүдийг бол судалсан байгаа.

Тэгэхээр энэ материаллаг хуулиуд, процессын хуулиуд, энэ институцийн хуулиуд бол бүхэлдээ гарч байж хуулийн нэгдсэн тогтолцоо бол энэ 2002 оноос хойш дахин нэг реформ хийгдэх ёстой юм байна гэж ингэж харагдаж байгаа юм. Тэр утгаар нь бол энэ Маршалын албаны тухай хуулийг бол хэлэлцэж шийдэх нь зүйтэй гэж дэмжиж байгаа.

Нэр усны хувьд бол мэдээж хэрэг монголчлох уу, яах вэ гэдэг талаас нь ярилцах ёстой. Маш олон улсууд үнэхээр олон нэр томьёо болчихсон зүйлийг бол яг англиар нь галиглаад улс орондоо хэрэглэдэг тохиолдол бол олон байдаг юм билээ. Тэгэхээр энэ дээр бол яг ажлын хэсэг гараад хэлэлцүүлэх үед бол тохиролцоод ярилцаад шийдвэрлэж болох байх гэж ингэж бодож байна. Тийм учраас хуулийг хэлэлцэх нь зүйтэй. Дэмжиж байна. Баярлалаа.

**3.Энхболд:** - Ш.Түвдэндорж гишүүн үг хэлнэ.

**Ш.Түвдэндорж:** - За энэний өмнөх хуулийг хэлэлцэж байх үед хэлсэн. Шүүх, ер нь хууль эрх зүйн салбарын шинэчлэлийн асуудлыг 2009 оноос хойш одоо Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж сонгогдсоноос хойш шүүхийн шинэчлэл, энэ эрх зүйн шинэчлэлтийн асуудал нэлээн шаргуу тавигдаж ирсэн. За энэ хугацаанд 2011 онд шүүхийн багц хуулиуд батлагдсан. Тэрний дагуу, за тэрний хүрээнд ч гэж хэлж болно. Одоо энэ эрх зүйн салбарын багц хуулиуд Улсын Их Хурлаар орж хэлэлцэгдэж байгаа.

За яг энэ хэлэлцэхийн явцад бас улс төрийн асуудал үүсээд Засгийн газар огцрох эсэх асуудал ингээд бас хугацаа нь хойшлоод. Яагаад би хугацаанд ингэж их санаа зовоод байгаа юм бэ гэхээр манай шүүхийн багц хууль маань 4 сарын 15-ны өдрөөс эхлээд хэрэгжээд эхэлчихсэн. Гол ажил төрөл нь эхэлж байдаг. Нөгөө Д.Лүндээжанцан гишүүний хэлээд байдаг бусад



дагаж бий болох ёстой юмнууд нь хоцрогдоод нэг ийм хачин байдалд ороод жонхуу болчихвий гэсэн тийм санаа зовсон үг хэлж байсан. Би тэр юуг дэмжиж энэ одоо дагалдан гарах энэ хуулиудын төслүүдийг яаралтай Их Хурлаар хэлэлцэх эсэхийг нь шийдээд, хэлэлцүүлэгт нь оруулаад хурдан. Ялангуяа энэ 11 хуулийг даруйхан хэлэлцэж баталж, тал талаас нь бас мэтгэлцэж хурдан шийдэх нь зүйтэй гэж үзэж байгаа.

Одоо өнөөдөр бол бид нарт манай нийгмийн хөгжил, ер нь хүн ардын амьдрал энэ бүх юманд хурдыг их шаардаж байна. Хурдыг шаардсан энэ үед бид нар хойргошиж. За яах вэ улс төрийн асуудлууд байна. Энийг хаа хаанаа ойлгож болно. Нэгэнт асуудал шийдсэн. Тэгэхдээ энэ хуулиудыг даруйхан одоо хэлэлцэж. За миний ойлгож байгаагаар энэ хуулиудтай холбоотой сонирхож байгаа, мөн санаа тавьдаг бүх хүмүүсийг оролцуулсан томоохон хэмжээний бас хэлэлцүүлгийг Хууль зүйн байнгын хорооноос явуулъя гэсэн бодолтой байгаа. Сүүлийн 6 хууль, за Мөрдөх албаны хууль ингээд дахин өргөн баригдаад хэлэлцээд, хэлэлцэх эсэх нь шийдэгдсэний дараа энэ асуудлуудыг Их Хурлын хэмжээнд, ер нь бүх их дээд сургуулиуд, сонирхогч тал, олон нийтийн байгууллага, гадаадын бас байгууллагуудтай хамтарч томоохон зөвлөгөөн ч гэдэг юм уу, семинар ч гэдэг юм уу, бага хурал ч гэдэг юм уу тийм зүйл хийе. Тэр дундаас бас эрдэмтэн мэргэдийн сонирхогчдын бас нэг зовлон үзсэн чавганц, тэр амьдралд нь оролцож явсан хүмүүс одоо амьдарч байгаа зөрчилдөж болзошгүй талууд. Эд нар бол хоорондоо бас энэ ойлголтдоо нэг мөр хүрэхэд энэ зөвлөгөөн, уулзалт маань хэрэг болох байх гэж бодож байгаа.

Тэгэхдээ бидний өмнө тулгамдаж байгаа зүйл бол бид нарын энэ асуудлыг шийдэх цаг хугацаа бол маш бага үлдсэн. Ийм учраас энэ хуулиудаа хэлэлцээд хурдхан дэмжээд Их Хурлаасаа одоо шийдвэрээ гаргаад явсан зүйтэй гэсэн ийм саналыг хэлж байна.

**3.Энхболд:** - За гишүүд үг хэлж дууслаа. Одоо хуулийн төслийн хэлэлцэх эсэхээр санал хураамаар байх юм. Маш олон эзэнгүй кноп байх юм. Эд нар одоо бүгдээрээ хэлэлцэхийг эсэргүүцээгүй байх гэж бодох юм. Үүдэнд байгаа гишүүдийг орж ирэхийг урьж байна. Өрөөндөө сууж байгаа гишүүдийг орж ирэхийг урьж байна. Сая кноп дарахад 69 гишүүн байсан. Буцаагаад ярих уу. Оруулж ирэхийн тулд.

Ц.Нямдорж гишүүн санал байвал индэр лүү гарч хэлэх үү. Зааланд байхгүй хэн нэгэн сайдыг ярья. За 5 минут хүлээе. 5 минутын санал хураана. Хэлэх дэг байхгүй л дээ, Ц.Нямдорж гишүүн ээ. Дэг өөрөө журам байхад болдог байсан. Одоо дэг өөрөө хууль болчихоор болохгүй байна шүү дээ.

За одоо хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлаар санал хураана. Байнгын хорооны саналаар Маршалын албан тухай хууль. Гүйцэтгэлийн ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт.

Санал хураалтад 69 гишүүн оролцож, 51 гишүүн зөвшөөрч, 73.9 хувийн саналаар миний дээр дурдсан хуулийн төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

***Долоо. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн төсөл, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд  
(хэлэлцэх эсэх)***

Дараагийн асуудал. Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн төсөл, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүйн сайд Х.Тэмүүжин танилцуулна.

**Х.Тэмүүжин:** - Улсын Их Хурлын дарга,

Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д төр нь хүний эрх, эрх чөлөөг хангах, эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх хүний эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүрэгтэй гэж Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар бүлэгт Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэхээр тус тус заасан.

Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай фактад гишүүн улс бүр уг фактаар хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөөнд зөрчигдсэн аливаа хүнийг үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтаар хангахыг үүрэг болгожээ. Мөн ирээдүйн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн 13 дугаар зүйлд гомдол гаргасан этгээд болон гэрчүүдийг гомдол гаргасан болон нотлох баримт гаргаж өгсөнтэй нь холбогдуулан зүй бусаар харьцаж, айлган сүрдүүлэхээс хамгаалах арга хэмжээ авна гэж заажээ. Түүнчлэн НҮБ-ын ассамблейн 2003 оны 58.4 дүгээр тогтоолоор баталсан Авлигын эсрэг конвенци, НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2000 оны 55, 25 дугаар тогтоолоор баталсан

үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенци болон бусад олон улсын гэрээ конвенцид оролцогч улс бүр энэхүү конвенцид тогтоосон гэмт хэргийн талаар мэдүүлэг өгч буй гэрч ба шинжээч, мөн зохих тохиолдолд тэдний хамаатан садан болон бусад ойрын хүнийг өс хонзон буюу айлган сүрдүүлэлтээс хамгаалах талаар зохих арга хэмжээ, өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн боломжийн хэмжээнд авна. Оролцогч улс бүр энэхүү конвенцид хамаарах гэмт хэрэг, ялангуяа өшөө авах буюу заналхийлэлээс хохирогчийг хамгаалах болон түүнд туслалцаа үзүүлэх зохих арга хэмжээ авна гэж тус тус үүрэг болгосон байна.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 40, 34 дүгээр тогтоолоор 1985 онд гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн улмаас хохирсон хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмын тухай тунхаглалыг батлан гаргасан нь олон улсын хэмжээнд хохирогчийн эрхийн талаар гаргасан үндсэн баримт бичиг болж байна. Уг тунхаглалын 6 дугаар зүйлд гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг нэн тохиромжтой нөхцөлөөр хангах, мөн заналхийлэл буй тохиолдолд гэрчийг хамгаалахыг улсуудад хуваарилсан байна.

Гэрч, хохирогч нь гэмт хэргийн шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангахад гол үүрэг гүйцэтгэдэг субъектүүд бөгөөд судалгаануудаас үзэхэд тэдний аюулгүй байдал хамгаалалтгүй байна. Гэрч хохирогчийг сүрдүүлэх, дарамтлах, хуурч мэхлэх, мөнгө өгөх, гуйх, ятгах, заналхийлэх зэрэг хэлбэрээр нөлөөлөх явдал гарсаар байгаа бөгөөд үүний үр дагавар мэдүүлэг өгөхгүй байх, эсхүл худал мэдүүлэг өгөх, сэтгэл зүйн хувьд хэвийн байдлаа алдах, амиа хорлох оролдлого хийх, амиа хорлох зэрэг үйлдэл болж буйг судлаачид тэмдэглэсэн байна.

Гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж буй этгээдүүд гэрч, хохирогчийг хамгаалах эрх зүйн зохицуулалт, тогтолцоо байхгүй гэсэн үндэслэлээр гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагаа хийдэггүй болох нь судалгаагаар тогтоогдсон байна. Харин амь нас, эрүүл мэндэд нь аюул заналхийлэл тулгарсан хүүхэд эмэгтэйчүүдийг Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг Хүйсийн тэгш эрхийн төв гэсэн төрийн бус байгууллагууд хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлдэгч маш бага хүрээг хамаардаг, санхүүгийн бэрхшээлтэй тулгардаг байна.

Бусад улсын эрх зүйн зохицуулалтын чиг хандлагыг судлан үзвэл гэрч, хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх зорилгоор эрх зүйн бие даасан зохицуулалтыг бий болгож, үүний үр дүнд хохирогч, гэрчийг хамгаалах туслалцаа үзүүлэх нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн байна. Дээрх шаардлагуудыг үндэслэн гэрч, хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Хууль зүйн салбарын шинэчлэлийн цогц бодлогын хүрээнд Засгийн газраас өргөн мэдүүлсэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн төслийг дагалдах хуулиудын төслийн хамт хэлэлцэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж

өгөхийг та бүхнээс хүсье.

**3.Энхболд:** - Хуулийн төслүүдийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Байнгын хорооны дарга Ш.Түвдэндорж танилцуулна. Индэрт урьж байна.

**Ш.Түвдэндорж:** - Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай, Цагдаагийн албаны тухай, Маршалын албаны тухай, төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн төслүүдийг санаачлан боловсруулж 2013 оны 04 сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ. Үүнээс Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлаар Хууль зүйн байнгын хороо 2013 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн төсөл болон Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаар.

Уг хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан Гэрч, хохирогчийг хамгаалах асуудлыг нэг мөр зохицуулан хуульчлахаар оруулж ирж байгаа нь томоохон дэвшил юм. Гэхдээ энэ хууль гарснаар гэрч, хохирогчдыг хавтгайруулан хамгаалалтад оруулах зэрэг асуудал гарч ирж болзошгүйг хэлэлцүүлгийн шатанд анхаарах нь зүйтэй гэсэн саналыг гаргаж байсан бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи нь гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулан хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**3.Энхболд:** - Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлтээс асуулттай гишүүд нэрээ өгнө үү.

Д.Лүндээжанцан гишүүнээр асуулт тасаллаа. Ц.Нямдорж гишүүн асууя.

**Ц.Нямдорж:** - Байнгын хорооны даргаас асууя даа. Энэ Маршалын хууль, Гэрч хохирогчийн хууль одоо бол тодорхой хэмжээний зардал шаардана. Яг энэ хуулийн тухайд миний үед боловсруулагдаж байсан хууль л даа. Хязгаараа яаж хумиж авах юм байгаа юм.

Тэгээд миний асуух гээд байгаа юм бол энэ шинэ хоёр хуультай холбогдуулж гарах зардлын тооцоог нарийвчилж гаргаж чадсан уу. Хэрвээ чадаагүй бол энэ хэлэлцүүлгийн явцад одоо яг хар зурэг дээр энийг буулгаж тооцоог нь гаргах хэрэгтэй. Нэг шүүхийн дэргэд хэдэн Маршалын албаны хүн байх юм. Тэд нар нь яаж ажиллах юм гэх мэтийн ийм одоо яг бодитой ажлын зураг гаргах хэрэгтэй. Энэ тал дээр энэ ажлын хэсэг байгуулахдаа ажиллах уу гэсэн ийм асуулт байна.

Зүгээр ер нь бол энэ Монголын нөхцөл гэж нэг сонин л юм байдаг юм шүү дээ. Одоо энэ Маршалын албаныхан оргосон зайлсан ялтанг хайж олно гээд л, эрэн сурвалжилна гээд явж байгаа. Яг эцсийн дүндээ Монголын 327 суманд сүлжээтэй ганц систем чинь цагдаагийн л систем шүү дээ. Би олон жил энэ алба хашихад эхэлж манай энэ шийдвэр гүйцэтгэх албаныхан алдсанаа мэдээд л. Тэгээд өөрсдөө нэг эрлийн групп гаргаад л. Давхар цагдаагийн бүхэл бүтэн сүлжээг өдөр шөнөгүй хөдөлгөж байж л нэг юм барьж авдаг юм шүү дээ. Ийм ийм юмнууд байгаа учраас энэ тооцоогоо их сайн магадлах хэрэгтэй. Энэ тал дээр Байнгын хороо ямар бодолтой байгаа вэ гэсэн асуулт асууя гэж бодсон юм.

Монголд гарч байгаа гэмт хэргийн 52.0 хувь нь хулгай байдаг. За нэг 25.0 орчим хувь нь хүч хэрэглэсэн, танхай, зодоон, орон гэртээ харилцан зодолдсон гэх мэтийн хэргүүд. Ийм л юмнууд байдаг юм л даа. Үлдсэн нь хүний амь гэх мэтийн хүнд хэргүүд. Дээрэм тонуул гээд. Ийм эрүүгийн нөхцөлтэй орны энэ Маршалын алба ямар байх ёстой талаар их л сайн бодолцох ёстой асуудал.

Чи үнэнээ хэлэх юм бол наад хөдөө гадаа гараад байгаа ахуйн шинжтэй саяны миний ярьдаг хүрээнд гардаг хэргүүдийн хувьд нэг их айлгаж сүрдүүлээд байх юм байдаггүй юм шүү дээ. Мөрдөн байцаалтын шатанд нухлагдаж нухлагдаж ирээд, хамаг юм нь баримтаараа нотлогдоод шүүхэд хоёр гараа өргөчихсөн хүн орж ирээд л хэдэн жил авах вэ гэдгээ залбирч хүлээж сууж байгаад өгсөн ялыг нь аваад явдаг л эд шүү дээ.

Одоогийн энэ манай зарим хүмүүсийн яриад байгаа юм бол нэг Оросын детектив кинонууд гардаг юм НТВ телевизээр. Тийм болчихсон юм шиг л юм ойлгоод л яриад байгаа байхгүй юу.

Миний мэдэхийн одоо энэ хэрэг төвгөөс үүдэлтэй нэг ганцхан удаагийн тийм будлиантай юм л нөгөө цагдаагийн дарга нарыг шийтгэж байхад л болсон доо. Бусад тохиолдолд жаахан бэрхшээл гарангуут цагдан хорих төв дээр нь шүүх хурал хийгээд л. Тэр нь хаалттай. Тэгээд л ерөнхийдөө бол аюулгүй дуусдаг л юм.

Зүгээр энэ хар тамхины хэрэг, зэвсгийн наймааны хэрэг гээд. За зэвсгийн

наймаа манайд бараг байхгүй дээ. Энэ сүүлд ганц нэг хэрэглэ.../минут дуусав/

**3.Энхболд:** - 1 минутаа авах уу, дараа нь авах уу? Ц.Нямдорж гишүүн 1 минут.

**Ц.Нямдорж:** - Тэгээд гол юм бол эцсийн дүндээ миний асуух гээд байгаа юм бол энэ тооцоогоо магадлаад яг одоо байгаа орон тоо дотроо зохицуулалт хийж байж энэ албыг байгуулах гэж байна уу, нэмэлт орон тоо шаардагдаж байна уу гэдэг хамгийн сонирхолтой асуулт энд байгаа байхгүй юу. Энэ дээрээ нэгдсэн ойлголтод хүрэх шаардлагатай. Ер нь бол ийм эдийн засгийн сайн биш нөхцөл байдлын үед бол хууль гаргахдаа гарах зардлын тооцоо гэж нэг гол юм байдаг юм л даа.

Миний хамгийн сүүлд оруулсан том хууль бол энэ жолоочийн даатгалын хууль байгаа юм. Тэр хууль хэрэгжээд 1 жил болж байна. 16.0 тэрбум төгрөгийн даатгалын хураамж төлөгдөж, 300 мянган машин. 4.9 тэрбум төгрөг нь нөхөн төлбөр хийгдсэн. Өөрөөр хэлбэл энэ хуулиар төсөвт төвлөрч байгаа хөрөнгө нэг 5, 6 дахин нэмэгдсэн ийм л тоо гарч байна л даа.

**3.Энхболд:** - Байнгын хороо хариулъя. Ш.Түвдэндорж гишүүн хариулъя.

**Ш.Түвдэндорж:** - За энэ зардлын тооцоог бол энэ номны. Та бүхэнд ном тараасан байгаа. Тийм ээ. Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд гэсэн ном дээр 7 дугаар хуудсан дээр зардлын тооцоонуудыг нь гаргаад өгсөн байгаа.

Ер нь бол бас энэ дээр анхаарал. Манай Байнгын хорооны хурал дээр бол гишүүд хэлж байсан. Хэлэлцэх эсэх асуудлыг нь ерөнхийдөө хэлэлцчихье. Тэгээд томоохон хэмжээний ажлын хэсэг байгуулъя. Тэгээд энэ бүх хуулиудаар дэд ажлын хэсэг байгуулаад нэлээн нухацтай хэлэлцээд тэгээд одоо томоохон семинар зөвлөгөөн хийгээд тал талаасаа ярилцаж байж энэ асуудлуудыг шийднэ гэдэг үүднээс энэ хэлэлцүүлгийн явцад энэ санхүүгийн асуудлуудыг нь, эдийн засгийнх нь тооцооны асуудлууд бол нэлээн нягталж яригдана гэж ойлгож байгаа.

Одоогоор Маршалын одоо энэ албаны тухай хуулийг бол С.Баярцогт гишүүн ахлахаар, Гэрч, хохирогчийн хуулийн төслийг нь болохоор Ц.Оюунбаатар гишүүн ахлахаар ингээд ажлын дэд хэсгүүд гараад ажиллаж байгаа. Ерөнхий ажлын хэсэг нь Р.Гончигдорж гишүүн ахалж байгаа.

Тухай бүрээр маш нягт ярилцана бид.

**3.Энхболд:** - Орон тоо нэмэгдэх юм уу, одоогийн орон тоондоо багтах юм уу гэдэг. Х.Тэмүүжин сайд хариулъя.

**Ш.Түвдэндорж:** - За тэгье. Зардал нь бол энэ дээр байгаа. Х.Тэмүүжин сайд хариулъя.

**Х.Тэмүүжин:** - Гэрч, хохирогчийг хамгаалахтай холбоотой, дагалдан гарч байгаа Маршалын албатай холбоотойгоор зүй ёсоор тавигдах асуулт бол үнэхээр энэ орон тоотой холбоотой, зардалтай холбоотой асуудал байгаа юм.

Ц.Нямдорж сайд ч гэсэн хэллээ. Үнэхээр манайд гарч байгаа нийт хэргийн 80 хувь нь бол үндсэндээ бол гэрч хохирогчийг хамгаалаад байх шаардлагагүйгээр ил өөрөө шийдэгддэг тийм хэргүүд байгаа юм. Үлдсэн 2 дээр нь бол тодорхой асуудлууд үүснэ. Тэр дундаа шинэ төрлийн гэмт хэргүүд дээр, одоо хүн худалдаалах, хар тамхи гэх мэтчилэн зохион байгуулалттай бүлэг этгээдүүдээс хийгдэж байгаа энэ гэмт хэрэг дээр илүүтэй гэр хохирогчид бодит заналхийллүүд бий болдог. Тийм учраас гэрч, хохирогчийг хамгаалах шаардлагатай тэр хэсэг бол жижигхэн хүрээ гарч ирнэ. Энэ хүрээнд бол тодорхой зардлууд өмнө нь байгаагүй учраас гарах байх.

Шүүхийн хамгаалалт болон дотоод зохион байгуулалттай тэр хэсэг дээр бол аль болох. Үндсэндээ бол бараг гуравны хоёр нь одоо байгаа орон тоо, цалин дээр нь энэ Маршалын алба зохион байгуулагдах юм. Угаасаа шүүхийн харуул гээд энгийн хүн байгаа. Цалинтай. Гэрээгээр ажилладаг. Дотор нь бол цагдаагийн нэг албан хаагч байгаа. Бас цалинтай, орон тоотой. Хуяглан хүргэлтүүд бас тийм байдлаар явж байгаа. Тэгэхээр энэ бол ямар ч байсан эхний ээлжинд бол Маршалын алба байгуулахад бид одоо бэлэн байж байгаа орон тоо, цалингийн фондтой тэр нөөцөөрөө энэ үйл ажиллагааг үе шаттайгаар хийнэ гэсэн төлөвлөлт хийж байгаа юм.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль дээр цагдаагийн байгууллага, мөрдөх алба, өөр тагнуул, авлигатай тэмцэх газар ч гэдэг юм уу энэ байгууллагууд өөрийн үйл ажиллагааны хүрээнд өөрийн төсөв болон зохион байгуулалтынхаа бүтцээр бол гэр хохирогчийг хамгаалах эхний алхам хийх үүрэгтэй байгаа. Тэр зардлууд нь тэр дээрээ угаасаа урсгал зардалдаа одоо байгаагаараа явчихна гэсэн үг. Харин тусгайлан заавал зардал гарах шаардлагатай, нэмэлт зохион байгуулалт хийх шаардлагатай, нүүлгэн шилжүүлэх гэдэг юм уу, тусгай хамгаалалтын байранд хамгаалалт хийх шаардлагатай болох юм бол тэр нь Маршалын алба хийх болж байгаа юм.

Тэгэхээр нийтдээ хамгаалагдаж байгаа гэрч, хохирогчийн яг энэ Маршалын албатай холбоотой тусгайлан зардал гардаг, тусгай тоног төхөөрөмж шаарддаг, тусгай байр шаарддаг, биеийн хамгаалалт шаардаж байгаа тэр хэсэг бол зардал гарна. Энэ зардлын тооцоонууд бол үе шаттайгаар нь тараасан энэ номны 7, 8 дугаар хэсэг дээр бол дэлгэрэнгүй бичсэн байгаа.

Хорих байгууллагатай холбоотой асуудал бас оргон зайлаад Маршалын алба хайна. Цагдаагийн бие бүрэлдэхүүн болон хорих байгууллага өөрөө энийг хийдэг гэж. Энийгээ бол хийнэ. Угаасаа хэрвээ хоригдол оргосон байх юм бол эрэн хайх ажлыг бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр бүрэн бүрэлдэхүүнээрээ жигд ингээд хяналт тавьчихсан байгаа. Цагдаагийн байгууллагын хүчийг ашиглан. Нөгөө шийдвэр гүйцэтгэх байгууллага өөрөө зохион байгуулалтыг хийнэ. Гэхдээ түрүүний хэлсэн зохион байгуулалттай шинэ төрлийн гэмт хэрэг гэж яриад байгаа.

Энэ гэмт хэргийн холбогдогчид шоронгоос оргонгуутаа бодит заналхийллийг 3 төрлийн хүнд л үзүүлдэг. Нэгдүгээрт нь, өөрийн гэрчилсэн буюу хэрэг үүсгэсэн хохирогчид заналхийлэл учруулдаг. Ялласан прокурорт заналхийлэл учруулдаг, хэргийг нь шүүсэн шүүгчид заналхийлэл учруулдаг. Тийм учраас зөвхөн Маршалын албад хүн орголоо, ийм хүн орголоо гэдгээ мэдэгдэнэ. Маршалын шаардлагатай үед энэ 3 төрлийн заналхийлэл учруулж байгаа хүнийг буцаагаад хорино гэдэг бол нөгөө гэрч хохирогчийг хамгаалж байгаа, шүүгчийг хамгаалж байгаа, шүүн таслах үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг харуулж байгаа энэ үндсэн үйл ажиллагааных нь эрсдэл багасна гэсэн үг.

Тийм учраас Маршалын алба өөрөө тийм хүчээр энийг хайх биш эрэн хайж байгаа энэ үйл ажиллагаанд оролцох тухай яриа юм. Нэг хоёр хүн нь оролцож мэдээллээ авч, тэр хүмүүс хаана байна гээд. Жишээ нь, үнэхээр гэрчид заналхийлэл учруулж байгаа хүн оргон зайлсан байх юм бол үндсэн энэ бүрэлдэхүүн нь энэ гэрчээ одоо хааш нь шилжүүлэх вэ, тэр гэрчийн аюулгүй байдлыг яаж хангах вэ гэдэг үндсэн үйл ажиллагааг зохион байгуулж, мэдээллээ авч хамтран ажиллахад зориулагдсан хэсэг байгаа юм. Тийм учраас давхардсан зардал юм уу, давхардсан нүсэр орон тоо, бүтэц гарах тухай ойлголт бол байхгүй.

**3.Энхболд:** - М.Батчимэг гишүүн асууя.

**М.Батчимэг:** - За энэ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн төсөл өргөн барьж байгаа нь бол маш чухал зүйл гэж бодож байна. Яагаад гэвэл энэ хууль аль эртнээс манайд хэрэгтэй байсан. Одоо ялангуяа хар тамхи, хүн худалдаалах, мөнгө угаах гээд үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг цаашдаа улам зохион байгуулалттай нарийн болж байгаатай холбоотойгоор үнэхээр Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг яаралтай батлан гаргах нь их чухал болж байгаа.

Надад хоёр асуулт байна. Нэгдүгээрт нь, сая хэлсэн тэр зохион байгуулалттай гэмт хэргүүд дээр нэмээд энэ гэрч хохирогчийг хамгаалах асуудал бол гэр бүлийн хүчирхийлэлттэй тэмцэх хүрээнд маш их яригддаг асуудал. Өнөөдөр Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэл маш санаа зовоох түвшинд хүрсэн байгаа. Эмэгтэйчүүд хүүхдүүд рүү чиглэсэн гэр бүлийн хүчирхийлэл бол үнэхээр санаа зовоох түвшинд хүрсэн байгаа гэдгийг онцолж хэлмээр байна.

Тэгээд үүнтэй холбоотойгоор өнөөдөр түрүүн хэлсэн. Төрийн гүйцэтгэж чадахгүй байгаа, одоо энэ хүчирхийлэлд автсан эмэгтэйчүүдийг хамгаалах, хүүхдүүдийг хамгаалах чиглэлээр төрийн хийж чадахгүй байгаа энэ чиг үүргийг өнөөдөр үндсэндээ эмэгтэйчүүдийн ахалсан, тэргүүлсэн төрийн цөөхөн төрийн бус байгууллагууд хийж байгаа, гол үүрэг гүйцэтгэж байгаа. Тэгээд эд нарт тохиолддог гол гол хүндрэл бэрхшээлүүдийг аваад үзэхээр нэгэнт төр энд бага үүрэг гүйцэтгэж байгаа учраас эдийн засгийн хувьд маш их хязгаарлагдмал нөхцөл байдалд байдаг. Түр байрлуулах орон байрны нөхцөл хүнд байдаг



гэдгийг хэлдэг. Үүний хамгаалалт маш их хүнд хэцүү байдаг гэдгийг хэлдэг.

Тэгэхээр би яг тухайлаад энэ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, гэр бүлгийн хүчирхийллийн золиос болж байгаа гэрч хохирогчийг хамгаалахад энэ гэрч хохирогчийг хамгаалах энэ хууль маань аль хир үр дүнгээ өгч чадах вэ гэдгийг асуумаар байна.

Хуулийн 18.1 дээр хамгаалалтад байгаа гэрч хохирогчид үзүүлэх туслалцааны төрөл гэдэг дээр хууль зүйн туслалцаа, сэтгэл зүйн туслалцаа, эрүүл мэндийн туслалцаа гэсэн 3 төрөл байна. Миний хувьд бол шаардлагатай нөхцөлд эдийн засгийн туслалцаа үзүүлэх асуудал магадгүй төрөөс яригдах ёстой гэж бодож байна. Дээрээс нь сая энэ нэмэлт хөрөнгө зардлын асуудал ярилаа. Энэ гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид одоо орон байрны туслалцаа үзүүлэх асуудлыг яг одоо тооцоо судалгаагаар нь яаж харж байгаа юм бэ гэдэг нэг асуулт байна.

Хоёрдугаарт нь, гэрч хохирогчийг хамгаалах асуудал, хууль өөрөө энэ хуулийн концепци, өөрөө хүний эрхийн концепцитай, хүний эрхийн хамгаалах асуудалтай маш их уялдаатай яригдах ёстой. Тэгэхээр энэ хууль батлагдсанаар хүний эрхийг хангах чиглэлээр ямар дэвшил гарах юм бэ? Тухайлбал гэрч, хохирогчийн эрхийг хамгаалах асуудлаар. Хуулийн 16 дугаар зүйл дээр байна л даа. Тухайлбал гэрч хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалалтын өөр хэмжээгээр, арга хэмжээгээр хангах боломжгүй тохиолдолд түүний зөвшөөрснөөр гадаад төрхийг мэс заслын аргаар өөрчилж болно гэж. Би бол энэ их болхи хэллэг байна гэж бодож байна.

Өөрөө хүсэлт гаргавал одоо өөрчлөх зүйл байна уу гэхээс биш чиний амь насанд аюул учраад байна, чамайг одоо мэс засал хийж өөрчилнө гэдэг зүйлийг бол ярьж болохгүй байх. Тэгэхээр энийг маш их хүний эрхийн мэдрэмжтэй хууль гарах ёстой гэж бодож байна. Энэ энэ асуудлууд бол хуулийн хэлэлцүүлгийн явцад сайжрах байх. Тэгэхдээ миний тавьж байгаа асуулт бол энэ хуулийн үзэл баримтлал чинь өөрөө хүний эрхийг хангах асуудалтай аль хир уялдаж гарсан бэ, аль хир дэвшил гарах вэ гэдэг ийм асуулт байгаа юм.

**3.Энхболд:** - Х.Тэмүүжин сайд хариулъя.

**Х.Тэмүүжин:** - Үнэхээр цөөнгүй байгууллагын судалгаагаар Монгол Улсад гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг бол төр өөрөө хийхгүй төрийн бус байгууллагаар хийлгэж байгаа. Төрийн бус байгууллагууд бол мэдээжийн хэрэг энэ хүч хэрэглэдэг. Ихэнхи тохиолдолд хэтэрхий увайгүй байдаг. Энэ гэрч, хохирогч руу заналхийлэл бий болж байна энэ гэмт тэр хэсэгтээ бол тэмцэх ямар ч чадавхгүй байгаа. Мөн гэрч, хохирогчийг хамгаалах хэмжээнд санхүүгийн том бэрхшээл учирдаг. Хамрах хүрээ их жижигхэн байдаг.

Зөвхөн нэг жишээ нь Хэрлэнчимэг гээд нэг хүний хэрэг. Та бүхэн бүгдээрээ санаж байгаа байх. Насанд хүрээгүй нэг эмэгтэйг боож алсан хэрэг. Тэдний хамаатан садан, найз нөхдүүд тэр хүрээнд хуулийнхан байсан учраас шүүх хурал нь 18 удаа хойшилж байсан. Тухайн шүүх хуралд гэрчлэх гэж байгаа

гэрчийг бүх төрлөөрөө заналхийлж, нөлөөлж, худалдаж авч, шүүхийн шийдвэрийг өөрийнхөө талд бүрэн гарах тийм бололцоотой хэмжээнд очсон байсан. Монгол Улсад шударга ёс, бодит байдал тогтоох ямар ч боломжгүй хэмжээнд очсон байсан. Тийм учраас энэ гэрч, хохирогчийг хамгаалах механизм Монголд яагаад чухал вэ гэдэг бол энэ зүйлээр харагдах байх.

М.Батчимэг гишүүн сая бас асуулаа. Үнэхээр энэ гэрч, хохирогчийг хамгаалах хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл, хүн худаалах болон бэлгийн мөлжлөгт өртсөн эмэгтэйчүүдийн асуудал бол бас маш их эмзэг сэдэв байдаг. Тэгээд энэ хүрээнд зөв харьцахаас авахуулаад, сэтгэл зүйн зөв эмчилгээг хийхээс авахуулаад хамгаалалтын байраа бас зөв шийдэхгүй бол гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой асуудал тэр хүчирхийллээс хамгаалж байгаа байранд нь ирээд хүчирхийлж байсан тохиолдол ч бас гарсан. Сүүлдээ бүр тэр байгууллага байраа өөрсдөө яаж солих вэ гэдэг асуудал дээр хүртэл тулж байсан. Нууцлалын асуудал, хамгаалалтын асуудал гээд олон зүйлээрээ. Тэгээд энэ хууль гарснаар нэлээн том дэвшил гарна.

Хүний эрхийн асуудлаар аль аль талаасаа харж байгаа. Үнэхээр гэрч хохирогчийг бодит заналхийлэл, тодорхой хэрэг гэрчилсний төлөө тодорхой өөртөө хохирсон хохирлыг нэхэмжилж, өөрийнхөө эрх ашгийг хамгаалах гэж оролдсоны төлөө ямар нэгэн бодит заналхийлэл, хүчирхийлэлд өртөхгүй байх талаасаа хууль бол бүрэн дүүрэн бичигдэх, зорилгыг хангах талаар боловсруулагдсан. Гэрч, хохирогчийн өөрийнх нь эрхтэй холбоотой асуудал боловсруулахад нэлээн хөндөгддөг. Уг нь дэлхийн бусад улс орнууд хамгийн бэрхшээлтэй хэсэг нь бол энэ л дээ. Тухайн хүний өөрийнх нь амьдралыг, түүхийг нь өөрчлөх, бичиг баримтыг нь өөрчлөх, эд хөрөнгийнх нь байршлыг өөрчлөх ч гэдэг юм уу, тэрний чанарыг нь дордуулахгүйгээр өөрчлөхтэй холбоотой асуудал тухайн шүүхэд гэрчилснийхээ төлөө, нийгэмд хууль ёсыг, шударга ёсыг бэхжүүлснийхээ төлөө хувь хүн өөрийнхөө амьдралын хүсээгүй өөрчлөлтөд автдаг. Энүүгээрээ бол хүний эрх бол үнэхээр хөндөгддөг. Аль болох асуудлыг гэрчилснийхээ төлөө тухайн хүн хохирохгүй байх талаасаа эдийн засгийнхаа хувьд, эрх зүйн хувьд ч, бас нэр төрийн хувьд ч бол энэ хууль бол сайн бодолцож хийгдэх ёстой.

Хамгийн маргаантай байдаг улс орнуудад байдаг хэсэг бол энэ нүүрний төрхийг өөрчлөх тухай асуудал. Мэдээжийн хэрэг тухайн хүн зөвшөөрөхгүй бол нүүрний төрхийг өөрчлөх эрх хэнд нь ч байхгүй. Гэхдээ нүүрний төрхийг өөрчлөөгүйгээрээ бас тухайн хүний амь нас өөрөө маш том эрсдэлд бас ордог. Тийм. Энд бол тэр хүний зөвшөөрөл гэдэг зүйл бол хамгийн чухал л даа.

**3.Энхболд:** - Д.Лүндээжанцан гишүүн асууя.

**Д.Лүндээжанцан:** - Би товчхон ганц нэг асуулт асууя. Гарчихлаа. Түрүүний тэр тооцооны хувьд л би жаахан санаа зовоод байгаа юм. Тийм. Х.Тэмүүжин сайд аа, энэ яах вэ хуулиндаа бол байж байх ёстой байх. Нөгөө кино гэдэг шиг. Кино үзлээ гээд. Кинон дээр тэгсэн гэж ярилаа гээд шүүмжлээд байгаа юм.

Тэгэхээр хамгийн сүүлийнх нь нүүлгэн шилжүүлэх. Жишээ нь, зардал гарахаар юм байгаа юм л даа. Хүсэлт тавиад байвал. Одоо бол тийм юм байхгүй. Нүүлгэн шилжүүлэх, гадаад төрхийг өөрчлөх гээд ингээд. Ийм зүйлүүд байгаа юм. Гадаад төрхийг одоо Монголд өөрчилнө гэдэг бол бас тийм ч амар зүйл биш л дээ. Тийм.

Тэгэхээр яривал жишээ татахаар кино ярилаа гэх гээд байдаг юм. Тийм ээ. Алдартай кинонууд байна шүү дээ, гадаад төрхөө өөрчилсөн тухай алдартай кинонууд. Тэгэхээр энэ зардал мөнгөн дээр үргэлж тийм юм гарахгүй байх гэж найдаж байгаа юм. Хуулиндаа бол одоо энэ байдлыг хийж өгөхгүй бол нэг юм нь дутуу үлдэх гээд л ингээд оруулаад ирсэн юм шиг байгаа юм.

Тэгээд би энийг бол гол нь эдийн засгийн тооцоотой холбож асуух гэсэн юм. Тэгэхдээ яах вэ энэ хууль дотроо бол энэ нүүлгэн шилжүүлэх юм уу. Нүүлгэн шилжүүлсний дараа чинь орон байрны асуудал гээд гараад ирж байгаа юм. Тэгээд одоо гадаад төрхийг өөрчлөх нь бол харьцангуй гайгүй байх. Нөгөө тархай бутархай. Манайх бол өргөн уудам газар нутагтай нэг онцлог байгаа. Үүний хажуугаар хамгийн хэцүү юм бол энэ гэрч хохирогчийг хамгаалах асуудал дээр Монголын хүн ам дэндүү цөөхөн. Бие биенийгээ бүгдээрээ мэддэг. Хамаатан садантай уулзахаас аргагүй болдог. Ингээд хамгийн хэцүү юм бол тэр байна л даа.

Тэгэхээр энэтэй холбогдуулаад Х.Тэмүүжин сайд маш товчхон. Ер нь одоо энэ нүүлгэн шилжүүлэх юм уу, жилд одоо 2 хүнийг, 2 айлыг. За нэг хүний төрхийг өөрчлөх асуудал гарлаа гэж бодоход одоо тооцоо, эдийн засгийн иймэрхүү нарийн тооцоо хийж чадсан уу, чадаагүй юу? За яах вэ нэг ойр зуурын сэтгэл санааны хамгаалалт хийж өгөх, бичиг баримтыг нь солих энэ тэр гээд. Бичиг баримтыг солих бол одоо нэг их хамгаалалтад нэг их нөлөө үзүүлэх нь бага шүү дээ.

Тэгээд Монгол шиг жижигхэн газарт бол одоо хүн ам цөөтэй оронд бол гэрч хохирогчийг хамгаалах гол арга бол ердөө л энэ нөгөө миний түрүүчийн ярьсан арга болчихоод байгаа юм. Мэдээж хэрэг тухайн үед нь аюулгүй байдлыг нь хангана гээд айл болгонд цагдаагаар байнгын хамгаалалт гаргалтай биш. Нэг ийм хүндрэл бэрхшээлүүд бол яг амьдрал дээр, хуулиа хэрэгжээд эхлэхээр амьдрал дээр бол бас зовлон бэрхшээлүүд гарах юм шиг байна лээ. Энэ талын судалгаа тооцоо юу байна вэ гэсэн асуулт байна.

**3.Энхболд:** - Х.Тэмүүжин сайд хариулъя.

**Х.Тэмүүжин:** - Гэрч, хохирогчийг хамгаалах хууль гарч байгаатай холбоотой ерөнхий судалгаанууд, тооцоонууд гарсан. Гэхдээ энд бас нэг зарчим байдаг гэдгийг хэлэх ёстой байх. Ямар гэмт хэрэг дээр гэдэг нь их чухал. Гэрч, хохирогчийг хамгаалахын тулд. Үндсэндээ бол зохион байгуулалттай, улс дамнасан, маш их хэмжээний мөнгө, эрх ашиг хөндөгдөж байгаа тийм хэргийн гэрч хохирогчийн хамгаалалт авдаг юм билээ. Жишээ нь бол гэрч хохирогчид гарч байгаа зардал, нөгөө гэмт хэргийг нь шийдээд буцааж хурааж байгаа зардал хоёр энэ нь давах юм бол бараг энэ хэрэг нь энэ гэрчгүйгээр өөр

байдлаар нотолсон нь хамаагүй дээр гэж үздэг юм билээ.

Ямар тохиолдолд яг энэ их хэмжээний зардал гардаг, энэ гэрчийн хамгаалалтууд явдаг вэ гэхээр маш их хэмжээний мөнгө бүхий. Одоо хар тамхины наймаа гэхэд л маш их хэмжээний мөнгө байж байдаг өөрөө. Тэгэхээр энэ нь өөрөө нөгөө талаасаа энэ их мөнгөө алдахгүйн тулд цаана нь зохион байгуулалттай бүлэг хэнийг ч усгахад бэлэн байж байдаг. Тэгэхээр гэрчид гарч байгаа зардал тухайн гэмт хэргээс одоо нөхөж авч байгаа, ял эдлүүлж байгаа, торгож, алдсан мөнгөө олж авч байгаа тэр зардал хоёр бол бас харьцуулалттай байх ёстой. Энийг тооцож л бусад улс орнууд аль гэрчийг хамгаалах вэ, аль тохиолдолд энэ гэрчийн хамгаалалт хийхгүйгээр энэ хэргийг өөрийг нь өөр зүйл болгож хувиргах вэ гэдгээ бас шийддэг юм билээ. Бүх хэргийн гэрчийн тухай яриа ерөөсөө биш энэ.

Одоо бидний тооцоогоор шинээр байгуулагдаж байгаа мөрдөх албаны харъяаллын хэргүүд дээр илүүтэй яригдана. Энэ гэрч, хохирогчийг хамгаалах асуудал. Одоо жишээ нь дор хаяж МИАТ гэхэд л одоо нэлээн их хэмжээний 6.0 сая доллар болон цаана нь ингээд нэлээн их хэмжээний мөнгө яригдаж байна шүү дээ. Тэгэхээр энэний гэрчтэй холбоотой асуудал хөндөгдөхөөс өөр арга байхгүй. Яагаад гэвэл буцаагаад хууль ёсоор, журам ёсоороо ажиллаад энэ чинь өөрөө алдагдсан мөнгөө олж байгаа нь арван хэдэн тэрбум байхгүй юу. Энэ арван хэдэн тэрбумын хэрэгийг гэрчилж байгаа гэрчид нэг 500.0 саяыг гаргах бол энэ бол эрүүл асуудал шүү дээ.

**3.Энхболд:** - Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо үг хэлэх гишүүд байна уу? Р.Гончигдорж гишүүн үг хэлнэ. Ц.Оюунгэрэл гишүүнээр тасаллаа.

**Р.Гончигдорж:** - За баярлалаа. Хоёрхон зүйл хэлье гэсэн юм. Сүүлд сайд хариулахдаа бас хэллээ. Энэ гэрч, хохирогчийг хамгаалах асуудлын санаачлага нь гэр, хохирогчийн хүсэлт, эсвэл гэрч хохирогчийг хамгаалах шаардлагатай байна гэж үзсэн тэр шийдвэр. За хамгаалах шаардлагатай байна гэсэн тэр шийдвэр гэрч, хохирогчийн хүсэлттэй ер нь татгалзах эрхийг бас өөртөө багтааж ингэж явах тухай асуудлууд байгаа л даа. Энийг хууль дээрээ бас тодруулах хэмжээнд бол зарим заалтууд шаардлагатай юм шиг байгаа юм. Тэрийг бол хууль хэлэлцэх явцдаа болно гэж.

Өөр нэг асуудал нэлээн хөндөөгүй асуудал бол энэ зардал гэдэг асуудлыг яриад байгаа юм л даа. Монголын нөхцөл гээд. Уучлаарай одоо Ц.Нямдорж, Д.Лүндээжанцан хоёртойгоо л нэг л нөгөө. Та хоёр хоёулаа болохоор олонхи. Би энийг ганцаараа болохоор цөөнх болоод байгаа юм уу хаашаа юм. Тэгээд нэг юм ярьчих гээд байгаа юм. Ерөөсөө л өнөөдөр бид нар хүний эрх, эрх чөлөөг ханган баталгаажуулахад байх ёстой арга хэмжээ, төрөөс байх ёстой үйлчилгээ, энэ ямар хэмжээнд байх ёстой вэ гэдэг тэр стандартаа бий болговол. Өөрөөр хэлэх юм бол хуулиудаа батлаад. Тэр хуулийг хэрэгжүүлэх ёстой, түүнд шаардлагатай хөрөнгө бол заавал зарч байх ёстой нэг тийм шаардлагыг авмаар байгаа юм.

Бидний боломж юу байгаа билээ гэдгээр хүний эрхийг хязгаарлаж

болохгүй гэсэн ийм л агуулга. Хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж болохгүй. Хохирсон эрх, эрх чөлөөг алдагдуулж болохгүй. Мөн ял завшигчийг бий болгож болохгүй. Энэ зарчим дээрээ энэ хуулиуд нэгтгэгдэж хийгээд. Тэгээд тэрний дагуу гарах зардлын тооцоо байна. Гэхдээ гарах зардлын тооцоо бол харьцангуй тооцооны асуудал.

Нэг л зүйлийг би Их Хурлын гишүүд бүрэн ойлгож зөвшөөрөх гэж бодож байгаа юм. Зардлын асуудлыг нь бид нар үнэ цэнээр нь биш харин энэ хуулиудаар зохицуулахаас өөр аргагүй байгаа. Зохицуулах ёстой тэр хэмжээнүүдийг нь хүлээн зөвшөөрөх нь чухал байх. Тэрний дараа арга нь олдох байх гэж ингэж бодож байгаа юм.

Өөр нэг асуудал бол энэ гэмт хэргийн төрлөөр нь нөхцөл байдлын шалтгаанаар нь бол энэ гэрч хохирогчийг хамгаалах тухай асуудал үүснэ гэдгийг бас нэлээн нарийвчилсан байдлаар энд зааж өгөх, тодруулах тийм зүйлүүд бол хууль хэлэлцэх явцад шаардлагатай байх гэж бодож байгаа юм. Тэгэхгүй бол хуульд нэлээн түгээмэл байдалтай, эсвэл нэлээн үзэмжийн байдалтай болохоор зэрэг, түгээмэл байдалтай болохоор хүн болгон хамгаалуулах. Тийм ээ. Хүн болгон энд байгаа тэр туслалцаануудыг авахыг хүснэ. Нөгөө талаас энийг бид нар шаардлагатай гэж үзэж байгаа юм гэж нөгөө талд эрх мэдэл очихоороо зэрэг үнэхээр шаардлагатай байгааг шаардлагагүй гэх. Шаардлагагүй байгааг шаардлагатай гэх тийм харилцаа үүсэж болзошгүй. Энэ үүднээсээ хуулиараа яг ийм ийм гэмт хэргүүдэд болон ийм ийм нөхцөл байдал үүссэн үед гэдгийгээ бол нэлээн нарийвчилсан байдлаар зааж өгөх хэрэгтэй. Энэ ч гэсэн манай гишүүдийн зардал чирэгдэл гэдэг яриад байгаа зүйл дээрээ бас үнэхээр энэ хуулийг зорилго болж байгаа зүйлүүдийг хангахад чиглэсэн ийм бодлого болж болох байх аа гэж ингэж бодож байгаа юм. Тийм учраас хуулийг хэлэлцэх нь зүйтэй гэдэг дээр санал нэгтэй байна. Цаашдаа бол гишүүдийн саяны асуудлын байдлаар хэлээд байгаа саналуудыг бол тодруулж зохицуулах боломжтой гэж үзэж байна. За баярлалаа.

**3.Энхболд:** - Ц.Оюунгэрэл гишүүн үг хэлнэ.

**Ц.Оюунгэрэл:** - За би Хууль зүйн байнгын хороонд ордоггүй учраас энэ хэлэлцэх эсэхийг хэлэлцэж байх үед нь бас нэг саналаа хэлье гэж бодож байна л даа. Энэ хүний эрхийг жинхэнэ утгаар нь хамгаалъя гэвэл, энэ гэмт хэрэгтэй тэмцье гэвэл, шударга ёсыг тогтооё гэвэл ерөөсөө л гэрч, хохирогчийг хамгийн эхлээд хамгаалах шаардлагатай байдаг. Тэгээд ийм хуулийн төсөл орж ирж байгаад маш их баярлаж байна.

Би өөрөө хүний эрхийн ажилтны хувьд хүний наймааны хохирогч бөгөөд гэрчийг бас нэлээн олон жил хамгаалж байсан. Тэгээд энэ одоо зодуулсан, нүдүүлсэн, янз бүрийн байдлаар хохирсон хүмүүсийг хамгаалахад гардаг маш олон асуудлууд байдаг. Тэгээд тэрийг хамгаалж ажилладаг хүний эрхийн байгууллагууд, одоо хүчирхийлэлтэй тэмцэх байгууллагуудыг дэмжих талаар, тэд нартай хамтарч ажиллах талаар энэ хуульд их тодорхой ормоор байна гэдэг санал хэлмээр байна.

Нөгөө талаас авлигалын эсрэг одоо гэрч мэдүүлэг өгөх бол маш хэцүү байдаг. Тэгээд авлигалын эсрэг одоо хэрэг гэрчлээд өөрөө одоо тэр авлигыг нь биеэрээ зөөсөн учраас, гараараа зөөсөн учраас тэрийг одоо шүүхэд мэдүүлснийхээ төлөө өөрөө эргээд эрүүгийн хариуцлагад уначих гээд, ингээд сүүлдээ гэрчээ хамгаалал хүсэж хандаж байсан хүн одоо байдаг. 2008 оноос хойш. Тэр хүн маань хэлмэгдэж явж явж дөнгөж өнгөрсөн долоо хоногт л одоо нөхөн олговороо төрөөс гаргуулж авах 85.0 сая төгрөгийн нөхөн олговор төрөөс гаргуулж авахаар боллоо.

Өөрөөр хэлбэл одоо дөнгөж одоо энэ үед ирж байж тэр хүн бол 2008 оноос хойш нуугдаж, наана цаана хамгаалалт хайж явсаар байгаад 2013 он хүртэл 5 жил болоход амьдралаараа маш их хэмжээгээр хохирсны дараа тэр хүн үнэн мөн нь цагаадаж гарч, хохирлоо төрөөс гаргуулж авах ийм амьдралын дүр зураг харагдаж байгаа юм.

Тэгэхээр гэрчийг хамгаална гэдэг нь өөрөө зүгээр нэг хэргийг шийдтэл хамгаалахад л 5, 6 жил болж байгаа юм. За тэр юуны хувьд гэвэл, одоо тэр хүний наймааны хохирогчийг би яг ингээд 2009 оны үед ингээд хамгаалж байхад, 2008 оны үед хамгаалж байхад юу болж байсан бэ гэхээр цагдаа нар нь одоо хуулийн байгууллагынхан өөрөө тэр хүнийгээ гэмт хэрэгтэн гээд шууд сонин хэвлэлээр зарлаж эхлээд, нөгөө гэрчийгээ шууд эрүүгийн хэрэгт үүсгэж эхлээд л, биеэ үнэлэгч болгоод ингээд шууруулаад явчихаж байсан. Тэгэхээр энэ хамгаалдаг алба нь цагдаагаасаа тусдаа, мөрддөг газраасаа тусдаа байх нь ямар чухал ач холбогдолтой юм бэ гэдэг бол ёстой. Үнэхээр тэр хохирогч, гэрчийг хамгаалах явцад хүний эрхийн байгууллагын хүмүүс бол яг биеэрээ мэдэрдэг. Тэгээд энэ харин ингэж тус тусдаа, мөрдөх алба нь тусдаа, хамгаалда алба нь тусдаа, тэр оргоод явчихсан хүмүүсээ барьдаг алба нь тусдаа гэж ингэж энэ цагдаагийн энэ хууль хяналтын албууд ингэж тусдаа гарч байгаа нь эргээд энэ хүний эрхийг батгаажуулах маш сайн баталгаа болох юм. Ийм учраас энэ хуулийг бол зайлшгүй батлах шаардлагатай.

Харин тэгээд тэр дээр Х.Тэмүүжин сайдын саяны асуултад хариулж байгаа дээр нэг л зүйл дээр жижигхэн эмзэглэлээ. Одоо жишээлбэл их мөнгөтэй холбоотой, их чухал асуудал бол төр бол хамгаална. За тэгээд хохирол зардал нь багахан шиг бол бараг тэр гэрч, хохирогч нь зөндөө хаягдаж магадгүй юм шиг юм ярьчихлаа. За тэгж хандах юм бол маш хүнд болно. Яагаад гэх юм бол ихэнхи одо хүний наймааны хохирогчид, ихэнхи нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид бол өөрсдөө бол ямар ч төрд одоо мөнгө төгрөг авчирч өгөх ийм найдваргүй. Тэгэхдээ зүгээр өөрсдийнх нь амь нас аюулд орчихсон ийм хохирогчид байдаг. Тийм учраас энэ хүмүүсээ үнэхээр их мөнгө гаргаж төр хамгаалж чаддаггүй юм бол тэр бага хэмжээний үр ашигтай мөнгөөр олууланг нь хамгаалдаг тэр хамгаалах төвүүдийг маш сайн дэмжиж өгөх талаар энэ бас давхар оруулмаар санагдаж байна. Тийм учраас төсөв хөрөнгө талаасаа энийг шийдэхдээ хамгаалах байруудыг ажиллуулдаг төрийн бус байгууллагуудыг дэмжих асуудал дээр үнэхээр анхаармаар байна.

Одоо манай Монголд гэр бүлийн хүчирхийллээс хүнийг хамгаалдаг. Яг өөрийн чинь ална шудна шүү гээд ингээд заналхийлээд байгаа хүнээс хүнийг

хамгаалдаг цорын ганц одоо нэг жижигхэн төрийн бус байгууллага байна. Тэгээд тэр байгууллага бол дандаа гадаад дотоодын мөнгөөр иргэдийг маань хамгаалж байгаа. Төр өөрөө тэр дээр нэг их мөнгө гаргаж өгдөг ч үгүй, тэрийгээ тоодог ч үгүй нэг ийм байдалд байгаад байгаа. Тийм учраас энэ хамгаалах байруудыг ажиллуулж байгаа сайн дурынхан, хамгаалах байгууллагыг ажиллуулж байгаа хүний эрхийн байгууллагуудтай энэ хууль яаж холбогдох вэ гэдэг дээр энэ Хууль зүйн байнгын хорооны гишүүд бас цаашдаа энэ хуулиа хэлэлцэхдээ илүү сайн анхаарч яваарай гэж хүсмээр байна. Баярлалаа.

**3.Энхболд:** - За гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураах ажил явагдана. Байнгын хорооны саналаар Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн төсөл, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт.

66 гишүүн оролцож, 44 гишүүн зөвшөөрч, 66.7 хувийн саналаар хуулийн төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ. Хууль зүйн байнгын хороонд шилжүүлээ.

***Найм. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн төсөл***  
(хэлэлцэх эсэх)

Дараагийн асуудал. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг эхэлье. Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүйн сайн Х.Тэмүүжин танилцуулна.

**Х.Тэмүүжин:** - Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт Монгол Улсын иргэн нь Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй.

55 дугаар зүйлийн 55.2-т шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхээ эдлэхэд нь хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.

19 дүгээр зүйлийн 19.1-д төрөөс хүний эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад утгаар бүрдүүлэх үүрэгтэй гэж тус тус заасан.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн Д-д зааснаар өөрийгөө биечлэн өмгөөлөх буюу өөрийн санал гарсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, өмгөөлөгчийн хөлсийг төлөх хүрэлцээтэй мөнгө хөрөнгө байхгүй бол үнэ төлбөргүй үйлчлүүлэх баталгаагаар хангагдах эрхтэй. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн

2-т энэ хуулийн 45.1.11-д заасан төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх өмгөөллийн үйлчилгээний зардлыг төр хариуцна гэж заажээ.

Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоолоор баталсан төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2 дахь зорилтод төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулсан хууль эрх зүйн актын төсөл боловсруулж батлуулахаар тус тус заасан энэхүү хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэс болж байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хууль зүйн салбарын шинэтгэлийн цогц бодлогын хүрээнд Засгийн газрын зүгээс өргөн мэдүүлсэн Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээс хүсье.

**3.Энхболд:** - Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсьё. Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Түвдэндорж танилцуулна.

**Ш.Түвдэндорж:** - Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай, Цагдаагийн албаны тухай, Маршалын албаны тухай, Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн төслүүдийг санаачлан боловсруулж 2013 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Үүнээс төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2013 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийн талаар уг хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Ж.Батзандан нараас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талуудын зөвхөн нэг талыг онцгойлон авч үзсэн байгаа нь Үндсэн хуулийн заалттай хэрхэн нийцэж байгаа тухай, мөн төлбөрийн чадваргүй яллагдагчид туслалцаа үзүүлэх улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаа нь Өмгөөллийн тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуультайгаа нийцэж байгаа эсэх. Мөн Шүүхийн тухай багц хууль 2013 оны 04 дүгээр сарын 15-наас хэрэгжиж эхэлсэнтэй уялдуулж дагалдах бусад хуулийг өргөн барих, эдгээр хуулийн хэрэгжилт хир зэрэг байгаа болон иргэдэд хүндрэл чирэгдэл учруулахгүй байх талаас нь анхаарах зэрэг саналуудыг тус тус гаргаж байсан болно.

Ийнхүү Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи нь



Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн тухай туслалцааны тухай хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулан хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**З.Энхболд:** - Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлтээс асуулттай гишүүд нэрээ өгнө үү.

Д.Лүндээжанцан гишүүний кнопыг засаж өгөхгүй бол. Хэд хэдэн удаа дарагдаж байж орж ирдэг. Д.Лүндээжанцан гишүүнээр асуулт тасаллаа. Ж.Банзандан гишүүн асууя.

**Ж.Батзандан:** - За тэгэхээр Хууль зүйн яамнаас орж ирж байгаа хуулийн төслүүдийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Ялангуяа гэрч, хохирогчийг хамгаалах асуудал, Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль цаг үеэ олсон хууль гэж үзэж байгаа.

Тэгэхээр зарчмын хувьд, агуулгын хувьд бол боломжийн хуулийн төслүүд орж ирж байгаа гэдгийг хэлмээр байна. Гэхдээ төлбөрийн чадваргүй яллагдагч гэж зөвхөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад энэ хуулийг бас хамруулахаар оруулж ирж байгаа.

Нэг зүйлийг. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх явцад төлбөрийн чадваргүй оролцогчдын асуудлыг бас яаж шийдвэрлэх тухай тодорхой концепци бас байна уу? Энэ хуулиараа нэгтгээд зохицуулаад явах бололцоо боломж байдаггүй юм уу гэж бас Хууль зүйн сайдаас асуухыг хүсэж байна.

**З.Энхболд:** - Х.Тэмүүжин сайд хариулъя.

**Х.Тэмүүжин:** - Үндсэндээ бол шүүхэд 3 төрлийн 4 төрлийн маргаан бол явдаг. Иргэний, захиргааны, эрүүгийн, Үндсэн хуулийн гээд. Энэ 4 төрлийн маргаан бол нотлох зарчим, нотолж байгаа субъектээрээ бол их ялгаатай. Иргэний маргаан шийдвэрлэхэд маргаанд оролцогч талууд өөрсдөө нотлох үүрэгтэй. Захиргааны маргаанд бол шүүхийн байцаалтаар асуудлыг нотолдог. Харин эрүүгийн маргаанд бол тухайн гэмт хэргийг прокурор гээд төрийн нэрийн өмнөөс тусгай чиг үүрэг бүхий албан хаагч нийтийн эрх ашгийг төлөөлөн нотолдог.

Нөгөөтэйгүүр хууль сахиулах үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагууд тухайн гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, хариуцлага тооцох бүх

үйл ажиллагааг явуулж байдаг. Тийм учраас эрүүгийн маргаан, гэмт хэрэгтэй холбоотой маргаан бол нэлээн хүнд, төвөгтэй бөгөөд бас хатуу процессыг туулдаг. Нөгөөтэйгүүр энэ шүүхээс иргэнд ял оноох байдлаар эрх чөлөөг нь хязгаарладаг. Тийм учраас хүнд бөгөөд хатуу шүүн таслах үйл ажиллагаанд иргэд оролцож байхдаа төлбөрийн чадваргүй байдлаасаа болоод шударга шүүхээр шүүлгэх шүүх хуулийн өмнө тэгш байх эрхээ бас алдаж болзошгүй байдаг учраас олон улсын практикаар бол төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхдээ зөвхөн гэмт хэрэгтэй холбоотой, гэмт хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаатай холбоотой асуудлаар л хязгаарлаж өгдөг. Яагаад гэвэл татвар төлөгчдийн мөнгийг өөр зүйлд төлөх эрх бол төр бас байхгүй.

Тэгээд олон улсын практик, олон улсын НҮБ-аас гаргасан болон олон улсын баримт бичгүүд дээр зөвхөн эрүүгийн хэрэгт шүүн таслах үйл ажиллагаанд оролцож буй төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай асуудлыг л хөнддөг. Тэгээд яг бид бол энэ концепциэ барьж энэ хуулийг бичсэн байгаа.

**3.Энхболд:** - Д.Лүндээжанцан гишүүн асууя.

**Д.Лүндээжанцан:** - Хууль зүйн байнгын хороон дээр хэлэлцэхэд бол нэг л асуудал нэг бид концепци гэдэг юм уу, үзэл баримтлалын шийдэл гараагүй нэг юм байгаад байгаа юм л даа. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль гэж.

Тэгэхээр сэжигтэн, хохирогч яах вэ гэдэг асуудал гараад байна. Тэгэхээр Х.Тэмүүжин сайд бол дараа орж ирэх Мөрдөн шалгах тухай хуульд гэмт хэргийг мөрдөн шалгах тухай хуульд бол сэжигтэн гэдэг юм байхгүй болно. Шүүгдэгч гэдэг юм байхгүй болно. Зөвхөн яллагдагч гэдэг зүйл бий болно гээд ингээд байна. Тэгэхээр тэр хууль одоо төрөөгүй хүүхэд. Одоо төрөх гээд дуншаад байгаа гээд байгаа юм л даа. Одоо өргөн баригдана гээд. Яг л нөгөө хууль зүйн үйл ажиллагаа нь, хууль сахиулах үйл ажиллагааны хууль, хууль сахиулагчийн эрх зүйн байдлын хуультайгаа агаар нэг юм. Тэгсэн мөртлөө яг тэр хуулиа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч гурвыг нийлүүлээд яллагдагч болно гэдэг асуудлыг Их Хурал бол одоо хараахан хүлээж авч тийм үү, шийдвэрлээгүй байгаа байхгүй юу. Тэгтэл түүнийг урьдчилаад энэ гурав байхгүй болоод нэг болох юм учраас яллагдагчид л зөвхөн хууль зүйн туслалцаа үзүүлэх гэдэг асуудал орж ирж байгаа юм гэхээр ингээд зөрчил үүсээд болохгүй байгаа юм.

Би бол үг хэлэхгүй. Энийг бол дэмжиж байгаа. Ер нь бол энэ хуулиудыг зарчмын хувьд дэмжилгүй яах вэ. Гэтэл энийг нэг асуултаараа бас үндэслэлийг нь дахиад нэг сонсох ёстой гэж бодоод байгаа. За хохирогч нь бол Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиараа яваад өгөх юм билээ. За тэр хохирогч бол хамаа алга. Гэхдээ бүх хэргийн хохирогч дээр төлбөрийн чадваргүй хохирогч дээр яригдах уу, гэр хохирогчийг хамгаалах хууль чинь заавал одоо сонгон хэрэглэнэ гээд байгаа шүү дээ. Төлбөрийн чадваргүй хохирогч гэж тэр Гэрч, хохирогчийг хамгаалах хуулиндаа оруулаад өгөх хэрэгтэй юм шиг байна гэж би ойлгосон. Тэгээд тэрүүгээрээ зохицуулагдчих байх.

За яллагдагчид эрх зүйн туслалцаа үзүүлэнгээ одоо сэжигтэн, шүүгдэгч, яллагдагч гурвыг одоо нэг болгож оруулж ирж байгаа гээд тэр хууль нь бол одоо орж ирж Их Хурлаар хүлээн зөвшөөрөгдөж дэмжигдээгүй байдаг. Ийм асуудал байгаа учраас энэ дээр бол одоо эргэлзээ, тээнгэлзээ бий болчихоод байна. Энийгээ нэг тайлбарлаж өгнө үү гэсэн ийм асуулт байна.

За үг хэлэхгүй. Хэлэлцэх эсэхийг нь дэмжиж байгаа.

**3.Энхболд:** - Х.Тэмүүжин сайд хариульъя.

**Х.Тэмүүжин:** - За хохирогчтой холбоотой асуудал болохоор төлбөрийн чадвартай байна уу, чадваргүй байна, яг эрүүгийн хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргийг нь прокурорт оноож байгаа юм. Тийм учраас хуучин бол хохирогчид нийтийн эрх ашгийг төлөөлөөд гэмт буруутай этгээдийг яллаад явж байгаа тэр хуульчид хохирогчийн асуудалд тийм хамаагүй юм шиг. Тэгээд давхар хохирогч нь өмгөөлөгч аваад. Хохирсон дээрээ нэмэлт зардал гаргаад. Шүүн таслах үйл ажиллагаанд бас нэлээн хүндрэлтэй төвөг бэрхшээлтэй байдаг байсан юм.

Бусад улс орнуудын туршлагыг харсан чинь ерөөсөө прокурор нь хохирогчдоо хууль зүйн туслалцаа үзүүлдэг юм билээ. Хүч хэрэглэсэн буюу хувь хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгтэй байх юм бол хохирол барагдуулах сангаас нь урьдчилаад хохирлыг нь төлж өгөөд тэгээд нөгөө буруутай этгээдээсээ төр нь буцаагаад тэр гарсан зардлаа буцааж авдаг тийм механизм байдаг юм билээ.

Тэгэхээр бид бол энэ зохицуулалтыг хийгээд хохирогчид хууль зүйн туслалцаатай холбоотой нэмэлт зардал гардаг байдлуудыг эрүүгийн хэрэгт өөрчилж байгаа. Гэмт хэргээс илүү би ийм хохирол учирсан гээд иргэний журмаар нэхэмжлэх бол тэр бол тусдаа асуудал гэж орхисон юм.

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч одоогоор манайд ийм 3 ойлголт байгаа юм. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн процессын явцад. Эндээс бусад улс орнуудын туршлагыг хараад нөгөө эрх зүйт ёс, хүний эрхийг эрхэмлэх гээд олон зарчмуудынхаа хүрээнд харахаар хууль зүйн үр дагавартай сэжигтэн гэдэг ойлголт бол бусад улсад байхгүй байгаа юм. Хууль сахиулах байгууллага, мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж байгаад хэн нэгэн иргэнийг сэжиглэж болно. Таамаг дэвшүүлж болно. Гэхдээ тэр хүний эрх чөлөөнд халдахгүйгээр тэр хүнийг ямар нэгэн эрх зүйн өөр үр дагавартай болгохгүйгээр бусад баримтуудаар тэр хүнээ энэ хэрэгт холбоотой юу гэдгийг эхний түүрэн хийхийг шаардаж байгаа юм.

Манайхан бол сэжигтэн гэж тооцонгуутаа л нэн түрүүн тэр хүнийг барьж хорьж хүчирхийлж эрх чөлөөг нь хязгаарлах гэж оролдоод байдаг. Одоо хуулийн байгууллагад сэжигтэн гэдэг ойлголт байхгүй. Та сэжигтэн гэдэг нэрийн доор иргэний эрх рүү халдахгүй гэдэг тэр шинэ эрх зүйн орчныг бий болгож өгч байгаа юм.

Хоёрт нь, шүүгдэгч гэдэг ойлголт бол байхгүй болж байгаа. Яагаад гэвэл хэн нэгнийг шүүхээр гэм буруутайг тогтоохоос нааш хэнийг ч гэм буруутай гэж үзэхгүй гэдэг Үндсэн хуулийн зарчим байсаар атал эрүүгийн шүүх дээр хүн маргаанаа таслуулах гээд ирж байхад бүр шүүгдэгч гээд нэр заагаад өгчихөж байгаа юм шүүхийн зүгээс.

Тэгээд энэ бол үндсэндээ шүүх хуулийн өмнө эрх тэгш байх, нөгөө саяны хэлсэн шүүхээр нотлогдоогүй бол гэмт буруутайд тооцогдохгүй гэдэг зарчмыг эвдсэн тийм нэр томъёо өгдөг. Хууль зүйн үр дагавартай нэр хоч, хаяг өгдөг. Тэгээд эрх зүйн байдлыг нь дордуулдаг энэ байдлыг бол одоо бид бол процессын хуулиасаа халах ёстой гэж үзсэн юм. Тэгээд ганцхан яллагдагч энэ ойлголт байгаа. Энэ нь бол тантай холбоотойгоор таныг гэмт хэрэгт холбогдуулан процесс эхэлж байна шүү гэдгийг прокурорын яллах дүгнэлт. Одоо бидний тэгж хэвшиж ярьдаг прокурорын тэр дүгнэлттэй холбоотой хэсгийг гаргаж ирж байгаа юм. Хүнийг яллагдагчаар татсан хойно л энэ хүний цагдаж хорих уу, эсвэл энэ хүнтэй холбоотой эрх зүйн хязгаарлалт хийх үү, өмч хөрөнгийг нь битүүмжлэх үү гэдэг яриа албан ёсоор гардаг болно.

Энэ прокурорын яллаж байгаа, энэ хүнийг буруутгаж байгаа энэ үйл явц бол зөвхөн прокурор сугандаа нэг цаас барьж ороод шүүгч рүү ороод бичүүлдэг биш ээ. Энэ бол өмгөөлөгчийг нь оролцуулаад, прокурор оролцуулаад тэр шүүхийн өмнөх шатны одоо шүүх жижигхэн хуралдаануудаа хийдэг. Шүүгч алхаараа тогшиж шийдвэрлэдээг тийм процесс болж хувирна гэдэг ийм хуулийн концепци боловсруулагдаж байгаа. Тийм учраас бид бол нэгэнт энэ өөрөө Үндсэн хуультай нийцэж байгаа учраас. Өмнөх процесс бол Үндсэн хууль зөрчөөд байдаг байсан юм байна. Энэ үүднээсээ шүүгдэгч, сэжигтэн гэдэг хоёр ойлголтыг хоёуланг гаргачихъя. Хүний эрх рүү халдаж хуулийн процесс явдаг юм бол яллагдагч энэ нэртэй холбоотой байгаа учраас яллагдагч, төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх гээд хамгийн оновчтой нэрлэхээр тэр процесст иргэн төлбөрийн чадваргүй байгаа байдлаасаа болоод процессын.../минут дуусав/

**3.Энхболд:** - Д.Лүндээжанцан гишүүн тодруулъя.

**Д.Лүндээжанцан:** - Тэгэхээр манай гишүүд бол одоо энэ хуулиуд бол нэлээн явдалтай хуулиуд л даа. Бас хүний эрх, эрх чөлөө рүү, түрүүн эрх, эрх чөлөө ярилаа. Хүний эрх чөлөө рүү шууд халдаж байгаа хүний амь бие, эрүүл мэнд, нэр алдар, төрийн аюулгүй байдал, бүх л нийгмийн харилцааг хамгаалахад чиглэгдсэн, халдсан гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хариуцлага хүлээлгэхтэй холбоотой маш том харилцаанууд одоо ингээд зохицуулагдахаар орж ирэх гэж байгаа юм шиг байна.

Гээд ингэхээр шүүгдэгч гэдэг чинь шүүгдэж байгаа хүнийг хэлж байгаа байхгүй юу. Шүүгдэж байгаа хүн ч бараг яллагдагч. Сэжигтэн гэхээр гүйцэтгэх ажлын шугамаар сэжиглэгдэж байгаагаас гадна өмнө материалаар хянаад тэгээд гүйцэтгэх ажил явуулаад сэжигтэнээр татахаар харин хүний эрх хохирох гээд ингээд өмгөөлөгч авч болохгүй болчихоод байна шүү дээ. Ийм нарийн зүйлүүд бас цаанаа байна.

**3.Энхболд:** - Х.Тэмүүжин сайд хариулъя.

**Х.Тэмүүжин:** - За хуулийн байгууллага, тэр дундаа мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд бол ямар ч тодорхой хэргийг илрүүлэх зорилготой ямар ч сэжиг таамаг дэвшүүлж болно. Гэхдээ шүүхийн систем бол бодитой баримт дээр л хүний эрхийг хязгаарлах тухай ярих болохоос биш хэн нэгний толгойд төсөөллөөр үүссэн сэжиг таамаар хүний эрхийг хязгаарлаж болохгүй. Энэ сэжигтэн гэдэг энэ ойлголт бол социалист ойлголт байсан. Бусад улс оронд сэжигтэн гэдэг эрх зүйн үр дагавартай ойлголт ерөөсөө байхгүй.

Тэгэхээр бид нэгэнт л энэ шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангах, иргэнийг хууль бусаар мөрдөн хавчдаггүй байх тэр баталгааг бүрдүүлэхийн тулд энэ социалист зарим нэг ойлголтоосоо салахаас өөр аргагүй. Энэ хуулийн байгууллага сэжиг таамаг дэвшүүлэх эрхгүй гэсэн үг ерөөсөө биш. Харин хуулийн байгууллага илүү хариуцлагатайгаар ажил гэдэг зарчим руу шилжиж байгаа юм. Ажлаа хий гэдэг зарчим руу.

**3.Энхболд:** - Х.Тэмүүжин сайд гүйцээгээд хариулчих.

**Х.Тэмүүжин:** - Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах гэдэг бол бас дахиад үндсэндээ бол социалист эрх зүйн үед эрүүгийн байцаан шийтгэх хуульд хэрэглэдэг байсан ойлголт юм.

2002 оны эрх зүйн шинэтгэлээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт гэдэг хоёр ойлголт чинь больсон шүү дээ. Харин манай цагдаагийн байгууллагын зохион байгуулалт дотор хэрэг бүртгэх байгууллага, мөрдөн байцаах байгууллага, эрүүгийн цагдаа гээд нөгөө социалист ойлголтоороо бол ингээд зохион байгуулалт нь яваад байгаа юм.

Харин бид нар хөнгөн хэрэг шийдвэрлэх тусгай журам, хялбаршуулсан журмаар. Харин тодорхой төвөг бэрхшээлтэй хэргүүдийг гүйцэд процессоор шийдэхтэй холбоотой процессын зохицуулалтыг 2002 онд хийчихсэн. Гэхдээ нэр томъёогоор өөрчлөөгүй учраас жаахан зовлон байгаа. Бусад улс оронд бол хойшлуулшгүй ажиллагаа гэж байдаг болохоос хэрэг бүртгэлт гэдэг ойлголт байдаггүй. Харин мөрдөн шалгаагүй үйл ажиллагааг эхлүүлэх гэдэг ойлголт байгаа. Тэгэхдээ иймэрхүү байдлаар бид бол нэлээн олон ойлголтыг шинэчлэх тийм цаг үе дээр бас ирсэн. Агуулгын хувьд бол 2002 онд шинэчилсэн. Нэр томъёоны хувьд бол энэ нэр томъёонууд байгууллагынхаа зохион байгуулалтаар одоо хүртэл байгаад байгаа учраас бидэнд бас ийм төөрөлдөл байгаа шүү гэдгийг хэлье.

**3.Энхболд:** - За гишүүд асуулт асууж дууслаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй юу? Д.Лүндээжанцан гишүүн үг хэлэх үү. Хэлэхгүй гэл үү. Үг хэлэх гишүүн алга байна.

Одоо хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлаар санал хураая. Байнгын

хорооны саналаар Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт.

66 гишүүн оролцож, 45 гишүүн зөвшөөрч, 68.2 хувийн саналаар хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

***Ес. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл (хэлэлцэх эсэх)***

Дараагийн асуудал Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг эхэлье. Хууль санаачлагчийн илтгэлийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр танилцуулна.

**Л.Гантөмөр:** - Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Олон мянган жилийн түүхтэй Монгол угсаатны өлгий нутаг, тусгаар тогтносон Монгол Улс бол Монгол судлалын гал голомт юм. Монгол судлал нь хэл, соёл, түүхийн цогц судалгаа байдаг.

Монгол судлалын олон салбар ухааныг тэгш хөгжүүлэх нь шинжлэх ухааны ач холбогдолтой төдийгүй Монгол Улсын гадаад нэр хүнд, тусгаар тогтнолын баталгаатай шууд холбоотой.

Монгол судлал 100 гаруй жилийн өмнө Өрнө дахинд үүсэж дэлхийн 20 гаруй орны 70 орчим эрдэм шинжилгээний байгууллагыг түшиглэн хөгжиж ирсэн боловч дэлхийн улс төр, нийгмийн өөрчлөлт, эдийн засгийн хямралаас шалтгаалан сүүлийн 20 гаруй жилд Америк, Герман, Англи зэрэг орны Монгол судлалын зарим төв хаагдаж үйл ажиллагаа нь хумигдаж байна. Иймд дотоод гадаадын Монгол судлалын үйл ажиллагааг хөрөнгө санхүүгээр дэмжиж эрдэм шинжилгээний ажлыг идэвхжүүлэх, Монгол судлаачдын шинэ үеийг бэлтгэх шаардлага тулгарч байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс Монгол судлалыг хөгжүүлэх тухай 2002 оны 10 дугаар зөвлөмжид даяаршлын нөхцөлд Монгол соёл, иргэншлийн аюулгүй байдлыг хангах, Монгол судлалыг хөгжүүлэх, идэвхжүүлэхэд чиглэсэн бодлого үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхийг 2006 оны 06\05 дугаар зөвлөмжид Монгол судлалыг төрийн бодлогоор хөгжүүлэхийг Улсын Их Хурлаас 2010 онд баталсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монголын түүх, хэл, соёл, шашин, зан заншлыг хамгаалах, хөгжүүлэх, судлах ажлыг төр ивээлдээ авахыг тус тус заасан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2012 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 14 дүгээр зарлигтаа их түүх үндэсний соёлын өв сангаа өргөн хүрээнд судлах, нээн илрүүлэх, баталгаажуулах, судалгааны эргэлтэд оруулах энэхүү ажил гадаад

орны эрдэмтдийг татан оролцуулах, тэдэнтэй нягт хамтран ажиллах, Монгол Улсад болон гадаад оронд Монгол судлалыг хөхиүлэн дэмжих, Монгол судлалыг хөрөнгө санхүүгийн хувьд ивээн тэтгэх замаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг идэвхжүүлэх, залуу судлаачдыг урамшуулах, тэдний залгамж үеийг бэлтгэх, чадавхжуулах, Монгол судлалын үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэлхий дахинд сурталчлах зорилгоор Монгол судлалын дэмжих сан байгуулахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосон байна.

Дээрх бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол судлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлснээр 2012 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 56 дугаар тогтоолоор батлан үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Монгол судлалыг дэмжих сан байгуулах тухай 2012 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 14 дүгээр зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуультай уялдуулан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн үзэл баримтлал, зохицуулах харилцааны хүрээнд боловсруулсан болно.

Монгол судлалыг дэмжих сангийн хөрөнгийн дийлэнх хувь нь улсын төсөв байх бөгөөд тусгай сангийн үйл ажиллагаанаас олсон орлого, дотоод гадаадын байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн хөтөлбөр, төслийн хөрөнгөөс бүрдэх юм.

Сангийн хөрөнгийг Монгол судлаачдын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, дэмжих, судлаачдыг бэлтгэх, Монгол Улсаа сурталчлах, дэлхий нийтэд таниулах зорилгоор олон улсын хурал, симпозиум зохион байгуулах, гадаад дахь Монгол судлалын төв, тэнхимийн үйл ажиллагааг сэргээх, шаардлагатай бол шинээр байгуулах зэрэг үйл ажиллагаанд зарцуулах юм.

Ингэснээр үндэсний хэл, соёл, түүх, зан заншлаа хадгалан үлдэж дэлхийн Монгол судлалын төв Монгол улс байх зорилтыг хэрэгжүүлэх юм. Монгол судлалыг дэмжих сан байгуулах тухай хуулийн төслийг эрдэмтдийн судалгааны үндсэн дээр боловсруулж Монгол судлалын үндэсний зөвлөл Боловсрол, шинжлэх ухааны сайдын зөвлөл Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжиж Их Хуралд өргөн барилаа.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

**З.Энхболд:** - Хуулийн төслийн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсьё. Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Дэмбэрэл гишүүн танилцуулна. Д.Дэмбэрэл гишүүнийг индэрт урьж байна.

**Д.Дэмбэрэл:** - Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Засгийн газрын тусгай сангийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2013 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Хуулийн төслийг хэлэлцэх эсэх тухай асуудлыг Төсвийн байнгын хороо 2013 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Засгийн газраас Монгол судлалыг дэмжих сан байгуулж, уг нь сан нь эх түүх, үндэсний соёлын өв санг өргөн хүрээнд судлах, нээн илрүүлэх, баталгаажуулах, энэхүү ажилд гадаад орны эрдэмтдийг татан оролцуулах, тэдэнтэй нягт хамтран ажиллах, Монгол Улсад болон гадаад оронд Монгол судлалыг дэмжих, хөрөнгө санхүүгийн хувьд ивээн тэтгэх замаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг идэвхжүүлэх, залуу судлаачдыг урамшуулах, чадваржуулах, Монгол судлалын үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэлхий дахинд сурталчлах зорилготой гэж үзэж хуулийн төслийг боловсруулжээ.

Төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт Монгол судлалын тусгай сан байгуулж ажиллахыг дэмжиж, сангийн зорилтыг тодорхой болгох, Монгол судлалын төвийг ажиллаж байгаа гадаад, дотоодын эрдэмтдийг дэмжих, Монголын нэртэй эрдэмтдээр дамжуулан монголоо сурталчлах, Түрк зэрэг бусад орны түүх соёлоо сурталчилж байгаа туршлагыг судлах, Монгол судлалын төв нь Монголд байгаа болохыг байнга баталгаажуулж байх, Монгол судалгааны чиглэлээр хөрөнгө зарцуулах шаардлагатай. Улсын Их Хурлын гишүүн Д.Дэмбэрэл язгуур угсаа нь Монгол гэдгээ дэлхий дахинд таниулахад хөрөнгө зарах нь зүйтэй. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээг хэлэлцүүлгийн шатанд тодорхой болгох, Монгол судлалын шилдэг бүтээлүүдийг шалгаруулах, урамшуулах, дэмжихэд анхаарах, бүтээлч ажил болгох. Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн хөгжлийн шинэ үедээ ирж байгаа өнөө үед улсынхаа сурталчилгааны асуудлыг анхаарах нь зөв бөгөөд сурталчилгааны зорилгоор хөрөнгө гаргах, аялал жуулчлалын чиглэлээр тусгай сан байгуулах асуудлыг Засгийн газар анхаарах нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан болно.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи нь үзсэн билээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**3.Энхболд:** - Д.Дэмбэрэл гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудлаар ажлын хэсэг чуулганы танхимд ирсэн байна. Ө.Сүхбаатар Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухааны хэлтсийн дарга, Д.Төмөртоого Олон улсын Монгол судлалын холбооны Ерөнхийлөгч, Ц.Өнөрбаян Монгол судлалын сургуулийн захирал. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулттай гишүүд байна уу? Болсон уу? Л.Энх-Амгалан гишүүнээрээ асуулт тасаллаа. С.Дэмбэрэл



гишүүнээр асуулт тасаллаа.

Ж.Энхбаяр гишүүн асууя.

**Ж.Энхбаяр:** - Монгол судлалыг дэмжээд сан байгуулж байгаа юм байна гэж ойлголоо. Л.Гантөмөр сайд аа, Монгол судлалыг та нэг шинжлэх ухааны үүднээс нь тодорхойлооч.

Энд нэлээн олон дотоод ганцхан асуудлууд л их байх шиг анзаарагдаад байх юм. Энэ төслийн миний ойлгож байгаагаар Монгол судлал гэдэг бол Германд байгаа Монголыг судалж байгаа сургууль, Америкт байгаа Монголыг судалж байгаа сургууль, Хятадад байгаа Монголыг судалж байгаа сургууль, шинжлэх ухааны байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих зорилготой байх ёстой гэж ойлгогдоод байдаг. Эндээс харахад дотоодод нэлээн ном зохиол, бүтээл гаргаад явах чиглэл рүү нэлээн байна. Ач холбогдлыг нь та бүр ялгаад өгөөч.

Тэгээд ер нь Монгол судлал гэдгийг юу гэж ойлгож байгаа гэдгээ та яг тодорхойлоод өгөөч. Монгол судлал гэж юу вэ? Монгол судлал гэдэг шинжлэх ухааныг та нэг томъёолдоо. Ийм учиртай юм аа гээд. Тэндээс л дараагийн логик гарч ирэх гээд байдаг.

**З.Энхболд:** - Л.Гантөмөр гишүүн хариулъя. Картаа аваад өөр суудал дээр суучих. Наадах чинь ажиллахгүй болчихлоо гэж байна шүү дээ.

**Л.Гантөмөр:** - Байна уу. За байна. За баярлалаа. Ж.Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Ерөнхий Монгол судлалын тухай ойлголт бол ерөнхий ойлголт бол танд байгаа байх аа гэж бодож байна. Монголынхоо хэлийг судална, Монголынхоо түүхийг судална, Монгол соёлоо судална. Та өөрөө ч судлах шаардлага бол байгаа.

Ер нь Монголчууд, аливаа улс үндэстэн бол сэргэн мандалтынхаа үед өөрийнхөө соёл, түүх, зан заншил, ахуй энийгээ судалж, олон улсад хүргэдэг л дээ. Тэгээд таны тавьж байгаа асуулт бол зөв өө. Ер нь Монгол судлалыг хөгжүүлэх гол үндэслэл нь бол одоо энэ сан байгуулаад Монгол судлалаа бид нар төрийнхөө ивээлд авч байгаа гол үндэслэл нь Монголыг судалдаг байсан гадаад ертөнц өөрчлөгдсөн байна. Нэг үгээр хэлбэл хуучин социалист орнууд нь судалдаг, нөгөө талдаа байгаа капиталист нийгэм нь судалдаг байсан бол одоо тэр ач холбогдол нь алдагдаад үндсэндээ 70, 80 гаруй судалгааны байгууллагууд байснаас нэг нэгээрээ татан буугдаад байгаа байхгүй юу.

Тийм учраас бид нар энэ сангийн зарцуулалт дотор та хэрвээ унших юм бол маш тодорхой байж байгаа. Гадаад Монгол судлалын үйл ажиллагаа явуулж байгаад татан буугдсан төвүүдийг сэргээх үйл ажиллагааг хийнэ. Энэ дээр хэлэлцүүлгийн явцад шинээр байгуулах гэдэг томъёоллыг нэмж оруулах юм бол бас их зохистой болов уу гэж бодож байгаа. Мөн одоо угсаа нэгт үндэстнүүд, жишээлбэл одоо Түрк гэдэг юм уу. Тийм ээ. Унгар. Эсвэл одоо Халимаг, Буриад, Тува, Өвөр Монгол гээд энэ Монгол угсаатны аймгууд дээрээ улс орнуудынхаа

хувьд бол бас бид нар түшиглэж Монгол судлалын төвүүдийг бол шинээр нэмэгдүүлэх ийм шаардлага бол байгаа юм. Тийм учраас зөвхөн дотооддоо судалгаа идэвжүүлэх биш гадна талын тэр судалгааны төвүүд Монгол судлалын салбаруудыг бол бид нар идэвхтэй дэмжиж ажиллах шаардлага бол зайлшгүй байгаа юм гэж хэлмээр байна.

Ер нь Монгол судлалын сан байгуулж байгаа үндэслэл бол аливаа шинжлэх ухааны багцад байгаа мөнгийг захиран зарцуулахдаа аль ч үедээ одоо ач холбогдлын эрэмбэ дараалал дотор бол яг энэ Монгол судлал нь бол байнга орхигдож, одоо зарцуулах мөнгөний хэмжээ нь байнга орхигдож явсан юм билээ л дээ. Тийм учраас одоо цаашдаа тодорхой мөнгийг төсөвлөөд ингээд энийгээ гүйцэд санхүүжүүлэхийн тулд тусгай сангаа байгуулаад ажиллах нь зөв өө гэж ингэж үзэж байгаа юм.

**3.Энхболд:** - Ж.Энхбаяр гишүүн тодруулъя.

**Ж.Энхбаяр:** - Миний ойлголтоор Монгол судлал гэдэг бол Монголын түүх, соёл, угсаатан, урлаг, хэл зэрэг ер нь Монголтой холбоотой бүх юмыг л судалдаг гадаадын шинжлэх ухааныг л Монгол судлал гэж ойлгож байгаа юм.

Бид Монголоо судлах гэж байгаа бол бид Орос судлалыг хөгжүүлэх хэрэгтэй. Оросыг судалж байж Монголыг олж авна. Хятад судлалыг хөгжүүлэх хэрэгтэй. Араб судлалыг хөгжүүлэх ёстой. Тэгж байж би Монголыг олж авах ёстой болохоос биш бид өөрсдөө мөнгө гаргаад Монголын эрдэмтэд дотроо бие биенийгээ судлаад, эндээс бид Монголыг олж авахгүй.

Тэгэхээр манай яамны бодлого хаашаа явах ёстой вэ гэвэл Оросыг судлах. Оросыг судалж байж Оросоос Орос-Монголын харьцааг гаргаж авна. Орос, Монголын түүх, шилжилт, угсаатны асуудлыг гаргаж ирнэ. Хятадыг судалж байж Хятад, Монгол хоёрын харьцааг гаргаж авах. Арабын ертөнцийг судалж байж тэнд байгаа тэр Монголын угсаатан зүйн судалгаа, тэнд байгаа өв соёлыг бид нар сэргээж авах. Ингэх юм бол Монгол судлал болно гэж ойлгож байгаа.

**3.Энхболд:** - Л.Гантөмөр сайд хариулах уу, ирсэн улсуудаар хариулуулах уу? Монгол судлалын талаар зөрүүтэй байр суурь байна л даа.

**Л.Гантөмөр:** - Яах вэ Монгол судлал бол өөрөө зөвхөн гадаадын улс орнууд Монголыг судалдаг шинжлэх ухаан биш л дээ. Одоо бид нарын хувьд бол алдагдсан, орхигдсон соёл, зан заншил бол асар их байна шүү дээ. Жишээлбэл, одоо уламжлалт анагаах ухаан гээд. Уламжлалт Монгол анагаах ухааныг одоо бид нар улсынхаа түүх, соёл, одоо тэр цаг хугацааныхаа хувьд сайн судалж гаргаж ирэх юм бол магадгүй дэлхийд өөрийн гэсэн экспорттой болох боломж бол бидэнд байгаа байхгүй юу даа. Гэх мэтчилэн бид бол Монгол судлал дээр илүү түлхүү өөрсдөө санаачлагч нь байгаад, өөрөө төв нь байгаад ингээд явах хэрэгтэй л дээ.

Тэгээд энэ чиглэлээр зөвхөн одоо гадаадынхан биднийг судлахыг хүлээгээд суух бол өрөөсгөл нэг талаасаа. Нөгөө талаасаа бол мэдээж бид бол

олон улсыг судлах судалгааны ажлуудаа бол хийх хэрэгтэй. Ялангуяа таны хэлж байгаа хоёр хөршөө судлах.../минут дуусав/

**3.Энхболд:** - Үг хэлэх боломж байгаа. Б.Бат-Эрдэнэ гишүүн асууя.

**Б.Бат-Эрдэнэ:** - Тэгэхээр би энэ хуулийн төслийг дэмжиж байна. Яах аргагүй одоо олон мянган жилийн түүхтэй энэ Монгол угсаатны өлгий нутаг, энэ тусгаар тогтносон Монгол Улс бол энэ Монгол судлалын гол төв байх ёстой гэдэг дээр бол санал нэг байна.

Тэгээд би бас сайдыг Ж.Энхбаяр гишүүний хэлсэн саналыг бас анхаарч үзэж байгаа гэж ингэж бодож байна. Яагаад ингэж хэлж байгаа вэ гэхээр энэ Монгол судлалын асуудал гэхээр зэрэг гадаадын эрдэмтэд нэг бодлогод зангидахгүй бол ерөөсөө өөрөө өөрийнхөө дураар. Яг үнэнээ хэлэх юм бол энэ Монголын энэ угсаатны, зөвхөн Монгол ч биш дэлхийн бусад улс орнууд, бүс нутгууд ч гэсэн энэ угсаатны судлалын чиглэлээр тодорхой хэмжээний хөрөнгө мөнгө босгоод тэр төслөө бол одоо өрхийнхөө санхүүжилтэд зөвхөн зориулаад зарцуулаад явдаг ийм зүйлүүд байдаг л даа. Тийм учраас энэ дээр бол одоо онцгой анхаараарай.

Би нэг тодорхой жишээ хэлье. Одоо Бурхан халдун хайрханы тухай асуудал байна. Бурхан халдун бол одоо бүх Монголчуудын дээдийн шүтээн. Хамгийн одоо. Бүх Монголчуудын шүтээн ийм уул, хайрхан. Тэгтэл энэ Бурхан халдун уулын судалгааны асуудал бол одоо хичнээн зуун жилийн өмнөөс эхлээд хийгдсэн. Дэлхийн олон орны эрдэмтэд судлаачдын анхаарлын төвд байсан. Олон судалгааны экспедицүүд бол нааш нь ирүүлж байсан. За сүүлийн үед бол эрчимжиж байгаа. Та бүхэн мэдэж байгаа. Та бол сайн мэдэж байгаа. Өмнөх Улсын Их Хурлын үеэр одоо Бурхан халдун уулын Тэнгэрийн овоо, одоо өвөг дээдсийн онгон шүтээн байна гээд сүйд болох шахсан шүү дээ.

Тэгээд тийм учраас энэ, зөвхөн би нэг жишээ хэлье. Бурхан халдун руу хандсан энэ судалгааны юмыг нэг цэгцэнд нь оруулахгүй бол дур дураараа одоо манай судлаачид бол гадаадын нэг байгууллага, хүмүүстэй холбоо бариад ингээд энэ чинь жолоодлогоос алдах гээд байгаа юм. Тийм учраас энэ дээр онцгой анхаарлаа хандуулж, тэгээд одоо тэр гадаад улс орнуудад байгаа. Түүрүүн хэлсэн орос, араб, энэ монгол үндэстэн гэдэг чинь өөрөө дэлхийд нэр алдраа мандуулж байсан энэ дэлхийн түүхийн нэг томоохон хэсэг байгаа учраас тэнд судалгааныхаа ажлыг бас өөрсдийнхөө судлаачдын хүчээр нэлээн анхаарал тавих талаар анхаарах хэрэгтэй байна.

Тэгээд би танаас асуух юм бол энэ Боловсрол, шинжлэх ухааны яам, Соёлын яам ер нь ямар оролцоотой байгаа юм. Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт асуулт бол ингээд өмнө нь бол иймэрхүү зорилго, чиглэлтэй сангууд бол их олон байгуулсан. Гэтэл тэр сангийн үйл ажиллагаа ил тод байх, тэнд одоо төвлөрсөн хөрөнгө мөнгөний зарцуулалт, мөн одоо тусгаж өгсөн хөрөнгө санхүүгийнх нь бололцоо нөөц нь ямар байна. Энд бол 8 тэрбум гаруй төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр ингээд тусгасан юм байна л дээ.

Тэгээд энэ хөрөнгө мөнгийг одоо ямар хэмжээнд байна гэж үзэж байгаа юм. Боллоцотой байна гэж үзэж байгаа юм уу? Ер нь одоо цаашдаа нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа юм уу. Яг энэ жагсаалтуудыг нь аваад үзэх юм бол энүүгээр санхүүжүүлэх, бас одоо биет болоод биет бус соёлын өвийн хүрээнд бол нэлээн судалгааны юмнуудыг хийхэд яг энэ хүрээгээр хязгаарлчих юм бол бас одоо арай дэндүү хүрээ бол одоо ийм хумигдмал маягтай байгаа юм уу даа гэсэн ийм л бодол надад байна л даа. Тэгээд энэ гурван асуултад та хариулж өгөөч.

**3.Энхболд:** - Л.Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** - Мэдээж сангийн удирдлага, зохион байгуулалт, ил тод байдал энэ болгон бол Засгийн газрын тусгай сангийн хуулиараа явна. Яг урьд нь бол Монгол судлалын чиглэлээр явуулж байсан Засгийн газрын сан бол байхгүй. Тэгээд шинээр байгуулж байгаа гэдгийг бол хэлмээр байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, аливаа судалгааг одоо бид нар удирдаж зохион байгуулах чиглэлээр Монгол судлалын үндэсний хөтөлбөр батлагдаад одоо ажил хэрэг болоод явж байгаа. Энэ дээр Монгол судлалын үндэсний зөвлөл байдаг. Тэгээд Монгол судлалын үндэсний зөвлөл дээрээсээ бид нар бол энэ мөнгөний санхүүжилтийн график чиглэлийг гаргаад явна гэж ингэж үзэж байгаа. Тэгэхээр мэдээж бид бол улс үндэстнийхээ эрх ашгийг одоо тэргүүн эгнээнд тавьсан судалгаанууд дээрээ өөрийнхөө санхүүжилтийг хийж дэмжлэг үзүүлж явах болно.

Гурав дахь асуултын хувьд бол 8.7 тэрбум төгрөгийг төсөөлж байгаа нь бол жишээлбэл өнгөрсөн жил 2012 онд Монгол судлал дээр зарцуулсан мөнгөний хэмжээ бол 266.0 сая төгрөг байдаг. Тэгээд ингээд харах юм бол ер нь 8 дахин өссөн мөнгийг бол зарцуулах саналыг гаргаж байгаа. Тэгэхдээ зарим нэг яг энэ төлөвлөгөөнд тусгагдсан асуудлууд дээр бол мэдээж Монгол судлалын сан байгуулагдаад цаашаагаа биеэ даагаад үйл ажиллагаа явуулахад бол эрдэмтдийн хэлэлцүүлэг, янз бүрийн хурал зөвлөгөөний үеэр гарч ирж байгаа сайн саналуудыг аваад явахад чиглэл зориулалт нь тухайн үеийнхээ, цаг үеийнхээ шаардлагад нийцүүлээд өөрчлөгдөх хувилбарууд бол гарах байх.

Би зүгээр өнөөдрийн төсөв, эдийн засгийн байдлыг харахад 8.7 тэрбум төгрөгийг зарцуулна гэдэг нь бол өөрөө их өндөр үзүүлэлттэй явах болов уу гэж харж байна.

**3.Энхболд:** - Л.Энх-Амгалан гишүүн асууя.

**Л.Энх-Амгалан:** - За би нэг гурван асуулт тодруулъя. Нэгдүгээрт нь, нийт 2013-2016 онд яг энэ үндэсний хөтөлбөр маягаар 8.6 тэрбум төгрөгийг зарцуулах юм байна. Нэгд. Тэгэхээр ерөнхийдөө яг ямар. Одоо байгаа ер нь Монгол судлал яг ямар түвшинд байгаа юм бэ? Ингээд 8.6 тэрбумыг 3 жилийн хугацаанд зарцуулсны дараа ер нь ямар үр дүн гарах вэ? Нийт Монголч эрдэмтэд, за Монгол судлалын төвүүд гээд энэ чиглэлээр одоо тодорхой хийсэн судалгаа байна уу? Хүлээж байгаа үр дүн байна уу гэдгийг тодорхой хэлээчээ

гэж.

Хоёрт болохоор яг 2016 он хүртэл гээд яг 2016 оноор тасалдах нь одоо ямар учиртай юм бэ? Монгол судлалын сан гэж байгаа бол энэ сан бол олон жил цаашаа санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхой байх ёстой. 2016 оноор тасалсан нь ямар учиртай юм бол гэж.

Гуравт, ер нь манай түүх, соёл, урлагын бүтээлүүд их олон оронд байдаг шүү дээ. Орост байгаа, Тайваньд байгаа, Иранд байгаа, Германд байгаа, Данид байгаа. Тэгэхэд яг энэ түүх, соёлын бүтээлүүдийн бүртгэл өнөөдрийг хүртэл ер нь тодорхой болсон юм байдаггүй юм. Тэгэхээр яг энэ чиглэлээр ер нь Монгол судлалын төвийн бас хийгдэх гол ажлуудын нэг нь энэ баймаар юм шиг надад бодогдоод байгаа юм. Тэгээд энэ чиглэлд яг нөгөө хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг харахаар яг энэ дээр тодорхой санхүүжилтийн эх үүсвэр тавигдаагүй байх юм. Энэ дээр ер нь ямархуу байр суурьтай байгаа вэ гэсэн ийм 3 асуудал дээр хариулт авахыг хүсэж байна.

**3.Энхболд:** - Л.Гантөмөр сайд.

**Л.Гантөмөр:** - За зарим асуултынхаа хариултыг ажлын хэсэг хариулаарай. 2016 он хүртэл төсөөлж байгаа нь бол мөнгөнийхээ зарцуулалтыг л ерөнхийдөө танилцуулж байгаа юм. Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бол энэ сан бол байгуулагдаад цаашдаа урт хугацаандаа ажлаа хийгээд явна. Хууль дээр бол тэдээс тэдэн оны хооронд ажиллана гэсэн ийм үг үсэг бол байхгүй л дээ. Ер нь бол одоо энэ сан байгуулагдсанаар ямар үйл ажиллагаа явуулах юм бэ, ямархуу зардал гарах юм бэ гэдэг ерөнхий төлөвлөлтийг танилцуулга хэлбэрээр оруулж ирж байгаа юм.

Ер нь хүлээгдэж байгаа үр дүнг бол бид нар хамгийн одоо өндөр хэмжээнд харж байгаа нь бол залуу судлаачид байгаа. Ялангуяа Монгол Улсын Их Сургуульд бол урьд нь бол маш олон гаднын оюутнууд ирж суралцдаг байсан. Тэгээд одоо бол бараг байхгүй. Харин ч Өвөр Монголын сургуульд монгол залуучууд очиж Монгол судлалаар сурч байгаа ийм дүр зураг байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар бол залуу эрдэмтдэд, залуу оюутнуудад одоо яг Монгол судлал дээрээ тэтгэлэг олгоод ингээд гаднын оюутнуудыг Монголдоо сургах. Нэг үгээр хэлбэл ирээдүйн Монгол судлаачдыг бэлтгэх ажлыг бол дотооддоо зохион байгуулна.

Нөгөө талдаа одоо бодитой хүлээж болох 2016 он гэхэд бидний одоо яг хүсэж мөрөөдөж байгаа хамгийн том зүйл бол томоохон их дээд сургуулиуд дээр Монгол судлалын төв байгуулах зорилгыг тавьж байгаа. Ийм боломжийг бол эрэлхийлнэ. Өнөөдөр Монгол судлал нь явагдаж байгаа тэр Европт байгаа сургуулиуд, Америкт байгаа сургуулиудынхаа үйл ажиллагааг бол одоо дэмжиж явуулна. Аль аль талаасаа мөнгө санхүүгээ гаргаад явна гэсэн ийм л дүр зурагтай байгаа. Тэр түүх асуусан уу. Тийм ээ. Соёлын асуудал. Ө.Сүхбаатар дарга тэр бүртгэл дээр хариулт.

**3.Энхболд:** - Ажлын хэсгийн микрофон. Ажлаа нэрээ хэлээд протоколд

орохын тулд.

**Ө.Сүхбаатар:** - Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухааны хэлтсийн дарга. Тэгэхээр үндэсний хөтөлбөр 4 үндсэн хэсэгтэй байгаа. Яг тэр хэрэгжилтийг хангахаар энэ санхүүгийн зарцуулалтаа тооцоолж гаргасан юм. Ер нь энэ үндсэн 4 хэсэг дээрээ Л.Энх-Амгалан гишүүний гурав дахь асуулт бол яг энэ үндсэн 4-ийг хэрэгжүүлэх хөтөлбөр дээр багтаж оруулсан байгаа. Гол нь Монголд энэ Монгол судлалын номын сан, музей, Монгол судлалын төв болгох энэ тал дээрээ бас тодорхой алхмууд хийхээр тусгасан байгаа.

**3.Энхболд:** - За дутуу хариулсан бол нэмээд хариулчих. Ажлын хэсэг.

**Ц.Өнөрбаян:** - Би зүгээр энэ ажлын хэсгийн. Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Монгол судлалын сургуулийн захирал Ц.Өнөрбаян.

Тэгэхээр энэ Монгол судлал гэдэг бол эсгий туургатны дотроос бол Монгол судлал, түрүүн одоо Ж.Энхбаяр гишүүн бас яриад байсан. Эсгий туургатны дотор Монгол судлал гэдэг ийм бие даасан судалгааны түүх, ийм салбар бий болгосон нүүдэлчдийн уугуул Монголоос өөр ер нь бараг байхгүй гэж ингэж үзэж болдог. Тийм учраас Монгол судлал бол маш өргөн хүрээтэй судлагдахуунтай. Гадаад дотоод. Гадаадын эрдэмтэд ч Монголыг судалж байгаа, Монголын эрдэмтэд ч Монголыг судалж байгаа. Ийм учраас их өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг.

Тэр дотроосоо тэр соёлын хувьд бол үнэндээ Монгол судлалын өнөөдөр дэлхийд байгаад Монголын соёлын дурсгалт зүйлүүд бол дэлхийн олон оронд байна л даа. Жишээлбэл би зүгээр одоо ажиллаж байсан Унгарын Будапештын их сургууль, Унгарын шинжлэх ухааны академид энэ Монгол судлалын маш олон тооны бичиг соёлын, оюуны соёлын дурсгалууд байдаг. Тэрийг бүрэн судалж тооцоо судалгаа хийж амжаагүй байгаа. Тийм учраас өнгөрсөн жилээс эхлээд бид энэ Монгол судлаачид энэ дэлхийн Монгол судлалын төвүүдэд байгаа Монгол оюуны соёлын одоо алдартай бүтээлүүд, за тэр биет болон биет бус өвийн алдартай бүтээлүүдийг судалж, тэрний тооцоог гаргаж тэнд ийм юм байна гэдгийг мэдээлэх ийм үйл ажиллагаа эхлүүлсэн юм. Энийг бол цаашид Монгол судлалын энэ үндэсний хөтөлбөр, сангийн үйл ажиллагааны хөрөнгөөр хийх байх гэж ингэж найдаж байна. Тэгээд Д.Төмөртоогоо бас нэмж тайлбарлах байх.

**Д.Төмөртоогоо:** - За Монгол судлалын тухай би бас нэг хоёр зүйл хэлье. Ж.Энхбаяр гишүүний хэлдэгээр Монголын судлал гэдэг бол анх 19 дүгээр зуунд гадаадын, Өрнө дахины эрдэмтэд Монголыг ажиглаж Монголын тухай, Монгол хэл, түүхийн тухай, Монголын судлал анх Өрнө дахинд үүсээд 1920, 1930-аад оноос Монгол Улс шинжлэх ухааны сэтгэлгээ, шинжлэх ухаан үүссэн цагаас эхлээд Монголчууд өөрсдөө өөрийнхөө хэл, түүх, соёлоо судалсан.

1960-аад оноос эхэлж гадаадынхан дэлхийн Монгол судлалын төв Монгол Улс боллоо гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Тийм учраас Монгол судлалыг бол одоо Монголын эрдэмтэд ч байна, гадаадын эрдэмтэд ч хийх ийм л нийт хүн

төрөлхтөний одоо өв соёлын нэг дундын бүтээл болж байгаа юм.

Бас нэг зүйл хэлэхэд энэ одоо гадаадын 20 шахуу орны музей, номын сан, архивт Монголын холбогдолтой, Монголын түүх, соёл, шашины холбогдолтой ном судар, биет зүйл маш олон байгаа. Энэ бүгдийн жагсаалт каталог гараагүй. Энийг одоо ойрын үед Соёлын яамтай нийлээд одоо энэ гадаадад байгаа Монголын холбогдолтой зүйлийн эхлээд каталогийг гаргах, жагсаалт гаргах, дараа нь хувилж авах. Болж өгвөл одоо тэгээд хувилж авах энэ жил дараалсан цаашаа бодлоготойгоор шат дараалсан ийм арга хэмжээ авах нь одоо Боловсрол, шинжлэх ухааны яам, Соёлын яамны хамтын үйл ажиллагааны үр дүнд бүтэх асуудал гэж бодож байна.

Мөнгө төгрөгтэй холбогдолтой ганц зүйл хэлье. Одоогоор гадаадын 7 их дээд сургуулиас бидэнд одоо Монгол судлалыг дэмжих санал ирсэн. Энэ саналуудыг тавьсан мөнгө нь үзэх юм бол өнөөдөр 5 тэрбум, монгол төгрөгөөр бодвол 5 тэрбум 750 сая төгрөгийн тусламжийг одоогоор биднээс хүсээд байгаа юм. Ганц Калифорнийн их сургууль 3 сая 840 мянган долларын тусламж үзүүл гэдэг санал ирсэн байгаа. Тэгэхээр бидний тавьсан 8 тэрбум төгрөг өнөөдрийн бидэнд тавигдаад байгаа гаднаас ирж байгаа хүсэлт хоёрыг харах юм бол Монгол судлалтай холбогдолтой хөрөнгө санхүү бол цааш цаашдаа бас нэмэгдэх, нэмэгдвэл одоо сайн гэж бодож байна.

**3.Энхболд:** - За С.Дэмбэрэл гишүүн асууя.

**С.Дэмбэрэл:** - Монгол судлалын дотоод одоо Монголд байх Монгол судлалын учрыг би сайн ойлгохгүй байна л даа. Бид бол миний ойлгож байгаагаар бол Монголоо маш сайн судалдаг. Маш олон хүрээлэнгүүд байгаа. Хэдийгээр Монгол судлал гэж нэргүй ч гэсэн. Шинжлэх ухааны академийн түүхийн хүрээлэн гэх мэтээр ингээд л өнгөрснийг ч судалдаг, өнөөдрийг нь ч судалж байдаг, эдийн засгийг нь судалж байна, улс төрийг нь ч судалж байна, стратегийг нь судалж байна, археологийг нь судалж байна, палентологийг нь ч судалж байна. Гэх мэтээр маш өргөн хүрээтэйгээр.

За гадаадад байгаа Монгол судлалын ерөнхий ханыг бол мэднэ. Тэгэхээр энэ асуудал маань дотооддоо гэхээсээ илүү гадаадад Монголыг үндэстнийх нь хувьд брэндинг хийх том бодлогын нэг хэсэг гэж би ойлгодог. Бусад улс орнуудын жишээг харж байхад ч гэсэн тухайн улс орны судлалыг үндэсний брэндингийнхээ нэг хэсэг болгоод явдаг юм билээ. Гэтэл энэ асуудал дээр яагаад энэ одоо соёлын асуудал нь орж ирдэггүй юм. Монгол судлал гэхээр эрдэм шинжилгээний бүтээлийг санхүүжүүлэх, эсвэл тэдэнд гранд олгох, зөвхөн энүүгээр хязгаарлчихвал энэ чинь өөрөө их явцуу болчихно.

Энэ одоо Ц.Оюунгэрэл сайд сууж байна. Энэ асуудлыг Монголын саяхан бид хуралдсан Монгол брэнд гээд энэ чинь бүтээгдэхүүний тухай асуудал биш шүү дээ. Үндэсний брэндинг том бодлогын нэг хэсэг болгоод хоёр яам хамтраад хамтарсан тийм сан болгох энэ асуудлыг оруулж ирж болоогүй юм уу гэсэн нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт нь, энэ сан цаашдаа ямар эх үүсвэрээс яаж тогтвортой үйл ажиллагаагаа хангаж байх юм бэ? Жил болгон улсын төсвөөр ихэнхи нь санхүүжиж явах юм уу, Монгол төрийн бодлогын хувьд. Эсвэл энийг гадаад дотоодын бусад эх үүсвэрүүдээс санхүүжүүлэх тэр боломжийг хайх энэ талаасаа хуулийн төсөлд энэ одоо оруулж ирж байгаа материалд яаж тусгагдсан юм бэ гэсэн энэ хоёр асуултад хариулж өгнө үү.

**3.Энхболд:** - Л.Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** - За баярлалаа. Монгол судлалыг дэмжих сангийн хөрөнгө нь 7.1-д зааснаас гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ гэсэн заалт байгаа. 21.1.1-д тусгай сангийн үйл ажиллагаанаас олсон орлого, дотоод гадаадын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн хөтөлбөр, төслийн хөрөнгө гэж байна. Тэгэхээр бид нар хамгийн том дэмжлэгээ төсвөөсөө харна. Монгол Улсын төсвөөр Монгол судлалыг дэмжье гэдэг ийм л шийдэл гаргах гэж байгаа юм. Тийм учраас сан байгуулъя гэж байгаа юм.

Тэгээд мэдээж энэ судалгааны ажил бол одоо бодитой байгаад, үр дүнтэй байгаад ингээд энэ судлал өөрөө ямар хэмжээнд хөгжих вэ гэдгээс хамаараад гадаад дотоодын хандивлагчид хамтарсан төсөл хөтөлбөрүүд бол одоо үйл ажиллагаа явуулах боломжууд бол бидэнд гарна.

Ер нь бол ОХУ болоод БНХАУ-ын Шинжлэх ухааны яамтай хамтарсан төсөл хөтөлбөрүүдийг, судалгааны ажлуудыг бид нар зохион байгуулдаг. Тэгээд энэ хамтарсан судалгаан дотор Монгол судлалаа бид нар оруулаад явахад бол гадаадын шинжлэх ухааны санхүүжилтээс бас тодорхой санхүүжилтийг авах боломж бол бидэнд бүрдэх юм. Тэгээд ер нь гадна талдаа Монголыг сурталчилдаг, гадна талд Монголын тухай ярьдаг, гадна талдаа бид нар Монголоо гэсэн сэтгэлтэй хүмүүсийг л олшруулах нь бол одоо хамгийн том зорилт байгаа юм.

Та бүхэн одоо Германд очиход Герман талд ажилладаг тэр Монгол хэлтэй судлаач гэж байгаа хүмүүсийн тоо ширхэгийг одоо бол анзаарч харж байгаа. Насыг нь харж байгаа. Одоо бол Монгол хэл мэддэг Америк хүн хэд байна вэ, Герман хүн хэд байна вэ, Польш хүн хэд байна вэ гээд харахад л санаа зовоосон тийм үзүүлэлтүүд гарч ирж байгаа байхгүй юу. Тийм учраас бид гадна ертөнцөд С.Дэмбэрэл гишүүний хэлдэгээр Монголын тухай ярьдаг, Монголыг судалдаг, Монгол хэл заадаг энэ хүмүүсийн тоог олшруулах, Монгол судлаачдыг нэмэгдүүлэхэд бид нар бодлогынхоо нэг хэсгийг чиглүүлнэ.

За тэгээд хуулийн нэмэлт, өөрчлөлтөд Монгол соёлын өв, түүхэн дурсгалт зүйлийг сэргээн засварлах, мэдээллийн сан бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ гэсэн заалт байгаа. Ер нь мэдээж Монгол судлал дотор соёл. Би түрүүн хэлсэн. Соёл, түүх, хэл гээд зөндөө олон зүйлийг хамарна. Тийм учраас соёлын асуудлууд бол эндээ ороод явах юм. Цаашдаа соёлын яамны оролцоог энэ дээр бий болгох шаардлагатай бол одоо хуулийн хэлэлцүүлгийн явцад бол бий болгоод явж болно. Энийг бол хэн нэгэн өмчлөхөөсөө илүүтэйгээр Монголынхоо, энэ Монгол судлалыг үнэхээр төсвийн мөнгөөр дэмжих хөгжүүлэх бол шаардлага байна гэж



хэлмээр байна.

**З.Энхболд:** - Хариулагдав уу? За асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү.

14 цаг 25 минутад эхэлсэн. Одоо 17 цаг 25 минут. Ингээд цаг дуусаж байна. Цаг сунгаад Ч.Улаан гишүүний нэг мэдээлэл байгаа юм. Тэр бас хугацаатай юм. Сонгуультай холбоотой улс орны төлөв байдлын мэдээлэл гээд. Индэр гарч уншаад л болоо. Нэг их батлах юм бол байхгүй тэр дээр. Хэдэн тоо л уншина л даа.

Одоо энэ Монгол судлалаараа санал хураагаад дуусгачихъя. Тэгэх үү? За Д.Лүндээжанцан гишүүний нэрийг нэмчихье. Тэгээд очроороо 2 дээр гэж байна. Д.Лүндээжанцан гишүүнийг 2 дээр нэмчихье. Одоо бол 6-хан хүн үг хэлнэ. Дэмжинэ дэмжихгүй. Би Монгол судлалыг дэмжихгүй хүн энэ дотор байгаа гэж бодохгүй байгаа учраас эхний 3 хүн үг хэлээд үндсэндээ дуусах байх. Шууд санал хураачих уу? Бүгд дэмжиж байгаа юм чинь. За тэгвэл ингэчих. Бүгдээрээ кнопоо дарчих. Тэгвэл бүгд алга болчихно. Бүгдээрээ кнопоо дараад нэрээ аваадаг. Тэгээд харъя.

Энэ бол хэлэлцэх эсэх шүү дээ. За за би дэмжсэн 3 гишүүнээр үг хэлүүлнэ. Араас нь дэмжихгүй гарахгүй байх гэж бодож байна. Г.Баярсайхан гишүүнээр үг тасалъя. Д.Лүндээжанцан гишүүн үгээ 1 минут хэлье гэсэн.

**Д.Лүндээжанцан:** - Тэгэхээр ингэж байна. Монгол судлалын төв Монголдоо байх гэдэг ерөнхий гол төв нь Монголд байх гэсэн ерөнхий концепци нь явж байгаа юм байна гэж ингэж ойлгогдож байгаа юм. Манай эрдэмтэд одоо гадаадын эрдэмтэдтэй уулзахаар хэлж байгаа шүү дээ. Бидний залгамж халаа тасарчих гээд байна. Тэр гадаадын эрдэмтдийн уугуул одоо өөрийн орны удирдагчдаа хэлэхдээ хэлж өгөөч гэж. Жишээ нь Германд В.Хэйссиг гуайн шавь байсан. В.Хэйссиг гуай нас барчихсан. К.Сагастер, М.Вайрс гээд хоёр өвгөн байсан. Хоёулаа одоо тэтгэвэртээ гарчихсан. Ингэхээр энэ дээр манай бодлогоор Германтай улс төр, дипломатын аргаараа болон бусад арга замаар харилцах ёстой болоод байна гэж.

Өнөөдөр хоёр, буддын судлалыг Монголд байна шүү дээ орхиж болмооргүй байна. Ц.Дамдинсүрэн гуайн хоёр шавь Д.Ёндон академич, Л.Хүрэлбаатар доктор хоёр бурхан болчихсон. Одоо энийг залгах хүн хэрэгтэй байна. Эцсийн эцэст энийг юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр. Та нар инээх юм биш ээ. Эцсийн эцэст байна шүү дээ мөнгө биш, байшин барилга биш хамгийн гол нь хүн бэлтгэх гэдэг асуудал бол хамгийн чухал юм байна. Өнөөдөр 2015 онд Өндөр гэгээн Занабазар судлалын одоо ингээд ой нь болно. Занабазар судлалын асуудлаар маш их юм хийх шаардлагатай байна. Яагаад одоо Төвдүүд судалдаг, лам нар судалдаг, шинжлэх ухааны түвшинд судлах шаардлага байгаа учраас энэ асуудал дээр анхаарах шаардлагатай байна гэж.

Гуравт нь, түүхийн цагаан толбыг арилгах шаардлагатай байна. Л.Гантөмөр сайд сууж байна. Түүх шинэчлэлийг хийхгүй бол болохгүй нь. 1950-

иад оноос хойш эхэлсэн энэ Монгол дундаж түүхийг гуйвуулчихсан. Дундад түүхийг хэвээр нь гаргаж ирээчээ гэдэг асуудлыг тавихаас өөр арга байхгүй. Үзэл сурталжсан түүх болсон. Энийг янзлах хэрэгтэй байна. Дундад түүх. Эртний түүхийн цагаан толбууд хэвээрээ байна. Үүний тулд яах вэ гэхээр Багдадын номын сан уруу нэвтрэх шаардлагатай байна. Иран уруу нэвтрэх шаардлагатай байна. Сая Ерөнхийлөгч очсон. Ярьсан шүү дээ. Яриад дарга нар айлчлаад байдаг. Ажил явдаггүй. Тайваны номын сан уруу нэвтрэх шаардлагатай байна. Тэр номын сангуудад очиход амархан. Гол нь тэр хэмжээнд бэлтгэгдсэн боловсон хүчин шаардлагатай байна. Хоёр гурав, дөрвөн улсын нарийн мэргэжлийн түүхчид, хил шинжээчид нийлж байж зөв түүхийг гаргаж ирэх ёстой. Ингэснээр их олон асуудал шийдэгдэх ёстой. Тэр битгий хэл манай энэ эзэн Чингисийн маань онгон шүтээний тухай асуудал ч тодрохыг үгүйсгэх арга байхгүй. Хичнээн нууцалсан ч гэсэн. Ингэхээр одоо олон түмэнд тодорхой асуудлуудыг гаргаж тавих хэрэгтэй.

Их Засаг судлалыг гучин хэдэн хүн судалж байна өнөөдөр. Их Засаг гэдэг хуулийг. Гэтэл эх нь олдохгүй байна. Тэр дээр ганц одоогийн хуучин бичиг, манж бичиг, кирилл бичигтэй хуульчид яваад бүтэхгүй шүү дээ. Ийм учраас олон зүйлийг тодорхой болгохын үүднээс энэ Монгол судлалыг бас түүх, хэл зүйн чиглэлд нь нэлээн анхаарах шаардлага байгаа нь харагдаж байгаа учраас би дэмжиж байгаа юм. Би энийг заавал анхаарах шаардлагатай учраас яриад байгаа юм шүү гэдгийг хэлье.

**3.Энхболд:** - Д.Лүндээжанцан гишүүн дэмжиж үг хэллээ. Ж.Энхбаяр гишүүн.

**Ж.Энхбаяр:** - Би ер нь эсрэг талдаа үг хэлэх гээд байгаа юм. Нэгдүгээрт, яагаад гэвэл шинжлэх ухааны нэр томъёоны хувьд буруу тодорхойлогдоод байна уу даа гэж. Бид өөрсдөө судлагдахууны гол объект. Монголд байгаа бид өөрөө өөрсдөө Монголоо судална гэдэг бол үгүй байх аа гэж бодож байна. Монгол судлал гэдэг бол гадна талаас бидний судалж байгаа судалгаа шинжлэх ухааны нэрээр Монгол судлал гэж ойлгодог. Бид бол Монголын цаг агаар, Монголын угсаатан, Монголын хөрс, Монголын шавьж, Монголын археологи гээд түүхийн юм явагдаж байгаа. Тэгэхээрээ тодорхой болгохгүй бол удахгүй тань дээр хэдэн улсууд монгол Чингисээ олно, эх орноо сайн сайхан болгоно гээд нэг төсөл бичээд орж ирж авсаар байгаад энэ Монгол судлагдахуун гарч чадахгүй, Монгол судлал болж чадахгүй. Нөгөө л бидний өдөр тутмын нөгөө хийж байгаа Монголд байгаа олон хүрээлэнгүүдийн нэг ажлын төсөл авах хэдэн мөнгөний эх үүсвэр болоод дуусах болов уу гэж бодож байна.

Үнэхээр Монголоо судлах гээд байгаа бол Арабыг судалж байж, араб хэлтэй 10 хэлтэй хүн бэлтгэж байж тэнд байгаа эртний тэр персийн, Ираны тэр номын сангуудад байгаа монголын түүх соёлын сурвалжуудыг гаргаж ирвэл жинхэнэ монгол судлагдахуун. Бид Хятадыг судалж байж, Тайваныг судалж байж, тэнд байгаа юм аа судалж гаргаж чадвал жинхэнэ монгол судлагдахуун гарах болов уу гэж бодож байгаа юм.

Тэгэхээр сая бид нар нэг юм өнгөрсөн онд, сая юу билээ дээ Монголын

Монгол судлалын үндэсний академи байгуулна гээд сая чуулган хэлэлцээд батлаад явж байгаа шүү дээ. Энэтэй чинь яаж ойлгох юм бэ ерөөсөө. Тэгэхээрээ наадах чинь томъёолоод нэр томъёон дахь хоёр өөр юмыг нэг болгоод нэг л жаахан шинжлэх ухааны хувьд нэр томъёоны хувьд алдаанд ороод явчих гээд байна уу гэж болгоомжлол байна.

Тэгэхээр энд хийгдэх ажлууд дээрээ үнэхээр. Дахин хэлэхэд хоёр хөршөө судлах чиглэл, Ойрхи Дорнодыг судлах чиглэл дээр гарч чадах юм бол жинхэнэ Монгол судлагдахуун гарч ирнэ шүү. Тэрнээс ахиад нэг археологио, ахиад нэг шавьж судална, ахиад түүх судална, ахиад шашин судална гээд ингээд орчихвол наад мөнгө чинь юу ч болохгүй. Тэгээд Монгол судлагдахууны төв нь Монгол гэж бас ойлгохгүй л байгаа юм даа Тэрийг та нар нэг сайн бодоорой.

За яах вэ Өвөр Монголтой барьцах тэр. Би ойлгоод байна. Таныг сайн санаж хийгээд ойлгоод байна. Тэгэхдээ тэрний цаана тийм нэр томъёоны алдагдалд ороод буруу ойлголттой болоод явчихвий дээ гэж санаа хэлээд байгаа байхгүй юу. Болдог бол энэ дотор байна шүү Монгол судлагдахуун гэж орж байгаа бол Арабыг оруулаад, Оросыг оруулаад, Хятадыг оруулаад, тэр Тайвань энэ тэрээс авах юм их байна шүү дээ. Тэгэхгүй бол энэ мөнгө чинь буруу гараар орчихвий дээ. Тодорхой заамаар байна шүү дээ. Тэгэх юм бол үндсэндээ 50 ширхэг гадаадын оюутныг Монголын Засгийн газар тэтгэлэгээр сургаад ийм ийм чиглэлээр судлагдахуунаа дэмжээд санхүүжүүлнэ гээд тодорхой зарлаад явахаас биш баахан хурал зөвлөгөөн, ном, атлас хэвлэнэ гээд энэ 8.0 тэрбум төгрөг явах юм бол харамсалтай үр дүн гарах болов уу гэж бодоод байгаа юм.

Тэгэхээр би тэр О.Баасанхүүгийн оруулж ирсэн Монгол судлалын үндэсний академи өнөөдрийн Монгол судлалын үндэсний сан хоёрын ялгаа чинь ерөөсөө юу болох вэ. Асар ялгаатай зүйл. Гэхдээ бид нэг гэж ойлгоод нэг нэр томъёон дээр авчраад байгаа болохоор наадах чинь асар их маргаан дагуулах болов уу даа. Тэрийг Л.Гантөмөр сайд аа, яг мэргэжлийн шинжлэх ухааны улсууд нэр томъёо нь хараад тодруулаарай. Тэгэхгүй бол их нэг тийм буруу юм явчихвий дээ гэж болгоомжлол төрөөд байгаа шүү. Би болгоомжлол талаасаа хэлээд байгаа юм.

**З.Энхболд:** - Ж.Энхбаяр гишүүн дэмжсэн үү, эсэргүүцсэн үү. За М.Батчимэг гишүүн.

**М.Батчимэг:** - Би бол Монгол судлалын сан байгуулахыг мэдээжийн хэрэг дэмжиж байгаа. Тэгэхдээ үнэхээр үг хэлэхгүй бол болохгүй байсан шалтгаан бол нэгдүгээрт хувь хүний хувьд энэ асуудлыг үнэхээр олон жил болоосой, бүтээсэй гэж бодож итгэл үнэмшил болж ирсэн. Яг өнөөдөр явж байгаа зүйл тодруулга хэрэгтэй байна гэж бодож байна. Сая Ж.Энхбаяр гишүүний хөндөж байгаа асуудал зарим талаасаа зөв гэж бодож байна. Бид нар өнөөдөр Монгол судлалыг ярихдаа дэлхийн нийт гадаад ертөнц монгол судлал, Монголыг судалдаг болох асуудлыг өргөжүүлэх дэмжүүлэх асуудлыг ярьж байгаа. Яг өнөөдөр Монгол судлал дээр юу хийх юм бэ гэхээр энийг их сайн нарийн тодорхойлж өгөхгүй бол бас буруу явчихвий гэж бодож байна.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд 2010 онд Монгол Улс тэр дундаа Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот Монгол судлалын дэлхийн төв болох ёстой гэдэг ийм үзэл санаа орсон. Ингэж орохдоо өнөөдөр Монголдоо Монголыгоо судалж байгаа Түүхийн хүрээлэн, Хэл шинжлэлийн хүрээлэнгээ нэгтгээд Монголыгоо судлах тухай яриагүй. Энэ ойлголт миний бодлоор одоо түрүүн Л.Гантөмөр сайдын ярианд дурьдагдсан л даа. Мэдээллийн нэгдсэн сан байгуулах гэж. Дэлхий даяар Монголыг судалж байгаа тэр мэдээллийн нэгдсэн санг байгуулах. Улаанбаатар өөрөө одоо дэлхийн дахины Монгол судлалын hub болох. Энд чинь Монгол судлалын эрдэмтэд цуглаж байдаг, чуулж байдаг, ирж одоо мэдээлэл солилцож байдаг, тэрийг нь Монголын төр засаг бодлогоор дэмжиж байдаг. Тэгээд Монгол судлалын сан нь дэлхий нийтэд Монгол судлалыг одоо дэмжих гол үйл ажиллагааг явуулж байдаг ийм агуулгаар ойлгож байгаа.

Тэгэхээр энэ сангийн үйл ажиллагаа энүүгээрээ яваасай гэж бодож байгаа. Тийм учраас би юу гэж хүсэх гээд байна вэ гэхээр зэрэг хэлэлцэх эсэхийг нь дэмжиж байна. Хэлэлцүүлэг болоод ороод ирэхэд анхны хэлэлцүүлэг дээр би бол ажлын хэсгээс шал өөр хариулт хүсмээр байгаа юм. Өнөөдөр маш их эргэлзээтэй юм ярьж байгаа. Түрүүн манай бүлэг дээр ярихад бас хэлж байсан. Нөгөө дотооддоо мөнгө шингээдэг юм уруу явчихвий гэсэн зовиол бол байна.

Тийм учраас дараагийн ээлжинд ажлын хэсгээс юу шаардмаар байна вэ гэвэл түрүүн Л.Гантөмөр сайд хэлсэн. Сангийн зорилго бол тодорхой байгаа гэж. Унтарчих гээд байгаа Монгол судлалын төвүүдийг дэмжмээр байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, оюутнуудад тэтгэлэг өгмөөр байна. Гуравдугаарт, Монгол судлалыг шинээр нэе гэж байгаа энэ том том сургуулиуд дээр шинээр нээмээр байна гэж. Тэгэхээр ажлын хэсэг ирэх энэ 8.0 тэрбум төгрөгөөр ирэх 3 жилд хэдэн хүнд тэтгэлэг олгох гээд байгаа юм бэ. Гадаадын хэдэн орны хэдэн хүнд. Хэдэн төвийн сэргээхэд дэмжлэг үзүүлэх гээд байгаа юм бэ. Ямар сургууль дээр шинээр Монгол судлал нээх гээд байгаа юм бэ. Ийм асуудлаа тодорхой орж ирж тодорхой юм ярьж танилцуулаачээ. Тэгэхгүй бол та нарын энэ ойлгомжгүй байдал чинь гишүүдийн дунд ийм ойлгомжгүй байдлыг үүсгэж байна. Ил тод биш байгаа юм шиг санагдаж байна.

Тухайлбал, одоо түрүүн хэлсэн. Калифорны их сургууль дээр 4 орчим сая доллар нэг удаа хийчих юм бол Монгол Улсыг хэдэн арван жилээр бид нар цаашаага мөнгө нэхэхгүйгээр Монголын судлалыг ингээд орчин үеийн Монгол судлалыг заагаад явах юм гэж. **Berkeley** [University of California, Berkeley] гэдэг өөрөө маш том төв шүү дээ. Америкийн том топ сургуулиудын нэг. Энэ сургууль Монгол судлалыг хэдэн арван жилээр өөрөө цааш нь аваад явна гэдэг бол Монгол өөрөө энэ чинь бас аюулгүй байдлын баталгаа. Тийм учраас жишээлбэл энэ асуудал энэ хүрээнд шийдэгдэх юм уу, үгүй юу. 2016 он гэхэд хэдэн хүн шинээр Монголын степенд авчихсан, хэдэн төв амилчихсан байх юм бэ. Энийг л ярьж орж ирээчээ.

Тэгэхгүй бол дахиад нэг дотооддоо мөнгө шингээдэг. Ер нь Шинжлэх ухааны академи, шинжлэх ухааны технологийн санг бид нар нэг яримаар л байгаа юм. Мөнгө өгдөггүй биш зөндөө мөнгө өгдөг шүү дээ. Гэтэл өнөөдөр Монголын шинжлэх ухаан хаана юу хийж яваа юм бэ. Баахан мөнгө эргэлддэг болсон. Хаалттай систем болчихсон. Залуучууд орж болдоггүй. Дотооддоо шилдэг залуу эрдэмтэд төрөх үүд хаалга ер нь хаалттай байгаа гэж үзэж байгаа шүү. Дандаа гадна төгсөж ирдэг. Гадаадад төгсгөсөн гэж Монгол мэдэхгүй гэж шүүмжлэгддэг. Хамгаалуулах зөвлөлүүд нь шинэ залуу хурц чадвартай хүмүүсээ ад үздэг. Ер нь бол нэг ийм тогтолцоо байгаа. Тийм учраас одоо Монгол судлалын санд 8.0 тэрбум төгрөг улс төсвөөс өгөх гэж байгаа бол Л.Гантөмөр сайд цоо шинэ өөрчлөлт хийх байх гэж хүлээж байгаагаа л хэлмээр байна.

**З.Энхболд:** - За 3 гишүүн дэмжээд үг хэлчихлээ. Одоо бол хэлэлцүүлгээр нэр дуусаж байгаа биш ээ. Юм дөнгөж эхлэх гэж байна. Бид хэлэлцэх эсэхийг нь. За Ё.Отгонбаяр гишүүн дэмжиж үг хэлье. Ж.Энхбаяр гишүүн дэмжээгүй учраас.

**Ё.Отгонбаяр:** - Их Хурлын дарга аа. Дэмжиж үг хэлэх гэж байгаа юм. Байнгын хороонд та бүхэн оруулахгүй юм. Одоо би эсэргүүцэж үг хэлж чадахгүй. Энэ өнгөрсөн Засгийн газрын үед Монгол Улсын судлалын төв. Их Хурлын дарга аа, би минутандаа үгээ хэлчихье л дээ. Яагаад гэдгээ тайлбарлачихъя. Та яагаад хүний үг хаагаад байгаа юм бэ.

Бас бухимдаж байна шүү дээ. Хэрүүл уруул хийж байж. Би дэмжих гэж байгаа шүү дээ. Энэ 4 жил энэ салбартай ноцолдсон учраас. Санаа оноогоо хэлчихье гэж ингэж л хүсэж байгаа юм. Битгий ам хаагаад байгаачээ гэж. Тэгээд би бас гишүүдийг энэ асуудлыг дэмжиж өгөөчээ гэж хүсэх гэж байгаа юм. Гэхдээ бас энэ асуудлыг хариуцаж оруулж ирсэн хүмүүс хоёр гурван бас санал санаа хэлэхгүй бол болохгүй нь.

Монгол судлалын сангийн асуудал бол дэмжигдэх ёстой асуудал. Гэхдээ энэ сангийнхаа асуудлыг боловсруулахдаа зөвхөн шинжлэх ухаан, хэл шинжлэл, түүх гэдэг үндсээс нь харсан маягийн болчихож. Нэгдүгээрт. Энийгээ та бүхэн эргэж хараачээ. Соёлын өвийн асуудал, биет болон биет бус соёлын өвийн асуудал. Сая Л.Энх-Амгалан гишүүн хөндөөд л байна лээ. Энэ бүх асуудал бол энэ Монгол судлалынхаа хүрээнд орж ирэх ёстой.

Би энэ Монгол судлалын сан байгуулах зорилгоор Засгийн газрын тусгай сангийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг харахаар бүрэлдэхүүн чинь голцуу хэл, түүхийн шинжлэх ухааны улсууд орчихсон байна. Тийм болохоороо энэ дээр соёлын хүмүүсээ оруулж байгаад арай өргөн хүрээнд энэ асуудлыг авч үзээчээ гэж ингэж хэлмээр байна. Жаахан явцуу байна гээд түрүүн С.Дэмбэрэл гишүүн шүүмжлээд байна лээ. Би тэрийг дэмжиж хэлмээр байна. М.Батчимэг гишүүний шүүмжлэлийг би яг давтаж хэлмээр байна. Энэ яг барьцтай эргээд юм байх ёстой. Ганц **Berkeley** биш. Хэд хэдэн газрын, хэд хэдэн их дээд сургуулиудын Монгол судлалын төвийг сэргээх тал дээр бодитой юм гаргамаар байна. Нэг тэрбум төгрөг 3 жил дотор гэдэг чинь нэг ч төвийг сэргээж чадахгүй. Одоо Кембрижийн их сургууль дээр байгаа төв

маань үндсэндээ Өвөр Монгол тал уруу явах гэж байна. Энэ мэтээс өгсүүлээд бидэнд санаа зовох зүйлс нэлээн байгаа гэдгийг зориулд хэлчихье.

Тэгээд энэ гадаад дотоодын, гадаадын хүмүүсээсээ гадна энэ дотоодын улсууддаа ч өөрсдөө хяналт тавиарай. Бурхан халдун уулын тухай аварга хөндөж ярьж байна лээ. Тэр Альберт Лин гэгч этгээд зөвшөөрөл авна гэж надад дээр орж ирэхэд нь би сайд байхдаа өгөхгүй гэж хэлээд гарахад манай Монгол судлалын байгууллагуудаар дамжаад зөвшөөрлөө аваад Ерөнхийлөгчийн зарлигаар хорьчихсон байгаа газар очоод шинжилгээ хийчихээд одоо дэлхий дахиар шуугуулаад яваад байгаа шүү дээ. Тэгээд ингээд өөрсдөө тийм улсуудын гар хөл болоод яваад байж болохгүй юм шүү. Энийг анхаарах ёстой гэдгийг хэлмээр байна.

Тэгээд энэ хэлэлцүүлгийн үеэр нэлээн санал онол хэлэх байх аа. Тэгээд Байнгын хороонд нь байдаггүй болохоор ингээд орхичихоод явчихаад байх юм. Зүгээр би эсэргүүцэх гэж байгаа юм биш. Сайжруулах талаар нь санал хэлэх гэж байгаа юм шүү. За баярлалаа.

**3.Энхболд:** - Ё.Отгонбаяр гишүүн Их Хурлын тухай хуулиа унших хэрэгтэй. Байнгын хорооны гишүүнээс үл хамааран хуралд нь чөлөөтэй оролцох. Тэрийг бол хэн ч, санал гаргах бүрэн эрхтэй байгаа.

За одоо хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлаар санал хураая. Байнгын хорооны саналаар Засгийн газрын тусгай сангийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн санал хураая. Санал хураалт.

Оролцсон 67, зөвшөөрсөн 53, 79.1 хувийн саналаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж байна.

Төсвийн байнгын хороонд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шилжүүлээ. Өнөөдрийн хурал дууслаа. Гишүүдэд баярлалаа. Маргааш өглөөний эхний хуралдаанаар Ч.Улаан сайдын санхүү, эдийн засгийн төлөвийн байдлын мэдээллийг сонсоно. Тэгээд Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай гэх мэтээр үргэлжлээд явна.

***Хуралдаан 17 цаг 44 минутад өндөрлөв.***

Соронзон хальснаас буулгасан:  
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД